



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛҮҮДИЙГ ЦОГЦ БАЙДЛААР ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС ШАЛТГААЛАН ОЙРЫН ХУГАЦААНД ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛД ЗААСАН ҮР АШГАА ӨГӨХӨӨРГҮЙ, ХИЛ ДАМЖУУЛАН СУУРИУЛАГДСАН ХҮЧИН ЧАДЛААР ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙХ БОЛОМЖГҮЙ БОЛСОН БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ТАВАН ТОЛГОЙ-ГАСУУН СУХАЙТ, ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, ҮР ДҮН
АУДИТЫН КОД: ГНАГ-2022/23-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2023 он

Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Д.Энхболд

Утас: 263755 Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Б.Саруул

Утас: 261805 Цахим хаяг: saruulb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Батдэлгэр

Утас: 261675 Цахим хаяг: batdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор И.Туяадарь

Утас: 261675 Цахим хаяг: tuyadarii@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан

Утас: 261675 Цахим хаяг: javkhlang@audit.gov.mn

Аудитор Т.Төмөрбаатар

Утас: 261675 Цахим хаяг: tumurbaatart@audit.gov.mn

Аудитор Р.Түмэн-Эрдэнэ

Утас: 261675 Цахим хаяг: tumenerdener@audit.gov.mn

Аудитор Ч.Баярмаа

Утас: 261675 Цахим хаяг: bayarmaach@audit.gov.mn 2023 он

Аудитор Ж.Чинбат

Утас: 261675 Цахим хаяг: chinbatj@audit.gov.mn

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	12
------------------------	----

БҮЛЭГ 1. ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ОЛОН УЛСЫН СТАНДАРТТАЙ УЯЛДУУЛАН ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛЖ, ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	19
---	-----------

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлагдаад 13 жил болсон ч бодлогыг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэр, бодлогын хэрэгжилтэд оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлоогүй байна..... 19

Хоёр төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг техникийн нэгдсэн бодлого, иж бүрэн судалгаанд үндэслэн төлөвлөөгүйгээс үргүй зардал гаргасан байна..... 22

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг дамжин өнгөрөх өртөөд, хилийн боомтын хүчин чадалтай нийцүүлэн төлөвлөөгүй байна 23

Зэвсэгт хүчний анги, нэгтгэлийг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах эрх зүйн зохицуулалт дутмаг, зарим зохицуулагдаагүй харилцаанд үйл ажиллагаа явуулснаас хууль зөрчиж, тодорхойгүй байдал үүсгэсэн байна 26

Төмөр замын бүтээн байгуулалтад шаардагдах норм, дүрэм, стандарт дутмаг байхад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулаагүй байна..... 29

Бодлогын хэрэгжилтэд хэлбэр төдий хяналт хэрэгжүүлж, бодлогын үр дүнг бодитой үнэлж, тайлагнаагүй байна 30

Бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ алдагдсан боломж, үр дүнг тооцоогүй байна 32

Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг харилцан адилгүй тогтоосон байна 34

Захиалагч болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч төрийн өмчит компаниудын засаглалын тогтворгүй байдлаас шалтгаалж компаниудын үйл ажиллагаа тогтвортой байж чадаагүй, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй ажиллаагүй байна..... 34

Тавантолгой төмөр зам ХХК, Зүүнбаян төмөр зам ХХК-д Эрдэнэс-Тавантолгой ХК өөрийн эзэмшлээс илүү хөрөнгө оруулсан ба хөрөнгийн үнэлгээ хийгдээгүй байна..... 36

Эрдэнэс-Тавантолгой ХК төрд ногдох ногдол ашгаар төмөр замын төслийг санхүүжүүлсэн нь компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцээгүй өгөөжгүй хөрөнгө оруулалт болжээ 38

БҮЛЭГ 2. ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН НЭВТРҮҮЛЭХ ЧАДВАР ХАНГАЛТГҮЙ, ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ДУТАГДАЛТАЙ БАЙДЛААС ШАЛТГААЛАН ТЭЗҮ-Д ЗААСАН ХҮЧИН ЧАДЛААР ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙЖ, БОГИНО БОЛОН УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХАД ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.....	40
--	-----------

Төслийн талбайд эрх бүхий этгээдээр инженер-геологи, геодезийн нарийвчилсан судалгаа хийлгэсэн байна 40

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг бүтээн байгуулалтын ажилтай зэрэгцүүлэн хийснээс нийт зөвлөмжийн 64.5 хувийг хэрэгжүүлээгүй байна..... 42

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын ТЭЗҮ-ийг тодотгох ажлыг бүтээн байгуулалтын ажилтай зэрэгцүүлэн хийжээ 45

Төмөр замын байгууламжийн зураг төсөл, төсвийг боловсруулж, эрх бүхий байгууллагууд магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргасан боловч зарим ажлын төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй байна 47

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр Зэвсэгт хүчний жанжин штаб ажилласан байна 50

Төслийн бүтээн байгуулалтад оролцсон зарим туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, давуу байдал олгосон байж болзошгүй байна..... 52

Бүтээн байгуулалтын ажил дуусаж, туршилт тохируулгын ажил хийгдэж байна..... 55

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал хангалтгүй байна..... 60

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажил гүйцэтгэгчийн удирдлагын зардлын 30 хувийг суутган авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна 62

Бүтээн байгуулалтын ажилд зарцуулах хөрөнгөөс 67.0 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмж бэлтгэсэн нь Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасантай нийцэхгүй байна 64

Улсын болон техникийн комиссоос өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, баримт бичгийн иж бүрдлийг хангах ажил хийгдэж байна..... 69

БҮЛЭГ 3. ТАВАНТОЛГОЙ-ГАСHUУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ХИЛ ХОЛБОЛТЫН ЦЭГИЙГ ТОХИРООГУЙ, ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУД БҮРЭН ХИЙГДЭЭГҮЙГЭЭС ОЙРЫН ХУГАЦААНД ЭДИЙН ЗАСАГТ ҮР АШИГ, ҮР НӨЛӨӨГӨӨ ҮЗҮҮЛЭХЭЭРГҮЙ БАЙНА 72

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд байгаль орчны төлөв байдалд байгаль орчны аудит хийх бэлтгэл ажил хийгдэж байна 72

Төмөр замын ТЭЗҮ-г төлөвлөлтийн шаардлага, мөрдөгдөж буй стандарт, норм ба дүрмийн дагуу боловсруулсан гэж холбогдох төрийн байгууллага дүгнэжээ..... 73

Төрийн захиргааны байгууллагууд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг хэлбэр төдий зохион байгуулжээ..... 75

Дотоодын аж ахуйн нэгж хооронд олон улсын фидик гэрээний мөнгөлөг загвараар гэрээ байгуулахдаа зарим харилцааг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлээгүй байна 77

Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн санхүүжилтээр 100 хувь гүйцэтгэсэн байна 78

Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах гүйцэтгэгчийг хэрхэн сонгосон нь тодорхойгүй, боловсруулсан ТЭЗҮ-ийг хуульд заасны дагуу баталгаажуулаагүй байна 82

Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн ажлыг техник, эдийн засгийн үндэслэлийн дүнгээр баталгаажсан зураг төсөвгүйгээр эхлүүлсэн байна 83

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын ажлыг байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгүйгээр гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн нь байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах боломжийг хязгаарласан байна 87

Шилжүүлэн ачих терминалын ажлыг гэрээгүйгээр гүйцэтгүүлж, баталгаажуулсан байна 92

Их хэмжээний урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид гуравдагч этгээдийн баталгаагүйгээр олгожээ 94

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслүүдийн ажлын бодит гүйцэтгэлээс давсан санхүүжилт олгосон байна 96

Хил орчмын төмөр замын зурвас газрын эзэмшлийг хуульд нийцүүлэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна 98

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд техникийн комиссоос өгсөн зарим үүрэг, даалгавар нь хэрэгжих боломжгүй байна..... 99

ДҮГНЭЛТ 102

ЗӨВЛӨМЖ..... 105

ХАВСРАЛТУУД 147

Хавсралт 1. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын байршлын зураг..... 147

Хавсралт 2. Монголын төмөр зам ТӨХК-ийн эзэмшилд байгаа хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад хийсэн судалгаа, сая нэгж..... 148

Хавсралт 3. Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн гүйцэтгэсэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн газар шорооны ажлын төсөвт өртгийн нэгтгэл, сая төгрөг 149

Хавсралт 4. Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн гүйцэтгэсэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн ус зайлуулах хоолойн ажлын төсөвт өртгийн нэгтгэл, сая төгрөг 150

Хавсралт 5. Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн гүйцэтгэсэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн НӨАТ шингээгүй ажлын өртгийн нэгтгэл, төгрөг 151

Хавсралт 6. ЗГХЭГ-ын даргын 2019 оны 44 дүгээр тушаалаар байгуулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд зохион байгуулах худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүн..... 152

Хавсралт 7. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, сая төгрөг 153

Хавсралт 8. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын төсвөөр бэлтгэсэн машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт, сая төгрөг 154

Хавсралт 9. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн ТЭЗҮ, гэрээний үнэ.....	155
Хавсралт 10. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын шилжүүлэн ачих терминалын ажилд шаардагдах хөрөнгө оруулалт, сая нэгж.....	156
Хавсралт 11. Тавантолгой - Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, сая ам.доллар, хувь.....	157
Хавсралт 12. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын нүүрс ачих логиستيкийн төвийн ажлын гүйцэтгэл, сая төгрөг, хувь.....	159
Хавсралт 13. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын холболтын төслийн ажлын гүйцэтгэл, сая төгрөг, хувь.....	160

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АБДОУБ	Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын байгууллага
АБДОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
БИЦҮГ	Барилга, инженерийн цэргийн удирдах газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БНБД	Барилгын норм ба дүрэм
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
БХТ	Барилгын хөгжлийн төв
БХЯ	Батлан хамгаалахын яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГНАГ	Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар
ГХС	Гадаад харилцааны сайд
ГХЯ	Гадаад харилцааны яам
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГХЭГД	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
ЗЗБНБД	Зам, замын байгууламжийн норм ба дүрэм
ЗТБХБС	Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ЗТЯ	Зам, тээврийн яам
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
ИШС	Инженерийн шугам сүлжээ
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн банк
МУХАУТ	Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЗНБД	Төмөр замын норм ба дүрэм
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХК	Хувьцаат компани
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ШУТЗ	Шинжлэх ухаан технологийн зөвлөл
ЭХЗЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭХХТ	Эрчим хүчний хөгжлийн төв
ЭХЭЗХ	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн

Хүснэгтийн товъёг:

Хүснэгтийн дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд төмөр зам барих зорилгоор концесс эзэмшигчийн 2008-2013 онд хийсэн судалгааны ажлууд	15
Хүснэгт 2	Шинэ төмөр зам төслийг хэрэгжүүлэхэд Евро бондын хөрөнгөөс авсан зээлийн зарцуулалт, сая ам.доллар	16
Хүснэгт 3	Шинэ төмөр зам төслийг хэрэгжүүлэхэд Чингис бондын хөрөнгөөс авсан зээлийн зарцуулалт, сая ам.доллар	17
Хүснэгт 4	Шинэ төмөр зам төслийг хүрээнд Каргилл олон улсын санхүүгийн байгууллагын зээлээр олгосон хөрөнгийн зарцуулалт, сая нэгж	17
Хүснэгт 5	Төмөр замын төслүүдийн санхүүжилтийн мэдээ, тэрбум төгрөг	18
Хүснэгт 6	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хэрэгцээг тодорхойлсон байдал, сая төгрөг	24
Хүснэгт 7	Зэвсэгт хүчний хөгжлийн санд төвлөрүүлсэн орлого, сая төгрөг	27
Хүснэгт 8	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.0 км төмөр замын ажлаас Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн гүйцэтгэсэн далан, хоолой, гүүр, өртөө зөрлөгийн ажлуудын төсөвт тооцсон НДШ, ашиг, НӨАТ-ийн дүн, сая төгрөг	28
Хүснэгт 9	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ажлын төсөвт өртөгт багтсан Монголын төмөр зам ТӨХК-ийн суутган авч үлдсэн НӨАТ-ын дүн, сая төгрөг	29
Хүснэгт 10	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ, 2017-2021 он, хувь	30
Хүснэгт 11	Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар тээсэн ачаа, сая тонн	32
Хүснэгт 12	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар 2019-2040 онд тээвэрлэх ачаа, олох орлогын төсөөлөл	32
Хүснэгт 13	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар 2019-2051 онд тээвэрлэх ачаа, олох орлогын төсөөлөл	33
Хүснэгт 14	Монголын төмөр зам ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлуудын ажилласан хугацаа, хуанлийн хоног	34
Хүснэгт 15	Сангийн яамнаас Монголын төмөр зам ТӨХК-тай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний мэдээлэл, мянган ам.доллар	35
Хүснэгт 16	Зүүнбаян төмөр зам ТӨХК-д оруулсан хөрөнгийн дүн, сая төгрөг	37
Хүснэгт 17	Тавантолгой төмөр зам ТӨХК-д оруулсан хөрөнгийн дүн, тэрбум төгрөг	38
Хүснэгт 18	Өрийн бичгийн төлбөрийн эргэн төлөлтийн хуваарь, тэрбум төгрөг	39
Хүснэгт 19	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын инженер-геологийн судалгаа хийсэн байдал, сая төгрөг	40
Хүснэгт 20	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад геодезийн хяналт хэрэгжүүлсэн компаниудтай байгуулсан гэрээний мэдээлэл, сая төгрөг	41
Хүснэгт 21	Геодезийн ажил гүйцэтгэсэн тоо хэмжээ	41
Хүснэгт 22	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ажилд байгаль орчны үнэлгээ, аудит хийлгэсэн зардлын гүйцэтгэл, сая төгрөг	42
Хүснэгт 23	Төмөр замын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	42
Хүснэгт 24	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад ашигласан ТТАМ-ын хэмжээ, ордын нөхөн сэргээлт хийсэн судалгаа	44
Хүснэгт 25	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуух төмөр замын зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан байдал	47
Хүснэгт 26	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлсэн зураг, төслийн ажлын зардлын гүйцэтгэл, сая төгрөг	47

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хүснэгт 27	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын эрчим хүчний барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан байдал, сая төгрөг	48
Хүснэгт 28	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуух эрчим хүчний байгууламжийн зураг төслийг боловсруулсан зардлын гүйцэтгэл, сая төгрөг	48
Хүснэгт 29	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуу өртөө, зөрлөгийн барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан байдал, сая төгрөг	49
Хүснэгт 30	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын холбоо дохиолол, шилэн кабелийн зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан байдал, сая төгрөг	49
Хүснэгт 31	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээний мэдээлэл, тэрбум төгрөг	55
Хүснэгт 32	Компаниудаас ирүүлсэн үнийн санал, сая төгрөг	57
Хүснэгт 33	Эрчим хүчний чиглэлээр хийсэн магадалшгүй ажлын жагсаалт, сая төгрөг	59
Хүснэгт 34	Тавантолгой төмөр зам ХХК-ийн санхүүгийн зарим үзүүлэлт, техник хяналтын зардлын бүрдүүлэлт, сая төгрөг	61
Хүснэгт 35	Зэвсэгт хүчний ангиуд болон ААНБ-ын хяналтын төсвийн удирдлагын зардлаас 30 хувиар тооцож суутгасан дүн, сая төгрөг	62
Хүснэгт 36	Зураг төсөл зохиогчийн хяналт ажлын зардлын гүйцэтгэл, сая төгрөг	63
Хүснэгт 37	Зураг төсөл зохиогчийн хяналтаар өгсөн зарим зөвлөмжүүд	64
Хүснэгт 38	Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд зориулж худалдан авсан техник, тоног төхөөрөмжийн жагсаалт, сая төгрөг	65
Хүснэгт 39	Төмөр бетон дэр нийлүүлэх гадаад валютаар байгуулсан гэрээний мэдээлэл, ам.доллар	66
Хүснэгт 40	Монголын төмөр зам ТӨХК-ийн ам.доллараар хийсэн гэрээнээс үүсэх 2023 оны ханшийн алдагдлын тооцоо, 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөр тасалбар болгон тооцсон, сая төгрөг	67
Хүснэгт 41	Korea National Railway ХХК-ийн гүйцэтгэлд ам.доллараас ханшийн зөрүүгээс үүсэх алдагдлын болзошгүй эрсдэлийн тооцоо	68
Хүснэгт 42	Улсын болон техникийн комиссын шийдвэрээр өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн мэдээлэл	69
Хүснэгт 43	Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн матриц	72
Хүснэгт 44	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн үндсэн болон нэмэлт гэрээний дүн, оруулсан өөрчлөлт, мянган ам.доллар	77
Хүснэгт 45	Ажил дуусгах хугацааг сунгаж, мастер төлөвлөгөөгөөр өөрчилсөн ажлын хуваарь	79
Хүснэгт 46	Давагдашгүй хүчин зүйлийн ажлын хуваарьт нөлөөлсөн байдал	79
Хүснэгт 47	Бодь интернэшнл ХХК-ийн нийлүүлсэн вагоны нэр төрөл, тоо	81
Хүснэгт 48	Тавантолгой төмөр зам ХХК-ийн илчит тэрэг түрээсэлсэн зардлын дэлгэрэнгүй, сая төгрөг	81
Хүснэгт 49	Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн хөрөнгө оруулалтын зардлын ангилал, сая нэгж	86
Хүснэгт 50	Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн гэрээгээр гүйцэтгүүлсэн зардлын ангилал, сая нэгж	86
Хүснэгт 51	Холболтын төмөр замын ТЭЗҮ-д заасан хөрөнгө оруулалтын зардал, сая төгрөг	88
Хүснэгт 52	Гэрээгээр олгосон урьдчилгаа төлбөрийн баталгааны мэдээлэл, тэрбум төгрөг	95
Хүснэгт 53	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажлын гүйцэтгэлээр Бодь интернэшнл ХХК-д олгосон санхүүжилт, сая нэгж	97
Хүснэгт 54	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн замын бүтээн байгуулалтын ажилд олгосон санхүүжилт, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар, тэрбум төгрөг	97
Хүснэгт 55	Техникийн комиссоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн мэдээлэл	100
Хүснэгт 56	Улсын комиссоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн мэдээлэл	101

Дүрслэлийн товъёг:

Дүрслэлийн дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд баригдах төмөр замын чиглэлүүд	18

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Дүрслэл 2	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрэх үр дүнгийн үзүүлэлт	31
Дүрслэл 3	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх явцад гарсан зөвлөмж, шийдвэр, бусад хэлцлүүд	51
Дүрслэл 4	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх явцад гарсан зөвлөмж, шийдвэр, бусад хэлцлүүд	74

Графикийн товьёг:

Графикийн дугаар	Агуулга	Хуудасны дугаар
График 1	Бодь интернэшнл ХХК-д нүүрсээр олгох болон олгосон санхүүжилтийг хугацааны дарааллаар харуулбал, сая ам.доллар	95

Зургийн товьёг:

Зургийн дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Зураг 1	Тавантолгой-Сайншанд болон Тавантолгой-Зүүнбаян трассын харьцуулалт	47
Зураг 2	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт хийгдэж буй улсын хилийн зурвас болон Говийн бага дархан цаазат газарт хамаарч буй газрын зураг	97

Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06, 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/12, 2023 оны А/04 дүгээр тушаалуудаар баталсан Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөг үндэслэн Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Үүнд:

- Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хууль тогтоомжийн дагуу төлөвлөсөн эсэх;
- Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын гүйцэтгэлд зарцуулсан хөрөнгө үр дүнтэй эсэх.

Аудитыг ЗГХЭГ, ЗТХЯ, УУХҮЯ, БХЯ, ЗХЖШ, Хилийн боомтын захиргаа, ТӨБЗГ, АМГТГ, ТЕГ, ГЕГ, Монголын төмөр зам ТӨХК, Тавантолгой төмөр зам ХХК, УБТЗ ХНН, орон нутгийн засаг, захиргааны нэгж, зураг төсвийг зохиогч, магадлал хийсэн, хянан баталгаажуулсан хуулийн этгээд, ЕРС гэрээний оролцогч талууд, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд болон аудитын сэдэвт хамаарал бүхий бусад холбогдох байгууллагын 2019-2022 оны үйл ажиллагааны үр дүнг хамруулан хийж, аудитын тайлан бэлтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитад Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг 2010 онд баталснаас 2018 оныг дуусталх хугацааны Монголын төмөр зам ТӨХК-ийн үйл ажиллагаа, Грант торнтон аудит ХХК-ийн 2019 онд баталгаажуулсан "Шинэ төмөр зам" төслийн хүрээнд хийгдсэн Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн ажлын дүнг хамруулаагүй болно.

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн гаргасан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит. Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит" стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалд заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх дүн шинжилгээг хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдлыг хянах гүйцэтгэлийн аудитын шалгуур үзүүлэлтийг баримтлан дараах хууль, эрх зүйн актыг эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

Монгол Улсын хуулиуд:

- Ашигт малтмалын тухай;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай;
- Байгаль орчныг хамгаалах тухай;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай;
- Барилгын тухай;
- Гаалийн тухай;
- Газрын тухай;
- Газрын хэвлийн тухай;
- Зэвсэгт хүчний тухай;
- Иргэний;

- Компанийн тухай;
- Нийгмийн даатгалын тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- Татварын ерөнхий;
- Төмөр замын тээврийн тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай;
- Төсвийн тухай;
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай;
- Хөдөлмөрийн тухай;
- Хөрөнгө оруулалтын тухай;
- Усны тухай;
- Үнэт цаасны зах зээлийн тухай;

УИХ-ын тогтоолууд:

- 2010 оны 32 дугаар “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”;
- 2010 оны 39 дүгээр “Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай”;
- 2016 оны 19 дүгээр “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”;
- 2016 оны 70 дугаар “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”;
- 2016 оны 45 дугаар “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- 2017 оны 42 дугаар “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”;
- 2018 оны 37 дугаар “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”;
- 2018 оны 73 дугаар “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- 2019 оны 54 дүгээр “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл тогтоол”;
- 2020 оны 24 дүгээр “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- 2020 оны 23 дугаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- 2020 оны 52 дугаар “Алсын хараа-2050”.

Засгийн газрын тогтоолууд:

- 2016 оны 249 дүгээр “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”;
- 2017 оны 89 дүгээр “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- 2018 оны 242 дугаар “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай”;
- 2018 оны 140, 2019 оны 290 дүгээр “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” баталсан тогтоол;
- 2019 оны 214 дүгээр “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”;
- 2019 оны 304 дүгээр “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- 2020 оны 206 дугаар “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;

Бусад

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр зарлигаар баталсан “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам”;

Аудитын баг, бүрэлдэхүүн	▪ Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”; ▪ Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”; ▪ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”; ▪ Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалаар баталсан “Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм”; ▪ Бусад холбогдох хууль, тогтоомж; Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Саруул хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батдэлгэр, И.Туяадарь, Г.Жавхлан, аудитор Ч.Баярмаа, Т.Төмөрбаатар, Р.Түмэн-Эрдэнэ, И.Дөлгөөнтуул, Ж.Чинбат нар гүйцэтгэв.
Хүндрэл, бэрхшээл	Аудитын горимыг хэрэгжүүлэх үе шатны ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд гүйцэтгэн, холбогдох үе шатны хяналтыг хийлгэн 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар баталгаажуулж, холбогдох байгууллагад хүргүүлэхээр төлөвлөсөн боловч: 1. Аудитын талбарын ажил эхлэхэд төслийн үйл ажиллагаа төрийн нууцад хамаарч байсан учраас нууцыг ил болгох, аудитад шаардлагатай баримт материалаар хангагдахад хугацаа шаардагдсан; 2. Аудитын явцад МУЗГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 434 дүгээр тогтоолоор Зүүнбаян төмөр зам ТӨХК-ийн үйл ажиллагааг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон зогсоож, Монголын төмөр зам ТӨХК-тай нэгтгэсэн; 3. МУЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Засгийн газрын ээлжит бус хуралдааны шийдвэрээр Тавантолгой төмөр зам ХХК-д онцгой дэглэм тогтоож, Бүрэн эрхт төлөөлөгчөөр ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмарыг томилж ажиллуулсан; 4. Компанийг татан буулгах, нэгтгэх, удирдлагаар Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгч томилогдох зэргээр компаниудын бүтэц, орон тоо байнга өөрчлөгдөж, ажил хариуцсан ажилтнууд солигдож байсан нь аудитын горим, сорил хэрэгжүүлэх, нотлох баримт цуглуулахад хүндрэл учруулсан; 5. Төмөр замын барилга, байгууламжийн зураг төслийг мөрдөгдөж буй норм ба дүрэм, стандартад нийцүүлэн боловсруулсан эсэхэд мэргэжлийн шинжээч ажиллуулахаар төлөвлөсөн боловч тухайн чиглэлийн дийлэнх мэргэшсэн боловсон хүчин бүтээн байгуулалтын ажилд оролцсон тул хөндлөнгийн шинжээчээр дүгнэлт гаргуулах боломжгүй байв. 6. Дээрх компаниудын дотоод хяналтын үйл ажиллагаа, ажилтнуудын ажлын хариуцлага сул зэргээс баримт материал, тооцоо судалгаа алдаатай илэрхийлэгдсэн, нотлох баримтаар бүрэн дэмжигдээгүй зэрэг нь мөн аудит хийх хугацаанд нөлөөлж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, ажлын гүйцэтгэл, авлага, өглөгийг баталгаажуулж авахад хүндрэлтэй байлаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Бодлого, эрх зүйн талаар

Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлого тодорхойлох” гэж заасныг үндэслэн УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаар тогтоолоор “Төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, ирээдүйд өсөн нэмэгдэх тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг үр дүнтэй, найдвартай хангахад чиглэсэн үр ашигтай үндэсний төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээг өргөжүүлж, улмаар улс орны дамжин өнгөрүүлэх чадавхийг дээшлүүлэн, салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ашигт малтмалын томоохон ордуудыг ашиглах, тэдгээрийн бүтээгдэхүүнийг экспортлох болон боловсруулан экспортолж улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах” зорилгоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газарт даалгасан байна.

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд шинээр суурь бүтэц барих 5,683.5 км төмөр замын төслүүдийг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, MacKenzie and company, Liberty Partners LLC, Pillsbury Winthrop Shaw Pittman ба BNP Paribas limited компаниас бүрдсэн Монголын төмөр зам ТӨХК-ийн зөвлөх баг нь 2011 оны 8 дугаар сард “Шинэ төмөр зам” төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.

Энэхүү ТЭЗҮ нь хамрах хүрээний хувьд “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого”-ын эхний үе шат болох Даланзадгад-Тавантолгой-Сайншанд-Баруун-Урт-Чойбалсан чиглэлийн 1100 км, гол тэнхлэгийг БНХАУ-ын төмөр замын сүлжээнд холбох 2 дугаар үе шатны ажлыг нэгтгэн багтааж, нийт урт 2100 км бөгөөд хөрөнгө оруулалтын дүнг ойролцоогоор 5.2 тэрбум ам.доллар байхаар тооцоолсон байна.

Монголын төмөр зам ТӨХК 2013 оны 5 дугаар сарын 14-ний өдөр МТЗ-ЗҮ-2013-02 дугаартай “Шинэ төмөр зам төсөлд техникийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г Nirron Koei ‘компанитай байгуулсан байна. Гэрээний үнийн дүн 9,111,423.0 ам.доллар буюу 15,119.0 сая төгрөг (Монголбанкнаас 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн зарласан ам.долларын албан ханш 1,659.34₮) болж байна.

Зөвлөх үйлчилгээний компани нь дараах чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-д тодотголын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Эрдэнэс-Тавантолгой – Ухаахудаг (10.8 км)
- Ухаахудаг - Тавантолгой - Сайншанд (447.7 км)
- Сайншанд - Хөөт (433.7 км)
- Хөөт - Чойбалсан (190.3 км)
- Чойбалсан - Эрэнцав (224.2 км)
- Хөөт - Бичигт (216.3 км)

УИХ-ын 2011 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 15 дугаар тогтоол, Засгийн газрын 2011 оны “Шинэ төмөр замын төслийн санхүүжилтийн тухай” 266 дугаар тогтоолоор төслийг хэрэгжүүлэхэд эхний ээлжид шаардагдах 55.0 сая ам.долларын санхүүжилтийг 2011 онд багтаан зохих журмын дагуу шийдвэрлэхийг МУХБ-ны ТУЗ-д зөвшөөрсөн байна.

Мөн УИХ-ын 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д заасан шинээр барих төмөр замын суурь бүтцийг барихад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийн тодорхой хэсгийг бүрдүүлэх зорилгоор Монголын төмөр зам ХХК-ийн үнэлгээг хийж, төрийн мэдлийн хувьцаа нь 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гаргаж, хувьцааг Монголын

болон гадаадын биржээр арилжихаар “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-д өөрчлөлт оруулжээ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 35/32 дугаартай зөвлөмжөөр Засгийн газарт дараах зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

- УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын шинээр барихаар заасан төмөр замын суурь бүтцийн концессыг төрийн өмчит, эсхүл төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд Концессын тухай хуулийн 17.1.1-т заасан журмын дагуу олгох;
- Шинээр барих төмөр замын ТЭЗҮ-ийг холбогдох тооцоо, судалгааны хамт 2011 оны 8 дугаар сард багтаан боловсруулж дуусах;
- 1, 2 дахь үе шатны төмөр замын суурь бүтцийг 2013 онд багтаан ашиглалтад оруулах;
- Бодлогын 3.2.6-д заасан 3 дугаар үе шатанд барьж эхлэх 3,600 км төмөр замын маршрутыг нарийвчлан тодорхойлж, УИХ-д танилцуулах.

Аудитад Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.0 км, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хамруулсан. (Бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байршлын газрын зургийг хавсралт 1-ээс харна уу)

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам:

- Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.3¹-т заасныг үндэслэсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр зарлигаар “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам”-ыг баталж, уг журмыг 2018 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг үүрэг болгосон;
- УИХ-ын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоолын 2-т “...Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх”-ийг Засгийн газарт даалгасны дагуу дээрх төмөр замын бүтээн байгуулалтын ажлын эхлэл тавигдсан байна.

Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах тухай” 153 дугаар тогтоолоор:

- 1-д Төрийн өмчийн 51-ээс доошгүй хувийн оролцоотой Дорнын төмөр зам ХХК-тай хамтарсан Зүүнбаян төмөр зам ХХК-ийг байгуулах;
- 2-т Зүүнбаян төмөр зам ХХК-ийн нийт хувьцааны төрд ногдох хувийг Монголын төмөр зам ТӨХК-д эзэмшүүлэх;
- 3-т Монголын төмөр зам ТӨХК, Дорнын төмөр зам ХХК-аас Сайншанд-Тавантолгой чиглэлийн төмөр замын төслийн бэлтгэл ажилд зориулан зарцуулсан хөрөнгөд аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр Зүүнбаян төмөр зам ХХК-ийн хувь хөрөнгөд оруулж тооцох;
- 4-т Зүүнбаян төмөр зам ХХК байгуулах болон хөндлөнгийн аудит хийлгэхэд шаардагдах зардлыг Монголын төмөр зам ХХК санхүүжүүлэх;
- 5-д Зүүнбаян төмөр зам ХХК-тай Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр барьж байгуулах хэлэлцээ хийж, гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг ЗТХС, Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ, ҮХГ, ТӨБЗГ-т тус тус даалгажээ.

Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолоор:

- 1-д Төмөр замын төслийн ТЭЗҮ-д тулгуурлан, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн хүүгүй, 20 хүртэлх жилийн хугацаатай 750.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнээр хаалттай хүрээнд худалдахаар гаргах зөвшөөрлийг Монголын төмөр зам ТӨХК-д олгох;
- 2-т Монголын төмөр зам ТӨХК-ийн гаргасан үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь нүүрс тээвэрлэлтийн төлбөрөөс суутгах зэрэг эргэн төлөх нөхцөлтэйгөөр Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаас худалдан авах;
- 3-т Төмөр замын төсөлд шаардагдах хөрөнгийн үлдэгдэл санхүүжилтийг Монголбанкны дэмжлэгээр бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх;

¹ Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр Засгийн газрын шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.

4-т Төмөр замыг холбогдох хууль тогтоомж, олон улсын стандарт, чанарын шаардлагад нийцүүлэн барьж байгуулахыг Сангийн сайд, ЗТХС, УУХҮС, БХС, Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-д тус тус үүрэг болгосон байна.

МУЕС-ын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 53 дугаар захирамжаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ЗГХЭГД, ЗТХС нараар ахлуулж, гишүүдээр нь Сангийн сайд, БХС, УУХҮС, БОАЖС, БХБС, ЭХС, ЗХЖШ, Өмнөговь, Дорноговь аймгийн Засаг дарга нар, Монголын төмөр зам ТӨХК, УБТЗ ХНН, Эрдэнэс-Тавантолгой ХК, Барилгын хөгжлийн төвийн холбогдох албан тушаалтнуудыг ажиллуулахаар байгуулж, ажлын хэсгийн удирдамжийг баталсан байна.

Ажлын хэсэгт удирдамжаар:

1. Төмөр замын бүтээн байгуулалтын ажлын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулах;
2. Төмөр замын шугамын зарим хэсгийг шинэчлэн тогтоох, бүтээн байгуулалт хийгдэх газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, төмөр замын зурвас газарт давхцал байгаа эсэхийг тогтоох, чөлөөлөх;
3. Төслийн ТЭЗҮ, инженерийн тооцоо, өртгийн төсөө, холбогдох зураг төслийн магадлалыг хэсэгчлэн хийлгэж, барилгын ажлыг тасралтгүй шуурхай гүйцэтгүүлэх;
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, холбогдох шинжилгээ дүгнэлтийг хийлгэх;
5. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох, түгээмэл тархацтай ашигт малтмал болон ус ашиглалтын төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг Засгийн газраар шийдүүлэх;
6. Бүтээн байгуулалтад шаардлагатай үлдэгдэл хөрөнгийг Сангийн яам, Монголбанкны дэмжлэгээр дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэх;
7. Төмөр замын барилгын ажил гүйцэтгэх гэрээг хууль тогтоомжид нийцүүлэн УБТЗ ХНН-тай байгуулах;
8. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц, үр дүнг улирал бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, бүтээн байгуулалтын ажлыг хэвийн тасралтгүй үргэлжлүүлэхэд байгууллага хоорондын ажлын уялдааг ханган ажиллахыг даалгасан байна.

Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 188 дугаар тогтоолоор:

- 1-д Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 53 дэх заалтыг хүчингүй болгож;
- 2-т Бүтээн байгуулалтын ажилд шаардагдах ус, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг ЗТХС, УУХҮС, БОАЖС нарт тус тус даалгаж;
- 3-т Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоолыг хүчингүй болгосон байна.

Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн “Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг оролцуулах тухай” 194 дүгээр тогтоолоор:

- 1-д төмөр замын бүтээн байгуулалтын 414.6 км далан барих ажилд Зэвсэгт хүчнээс 2300 хүртэл алба хаагч, 900 хүртэл нэгж техникийг 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс мөн оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлт хугацаанд ажиллуулах;
- 2-т Бүтээн байгуулалтын ажилд оролцох бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг бэлтгэж, ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэхийг БХС-д үүрэг болгожээ.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Тавантолгойн уурхайгаас Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян өртөө хүртэлх гол замын урт 416.0 км, дэлгэмэл урт нь 463.4 км, 1 өртөө, 6 зөрлөгтэй, 23.5 тонны голын даацтай, 1520 мм-ийн өргөн царигтай, жилд 15.0 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай байхаар төлөвлөгдсөн байна.

Тус төмөр замын бүтээн байгуулалтын ажлын нийт өртгийн 16.3 хувийн ажлыг Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүд, 15.3 хувийн ажлыг УБТЗ ХНН, үлдэх ажлыг туслан гүйцэтгэгч ААН-үүд гүйцэтгэжээ. Үүнд:

Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүд:

- 416.0 км 25.5 сая шоо метр газар шорооны ажлын 26.3 хувь, өртгөөр илэрхийлсэн дүнгийн 25.1 хувь;
- Ус зайлуулах 596 ширхэг хоолойн барихаас 288 ширхэг буюу 48.3 хувь, өртгөөр илэрхийлсэн дүнгийн 48.0 хувь;
- Нийт 27 ширхэг гүүрийн байгууламж барихаас 57.3 у/м 1 гүүр буюу 2.4 хувь, өртгөөр илэрхийлсэн дүнгийн 2.6 хувь;
- Өртөө, зөрлөгийн болон бусад 43,476.1 сая төгрөгийн өртөг бүхий барилга, байгууламжийн ажил;
- 22,136.4 сая төгрөгийн балласт үйлдвэрлэх;
- 12,470.3 сая төгрөгийн төмөр замын сараалж гараар угсрах;
- Зам төмөр, бетон дэр, жижиг хэрэгсэл тээвэрлэх 12,163.2 сая, ачиж буулгах 742.7 сая төгрөгийн;
- Балласт тээвэрлэх 2,831.3 сая, ачих 331.3 сая төгрөгийн;
- 1,078.6 сая төгрөгийн технологийн зам засвар, арчлалтын;
- зам төмөр, бетон дэр, жижиг хэрэгсэл ачиж буулгах, нийт 227,371.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн байна.

Улаанбаатар төмөр зам ХНН:

- 129,449.7 сая төгрөгөөр зам төмөр, 8,603.5 сая төгрөгөөр хавчаар, боолт, шайб, гайк зэрэг дагалдах хэрэгсэл;
- 9,066.9 сая төгрөгөөр суман шилжүүлэг, 2,018.4 сая төгрөгөөр суман шилжүүлгийн төмөр бетон;
- 58.9 мянган шоо метр буталмал чулуу буюу балластыг 2,384.0 сая төгрөг;
- 52.6 мянган ширхэг төмөр бетон дэрийг 10,140.0 сая төгрөгөөр тус тус нийлүүлж,
- 47,977.9 сая төгрөгөөр үе угсрах ажил;
- 2,627.9 сая төгрөгийн тээвэр, нийт 212,268.3 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын дэд бүтцийг УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.4-т заасан II үе шатанд барихаар төлөвлөсөн байна.

Засгийн газрын 2011 оны “Концессын зүйлийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай” 185 дугаар тогтоолоор төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын 94 дэх хэсэгт Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогоор 2 дугаар шатанд баригдах зарим замуудыг хамруулахаар өргөжүүлж, Ухаахудаг-Гашуунсухайт, Хөөт-Тамсагбулаг-Нөмрөг, Хөөт-Бичигт чиглэлд нийт 960 км төмөр зам барих асуудлыг нэмж тусгасан байна.

Хүснэгт 1. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд төмөр зам барих зорилгоор концесс эзэмшигчийн 2008-2013 онд хийсэн судалгааны ажлууд

№	Он	Судалгааны ажлын нэршил	Гүйцэтгэгчийн нэр
1	2008	Техник, эдийн засгийн үндэслэл	Parsons Brinckerhoff Australia Pty Limited
2	2009	Нарийн цариг бүхий төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл	DBI
3	2012	Өргөн цариг бүхий төмөр замын урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл	AECOM Asia co.ltd
4	2012	Техник, эдийн засгийн үндэслэл болон эдийн засгийн DBI шинжилгээ	ZAZA, CANARAIL
5	2013	Өргөн цариг бүхий төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл	AECOM Asia co.ltd

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

Засгийн газрын 2012 оны “Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” 93 дугаар тогтоолоор, Төмөр замын суурь бүтэц эзэмшигч хувьцаат компанийн үйл ажиллагаа эхлэх хүртэл Сайншанд-Тавантолгой-Ухаахудаг чиглэлийн төмөр замын суурь бүтцийг “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр концессыг шууд олгохыг ЗТБХС (хуучин нэрээр) Ц.Дашдорж, ТӨХ (хуучин нэрээр)-ний дарга Б.Заяабал нарт даалгасны дагуу Засгийн газрын 2012 оны “Төмөр замын суурь бүтцийг барих концессын гэрээний тухай” 161 дүгээр тогтоолоор “Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ”-г Энержи ресурс болон Энержи ресурс рэйл ХХК-тай байгуулахыг зөвшөөрчээ.

Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих төсөл нь нийт 1.1 тэрбум ам.долларын өртөгтэй, 6 багц ажлаас бүрдэх бөгөөд төмөр замын суурь

бүтцийг барьж, ашиглалтад оруулснаас хойш 19 жилийн дараа суурь бүтцийн 51.0 хувийг төрд шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээг 2012 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Энержи ресурс болон Энержи ресурс рэйл ХХК-тай байгуулсан байна.

Энержи ресурс рэйл ХХК нь ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, инженерийн хайгуулын судалгаа, төсөлд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг шийдвэрлэхтэй холбоотой ажлуудыг гүйцэтгэж, ТЭЗҮ-ээрх багц 1 дэх ажлын ерөнхий гүйцэтгэгчээр Samsung C and T компанийг сонгон шалгаруулж, тус компанитай 439.8 сая ам.долларын гэрээг 2012 оны 10 дугаар сарын 31-ний өдөр байгуулж, газар шорооны ажлын 2 орчим хувийг гүйцэтгүүлжээ.

МУЕС-ын 2012 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 13 дугаар захирамжаар “Тавантолгойн орд газрыг ашиглах болон түүний дэд бүтцийн асуудлаар дүгнэлт гаргах” чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгээс нэр бүхий компаниудад концессын эрх олгосон нь холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн, төмөр замын суурь бүтцийг барихад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг төслийн тусгай зориулалтын компаниар дамжуулан бүрдүүлэх санал, дүгнэлтийг Засгийн газарт танилцуулсан байна.

Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 121 дүгээр тогтоолоор төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг Монголын төмөр зам ТӨХК-д олгож, Засгийн газрын 2012 оны 93, 161 дүгээр тогтоолуудыг хүчингүй болгосноор дээрх концессын гэрээг 2013 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөр тасалбар болгон цуцалжээ.

Концессын гэрээг цуцалсантай холбогдуулан ЗТС (хуучин нэрээр), ТӨХ (хуучин нэрээр)-ны даргын хамтарсан 91 дүгээр тушаал гарч уг гэрээний эрх, үүргийг зохих журмын дагуу Монголын төмөр зам ТӨХК-д шилжүүлэн өгч, багц 1 дэх ажлын ерөнхий гүйцэтгэгч буюу Samsung C and T компанийг үргэлжлүүлэн ажиллуулахаар шийдвэрлэж, концесс эзэмшигчийн 83.7 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийг бодитоор гарсан гэж зөвшөөрч, хүлээн авсан байна.

Засгийн газрын 2013 оны “Шинэ төмөр зам төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 28 дугаар тогтоолоор I, II үе шатанд барих төмөр замын суурь бүтцийн “барих-ашиглах-шилжүүлэх” концессыг Монголын төмөр зам ТӨХК-д олгож, төслийн хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, санхүүжүүлэхийг МУХБ-д даалгасан байна.

Төмөр замын суурь бүтцийг барих төслийг санхүүжүүлэх, санхүүжилтийг эргэн төлүүлэх үйл ажиллагааг МУХБ, ЭЗХЯ болон ЗТЯ (хуучин нэрээр)-тай тодорхой нөхцөлүүдээр харилцан тохиролцож Евро бондын хөрөнгөөс 55.0 сая ам.доллартой тэнцэх үнийн дүнтэй, 7.38 хувийн хүүтэй “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” 3-ТЗ-Б 2013-5 тоот гэрээг 2013 оны 2 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан бөгөөд үүнээс 22.5 сая ам.долларыг доорх ажлуудад зарцуулсан байна. Үүнд:

Хүснэгт 2. Шинэ төмөр зам төслийг хэрэгжүүлэхэд Евро бондын хөрөнгөөс авсан зээлийн зарцуулалт, сая ам.доллар

№	Гүйцэтгэгч байгууллага	Гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ	Гэрээний дүн	Ажлын гүйцэтгэл	
				Мөнгөн дүн	Хувь
Тавантолгой-Сайншанд-Хөөт-Чойбалсан-Эрээнцав, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөл:					
1	Геомастер ХХК-аар ахлуулсан дотоодын 17 компани	Геодезийн судалгаа	3.9	1.9	100.0
2	Эко гидро гео ХХК-аар ахлуулсан дотоодын 11 компани	Геологийн судалгаа	3.5	1.7	100.0
3	Найчрал Састайнэблэ ХХК-аар ахлуулсан дотоодын 4 компани	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	0.6	0.3	100.0
4	MacKenzie and company	ТЭЗҮ (Хаан банкны үндсэн зээл, хүүгийн хамт)	6.5	6.5	100.0
5	Археологи	Археологийн судалгаа	0.02	0.02	100.0
6	Палеонтологи	Палеонтологийн судалгаа	0.04	0.02	100.0
Аудитын код: ГНАГ-2022/23-ШТА-ГА				Хуудас 16	

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

7	Nippon Koei LLC	Техникийн зөвлөх үйлчилгээ	19.1	5.9	100.0
8	Sidley Austin LLP, MDS Associate	Хуулийн зөвлөх үйлчилгээ	7.5	4.2	50.0
9	BNP Paribas (China) Limited, Guggenheim International LLC, Liberty Partners LLC	Санхүүгийн зөвлөх үйлчилгээ	3.6	1.8	50.0
Нийт дүн			44.8	22.5	

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

Засгийн газрын 2013 оны 82 дугаар тогтоолоор Чингис бондын хөрөнгөөс “Шинэ төмөр зам” төслийг санхүүжүүлэх 200.0 сая ам.доллартой тэнцэх хөрөнгийг МУХБ-аар дамжуулан авах “Засгийн газрын бондын хөрөнгөөр төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” Г03/95/3-ТЗ-ХО 2013.16 дугаар гэрээг 2013 оны 5 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 3. Шинэ төмөр зам төслийг хэрэгжүүлэхэд Чингис бондын хөрөнгөөс авсан зээлийн зарцуулалт, сая ам.доллар

№	Хийгдсэн ажил	Гэрээний үнийн дүн	Ажлын гүйцэтгэл	
			Мөнгөн дүн	Хувь
1	Samsug C and T компанийн төлбөр	483.8	187.6	55.0
2	Монголын төмөр зам ТӨХК-ийн үйл ажиллагааны зардал	-	2.3	
3	Ус ашигласны төлбөр	-	0.1	
4	ЦДАШ, дэд станцын зураг төсөл	0.2	0.1	100.0
5	Өртөө зөрлөгийн барилгын зураг төсөл	0.4	0.2	95.0
6	Хууль зөвлөх үйлчилгээ	-	1.4	
7	Санхүү зөвлөх үйлчилгээ	-	0.9	
8	Техник зөвлөх үйлчилгээ	-	3.2	
9	Хяналт зөвлөх үйлчилгээ	4.4	0.9	55.0
10	Сургалт	-	0.1	
11	Палеонтологи сүүлийн 50 хувь	-	0.0	
12	Зөвлөх үйлчилгээнээс суутган татварын төлбөр	-	0.5	
Нийт дүн		488.8	197.3	

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

Засгийн газрын 2016 оны “Төлбөрийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 83 дугаар тогтоолоор “Шинэ төмөр зам төсөл”-ийн техникийн зөвлөх үйлчилгээний үлдэгдэл төлбөрт 3.05 сая ам.доллар, 3,872.9 сая төгрөгийн санхүүжилт олгохыг ЗТС (хуучин нэрээр, М.Зоригт), МУХБ-нд даалгасан бөгөөд Засгийн газрын 2016 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоолоор дээрх дүнд өөрчлөлт оруулж 4.6 сая ам.доллар, 3,663.9 сая төгрөг болгожээ. Энэхүү тогтоолын хүрээнд МУХБ, Монголын төмөр зам ТӨХК-ийн хооронд 2016 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр зээлийн гэрээ байгуулж, Каргилл Олон Улсын санхүүгийн байгууллагын зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс 4,612.1 мянган ам.доллар, 3,663.8 сая төгрөгийн санхүүжилтийг 7.37 хувийн хүүтэйгээр Монголын төмөр зам ТӨХК-д олгож, доорх ажлуудыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 4. Шинэ төмөр зам төслийг хүрээнд Каргилл олон улсын санхүүгийн байгууллагын зээлээр олгосон хөрөнгийн зарцуулалт, сая нэгж

№	Санхүүжилт	Ам.доллар	Төгрөг
1	Техникийн зөвлөх үйлчилгээ (Nippon Koei LLC)	2.8	3,663.8
2	Хяналтын зөвлөх үйлчилгээ (DBI international)	1.7	
Нийт дүн		4.6	3,663.8

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

Төсөлд 2013-2016 оны хооронд МУХБ-аас нийт 224.4 сая ам.доллар, 3,663.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1 дүгээр багц болох төмөр замын дээд болон доод суурь бүтэц барих ажил 2015 оны 2 дугаар сараас хойш санхүүжилтгүйн улмаас зогсжээ.

УИХ-ын 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан байна.

Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2018 оны “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай” 242 дугаар тогтоолоор төрийн өмчийн 51-ээс доошгүй хувийн оролцоотой Тавантолгой төмөр зам ХХК-ийг байгуулах, төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгох, Монголын төмөр зам ТӨХК-аас тус төсөлд зарцуулсан хөрөнгийг хөндлөнгийн аудит хийлгэж баталгаажуулах, төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай хөрөнгийн тодорхой хэсгийг нүүрс урьдчилан борлуулах гэрээ байгуулах замаар санхүүжүүлэх, ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулахыг холбогдох хуулийн этгээдүүдэд тус тус даалгасан байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа төмөр замын дараах төслүүдэд 6,324.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2024 оныг дуустал хийхээр төлөвлөснөөс 2023 оны 6 дугаар сарыг дуусталх хугацаанд нийт 5,406.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулжээ.

Хүснэгт 5. Төмөр замын төслүүдийн санхүүжилтийн мэдээ, тэрбум төгрөг

Төслийн нэр	Мөнгөний нэгж	Төсөвт өртөг	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн санхүүжүүлсэн дүн		Ерөнхий гүйцэтгэгчид олгосон дүн	
			мөнгөн дүнгээр	хувиар	мөнгөн дүнгээр	хувиар
Грант торнтон аудит ХХК-ийн баталгаажуулсан "Шинэ төмөр зам" төслийн хүрээнд хийгдсэн Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн ажлын дүн	Сая ам.доллар	276.4				
Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл	Сая ам.доллар	1,005.6	804.7	80.0	801.5	79.8
Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл	Тэрбум төгрөг	1,392.3	1,316.1	94.5	1,316.1	94.5
Тавантолгой нүүрс ачих логикийн төвийн төсөл	Тэрбум төгрөг	313.2	217.0	69.3	200.8	64.1
Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын холболтын төсөл	Тэрбум төгрөг	218.0	218.0	100.0	189.1	86.7
НИЙТ ДҮН	Сая ам.доллар	1,282.0	804.7	80.0	801.5	79.8
	Тэрбум төгрөг	1,923.5	1,751.1	91.0	1,706.0	88.7
	Монгол банкны 2023.06.30-ны өдрийн зарласан ханшаар 1\$=3432.66₮, тэрбум төгрөг	6,324.1	4,513.4		4,457.3	

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, Монголын төмөр зам ТӨХК, Тавантолгой төмөр зам ХХК, Грант торнтон аудит ХХК-ийн 2019 оны 2 дугаар сард ирүүлсэн үнэлгээний тайлан


БҮЛЭГ 1. ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ОЛОН УЛСЫН СТАНДАРТТАЙ УЯЛДУУЛАН ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛЖ, ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлагдаад 13 жил болсон ч бодлогыг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэр, бодлогын хэрэгжилтэд оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлоогүй байна

Бүтээн байгуулалтын ажил, хэрэгжүүлэх дэс дарааллын хувьд:

1.1. УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод шинээр нийт 7900 орчим км төмөр замыг 3 үе шаттайгаар барихаар төлөвлөсөн байна. Үүнд:

Дүрслэл 1. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрээнд баригдах төмөр замын чиглэлүүд



Эх сурвалж: Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг

1.2. Бодлогод бүтээн байгуулалтын ажлын үе шат бүрийн эхлэх хугацааг эдийн засаг, нийгмийн хөгжил, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан Засгийн газар тухай бүр нь шийдвэрлэхээр заажээ.

I шатны бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэснээр:

- Экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээ жилд дунджаар 50 орчим сая тоннд хүргэх;
- Өмнөговь, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод зэрэг аймгийн дэд бүтэц хөгжих хэрээр ажлын байр нэмэгдэж, амжиргаа, амьдрах орчин сайжирснаар төв рүү чиглэсэн хүн амын нүүдэл саарах;
- Гадаад худалдаа, хамтын ажиллагаа өргөжиж, уул уурхайн бүтээгдэхүүнийг гуравдагч зах зээлд экспортлох боломж бүрдэх;
- Зүүн болон Говийн бүсүүд төмөр замаар холбогдсоноор хот, суурин газрууд бий болох.

II шатны бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэснээр:

- Өмнөговь аймагт дэд бүтэц хөгжиж үйлдвэржих хэрээр ажлын байр нэмэгдэж, амжиргаа, амьдрах орчин сайжрах;
- Төмөр замын хилийн боомт шинээр нээгдэх;
- Монгол Улс, БНХАУ-ын төмөр замын салбарын хамтын ажиллагаа эрчимжих;
- Сүхбаатар-Замын Үүд чиглэлийн гол шугамын тээх, нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх боломж бүрдэнэ.

III шатны бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэснээр:

- Баруун чиглэлийн төмөр замын ирээдүйд ашиглах ордууд болон бүс нутгийн хөгжлийн бодлого, хүн амын суурьшилтай уялдуулж төлөвлөх;
- Төмөр замын хөндлөн болон баруун босоо чиглэл нь дамжин өнгөрүүлэх чадавхыг нэмэгдүүлсэн байх;
- Улаанбаатар-Хархорин чиглэлийн төмөр замтай болсон байх гэж хүрэх үр дүнг тодорхойлжээ.

1.3. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлагдсанаас хойш Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт шинээр барих төмөр замуудын чиглэл, нэршил, өртөг, хэрэгжүүлэх хугацааг өөр өөрөөр илэрхийлж ирсэн нь бодлогыг хэрэгжүүлэх хугацаа, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулаагүй, эрэлт хэрэгцээтэй уялдуулан судалгааны үр дүнд

үндэслэн нэгдсэн бодлогын хүрээнд эрэмбэ дараатай төлөвлөх боломжийг алдагдуулсан шийдвэрүүд гаргаж байжээ. Тухайлбал,

Хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигт:

УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан **“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”** (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор хүчингүйд тооцсон)-д

- I үе шат (2016-2020): ... Ухаа худаг–Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглах, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх;
- II үе шат (2021-2025): Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж дуусгах, бүсүүдийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх;
- III үе шат (2026-2030): Тээвэр логиcтикийн шинэ төвүүдийг хөгжүүлж, ... бүсүүдийн төмөр замыг барьж дуусгах.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан **“Алсын хараа-2050”** хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны:

- 8.1.3-т Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон дараах чиглэлийн төмөр замуудыг барьж, байгуулна.
 - Тавантолгой-Зүүнбаян;
 - Зүүнбаян-Ханги мандал;
 - Нарийн сухайт-Шивээ хүрэн;
 - Тавантолгой-Гашуунсухайт;
 - Сайншанд-Баруун-Урт-Хөөт.
- Бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуураар 2025 он гэхэд шинээр баригдсан төмөр замын урт 1174 км байна.

УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан **“Шинэ сэргэлтийн бодлого”**-ын

- Боомтын сэргэлтийн хүрээнд хийгдэх ажлын 1.2-т “хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логиcтикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ”;
- Хүрэх үр дүнг 4600 км төмөр зам барьж, шинээр 4 боомтыг төмөр замаар холбоно гэж тодорхойлсон байна.

Дунд хугацааны бодлогын баримт бичигт:

УИХ-ын 2008 оны 35 дугаар тогтоолоор баталсан **“Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт:**

- 2.2.24-т Стратегийн ач холбогдол бүхий ордуудын цахилгаан хангамж, автозам, төмөр замын асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.4.12-т ... говийн бүсийн төмөр зам, ...зүүн бүсийн төмөр зам, зэрэг томоохон /мега/ төслийн зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ.
- 2.4.14-т Монгол Улсын төмөр замын тээврийн дамжин өнгөрүүлэх чадавхыг сайжруулж, үйлчилгээний чанар, хамрах хүрээг өргөтгөн, техник, технологийг шинэчлэх хүрээнд хөдлөх бүрэлдэхүүний паркийг 20 зүтгүүр, 2000 ачааны вагоноор нэмэгдүүлнэ.
- 2.4.32-т Төмөр замын шинэ салаа зам байгуулах, хилийн гарцын тоог нэмэгдүүлэх, хос шугам барьж, цахилгаанжуулах асуудлыг судалж, үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 5.1.4-т Монгол Улсын гадаад эдийн засгийн харилцааг түлхүү анхаарч, далайд гарцгүй орны эрх ашгийг хамгаалсан бодлогыг тууштай явуулах, түүний дотор ОХУ, БНХАУ-ын нутаг дэвсгэр дээгүүр монголын бараа бүтээгдэхүүн, ачааг дамжин өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх, бүс нутгийн орнуудтай хамтран авто зам, төмөр зам, өндөр хүчдэлийн шугам, холбоо зэрэг дэд бүтцийн төслүүдийг эхлүүлж, хилийн боомтын байршлыг оновчтой тогтоон байнгын ажиллагаатай болгоход анхаарч ажиллана.

УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан **“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөр ...Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого,... хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилт дэвшүүлж:**

- “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан төмөр замыг барьж байгуулах;
- “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан УБТЗ ХНН-ийн шинэчлэлийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, гурав дахь үе шатанд барьж эхлэх төмөр замын суурь бүтэц (нийт 3600 орчим км)-ийн судалгааг дуусгах;

УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан **“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөр эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, логиcтикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх зорилт дэвшүүлж:**

- 2.112-т “Тавантолгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулна;
- 2.113-т “Тавантолгой-Гашуун сухайт” чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, “Шивээ хүрэн-Сэхэ” чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгана;
- 2.114-т “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ.

УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан **“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.6-д Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах зорилт дэвшүүлж:**

- 3.6.1.1-д Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж дуусган, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлнэ гэж заажээ.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий төслийг Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхээр заасны дагуу:

МУЗГ-ын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт:

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 950.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий 267 км төмөр замыг 2018 онд эхлүүлж, 2021 онд дуусгахаар төлөвлөсөн ч санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй;
- Тавантолгой-Сайншанд чиглэлийн 2,789.5 тэрбум төгрөгийн өртөгтэй 447.7 км төмөр замыг 2019 онд эхлүүлж, 2021 он гэхэд 1,673.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байхаар төлөвлөсөн ч санхүүжилтийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй;
- Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 392.4 тэрбум төгрөгийн өртөгтэй 45.3 км төмөр замыг 2019-2020 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барьж дуусгахаар төлөвлөсөн ч эхлээгүй.

УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт:

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 3,008.3 тэрбум төгрөгийн өртөгтэй 414.6 км төмөр замыг 2020 онд 199.3 тэрбум төгрөгийн ажил хийгдсэн, үргэлжлүүлэн 2021-2023 онд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн шууд хөрөнгө оруулалтаар 2,809.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж барьж дуусгахаар;
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 950.7 тэрбум төгрөгийн өртөгтэй 267.0 км төмөр замыг 2021-2022 онд Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн шууд хөрөнгө оруулалтаар 950.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж барьж дуусгахаар тус тус төлөвлөсөн байна.

Царигийн сонголтын хувьд:

1.4. Бодлогын 4.1.2-т “...шинээр барих төмөр зам нь одоо ашиглагдаж байгаа төмөр замтай шууд холбогдох буюу огтлолцох нөхцөлд царигийн өргөн 1520 мм байх ба экспортод шууд тээвэрлэх ачаа тээвэрлэлтийн зориулалттай төмөр замын шугамын царигийн өргөнийг Засгийн газар УИХ-д танилцуулж шийдвэрлүүлнэ” гэж заасан бөгөөд бодлогын 4.2-т 1520 мм царигтай төмөр замын шугамын ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Уул уурхайн бүтээгдэхүүнийг нэг зах зээлээс хараат бусаар олон улсад нийлүүлэх боломж сайжрах;
2. ОХУ болон тухайн орноор дамжуулан гуравдагч зах зээлд нийлүүлэх;
3. Төмөр замын ашиглагдаж байгаа шугамын ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх;
4. Сайншанд аж үйлдвэрийг цогцолборыг хөгжүүлэх дэд бүтцийн үндэс сайжрах гэжээ.

1.5. УИХ-ын 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор “Тавантолгой-Гашуунсухайт, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1435 мм-ийн царигтай, Арцсуурь-Эрдэнэт, Тавантолгой-Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Чойлбалсан, Хөөт-Нөмрөг чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1520 мм-ийн царигтай барих”-ыг Засгийн газарт даалгасан боловч дээрх тогтоолыг УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 57 дугаар тогтоолоор Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн (Хууль, тогтоомжийн тухай хууль 2015 онд батлагдсанаар хүчингүй болсон) 10 дугаар зүйлийн 10.1.2-т “Засгийн газраас санаачлах хуулийн төслийн үзэл баримтлалыг холбогдох төрийн төв байгууллагатай хамтран батлах” гэж заасныг зөрчсөн маргааныг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн дүгнэлтэд үндэслэн хүчингүй болгожээ.

1.6. Төмөр замын царигийн сонголтын хувьд дэлхийн улс орнуудын 60 орчим хувь нь ердийн буюу 1435 мм цариг ашигладаг бол манай улсын хувьд 2013-2019 онд боловсруулж, хүлээн авсан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын ТЭЗҮ-ээр царигийн өргөнийг 1520 мм байхаар төлөвлөсөн байна.

1.7. Манай улсын хувьд БНХАУ-ын нутаг дэвсгэр дээгүүр өөрөө тээвэрлэлт хийх боломжгүй тул өргөн царигтай байх нь тээвэрлэлтийн үр дүнд нөлөөлөхгүй байх талтай

ч хил холболтын цэгийг эцэслэн тогтоогоогүй, холболтын төмөр замын бүтээн байгуулалтад нэмэлт хөрөнгө оруулалт шаардагдаж бүтээн байгуулалтын ажлын өртөг, цаг хугацаанд сөргөөр нөлөөлж байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд:

1.8. Бодлогын 6.2.1-д төмөр замын хөрөнгө оруулалтыг:

- Улс болон орон нутгийн төсөв;
- Дотоод гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж;
- УИХ-аас хуульчлан баталсан бусад;
- Хувийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэхээр заасан бөгөөд төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2019 онд эхлүүлж, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн байна.

Хоёр төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг техникийн нэгдсэн бодлого, иж бүрэн судалгаанд үндэслэн төлөвлөөгүйгээс үргүй зардал гаргасан байна

1.9. Аудитад Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогоор хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хамруулсан бөгөөд эдгээр төслүүд Монгол Улсад хэрэгжсэн мега төсөл болж, төслийг манай улс өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нь давуу тал боловч төслийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, мэргэшсэн хүний нөөц, техник хэрэгсэл дутагдалтай байжээ.

1.10. Олон улсын түвшинд мега төслүүдийн хэрэгжилтэд хийсэн судалгаанаас харахад төмөр замын төслүүдийн хувьд зардал нь дунджаар 44.7 хувиар нэмэгдэж, орлого 51.4 хувиар буурдаг, 77.0 хувь нь анх төлөвлөсөн хугацаагаа 40.0 хувиар сунгадаг (*Bent Flyvbjerg: Megaproject Planning and Management: Essential Readings, Volume 1, 2014*) гэсэн үр дүн бичигдсэн байна.

1.11. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг 2018 онд 2,789.5 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан бол хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээгээр 1,392.3 тэрбум төгрөгөөр буюу дахин бага хөрөнгө шаардагдах тооцоолол хийж хэрэгжүүлсэн ч дамжин өнгөрөх Зүүнбаян өртөөний тээх, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлээгүйгээс төлөвлөсөн хүчин чадлаар тээвэрлэлт хийх боломжгүй, тээвэрлэлт хийх хөдлөх бүрэлдэхүүн хүрэлцээгүй, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг анх 950.7 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан бол 3,653.7 тэрбум орчим төгрөгөөр буюу 3.8 дахин их хөрөнгөөр хэрэгжүүлсэн ч хил холболтын төмөр замын ажил эхлэлийн шатандаа явагдаж байгаагаас одоогоор хил дамжуулан тээвэрлэлт хийх боломжгүй замууд болсон байна.

1.12. Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөхдөө техникийн нэгдсэн бодлого боловсруулаагүй, иж бүрэн цогц судалгаа хийгээгүй, хэрэгжүүлэх дараалал, эдийн засгийн өгөөжөөр эрэмбэлээгүй, хэрэгжилтэд оролцогч байгууллагуудын уялдаа холбоог тодорхойлж, хангаагүй, улс төрийн шинжтэй шийдвэр гаргаж ирсэн нь үргүй зардал гаргах үр дагаварт хүргэсэн байна. Тухайлбал,

Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн “Шинэ төмөр зам” төслийн хүрээнд 2013-2019 онд зарцуулсан хөрөнгө оруулалтын зардлаас:

- Грант торнтон аудит ХХК 2019 онд төслийн нийт зардлын дүнг 276.4 сая ам.доллаароор баталгаажуулсан бөгөөд зардлын дүн нь Монголын төмөр зам ХХК-ийн бүртгэсэн дүнгээс 9.2 сая ам.доллаароор илүү илэрхийлэгдсэн нь төслийг хэрэгжүүлэгч буюу Монголын төмөр зам ТӨХК төслийн нэгжийн зардлыг тусад нь бүртгээгүй, анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй, боловсон хүчин тогтвортой ажиллаагүй, MacKenzie and company, Liberty partners, BNP Paribas (China) Limited зэрэг компаниудын ажлын тайлан болон холбогдох анхан шатны баримт материал АТГ-т шалгагдаж байсны улмаас танилцаагүй, Монголын төмөр зам ТӨХК зарим зардлыг ТУЗ-өөс баталсан төсвийн дүнгээр шууд зардлаар бүртгэж байсан, төгрөгөөр илэрхийлсэн зардлыг ам.долларт шилжүүлэн тооцохдоо Монгол банк болон төлөхөөр заасан өдрийн спот ханш, жилийн дундаж ханшаар хөрвүүлэн тооцсон зэргээс үүссэн байж болзошгүй байна.

- Төслийн нэгжийн 2013-2014 оны үйл ажиллагааны зардал Монголын төмөр зам ТӨХК-ийн бүртгэснээр 11,527.1 сая төгрөг байхад Грант торнтон аудит ХХК 10,556.1 сая төгрөгийн зардлыг баталгаажуулж, 970.9 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд энэ зардлыг хэн хариуцах нь тодорхойгүй байна.

- Төслийн 2013-2014 оны үйл ажиллагааны зардлыг МУХБ-ны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бөгөөд хүүгийн зардалд 74.1 сая төгрөгийг зарцуулсан;

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын 2011-2018 оны ажлын гүйцэтгэлд:

- Бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэн орхисоноос AECOM Asia co.ltd-ийн 2013 онд боловсруулсан ТЭЗҮ-д үндэслэн Dong Myeong engineering consultants and architecture компанийн 2019 онд шинэчлэн боловсруулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын ТЭЗҮ-д тусгагдаагүй суурь бүтцийн ажлын эвдрэл гэмтлийг засварлах 26,998,321 ам.долларын нэмэлт зардал гарсан. Хос алтан пирамид ХХК-ийн Тавантолгой төмөр зам ХХК-ийн захиалгаар 2019 онд АГ-01/163/12 дугаартай 599.4 сая төгрөгийн гэрээгээр гүйцэтгэсэн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын газар шорооны ажил (далан, ухмал), чигжээс, гүүр хоолойн эзлэхүүн, хэмжээг баталгаажуулах, эвдрэл гэмтлийн хэмжээг тодорхойлж, үнэлсэн тайлангаар эвдрэл гэмтлийг засварлах төсвийг 28,527,242.22 ам.доллар гэж тооцсон бөгөөд өртгийн тооцооллыг магадлалаар баталгаажуулаагүй байна.

Төслийг техникийн нэгдсэн бодлогоор боловсруулаагүй, хэрэгжүүлэхэд хугацаа алдсанаас:


- MacKenzie and company-ийн 2011 онд 6.5 сая ам.долларын үнийн дүнгээр боловсруулсан ТЭЗҮ-г төслийг хэрэгжүүлэхэд бүрэн ашиглаагүй бөгөөд үргүй зардал болсон.
- Өрх ХХК-ийн 2014 онд 482.8 сая төгрөгийн зардлаар гүйцэтгэсэн барилга, байгууламжийн зөвлөх үйлчилгээний тайланг ашиглаагүй, үргүй зардал болсон.
- Монцахэр ХХК-ийн 2014 онд 263.8 сая төгрөгийн зардлаар боловсруулсан цахилгаан, эрчим хүчний зураг төслийг ашиглаагүй бүрэн хэмжээнд ашиглаагүй, үргүй зардал болсон.
- Бүтээн байгуулалт хийх газар нутагт байрлаж байсан иргэн, ААН-ийг нүүлгэн шилжүүлэх ажлыг 2 удаа зохион байгуулсан;
- Европын холбооны шийдвэрээр 2035 он гэхэд дотоод шаталтын хөдөлгүүр бүхий автомашин худалдахыг хориглож, 2050 он гэхэд дотоод шаталтын хөдөлгүүрийг зах зээлээс бүрэн гаргана гэж шийдвэрлэсэн байхад ТЭЗҮ-ээр дотоод шаталтын хөдөлгүүр бүхий зүтгүүрүүд ашиглахаар төлөвлөж, худалдан авалт хийсэн.
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 247.0 км төмөр зам барих төслөөр Хилийн хяналтын бүс хүртэл төмөр зам тавьсан боловч хил холболтын төмөр замын зураг төслийг боловсруулах шатандаа байгаагаас хил дамнасан төмөр замын тээвэрлэлт хийх боломжгүй зам болсон;
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.0 км төмөр зам барих ажил хийгдсэн ч цааш нэвтрүүлэх боомтын хүчин чадлыг нэмэгдүүлээгүйгээс суурилагдсан хүчин чадлаар тээвэрлэлт хийх боломжгүй, үйл ажиллагаа нь жигдрээгүй байна.

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг дамжин өнгөрөх өртөөд, хилийн боомтын хүчин чадалтай нийцүүлэн төлөвлөөгүй байна

1.13. Шинээр баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа-2050”-д 2021-2030 оныг эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе гээд, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлэх зорилтуудыг дэвшүүлжээ.

1.14. Зүүнбаян, Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд дууссан хэдий ч 2022 онд зориулалтын бус замаар 3594 тээврийн хэрэгсэл 16,230 удаагийн рейсээр 3,594.0 мянган тонн нүүрсийг Мааньт, Өргөн, Ханги, Чойр чиглэлд, 2023 оны эхний 5 сарын байдлаар 15,097 удаагийн рейсээр 1,303.4 мянган тонн нүүрсийг Ханги чиглэлд тээвэрлэсэн нь хүнд даацын тээврийн хэрэгслүүд их хэмжээний тоос шороо босгох, хөрсний эвдрэл үүсгэх, бэлчээр талхлах нөхцөл болсон байна.

1.15. Монголын төмөр зам ТӨХК-ийн “Шинэ төмөр зам” төслийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хэсгийн 2019 онд тодотгосон ТЭЗҮ-ээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар жилд 15.0 сая тонн ачааг тээхдээ хоногт 5680 тонн ачаатай 80 вагоноос бүрдсэн 8 галт тэрэг явуулахаар, өртөө хоорондын зүтгүүрийн эргэлт Тавантолгой-Зүүнбаян хооронд 24 цаг 34 минут, вагон эргэлт Тавантолгой-Сайншанд өртөөнд 39 цаг 34 минут, Тавантолгой-БНХАУ-ын Эрээн өртөөнд 71 цаг 37 минут байхаар тус тус тооцжээ.



1.16. Дээрх тооцооллын дагуу тодотгосон ТЭЗҮ-ээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн 24 зүтгүүртэй, 1272 вагонтай байхаар байна.

Хүснэгт 6. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хэрэгцээг тодорхойлсон байдал, сая төгрөг

Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Шаардагдах хөрөнгө оруулалт
Зүтгүүр	24	7,944.0	190,656.0
Вагон	1,272	211.8	269,460.0
НИЙТ ДҮН	1,296		460,116.0

Эх сурвалж: Шинэ төмөр зам төслийн ТЭЗҮ-ийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хэсгийн тодотгол

1.17. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ТЭЗҮ-д 460.1 тэрбум төгрөгөөр хөдлөх бүрэлдэхүүн авахаар төлөвлөсөн боловч санхүүжилтийн гэрээнд хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт тусгагдаагүй тул Монголын төмөр зам ТӨХК-ийн өмчлөлд ашиглагдаж байгаа 30,162.8 сая төгрөгийн үнэ бүхий 8 зүтгүүр, 35,727.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий 275 вагоны техникийн бэлэн байдлыг харуулбал, (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 2-оос харна уу) Үүнд:

Зүтгүүрийн хувьд:

- 2009 онд 8,208.3 сая төгрөгөөр худалдан авсан АНУ-ын 1 шинэ зүтгүүрээр 4,120.0 сая төгрөгийн орлого олж, 2019 оноос хүнд гэмтэлтэй шалтгаанаар ашиглах боломжгүй;
- 2011 онд 9,000.0 сая төгрөгөөр худалдан авсан ОХУ-ын их засвар хийгдсэн 2 зүтгүүрээр 2,697.4 сая төгрөгийн орлого олж, 2014 оноос хойш хүнд гэмтэлтэй шалтгаанаар ашиглах боломжгүй;
- 2012 онд 12,954.5 сая төгрөгөөр худалдан авсан БНХАУ-ын 5 шинэ зүтгүүрээр 7,075.4 сая төгрөгийн орлого олж, 1-д нь 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хүнд гэмтэл гарч, 2023 оны 02 дугаар сарын 24-нд БНХАУ-руу засварлуулахаар хүргүүлсэн, нөгөө 1 нь 2023 оны 5 дугаар сараас хүнд гэмтэлтэй шалтгаанаар зогссон, 3 нь Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар тээвэрлэлт хийж байна.

Вагоны хувьд:

- Нүүрс тээвэрлэх зориулалт бүхий 6,185.6 сая төгрөгийн 50 ширхэг тавцант вагон, 28,092.8 сая төгрөгийн 215 ширхэг хагас вагон, 1,449.5 сая төгрөгийн 10 ширхэг битүү вагон өмчилж, ашиглаж байгаагаас элэгдэл 35.7 хувьтай байна.

1.18. Энэ нь өндөр өртөгтэй техникуудийн ашиглалтыг сайжруулах нэгдсэн бодлогогүй, их болон урсгал засварыг төлөвлөгөөт хугацаанд нь хийгээгүйтэй холбоотой байна.

1.19. Тодотгосон ТЭЗҮ-ээр хөдлөх бүрэлдэхүүний тоог 24 зүтгүүртэй байхаар тооцсон байхад 33.3 хувь буюу 8 зүтгүүр эзэмшиж байгаагаас 12.5 хувь буюу 3 нь техникийн бэлэн байдал хангасан, 1272 вагонтай байхаар тооцсон байхад 21.6 хувь буюу 275 вагонтай байгаа нь төслийн хүчин чадлаар ачаа тээхийн тулд зүтгүүр болон вагоны тоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

1.20. Одоо ашиглаж байгаа гол замын 5 зүтгүүрийн техникийн бэлэн байдлыг хангаж, Цогтцэций-Зүүнбаян чиглэлд өдөрт 2.5 хос галт тэрэг явуулна гэж тооцвол жилд 2,789,325.0 тонн ачаа тээж, суурь бүтцийн хүчин чадлын 18.6 хувийг ашиглахаар байна.

1.21. ЗТХС-ын 2023 оны А/37 дугаар тушаалын хавсралтаар суурь бүтэц хооронд ачаа солилцох, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохион байгуулах түр журмыг, тус журмын хавсралтаар суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох зөвлөгөөнийг зохион байгуулах дэгийг баталсан байна.

1.22. Дэгийн дагуу хийсэн 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн зөвлөгөөний 01 дугаартай тэмдэглэлээр "... Монголын төмөр зам ТӨХК-УБТЗ ХНН-ийн суурь бүтцээр 2023 онд Цогтцэций-Зүүнбаян-Замын-Үүд өртөөгөөр 0.04 сая тонн экспортын нүүрс, 0.052 сая тонн зэсийн баяжмал, нийт 0.092 сая тонныг, Тавантолгой төмөр зам ХХК-Монголын төмөр зам ТӨХК-УБТЗ ХНН-ийн суурь бүтцээр Тавантолгой-Цогтцэций-Зүүнбаян өртөөгөөр 0.738 сая тонн Мидлинг" тээвэрлэж, солилцохоор тохиролцсон байна.

1.23. Сайншанд-Зүүнбаян чиглэлийн төмөр замын нэвтрүүлэх дээд чадварыг дараах томъёог ашиглан тооцвол, хоногт 8.45 хос галт тэрэг тээвэрлэлт хийснээр жилд 2.6 сая тонн (330 хоног*8 (хос галт тэрэгний тоо) *1575 тонн (галт тэрэгний цэвэр жин)= 2,598,750.0 тонн) ачаа тээвэрлэхээр байна.

$$N = \frac{(1440 - T_{np} - t_{max})\alpha_n}{T}$$

N - хоногт явах хос галт тэрэгний тоо

T_{np} - хоногт засвар, үйлчилгээ хийх хугацаа

T - ачаа тээвэрлэх хугацаа

α_n - Өртөө, зөрлөг дэх хүлээн авах болон гарах төмөр замын шугамын тоо

$$N = \frac{(24 \text{ цаг} * 60 \text{ минут} - 60 \text{ минут})}{160 \text{ минут}} * 0.98 = 8.45 \text{ хос галт тэрэг}$$

1.24. Энэ нь Зүүнбаян өртөө галт тэрэг хүлээн авах, явуулах 4 замтай, сэлгээний илчит тэрэггүй, 1984 онд баригдсанаас хойш замын их болон дунд хугацааны засвар хийгдээгүй, хоногт ачааны 2 галт тэрэг найруулж, 81 вагон боловсруулах хүчин чадалтай, өртөөний зам сумыг гараар удирддаг, сум дохионы цахилгаан төвлөрүүлтэд холбоогүй, өргөтгөл шинэчлэл хийгээгүйгээс өндөр хүчин чадалтай галт тэрэг явуулах боломжгүйтэй холбоотой байна.

1.25. Иймд Тавантолгой-Зүүнбаян болон Ханги чиглэлийн төмөр замын суурь бүтцийн хүчин чадалд нийцүүлэн Сайншанд-Зүүнбаян чиглэлийн төмөр замын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах, Зүүнбаян өртөөний өргөтгөл, шинэчлэлийг хийх шаардлагатай байгааг харуулж байна.

1.26. Тавантолгой төмөр зам ХХК, БНХАУ-ын Төмөр замын зураг төслийн корпораци ХХК-ийн хооронд Хил холболтын төмөр замын ТЭЗҮ, иж бүрэн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ТТЗ/202302079 дугаартай гэрээг 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдөр байгуулж, 180 хоногт багтаан гүйцэтгэх график төлөвлөгөө баталснаас харахад зураг төсөл боловсруулагдаж, бүтээн байгуулалтын ажил дуусах хүртэл 2-3 жил шаардагдахаар байна.

1.27. Энэ нь УИХ-ын 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 68 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт "...бүтээн байгуулалтын ажлыг зураг төслийн дагуу БНХАУ-ын Ганцмод боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг Эрдэнэс-Тавантолгой ХК-аас санхүүжүүлэх" эрх олгосон ч Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын хил холболтын төмөр замын ТЭЗҮ

бүрэн хийгдээгүй, зүтгүүрүүд нь хугацаандаа нийлүүлэгдээгүй, нүүрс ачих байгууламжийн ажил дуусаагүй байгаатай холбоотой байна.

Зэвсэгт хүчний анги, нэгтгэлийг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах эрх зүйн зохицуулалт дутмаг, зарим зохицуулагдаагүй харилцаанд үйл ажиллагаа явуулснаас хууль зөрчиж, тодорхойгүй байдал үүсгэсэн байна

1.28. Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлж эхлэх үед болон хэрэгжүүлэх хугацаанд хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй нь төслийг төлөвлөх, удирдлага зохион байгуулалтаар хангах, төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийг санхүүжүүлэх, хяналт тавих нэгдсэн тогтолцоо байхгүйтэй холбоотой байна. Тухайлбал,

Төлөвлөх:

- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах зааврыг 2018 онд баталсан;
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг боловсруулах аргачлал, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлалыг 2020 оны 6 дугаар сард баталсан.
- “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх хяналт тавих, үнэлэх журам”-ыг 2021 оны 1 дүгээр сард шинэчлэн баталсан.

Хэрэгжүүлэх:

- **Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасныг үндэслэн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах явцад хуульд өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчныг нөхөж бүрдүүлсэн:**
 - ✓ Хуулийн 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр: 11 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх хэсгийн 11.1.15-д “зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журмыг тогтоох” эрхийг олгосон нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр зарлигаар баталсан “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам” нь цаг хугацааны хувьд хуулиар олгогдоогүй эрхийг хэрэгжүүлсэн харагдаж байна.
 - ✓ Хуулийн 13 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх хэсгийн 13.1.13-т “улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, цэргийн албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална” гэж нэмэлт өөрчлөлт оруулсан нь бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх мэргэшсэн цэргийн албан хаагч бэлтгэх үндсийг тавьсан.
- Их хэмжээний **урьдчилгаа төлбөрийн баталгааг хуульд нийцүүлэн гаргах боломж бүхий** үндэсний аж ахуйн нэгж байхгүйгээс Тавантолгой төмөр зам ХХК, Бодь интернэшнл ХХК-ийн удирдлагууд 2 талын гарын үсгээр баталгаажуулж урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргасан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.8-д “урьдчилгаа төлбөрийн баталгаа” гэж захиалагч урьдчилгаа төлбөр төлөх тохиолдолд уг төлбөрийг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах үүргээ баталгаажуулж, гүйцэтгэгчээс захиалагчид ирүүлсэн банкны баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг хэлнэ гэж заасантай нийцэхгүй байна.

1.29. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах, орлого олох, түүнийг зарцуулах асуудлыг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн:

- 20 дугаар зүйлийн 20.1-д батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Зэвсэгт хүчний тухай хуулийн:

- 6 дугаар зүйл. Зэвсэгт хүчний чиг үүргийн 6.3-т Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр Засгийн газрын шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.
- 13 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн 13.1.5-д зэвсэгт хүчний батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавих, ангилал хооронд зохицуулалт хийх;
- 15 дугаар зүйл. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын бүрэн эрхийн 15.4.9-д төсөв, хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах;
- 18 дугаар зүйл. Зэвсэгт хүчний санхүүжилт хэсгийн 18.1-д зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Зэвсэгт хүчний тухай хуульд 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр:

- 3 дугаар зүйлийн 3.1.17-д “барилга-инженерийн цэрэг” гэж улсын онц чухал объект, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын барилга, инженерийн байгууламжийг барих, сэргээн засварлах, дайн байлдааны болон гамшгийн дараах сэргээн босгох, дотоод, гадаадад хүмүүнлэгийн тусламж, энхийг дэмжих ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцох цэргийн хүчнийг;
- 6 дугаар зүйлийн 6.2.11-д бүтээн байгуулалтын ажилд оролцох;

Зэвсэгт хүчний тухай хуульд 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр:

- 18¹ дугаар зүйлийн 18^{1.1}-д Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүнийг сургах, чадавхыг нэмэгдүүлэх, батлан хамгаалах салбарын алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилго бүхий Зэвсэгт хүчний хөгжлийн сантай байна.
- 18¹ дугаар зүйлийн 18^{1.2}-т Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ. 18^{1.2.6}-д улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад цэргийн анги, салбар, нэгжийг оролцуулснаас олсон ашиг;
- 18^{1.3} дугаар зүйл. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна: 18^{1.3.3}-т зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах, цэргийн анги, байгууллагын болон сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, 18^{1.3.8}-д улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад оролцох анги, салбар, нэгжийн бэлтгэлийг хангах;
- 18^{1.4}-т Энэ хуулийн 18^{1.2.6}-д заасан эх үүсвэрээр улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг Зэвсэгт хүчний хэрэгцээнд худалдан авч болно.
- 18^{1.5}-д Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад цэргийн анги, салбар, нэгжийг оролцуулснаас олсон төлөвлөх боломжгүй орлогыг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогод тооцож, батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулна.
- 18^{1.7}-д Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийг энэ хуульд зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно гэж тус тус заасан байна.

1.30. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Тусгай сангийн орлого, зарлагын тайлан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байх” ба 5 дугаар зүйлийн 5.3.7-д “зэвсэгт хүчний хөгжлийн сан” гэж зааснаар дээрх сан нь Засгийн газрын тусгай сангуудын бүрэлдэхүүнд багтаж байна.

1.31. Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцсон БИЦУГ УТҮГ, зэвсэгт хүчний анги нэгтгэлүүд гэрээний үндсэн дээр ажил, үйлчилгээ үзүүлсэн ашгаас 2021-2022 онд Зэвсэгт хүчний хөгжлийн санд 15.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 7. Зэвсэгт хүчний хөгжлийн санд төвлөрүүлсэн орлого, сая төгрөг

№	Анги, нэгтгэлийн нэр	Зэвсэгт хүчний хөгжлийн санд төвлөрүүлсэн (Зэвсэгт хүчний тухай хуулийн 18 ^{1.2.6})		БХЯ-ны нэмэлт санхүүжилтийн дансанд (Зэвсэгт хүчний тухай хуулийн 18 ^{1.5})		Нийт төвлөрүүлсэн орлогын дүн
		2021 он	2022 он	2021 он	2022 он	
1	БИЦУГ УТҮГ	1,000.0	3,000.0	1,592.8	8,077.1	13,669.9
2	Зэвсэгт хүчний 340 дүгээр анги		900.0			900.0
3	Зэвсэгт хүчний 345 дугаар анги	3.4	150.0			153.4
4	Зэвсэгт хүчний 7780 дугаар анги		999.8			999.8
5	Зэвсэгт хүчний 7781 дүгээр анги		147.1			147.1
	НИЙТ ДҮН	1,003.4	5,197.0	1,592.8	8,077.1	15,870.3

Эх сурвалж: Зэвсэгт хүчний жанжин штаб

1.32. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.9-д “Тусгай сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу төлөвлөж, тайлагнана” гэж заасан боловч төмөр замын бүтээн байгуулалтаас олсон орлогын хувьд дээрх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.33. Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд зааснаар БИЦУГ УТҮГ болон зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдийг улсыг хөгжүүлэх бүтээн

байгуулалтын ажилд оролцуулж ашиг олж, зарцуулж болохоор байгаа ч эдгээр байгууллагууд нь батлагдсан төсвөөр, Төсвийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, ашгийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй, зам, барилгын төсөвт өртөгт жишиг норм, хувиар тооцсон НӨАТ төлөгч биш, нийгмийн даатгалын шимтгэлийг нь улсын төсвөөс хариуцахаар байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль:

- 15 дугаар зүйл. Төрийн өмчит үйлдвэрийн газрын ангиллын 15.1-д төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна. 15.3-т өөрт олгоогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.
- 17 дугаар зүйл. Улсын төсөвт үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх хэсгийн 17.1-д Улсын төсөвт үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, албан газартай нэгэн адил эрхтэй.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль:

- 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолтын 3.1.4-т “нийтийн албан тушаалтан” гэж хуулийн 4.1-д заасан этгээдийг, 3.1.7-д “ашигийн төлөө үйл ажиллагаа” гэж компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг;
- 4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн 4.1-д энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна.
- 7 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийн 7.1-д төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.

Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм (БНБД 81-94-12), Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм (ЗЗБНБД 81-013-2019)-д:

- Барилга угсралт, барилга засварын ажлыг гүйцэтгэгч байгууллагын өртөг нь барилгын талбайн зардал, ашиг, нийгмийн даатгалын шимтгэл, норм нормативын санд төвлөрүүлэх хөрөнгө, НӨАТ-аас бүрдэнэ. (НӨАТ-ыг төсвийн нийт дүнгээс тооцох учир барилга угсралтын ажлын төсвийн материалын нөөцийн үнийг НӨАТ-гүй дүнгээр авна)
- Төсөвт ашиг нь барилгын гүйцэтгэгч байгууллагын үйлдвэрлэлээ өргөжүүлэх, ажиллагсад материаллаг урамшуулал үзүүлэх, холбогдох хууль тогтоомжийн дагуу татварын зардлыг нөхөх зориулалттай. Төсөвт ашиг нь барилга угсралтын ажлын талбайн өртөгт хамаарахгүй.
- Барилгын ажилд ногдуулах НӨАТ-ын хэмжээг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтын дагуу нэгдсэн төсвийн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгээс 10.0 хувиар тооцно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль:

- 5 дугаар зүйл. Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх эх үүсвэрийн 5.1-д цэргийн тэтгэвэр, тэтгэмжийг улсын төсвөөр санхүүжүүлнэ.

1.34. Зэвсэгт хүчний анги, нэгтгэл, БИЦУГ УТУГ-ыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт бүрэн бүрдээгүйгээс анги нэгтгэлүүдийн гүйцэтгэсэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтэц барих далан, ус зайлуулах хоолой, гүүр, өртөө зөрлөгийн барилгын ажлын төсөвт өртөгт төсвийн норм, жишиг үнэлгээгээр тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийн 3,072.5 сая, ашгийн 15,568.6 сая, НӨАТ-ын 14,999.2 сая төгрөгийг тайлагнаж баталгаажуулаагүй байна. (Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн газар шорооны ажлын төсөвт өртгийн нэгтгэлийг хавсралт 3, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн ус зайлуулах хоолойн ажлын төсөвт өртгийн нэгтгэлийг хавсралт 4-өөс харна уу)

Хүснэгт 8. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.0 км төмөр замын ажлаас Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн гүйцэтгэсэн далан, хоолой, гүүр, өртөө зөрлөгийн ажлуудын төсөвт тооцсон НДШ, ашиг, НӨАТ-ын дүн, сая төгрөг

№	Зардлын нэр	Ажлын нэр, төрөл				НИЙТ
		Далан	Хоолой	Гүүр	Барилга, байгууламж	
1	Нийгмийн даатгалын шимтгэл	1,355.1	1,019.6	109.9	587.9	3,072.5
2	Ашиг	6,710.0	5,048.8	382.3	3,427.4	15,568.6
3	НӨАТ	6,971.3	4,329.7	-	3,698.3	14,999.2
	ДҮН	15,036.4	10,398.1	492.2	7,713.6	33,640.3

Эх сурвалж: Зэвсэгт хүчний жанжин штаб

1.35. Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдэд дээрх зардлыг тайлагнах нөхцөл бүрдээгүйгээс дээрх “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажил”-ын барилга, далан, хоолой, өртөө зөрлөгийн барилга, гарам байгуулах 140,919.0 сая төгрөгийн өртөгтэй ажилд ногдох 12,455.7 сая төгрөгийн НӨАТ-ыг Монголын төмөр зам ТӨХК гэрээ байгуулж, суутган авч үлдсэн боловч тайлагнаагүй, татварын орлого болгон төвлөрүүлээгүй тул улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Хүснэгт 9. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ажлын төсөвт өртөгт багтсан Монголын төмөр зам ТӨХК-ийн суутган авч үлдсэн НӨАТ-ын дүн, сая төгрөг

№	Гүйцэтгэсэн ажлын нэр	Гүйцэтгэгчийн нэр	Нийт гүйцэтгэсэн ажлын өртөг	НӨАТ-ын дүн
1	Далан байгуулах	БИЦУГ УТҮГ	77,498.2	6,828.4
2	Ус зайлуулах хоолой хийх	БИЦУГ УТҮГ	48,439.3	4,273.4
3	Тавантолгой өртөөний 40 айлын орон сууцны барилга	Зэвсэгт хүчний 339 дүгээр анги	2,744.7	249.5
4	Тавантолгой өртөөний барилга, уурын зуухны барилга, гадна тохижилт, гадна цахилгаан	Зэвсэгт хүчний 338 дугаар анги	3,807.7	339.4
5	Тавантолгой өртөөний 40 айлын орон сууцны барилга	Зэвсэгт хүчний 110 дугаар анги	2,794.6	249.1
6	Тавантолгой өртөөний 40 айлын орон сууцны барилга	Зэвсэгт хүчний 017 дугаар анги	3,462.3	314.2
7	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн ПК371.940-ПК374.820, ПК401.700-ПК402.900 хүртэлх түр далан байгуулах	БИЦУГ УТҮГ	578.6	57.9
8	Төмөр замын хаалтгүй гарам байгуулах	БИЦУГ УТҮГ	901.3	82.0
9	Төмөр замын зөрлөгийн 6 дугаар барилга	Зэвсэгт хүчний 339 дүгээр анги	692.2	61.8
НИЙТ			140,919.0	12,455.7

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

1.36. Мөн дээрх шалтгаанаар Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдээр 19 нэр төрлийн 55,047.4 сая төгрөгийн ажлыг НӨАТ тооцоогүй дүнгээр гэрээ байгуулан, гүйцэтгүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас харна уу)

1.37. Түүнчлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж орлого олсон боловч татвараа төлж, тайлагнаагүй нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 5 дугаар зүйлийн 5.1², 7 дугаар зүйлийн 7.4.1³-д заасныг тус тус зөрчсөн байна.

1.38. Аудитаар БХС-д Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх албан шаардлага хүргүүлээ

Төмөр замын бүтээн байгуулалтад шаардагдах норм, дүрэм, стандарт дутмаг байхад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулаагүй байна

1.39. ЗТХС-ын “Норм дүрэм батлах тухай” 2020 оны А/129 дүгээр тушаалаар Төмөр замын дээд бүтцийг барьж угсрах техникийн шаардлага, технологийн аргачлал ТЗНБД 01-II-01-2020, Төмөр замын зам, гүүрийн зураг төсөл боловсруулах үнэ тооцох дүрэм ТЗНБД 01-II-02-2020, Төмөр замын, замын дээд бүтцийн ажлын төсөв зохиох суурь норм ба дүрэм ТЗНБД 01-II-03-2020, Төмөр замын замын дээд бүтэц барих ажлын төсөв зохиох дүрэм ТЗНБД 01-II-04-2020-ийг тус тус баталсан байна.

1.40. Гэвч Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 1/1881 дугаартай албан бичгээр ЗТХС-ын тушаалаар техникийн шаардлага, технологийн

² тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл орлого олоогүй боловч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгж нь албан татвар төлөгч байна.

³ албан татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогод албан татвар ногдоно.

аргачлал, суурь норм ба дүрмийг баталсан нь дор дурдсан хуульд заасантай тус тус зөрчилдөж байх тул хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, тусгайлан эрх олгосон захиргааны байгууллагаар баталж, мөрдүүлэхийг мэдэгдсэний дагуу дээрх тушаалыг хүчингүйд тооцсон байна. Үүнд:

Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн:

4.1.1-д “стандартчилал гэж бүтээгдэхүн үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг”;

4.1.2-т “стандарт гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонон хэрэглэх баримт бичгийг”;

4.1.3-т “техникийн зохицуулалт гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, тандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж мөрдөх баримт бичгийг” хэлнэ гэж заасан.

6 дугаар зүйлийн:

6.1-д техникийн зохицуулалтыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, энэ хуулийн 6.4-т заасан дүгнэлтийг үндэслэн Засгийн газар батална”.

9 дүгээр зүйлийн:

9.1-д “үндэсний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална”;

Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн:

10.1.10-т “төмөр замын тээврийн салбарт мөрдөх улсын стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагатай хамтран батлах”;

Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн:

60.1.2-т “тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх”.

1.41. Иймд төмөр замын суурь бүтэц барих, ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах норм, норматив, дүрэм, стандартыг хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бодлогын хэрэгжилтэд хэлбэр төдий хяналт хэрэгжүүлж, бодлогын үр дүнг бодитой үнэлж, тайлагнаагүй байна

1.42. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого нь 7 бүлэг, 19 зүйл, 75 арга хэмжээнээс бүрдэж байгаагаас 39 арга хэмжээ нь бодлогын дэд зорилго, зорилт, баримтлах зарчим, бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг тодорхойлсон хэлбэртэй буюу явцын үнэлгээ өгөх боломжгүй байдлаар тодорхойлогджээ.

Хүснэгт 10. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ, 2017-2021 он, хувь

Бодлогын		Хэрэгжилтийн үнэлгээ, хувиар				
Дугаар	Нэр	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Нийтлэг үндэслэл	76.0	74.3	61.4	91.4	95.7
2	Төмөр замын тээвэр, ашигт малтмалын орд	40.0	58.0	44.0	62.7	67.3
3	Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ	36.7	55.2	48.1	78.2	78.8
4	Төмөр замын шугамын цариг	70.0	52.0	40.0	71.7	71.7
5	Төмөр замын тээврийн салбарын эрх зүйн зохицуулалт	55.0	70.0	70.0	100.0	100.0
6	Бодлогын хэрэгжилт, санхүүжилтийн эх үүсвэр	47.0	70.0	58.3	82.5	82.8
7	Бодлогын хэрэгжилтийн үр дүн	32.0	36.7	43.3	83.3	83.3
Нийт хэрэгжилтийн хувь		47.0	57.9	50.2	78.3	79.7
Үнэлгээ		Хангалтгүй	Эрчимжүүлэх шаардлагатай	Хангалтгүй	Удаашралтай	Удаашралтай

Эх сурвалж: ЗТХС-ын ЗГХЭГ-ын даргад хүргүүлсэн 2017-2021 оны бодлогын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

1.43. ЗТХЯ-аас 2017-2019 оны бодлогын хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, 2020-2021 оныход Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан аргачлалыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийжээ.

1.44. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай 2020 оны хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д зааснаар “хөгжлийн бодлого”-ыг ...салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичиг гэж тодорхойлсон байна.


1.45. Хэдийгээр Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг боловсруулах үед хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлоогүй байсан боловч бодлогыг хэт ерөнхий байдлаар томъёолсон, хэрэгжүүлэх хугацаа, санхүүжүүлэх эх үүсвэр тодорхойгүй, бодлого батлагдсанаас хойших 13 жилийн хугацаанд I, II үе шатны ажлаас 3 төмөр замын ажил хийгдсэн ч бүрэн дуусаагүй, бодлогын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар жил бүр хууль, эрх зүй, суурь түвшин, хүрэх үр дүнтэй нь нийцүүлж бодлогыг шинэчлэн боловсруулж, батлуулахыг зөвлөсөн байхад бодлогыг шинэчлэн боловсруулаагүй байна.

1.46. Бодлогыг хэрэгжүүлэх олон талын оролцоог хангаагүй, бодлогод заасан арга хэмжээг төлөвлөх, удирдлага зохион байгуулалтаар хангах тогтолцоо бүрдээгүй, хэрэгжилтэд тавих хяналт хэлбэр төдий байгаагаас шалтгаалж, бодлогын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал,

- Бодлогын 1.2.1.2-т заасан “ОХУ, БНХАУ-ын төмөр замын тээврийн сүлжээг ашиглан гуравдагч зах зээлд хүрэх худалдаа, тээврийг хөгжөөчилсөн шинэ замнал (маршрут)-ыг бий болгон далайн боомтуудад гарцтай болох” арга хэмжээний хэрэгжилтийг 2009-2014 онд ЗТЯ (хуучин нэрээр) болон Төмөр замын газраас БНХАУ болон ОХУ-тай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан үр дүнгээр 2017-2021 онд жил бүр 100.0 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнаж ирсэн бөгөөд оролцоо нь заавал шаардлагатай бусад төрийн төв байгууллага буюу ГХЯ, Сангийн яамны оролцоог хангаагүй байна.
- Бодлогын 5 дахь бүлэгт заасан төмөр замын тээврийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, төмөр замын салбарт дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн сайжруулах, тээвэрлэлтийн үйл ажиллагааны харилцааг хуульчлах замаар салбарын эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийг 2012 онд батлуулсан “Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах, тусгай зөвшөөрөл олгох журам”, 2014 онд батлуулсан төмөр замын дохиолол, цахилгаан төвлөрүүлэлтийн 6 стандартад үндэслэн хэрэгжилтийг 100.0 хувьтай гэж тайлагнасан боловч эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйг аудитын тайлангаас харах боломжтой..
- Бодлого батлагдсанаас хойш 2020 оныг дуусталх хугацаанд бодлогын 2.3 дахь “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборыг байгуулах ажлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг “0” хувьтай тайлагнасан бөгөөд 2013 онд Засгийн газраас 76 дугаар тогтоолыг баталсан агуулгаар 2021 онд хэрэгжилтийг 30.0 хувьтай гэж тайлагнасан зэргийг дурдаж болохоор байна.

1.47. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод нэгдүгээрт экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээг жилд дунджаар 50 орчим сая тоннд хүргэхээр төлөвлөсөн ч 2022 оны жилийн эцсийн статистик мэдээгээр 38.0 сая тоннд хүрсэн, хоёрдугаарт эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэхийг гол зорилго болгосон ч бодлогын хэрэгжилтээр дээрх 2 зорилтын хүрээнд хэмжигдэхүйц бодитой үр дүн гараагүй байхад 2021 оны жилийн эцэст 79.7 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Дүрслэл 2. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хүрэх үр дүнгийн үзүүлэлт



Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

1.48. Иймд Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын зорилго, зорилтыг оновчтой тодорхойлж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн суурь түвшин, хүрэх үр дүн нь хэмжигдэхүйц, үнэлэгдэхүйц байдлаар, хөрөнгийн үүсвэр, хэрэгжих хугацааг тодорхойлж шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллах шаардлагатай болжээ.

Бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ алдагдсан боломж, үр дүнг тооцоогүй байна

1.49. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ алдагдсан боломж, үр дүнг тооцоогүй байна.

Хүснэгт 11. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар тээсэн ачаа, сая тонн

Тээвэрлэсэн хугацаа	Төмөр замын чиглэл	ТЭЗҮ-ээр төслийн эхний жилд тээх ачаа	Төслийн хоёрдахь жилд тээх ачаа	2022 он	2023 он	Нийт
				Тээсэн ачаа		
2022.03-2023.06	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам	10.00	10.00	0.73	0.64	1.37
2022.07-2023.06	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам	10.56	21.12	0.12	0.24	0.36
Нийт дүн		20.56	31.12	0.86	0.88	1.73

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, Монголын төмөр зам ТӨХК, Тавантолгой төмөр зам ХХК

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хувьд:

1.50. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар тээвэрлэгдэх ачааны хэмжээг ТЭЗҮ-ээр 2021 оноос эхлэн 10.0-15.0 сая тонн, нүүрс тээвэрлэх үндсэн тарифыг тонн/км тутамд 0.035 ам доллар буюу 92.45 төгрөг байхаар, бүтээгдэхүүн, үйлчилгээний ханшийн өсөлтөөс хамааруулан 2 жилд 5 хувиар нэмэгдүүлэн тооцсон байна. Өөрөөр хэлбэл, 2021 онд 10.0 сая тонн ачаа тээвэрлэж 383,689.5 сая, 2022 онд 10.0 сая тонн ачаа тээвэрлэж 383,689.5 сая, 2023 онд 12.0 сая тонн ачаа тээвэрлэж 483,458.4 сая төгрөгийн орлогыг тээврийн үйл ажиллагаанаас олохоор тооцжээ.

Хүснэгт 12. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар 2019-2040 онд тээвэрлэх ачаа, олох орлогын төсөөлөл

№	Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025-2040
1	Ачаа тээвэрлэлтийн хэмжээ, сая тонн	Бүтээн байгуулалтын ажил хийгдэнэ		10.0	10.0	12.0	12.0	15.0
2	Тариф, тонн/км, төгрөг	байгуулалтын ажил хийгдэнэ		92.45	92.45	97.08	97.08	101.9-134.3
3	Тээврийн орлого, тэрбум төгрөг	байгуулалтын ажил хийгдэнэ		383.7	383.7	483.5	483.5	634.5-835.8

Эх сурвалж: Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын 2019 оны тодотгосон ТЭЗҮ

1.51. Харин ТӨБЗГ-ын “Монголын төмөр зам ТӨХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай” 2022 оны 727 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар 4,510.6 мянган тонн ачаа тээвэрлэж, 133,871.8 сая төгрөгийн тээврийн үйл ажиллагааны орлого олохоор баталсан байхад 2023 оны эхний хагас жилийн байдлаар ачаа тээврийн гүйцэтгэл 14.1 хувь, орлогын гүйцэтгэл 19.8 хувьтай байна.

1.52. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар 2022 онд 732.6 мянган тонн ачаа тээвэрлэж 20,602.7 сая, 2023 оны эхний 6 сард 636.4 мянган тонн ачаа тээвэрлэж 26,452.3 сая, нийт 1,369.0 мянган тонн ачаа тээвэрлэж, 47,055.0 сая төгрөгийн орлого олсныг ТЭЗҮ-ээр төлөвлөсөнтэй харьцуулбал, төслийн ажил төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүйгээс 962,053.2 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан байна.

1.53. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн ажилд Эрдэнэс Тавантолгой ХК-аас олгосон санхүүжилт 2023 оны 7 дугаар сарын байдлаар 1,316.1 тэрбум төгрөг буюу санхүүжилтийн гэрээнд заасан хөрөнгө оруулалтын дүнгийн 94.5 хувийг олгосноос төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалт, санхүүжилтэд 1,238.8 тэрбум, Зэвсэгт хүчнийг техникжүүлэхэд 67.0 тэрбум, Зүүнбаян төмөр зам ХХК-ийн үйл ажиллагааны зардалд 10.3 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын хувьд:

1.54. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам нь урд хэсгээрээ БНХАУ-ын Ганц мод боомт дахь БНХАУ-ын төрийн мэдлийн төмөр замын шугам ба уул уурхай, эрчим хүчний томоохон групп болох Шэнхуагийн төмөр замын сүлжээнд холбогдоно. Эдгээр төмөр замын тээвэрлэх хүчин чадал жилд 30 сая тонн бөгөөд цаашид 60 хүртэлх сая тоннд хүргэн нэмэгдүүлэх боломжтой гэж үзжээ.

Хүснэгт 13. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар 2019-2051 онд тээвэрлэх ачаа, олох орлогын төсөөлөл

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026	2027-2029	2030-2031	2032-2036	2037-2041	2037-2041	2042-2046	2047-2051
Ачааны хэмжээ, сая тонн	10.56	21.12	26.40	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68	31.68	50.16	50.16
Тариф, тонн/км, ам.доллар	0.030	0.030	0.030	0.030	0.030	0.031	0.031	0.031	0.032	0.033	0.034	0.035
Тээврийн орлого, сая ам.доллар	75.0	150.2	187.2	216.2	216.2	222.5	224.8	231.3	237.9	237.9	370.6	381.5

Эх сурвалж: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын Dong Myeong engineering consultants and architecture компанийн 2019 онд шинэчлэн боловсруулсан ТЭЗҮ

1.55. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ээр 2022 онд 10,560.0 мянган тонн ачаа тээвэрлэж 74,980.0 сая, 2023 онд 21,120.0 мянган тонн ачаа тээвэрлэж 150,190.0 сая төгрөгийг тээврийн үйл ажиллагаанаас олохоор тооцсон байна.

1.56. Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-ийн “Компанийн 2023 оны батлагдсан төсвийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 08 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2023 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингээр 5,000.0 мянган тонн ачаа тээвэрлэж, 117,915.8 сая төгрөгийн борлуулалтын орлого олохоор баталсан байхад эхний хагас жилийн байдлаар ачаа тээврийн гүйцэтгэл 16.6 хувь, орлогын гүйцэтгэл 7.2 хувьтай гарчээ.

1.57. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар 2022 онд 124.8 мянган тонн ачаа тээвэрлэж 5,240.6 сая, 2023 оны эхний 6 сард 239.2 мянган тонн ачаа тээвэрлэж 6,505.6 сая, нийт 364.0 мянган тонн ачаа тээвэрлэж, 11,746.2 сая төгрөгийн орлого

олсныг ТЭЗҮ-ээр төлөвлөсөнтэй харьцуулбал, төслийн ажил төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүйгээс 213,423.8 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан байна.

1.58. Энэ нь дээрх чиглэлийн төмөр замуудаар тээвэрлэх ачааны хэмжээг ТЭЗҮ-д заасан хэмжээнд хүргэх нөхцөлийг бүрдүүлэн төслийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын үр нөлөөг сайжруулах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг харилцан адилгүй тогтоосон байна

1.59. Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайх, ашиглах тусгай журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4-т “*аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*”, 3.4.2-т “*түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг тогтоох, өөрчлөх*” гэж заасныг үндэслэн Дорноговь аймгийн ИТХТ-ийн 2019 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 51 дүгээр тогтоол болон Өмнөговь аймгийн ИТХТ-ийн 2019 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 126 дугаар тогтоолоор ТТАМ-ын борлуулалтын үнэлгээг дараах байдлаар тогтоожээ. Үүнд:

- ✓ Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд орон нутагтай нэг шоо метр ТТАМ-ын үнийг 125 (нэг зуун хорин таван) төгрөг;
- ✓ Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтад нэг шоо метр ТТАМ-ын үнийг 1 (нэг) төгрөг байхаар тус тус тогтоожээ.

1.60. Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан дээрх журмын 5 дугаар зүйл.Төлбөр тооцох, төлөх хэсгийн 5.2-т “*Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр тооцох борлуулалтын үнэлгээ нь түгээмэл тархацтай ашигт малтмалын төрлөөс хамаарч нэг шоо метр нь 5000 төгрөгөөс хэтрэхгүй байна*” гэж заасан бөгөөд тухайн цаг үед ихэнх аймгууд 1 шоо метр ТТАМ-ыг 5.0 мянган төгрөгөөр борлуулж байжээ.

1.61. Өмнөговь, Дорноговь аймгийн хувьд ТТАМ-д тогтоосон дээрх үнэлгээг эх орны хэмжээний бүтээн байгуулалтад орон нутгаас оруулж буй хувь нэмэр, дэмжлэг гэж үзэж болох ч Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад 1 шоо метр ТТАМ-ын төлбөрийг Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад олгосон үнээр буюу 125 төгрөгөөр тооцож олгосон бол орон нутгийн төсөвт 2.4 тэрбум орчим төгрөгийг төвлөрүүлэх бололцоотой байжээ.

Захиалагч болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч төрийн өмчит компаниудын засаглалын тогтворгүй байдлаас шалтгаалж компаниудын үйл ажиллагаа тогтвортой байж чадаагүй, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй ажиллаагүй байна

1.62. Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ-ийн шийдвэрээр 2008-2023 оны хооронд гүйцэтгэх удирдлагыг 14 удаа томилон ажиллуулж, нэг гүйцэтгэх удирдлагын ажилласан дундаж хугацаа хуанлийн 428 хоног байгаагаас дүгнэхэд компанийн үйл ажиллагаа болон засаглалыг сайжруулах урт хугацааны үр нөлөөтэй бодлого хэрэгжүүлж ажиллах боломжгүй байжээ.

Хүснэгт 14. Монголын төмөр зам ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлуудын ажилласан хугацаа, хуанлийн хоног

№	Захирал, үүрэг гүйцэтгэгчийн нэрс	Томилогдсон огноо	Чөлөөлөгдсөн огноо	Эрх, үүрэг хэрэгжүүлсэн хуанлийн хоног	Тайлбар
1	А.Батболд	2008.04.11	2011.01.20	1,014	Гүйцэтгэх захирал
2	Б.Батзаяа	2011.01.20	2012.05.15	481	Гүйцэтгэх захирал
3	Д.Нямлхагва	2012.05.15	2012.10.18	156	Түр орлон гүйцэтгэгч

4	М.Энхсайхан	2012.10.18	2013.01.14	88	Гүйцэтгэх захирал
5	П.Бат-Эрдэнэ	2013.01.14	2014.03.21	431	Гүйцэтгэх захирал
6	П.Батсайхан	2014.03.21	2015.03.06	350	Гүйцэтгэх захирал
7	Д.Ганбат	2015.03.06	2016.08.01	514	Гүйцэтгэх захирал
8	Ц.Түмэнбаяр	2016.08.01	2016.10.07	67	Түр орлон гүйцэтгэгч
9	Х.Хэрлэн	2016.10.07	2017.12.08	427	Гүйцэтгэх захирал
10	Б.Цэнгэл	2017.12.08	2019.09.26	657	Гүйцэтгэх захирал
11	Р.Батсүх	2019.09.26	2021.08.16	690	Гүйцэтгэх захирал
12	О.Батнасан	2021.08.16	2022.05.23	280	Гүйцэтгэх захирал
13	П.Ганхүү	2022.05.23	2023.07.05	408	Гүйцэтгэх захирал
14	Б.Отгонсүх	2023.07.05			Гүйцэтгэх захирал
Нэг гүйцэтгэх удирдлагын ажилласан дундаж хоног				428	

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал томилж, чөлөөлсөн ТУЗ-ийн шийдвэрүүд

1.63. Иймд Монголын төмөр зам ХХК-ийн үйл ажиллагааг хэвийн, эдийн засгийн хувьд үр ашигтай явуулахын тулд засаглалыг тогтвортой байлгаж, урт дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж ажиллах боломж нөхцөлөөр хангах, тээвэрлэлтийг нэмэгдүүлж, ингэснээр төмөр замын суурь бүтцийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

Бүтээн байгуулалтын зарим ажлыг санхүүжүүлэх зорилгоор авсан дамжуулан зээлийн зээл, хүүгийн төлбөр хугацаандаа бүрэн төлөгдөөгүй байна

1.64. Төмөр замын төслүүдийн зарим бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх зорилгоор дамжуулан зээлийн доорх төслүүдээс хөрөнгө зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 15. Сангийн яамнаас Монголын төмөр зам ТӨХК-тай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний мэдээлэл, мянган ам.доллар

Огноо	2010 15 122 CNR-Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төсөл - Зүтгүүр вагон, калмар			OL-201124175 CSR-Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх төсөл -Машин механизм			OL-2719-MON Бүс нутгийн логиcтикийн төвийг хөгжүүлэх төсөл			Дамжуулан зээлдүүлэх зээлийн нийт дүн
	Зээлийн төлөлт	Зээлийн хүүгийн төлөлт	Хуримтлагдсан хүүгийн төлбөр	Зээлийн төлөлт	Зээлийн хүүгийн төлөлт	Хуримтлагдсан зээл, хүүгийн төлбөр	Зээлийн төлөлт	Зээлийн хүүгийн төлөлт	Хуримтлагдсан хүүгийн төлбөр	
Эхний үлдэгдэл	35,692.2	6,631.4	3,962.5	21,441.3	2,345.1	10,693.5	35,470.0	5,431.3	1,156.2	122,823.6
2019 он	200.0	624.6	990.6							1,815.2
2020 он	199.9	623.7	990.6							1,814.3
2021 он		620.2	990.6		367.4	1,291.6	2,086.5	611.6	356.0	6,323.9
2022 он		616.7			336.1			573.1		1,526.0
Эцсийн үлдэгдэл	35,292.3	4,146.1	990.6	21,441.3	1,641.6	9,401.9	33,383.5	4,246.7	800.3	111,344.3

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

1.65. Дээрх дамжуулан зээлийн төлбөрийг 2021-2037 онд төлж барагдуулах хугацаатай бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 111.3 сая ам.долларын үлдэгдэлтэй, үүнээс 11.2 сая ам.долларын зээл, хүүгийн төлбөр хугацаандаа төлөгдөөгүй байна. Үүнд:

- Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх 201015122 зээлийн дугаартай төслийн Сангийн яам, ЗТХЯ, Монголын төмөр зам ТӨХК-ийн 2019.03.13-ны өдөр байгуулсан дамжуулан зээлдүүлэх гуравласан нэмэлт гэрээгээр зээлийг 2019-2035 оны хооронд төлж барагдуулах бөгөөд үндсэн төлбөр, хүү, хуримтлагдсан хүүгийн үлдэгдэл 40.4 сая;
- Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх 5/3Г-21/24-24/02 зээлийн дугаартай төслийн 2021.02.16-ны өдөр байгуулсан дамжуулан зээлдүүлэх нэмэлт гэрээгээр зээлийг 2021-2032 хооронд төлж барагдуулах ба үндсэн төлбөр, хүү, хуримтлагдсан хүүгийн 32.5 сая;
- Бүс нутгийн логиcтикийн төвийг хөгжүүлэх OL-2719-MON зээлийн дугаартай төслийн 2021.03.19-ний өдөр байгуулсан дамжуулан зээлдүүлэх нэмэлт гэрээгээр зээлийг 2021-2037 оны хооронд төлж барагдуулах ба үндсэн төлбөр, хүү, хуримтлагдсан хүүгийн 38.4 сая ам.долларын үлдэгдэлтэй байна.

Тавантолгой төмөр зам ХХК, Зүүнбаян төмөр зам ХХК-д Эрдэнэс-Тавантолгой ХК өөрийн эзэмшлээс илүү хөрөнгө оруулсан ба хөрөнгийн үнэлгээ хийгдээгүй байна

Зүүнбаян төмөр зам ХХК-д оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалтын бүртгэл:

1.66. Засгийн газрын 2019 оны “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх зорилгоор төмөр замын бүтээн байгуулалтад шаардагдах нэг удаагийн, хүүгүй, 750.0 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргах зөвшөөрлийг Монголын төмөр зам ТӨХК-д олгож, гаргасан үнэт цаасыг хаалттай хүрээнд нэрлэсэн үнээр худалдахаар шийдвэрлэж, 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн ЭТТ-2019/730 дугаартай “Үнэт цаас худалдах, худалдан аван гэрээ” байгуулан, Эрдэнэс-Тавантолгой ХК худалдан авсан байна.

1.67. Засгийн газрын 2020 оны “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай” 117 дугаар тогтоолоор Зүүнбаян төмөр зам ХХК-ийг байгуулах, тус хуулийн этгээдэд төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох, нийт хувьцааны 66.0 хувийг Эрдэнэс-Тавантолгой ХК, 34.0 хувийг Монголын төмөр зам ТӨХК-д тус тус эзэмшүүлэхээр тогтоосон байна.

1.68. Эрдэнэс-Тавантолгой ХК нь Монголын төмөр зам ТӨХК-тай 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ЭТТ-2020/693 дугаартай “Зүүнбаян төмөр зам ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ”-г байгуулжээ.

1.69. Энэхүү гэрээнд Зүүнбаян төмөр зам ХХК-ийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааны зорилго, үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг гаргах, худалдах, худалдан авах харилцааг тодорхойлж, хувьцаа эзэмшлийн хувь хэмжээг гэрээний 4.1.1-т Зүүнбаян төмөр зам ХХК нь хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргах бөгөөд тэдгээрээс эргэлтэд гаргасан нийт хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны 66.0 хувийг Эрдэнэс-Тавантолгой ХК-д, 34.0 хувийг Монголын төмөр зам ТӨХК-д эзэмшүүлэхээр заасан байна.

1.70. Мөн Засгийн газрын 2019 оны 135, 2020 оны 119 дүгээр тогтоолоор өгсөн чиглэлийн дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК нь Монголын төмөр зам ТӨХК-тай 2020 онд 133.0 тэрбум, 2021 онд 270.5 тэрбум, 2022 онд 120.0 тэрбум, нийт 2022 оныг дуусталх хугацаанд 523.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн гэрээ байгуулснаар оруулах хөрөнгийн дүн 1,273.5 тэрбум төгрөг, олгосон санхүүжилт 1,238.8 төгрөг байна. (Засгийн газрын 2019 оны 135, 2020 оны 119 дүгээр тогтоолд үндэслэн байгуулсан санхүүжилтийн мэдээллийг хүснэгт 31-ээс харна уу)

1.71. Монголын төмөр зам ТӨХК нь Эрдэнэс-Тавантолгой ХК-тай 2019 оны 5 дугаар сарын 07-ны өдөр ЭТТ-2019/351/ХАГ-19/5853/09 дугаартай “Төслийн санхүүжилтийн урьдчилгаа төлбөр олгох гэрээ”-г байгуулсан ба урьдчилгаа төлбөрийн хэмжээг 157.0 тэрбум төгрөгөөр тогтоосон байна.

1.72. Мөн Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоолын дагуу 2020 онд Эрдэнэс-Тавантолгой ХК-аас санхүүжүүлсэн 58.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг Монголын төмөр зам ТӨХК хүлээн зөвшөөрсөн байна.

1.73. Зүүнбаян төмөр зам ХХК 100,000.00 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг энгийн хувьцааг эргэлтэд гаргаж, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь

10,000,000.00 төгрөг байсан бөгөөд түүнийг дараах хувь хэмжээгээр хувьцаа эзэмшигчид⁴ нь эзэмшсэн байна. Үүнд:

Хүснэгт 16. Зүүнбаян төмөр зам ТӨХК-д оруулсан хөрөнгийн дүн, сая төгрөг

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	НИЙТ ДҮН	Эзлэх хувь
Эрдэнэс-Тавантолгой ХК	66000	6.6	6.6	66.0
Монголын төмөр зам ТӨХК	34000	3.4	3.4	34.0
ДҮН	100000	10.0	10.0	100.0

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

1.74. Зүүнбаян төмөр зам ХХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар эзний өмчийн эхний үлдэгдэл 348.4 тэрбум төгрөг, эцсийн үлдэгдэл 17.6 сая төгрөгөөр бүртгэгдсэн байна.

1.75. Засгийн газрын 2022 оны “Зүүнбаян төмөр зам ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай” 434 дүгээр тогтоолоор Зүүнбаян төмөр зам ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, Монголын төмөр зам ТӨХК-д нэгтгэн зохион байгуулжээ.

1.76. ТӨБЗГ-ын 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн “Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 112 дугаар тогтоолоор, хөрөнгийн үнэлгээ хийлгэлгүйгээр 168 нэрийн 475.9 тэрбум төгрөгийн балансын үнэ, 258.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг Зүүнбаян төмөр зам ХХК-аас Монголын төмөр зам ТӨХК-д хүлээлгэн өгсөн нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Нийтийн эрх ашгийг хөндсөн дараах хөрөнгийн үнэлгээг үнэлгээний хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ”, 5.2.3-т “төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийг өөрчлөхөд” гэж заасныг зөрчсөн байна.

1.77. Зүүнбаян төмөр зам ХХК-ийг Засгийн газрын шийдвэрээр татан буулгаж, Монголын төмөр зам ТӨХК-д нэгтгэснээр хөрөнгө оруулагч тал буюу Эрдэнэс-Тавантолгой ХК 66.0 хувийн хөрөнгө оруулалтын үр өгөөжөө хүртэх боломжгүй болж, төслийн бүтээн байгуулалтад 2023 оны 6 дугаар сарыг дуусталх хугацаанд зарцуулсан 566.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг хэрхэх талаар талууд нэгдсэн шийдвэрт хүрээгүй байна.

Тавантолгой төмөр зам ХХК-д оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалтын бүртгэл:

1.78. Засгийн газрын 2018 оны “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай” 242 дугаар тогтоолоор Тавантолгой төмөр зам ХХК-ийг байгуулсан байна.

1.79. Мөн Засгийн газрын 2019 оны “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 304 дүгээр тогтоолоор Тавантолгой төмөр зам ХХК-ийн 66.0 хувийг Эрдэнэс-Тавантолгой ХК-д, 34.0 хувийг Монголын төмөр зам ТӨХК-д тус тус эзэмшүүлсэн байна.

1.80. Тавантолгой төмөр зам ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн зүгээс тус төмөр замын төсөлд нийт 2,040.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж, 2022 оны жилийн эцсийн байдлаар Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 659.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хувьцаанд хөрвүүлэхээр хүлээгдэж байна.

⁴ Зүүнбаян төмөр зам ХХК-ийг үүсгэн байгуулах 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Засгийн газрын тогтоол

Хүснэгт 17. Тавантолгой төмөр зам ТӨХК-д оруулсан хөрөнгийн дүн, тэрбум төгрөг

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	Нэмж оруулсан хөрөнгийн дүн	НИЙТ ДҮН	Эзлэх хувь
Эрдэнэс-Тавантолгой ХК	538686654	1,346.7	659.1	2,005.8	74.3
Монголын төмөр зам ТӨХК	277505246	693.8		693.8	25.7
ДҮН	816191900	2,040.5	659.1	2,699.6	100.0

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

1.81. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн нийт хөрөнгө оруулалт 2,005.8 тэрбум төгрөг буюу 74.3 хувь, Монголын төмөр зам ТӨХК-ийн хөрөнгө оруулалт 693.8 тэрбум төгрөг буюу 25.7 хувийг эзэлж байна.

1.82. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс төслийн хөрөнгө оруулалтыг 66:34 харьцаагаар санхүүжүүлж ажиллах нь зүйтэй бөгөөд Эрдэнэс-Тавантолгой ХК нь өөрийн эзэмшиж буй 66.0 хувийн хувьцаанд ногдох хөрөнгө оруулалтаас давсан хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн байна.⁵

1.83. Цаашид холбогдох хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн үнэлгээг хийлгэх, төсөлд оролцож буй хувь эзэмшлийн харьцаагаар хөрөнгийн хариуцлага хүлээх зайлшгүй шаардлагатай байна.

Эрдэнэс-Тавантолгой ХК төрд ногдох ногдол ашгаар төмөр замын төслийг санхүүжүүлсэн нь компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцээгүй өгөөжгүй хөрөнгө оруулалт болжээ

1.84. Засгийн газрын 2019 оны “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолын:

- 1-д “...хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн, хүүгүй, 20 хүртэл жилийн хугацаатай 750.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнээр хаалттай хүрээнд худалдахаар гаргах зөвшөөрлийг Монголын төмөр зам ТӨХК-д олгохыг Сангийн сайдад, үнэт цаас гаргах ажлыг зохион байгуулахыг ЗТХС, Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ-д” тус тус даалгасан.
- 2-т “...гаргасан үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь, нүүрс тээвэрлэлтийн төлбөрөөс суутгах зэрэг эргэн төлөх нөхцөлөөр Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаас худалдан авахыг УУХҮС, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-д” даалгасан;
- 3-т “...үлдэгдэл санхүүжилтийг Монголбанкны дэмжлэгээр бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэхийг Сангийн сайд, ЗТХС, УУХҮС нарт даалгаж, Монгол банкны ерөнхийлөгчид” зөвлөсөн байна.

1.85. Монголын төмөр зам ТӨХК нь үнэт цаас гаргахдаа ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 16⁶-д заасны дагуу хүсэлт гаргаж, Сангийн яамнаас “хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн нөхцөлд татгалзах зүйлгүй” гэсэн хариу ирүүлсэн байна.

1.86. Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолын 1, 2 дахь хэсэг, МУЕС-ын 2019 оны 53 дугаар захирамжаар баталсан удирдамжид заасныг хэрэгжүүлэхдээ Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж, компанийн хувьцааны төрд ногдох ногдол ашиг болох Ирээдүйн өв санд төвлөрүүлэх 880.2 тэрбум төгрөгийг санд төвлөрүүлэлгүйгээр Эрдэнэс-Тавантолгой ХК нь Монголын төмөр зам ТӨХК-ийн гаргасан 750.0 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичгийг худалдан авсан байна.

⁵ Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

⁶ Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана.

1.87. Энэ нь Монгол Улсын Засгийн газар “хууль дээдлэх ⁷” зарчмыг хэрэгжүүлэхгүйгээр, Монгол Улсын Үндсэн хууль болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хуулийн:

- 6 дугаар зүйлийн 6.2-т ...Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ;

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн:

- 7 дугаар зүйлийн 7.1-д Сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 7.1.1-д ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
- 8 дугаар зүйлийн 8.2-т Энэ хуулийн 7.1-д заасан эх үүсвэрийг энэ хуульд зааснаас бусад хэлбэрээр зарцуулахыг хориглоно;
- 9 дүгээр зүйлийн 9.5-д Сангийн эх үүсвэр, хөрөнгөөс 2030 он хүртэл энэ хуулийн 9.1-д зааснаас бусад хэлбэрээр зарцуулахыг хориглоно;
- 12 дугаар зүйлийн 12.1.5-д Сангийн хөрөнгийг зөвхөн олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан гадаад улсын нутаг дэвсгэрт арилжаалагдаж байгаа хөрөнгө оруулах хэрэгсэлд байршуулах;
- 13 дугаар зүйлийн 13.2-т Сан нь Засгийн газрын тусгай сан бөгөөд орлого, эх үүсвэр, хуримтлалын хувьд улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

1.88. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн зорилго нь нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байх тул төрийн аудитын байгууллагаас төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашгийг Ирээдүйн өв санд төвлөрүүлээгүй, албан тушаалтанд хариуцлага тооцуулж, ирээдүйн өв сангийн хөрөнгийг нөхөн төлүүлэхээр дээрх асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн.

1.89. Дээрх шийдвэрүүдийн дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК, Монголын төмөр зам ТӨХК-тай “Үнэт цаас худалдах, худалдан авах” ХХА-19/255224/93 ЭТТ-2019/730 дугаар, “Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой хамтын ажиллагаа”-ны ХАГ-19/256225/12 ЭТТ-2019/731 дугаартай гэрээг 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр байгуулж, доорх хүснэгтэд заасан хуваарийн дагуу 19 жилийн хугацаанд Эрдэнэс-Тавантолгой ХК-д төлөхөөр байна.

Хүснэгт 18. Өрийн бичгийн төлбөрийн эргэн төлөлтийн хуваарь, тэрбум төгрөг

Он	Төлөх хэмжээ	Үлдэгдэл	Он	Төлөх хэмжээ	Үлдэгдэл	Он	Төлөх хэмжээ	Үлдэгдэл	Он	Төлөх хэмжээ	Үлдэгдэл
2022	3.0	747.0	2027	18.0	695.0	2032	63.0	504.0	2037	63.0	189.0
2023	5.0	742.0	2028	19.0	676.0	2033	63.0	441.0	2038	63.0	126.0
2024	5.0	737.0	2029	23.0	653.0	2034	63.0	378.0	2039	63.0	63.0
2025	11.0	726.0	2030	23.0	630.0	2035	63.0	315.0	2040	63.0	-
2026	13.0	713.0	2031	63.0	567.0	2036	63.0	252.0			

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

1.90. Монголын төмөр зам ТӨХК гэрээний дагуу 2022, 2023 онд өрийн бичгийн буцаан төлөлтийг хийгээгүй нь төмөр замын тээврийн үйл ажиллагаа жигдрээгүйгээс 2022 онд 20.6 тэрбум тээврийн орлого олсон, мөн санхүүгийн тайлангаар урт хугацаат өр төлбөр 1,611.1 тэрбум, богино хугацаат өр төлбөр 83.7 тэрбум төгрөг байгаа зэргээс харагдаж байна.

1.91. Эрдэнэс-Тавантолгой ХК хүүгүй, 20 жилийн хугацаатай үнэт цаасыг худалдан авсан, охин компанид эзэмшиж буй хувь хэмжээнээс илүү хөрөнгө оруулалт хийсэн зэрэг нь компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцээгүй, санхүүгийн хувьд өгөөжгүй хөрөнгө оруулалт болсон байх тул төмөр замын төслүүдэд оруулсан хөрөнгө оруулалтаас өгөөж хүртэх боломжийг судалж, хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

⁷ Үндсэн хуулийн 2 дугаар зүйл “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

БҮЛЭГ 2. ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН НЭВТРҮҮЛЭХ ЧАДВАР ХАНГАЛТГҮЙ, ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ДУТАГДАЛТАЙ БАЙДЛААС ШАЛТГААЛАН ТЭЗҮ-Д ЗААСАН ХҮЧИН ЧАДЛААР ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙЖ, БОГИНО БОЛОН УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХАД ЭРСДЭЛТЭЙ БАЙНА

Энэ бүлэгт Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын ТЭЗҮ, зураг төсөл, гүйцэтгэгчийг хэрхэн сонгосон болон ажлын гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын үр дүнг тайлагнасан.

Төслийн талбайд эрх бүхий этгээдээр инженер-геологи, геодезийн нарийвчилсан судалгаа хийлгэсэн байна

2.1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын өртөө, зөрлөгийн барилга, төмөр замын трасс, гүүр барих, түгээмэл тархацтай ашигт малтмал хайх зэрэг 4 чиглэлээр инженер-геологийн судалгааны ажлыг гүйцэтгүүлэхэд нийт 1,327.6 сая төгрөгийн гэрээг ААН-үүдтэй байгуулж, 1,292.9 сая төгрөгийн гүйцэтгэлд санхүүжилт олгож, 34.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь чанарын баталгааны 5 хувийн санхүүжилтийг суутган авч үлдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 19. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын инженер-геологийн судалгаа хийсэн байдал, сая төгрөг

№	Судалгаа хийсэн чиглэл	Гүйцэтгэгч нэр	Ажил гүйцэт-гэсэн огноо	Байгуулсан гэрээний		Гүйцэтгэлээр санхүү-жүүлсэн	Чанарын баталгааны 5 хувь	Тайлбар
				Тоо	Үнийн дүн			
1	Төмөр замын трасс	Эко гидро гео ХХК	2011	1				Төмөр замын 0-290 км дэх ажлын зургийг гүйцэтгэхэд ашигласан
		Таван үндэс ХХК	2019	1	441.4	419.4	22.0	Төмөр замын 290 дэх км-ээс Зүүнбаян өртөө хүртэлх 124 км трассын дагуу судалгаа хийсэн
2	Барилга	Таван үндэс ХХК	2019	3	22.6	21.5	1.1	Зөрлөгийн 1, 4, 5, 6 барилга, Тавантолгой өртөөний барилга,
3	Гүүр	Минторес ХХК	2019	2	454.6	445.2	9.4	Энгийн 5, дунд төвөгшилтэй 7, төвөгшилтэй 12, нийт 24 гүүр
4	Түгээмэл тархацтай ашигт малтмал	Жи Ди Эс Эс ХХК	2019	1	204.5	204.5	-	0-120 дахь км-ийн трассын дагуу 12 карьер бүхий 5.0 сая шоо метр балласт, 22 карьер бүхий 15.6 сая шоо метр далангийн материалын нөөц тогтоосон
		Ган ресурс ХХК	2019	1	204.5	202.3	2.2	121-240 дэх км-ийн трассын дагуу 22 карьер бүхий балласт, 24 карьер бүхий далангийн материалын нөөц тогтоосон
ДҮН				9	1.327.6	1.292.9	34.7	

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

2.2. Харин бүтээн байгуулалтын ажлын явцад дор нэр бүхий 8 компани геодезийн хяналтыг хэрэгжүүлж, сар бүр төмөр замын трассын дагуу гүйцэтгэлийн хөндлөн огтлол, балластын түвшин, төмрийн дээд түвшнийг шалгаж баталгаажуулах, өртөө, зөрлөгүүдийн эрчим хүчний болон бусад барилга байгууламжийн тэг тэнхлэгийг газарт бэхлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэжээ.

Хүснэгт 20. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад геодезийн хяналт хэрэгжүүлсэн компаниудтай байгуулсан гэрээний мэдээлэл, сая төгрөг

№	Хяналт хэрэгжүүлсэн ААН-ийн нэр	Дэд ажлын хэсгийн зөвлөмж		Гэрээний		Үнийн дүн	Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ
		Огноо	Дугаар	Огноо	Дугаар		
1	Геомэп инженеринг ХХК (түншлэл)	2019.10.15	59	2019.05.22 2019.10.17 2020.03.03	АГГ-19/ 8176/23 АГГ-19/ 247216/96 ҮҮГ-20/38-37/08	870.1	Газар шороо, хоолой, хиймэл байгууламж болон гүүрийн ажилд
2	Тэгш хэм групп ХХК-аар ахлуулсан консерциум	2019.06.07	3	2019.06.13	АГГ-19/ 102-96/30	363.8	352 дахь км-ээс Зүүнбаян өртөө хүртэлх 62.7 км-т
3	Монмэп ХХК	2019.06.07	3	2019.06.14	АГГ-19/ 10498/31	363.8	290 дэх км-ээс-352 дахь км хүртэлх 62 км-т
4	Геомастер ХХК			2019.06.14	АГГ-19/ 106100/32	79.5	Тавантолгойн уурхайгаас 290 дэх км хүртэл
5	Топсүрвэй ХХК	2019.07.19	17	2020.03.03 2019.07.24	ҮҮГ-20/39-38/09 АГГ-19/ 148141/51	948.0	Газар шороо, хоолой, хиймэл байгууламж болон гүүрийн ажилд
6	Кадсүрвэй ХХК	2019.07.19	17	2019.07.24 2020.03.03 2021.02.10	АГГ-19/ 147140/50 ҮҮГ-20/ 40-39/10 АГГ-21/ 28-28/05	1,624.0	Газар шороо, хоолой, хиймэл байгууламж болон гүүрийн ажилд
7	Агар-Од инженеринг ХХК	2020.02.21	97	2020.03.03	ҮҮГ-20/ 41-40/11	366.4	Газар шороо, хоолой, хиймэл байгууламж болон гүүрийн ажилд
8	Эй Эс Эм И Эм ХХК	2020.02.21	97	2020.03.03	ҮҮГ-20/ 42-41/12	571.2	Газар шороо, хоолой, хиймэл байгууламж болон гүүрийн ажилд

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

2.3. Геодезийн зөвлөх үйлчилгээний багууд ажлаа 3 үе шаттайгаар төлөвлөн, гүйцэтгэсэн байна. Үүнд:

Бэлтгэл шатанд	Хээрийн судалгааны ажил	Талбарын ажлын явцад
-Захиалагчийн үйл ажиллагааны танилцуулга, төслийн техникийн шаардлага боловсруулах; -Хяналт хийгдэх хэсгүүдийн нутаг дэвсгэрийн уур амьсгалын төлөв байдлыг тодорхойлох	-Төслийн талбайн бүсэд Улсын геодезийн цэг тэмдэгтийн судалгаа хийх; -Агаарын, сансрын зураг ашиглан судалгааны суурь зураг бэлтгэх; -Зөвлөх багийн хэмжилт хийх;	-Трассын тэнхлэгийн байршил, хормойн гадаслагаа хийх; -Үндсэн болон түр репер шалгах; -Газрын гадаргын түвшин шалгах; Хөрс хуулалтын дараах түвшин шалгах -Далангийн үеийн түвшин шалгах; -Хормойн өргөн шалгах; -Барилгын тэг тэнхлэг газарт бэхлэх; -Хиймэл байгууламжийн түвшин байрлал шалгах; -Гүүрний байгууламжийн түвшин байрлал шалгах; -Төмөр замын балластын түвшин шалгах; -Зам төмрийн дээд түвшин шалгах; -Бутлуур дээрх балластын тоо хэмжээ тогтоох; -Цахилгааны унжилт хэмжих; Гүйцэтгэлийн тоо хэмжээ шалгаж баталгаажуулах

2.4. Геодезийн зөвлөх компаниудын зургийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг доорх хүснэгтэд харуулав. Геодезийн зөвлөх компаниуд үе шатны ажил хянуулах нийт 29170 хүсэлт авч, 25116 хүсэлтийг шалгаж баталгаажуулан, ажлын талбай бэлэн болоогүй, техникийн шаардлага зөрчсөн болон бусад шалтгаанаар 4054 хүсэлтэд татгалзаж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 21. Геодезийн ажил гүйцэтгэсэн тоо хэмжээ

Байршил	ПК 0+000-ПК 44+500	ПК 44+500-ПК 94+000	ПК 94+000-ПК 147+680	ПК 147+680-ПК 196+620	ПК 196+620-ПК 274+320	ПК 274+320-ПК 340+200	ПК 340+200-ПК 373+000	ПК 373+000-ПК 416.165	Нийт
Хоорондын зай, км	44.50	49.50	53.68	48.94	77.70	65.88	32.80	43.16	416.16
Туслан гүйцэтгэгчийн тоо	10	5	6	17	14	12	12	9	85
Далан (мян. шоо метр)	2,583.3	1,836.3	2,404.2	2,243.3	3,667.2	2,283.7	1,013.0	1,512.2	17,543.2
Ухмал (мян. шоо метр)	911.5	514.5	1,404.2	510.9	19.8	503.9	195.5	383.6	4,444.0
Хоолойн тоо	71	67	82	79	157	60	27	52	595
Гүүрийн тоо	2	1	1	1	8	7	5	2	27

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг бүтээн байгуулалтын ажилтай зэрэгцүүлэн хийснээс нийт зөвлөмжийн 64.5 хувийг хэрэгжүүлээгүй байна

2.5. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар хийж гүйцэтгэх зорилгоор 4 ААН-ээр байгаль орчны аудит, байгаль орчны хяналт-шинжилгээ, БОННУ хийлгэсэн байна. Үүнд:

Хүснэгт 22. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ажилд байгаль орчны үнэлгээ, аудит хийлгэсэн зардлын гүйцэтгэл, сая төгрөг

№	Гүйцэтгэгчийн нэр	Ажлын нэр	Дэд ажлын хэсгийн зөвлөмж ⁽¹⁾		Гэрээний		Олгосон санхүүжилт
			Огноо	Дугаар	Дугаар	Үнийн дүн	
1	Өндөрхаан трейд ХХК	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх	2019.06.19	5	АГГ-19/116-109/38	130.0	130.0
2	Экологийн бүтээмж ХХК	Байгаль орчны хяналт-шинжилгээ хийх	2020.05.22	127	АГГ-20/154-151/46	35.0	33.3
3	Энвйронментал комплайнц ХХК	Байгаль орчны аудит хийх			ҮҮГ-20/269-266/78	17.6	17.6
4	Байгаль экологи ХХК	Байгаль орчны хяналт шинжилгээ хийх			АГГ-21/159-158/36	18.0	18.0
Нийт дүн						200.6	198.9

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

2.6. Өндөрхаан трейд ХХК Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд БОННУ-г хийж, үнэлгээний тайланг БОАЖЯ баталгаажуулж, Монголын төмөр зам ТӨХК-д 8 бүлэг бүхий 96 зөвлөмжийг хүргүүлснийг 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүлээн авсан байна.

2.7. БОННУ-ний тайлангаар сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 23. Төмөр замын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай чиглэлүүд	Үе шатан дахь сөрөг нөлөөлөл	
		Бүтээн байгуулалт	Ашиглалт
1	Тоосжилт	их	дунд
2	Газрын гадарга, ургамлан нөмрөг	их	нөлөөгүй
3	Амьтны аймаг	дунд	дунд
4	Дуу чимээ /өртөө зөрлөг дээрх/	нөлөөгүй	дунд /70дБа/
5	Малчдын бэлчээр, худаг ус, гарам	бага	бага
6	Газрын гүний ус	бага	дунд
7	Газрын гадаргын ус	бага	нөлөөгүй
8	Археологи	нөлөөгүй	нөлөөгүй
9	Палеонтологи	бага	нөлөөгүй

Эх сурвалж: БОННУ-ний тайлан Өндөрхаан трейд ХХК, 2019 он

2.8. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны 5 дугаар сард БОННУ-тэй зэрэгцүүлэн эхлүүлсэн нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т “Суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргахдаа энэ хуулийн 16.2-т зааснаас гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ”, 16.3.1-д “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэж заасныг зөрчсөн байна.

2.9. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1⁸, 10.2⁹-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монголын төмөр зам ТӨХК 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Экологийн бүтээмж ХХК-тай Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн 2020 оны Байгаль орчны хяналт-шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэх гэрээг байгуулж, газрын гадарга, хөрсний бүтэц болон амьтны аймагтай холбоотой 6 зөвлөмжийг Монголын төмөр зам ТӨХК-д хүргүүлсэн байна. Үүнд:

Газрын гадарга, хөрсний бүтцийн тухайд:

- Ажилчдын сууц, оффисын ойр орчмын хөрс эвдрэхээс сэргийлэх;
- Хөрс салхиар хийсэх, тоосжилт үүсэхээс сэргийлэх, замын усалгаа хийх;
- Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, хогийг зөөвөрлөх;

Амьтны аймгийн тухайд:

- Мониторинг судалгаанд амьтанд зориулсан гарц бүрд хөдөлгөөн болон дулаан мэдрэгч автомат камер ашиглан мэдээлэл цуглуулж судалгаа хийвэл илүү үр дүнтэй байх болно.
- Зэрлэг амьтанд зориулсан гарц, гарам, гүүрүүдэд айл, мал нутаглуулахгүй байх талаар орон нутагтай гэрээ байгуулан тохиролцох (5км-ээс дотогш буулгахгүй байх). Энэ талаар MNS 6515:2015. Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтадад зориулсан гарц. Ерөнхий шаардлага/ стандартад заасан чиглэлийг баримтлах;
- Зарим байршлуудад судалгааны үндсэн дээр нэмэлт нэг түвшний гарц байгуулснаар зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнд учрах саад багасах боломжтой.

2.10. Мөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дугаар зүйлийн 10^{1.10}-т заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК, Энвайроментал комплайнц ХХК-ийн хооронд 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдөр ҮҮГ-20/269-266/78 дугаартай “Байгаль орчны аудит хийх ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, байгаль орчны нийцлийн аудит хийж, дараах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргасан байна. Үүнд:

БОННУ-ний тайлангаар 2019 онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт:

- Нийт 27 (35.5 хувь) зөвлөмжийг хэрэгжүүлсэн, 8 (10.5 хувь) зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 41 (54.0 хувь) зөвлөмж нь нарийвчилсан үнэлгээгээр тодорхой мэдээлэл өгөөгүйн улмаас хэрэгжсэн эсэхийг нь тодорхойлох боломжгүй эсвэл хэрэгжүүлэх боломжгүй зөвлөмжүүд байна гэж дүгнэсэн.
- Зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн хамт Өмнөговь болон Дорноговь аймгийн БОАЖГ-т хүргүүлэх зөвлөмжийг өгчээ.

Орон нутгийн хэмжээнд бохир ус зайлуулах, тээвэрлэх, эрх бүхий иргэн, аж ахуй нэгж байхгүй тул ахуйн бохир усыг хөрсөнд нэвчихгүй байхаар шийдэх талаар аудитаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжээгүй байна.

2.11. Монголын төмөр зам ТӨХК “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний биелэлтийн тайланг, байгаль орчны аудитын дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн хамт жил бүр Өмнөговь болон Дорноговь аймгийн БОАЖГ-т тус тус хүргүүлж ажилласан байна.

2.12. Аудитаар төмөр замын бүтээн байгуулалтын үе шатанд сөрөг нөлөөллийн эрчим дундаас дээш байх дараах 2 чиглэлийг авч үзлээ.

А. Газрын гадарга, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн талаар:

2.13. Төмөр замын трассын дагуух хөрс нь элсэнцэр, зарим газраа нарийн элс, элсэрхэг шавар механик бүрэлдэхүүнтэй байна. Мөн ургамлын төрөл зүйлийн хувьд 25 овгийн 55 төрлийн 67 зүйл ургамал бүртгэгдсэн байна.

2.14. Авто тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйл. “Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүрэг”-ийн 11.1.7-д “авто зам, замын байгууламжийн барилга, их засвар шинэчлэлтийн ажилд ашиглах материал, хийц эдлэлийн нормыг хянан шалгах, дүгнэлт гаргах, баталгаажуулах” гэж заасны дагуу

⁸ Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээнд байгаль орчны төлөв байдал, түүний хувьсал өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, илэрсэн сөрөг өөрчлөлтийг зогсоох, арилгах арга хэмжээ боловсруулах үйл ажиллагаа хамаарна.

⁹ Төрийн захиргааны төв байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажлыг хэрэгжүүлэх зорилгоор байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээний сүлжээг зохион байгуулж ажиллуулна.

¹⁰ Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд ашигласан материалын чанарт ЗТХТ ТӨҮГ, Экотехпроект ХХК, Лабо ХХК, Сойл трейд ХХК зэрэг 4 ААН, байгууллага хяналт хэрэгжүүлсэн байна.

2.15. Монголын төмөр зам ТӨХК-аас дээрх 4 компанитай нийт 5,736.3 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулснаас гүйцэтгэлээр нь 5,450.1 сая төгрөгийг шилжүүлж, гэрээт ажлын чанарын баталгааны 5 хувьтай тэнцэх 286.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.16. Бүтээн байгуулалтад ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын шинжилгээний дүн бүхий хуудсыг хээрийн нөхцөлд лабораторийн инженер болон туслах ажилтнууд гарын үсэг зурсан боловч лабораторийн тамгыг дарж баталгаажуулаагүй байна. Энэ нь MNS 5140-2:2011 “Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага”-ын 4.2-т заасантай нийцэхгүй байна.

2.17. Өмнөговь, Дорноговь аймгийн ИТХТ-ийн тогтоолууд (борлуулалтын үнэлгээ тогтоох тухай), Монголын төмөр зам ХХК болон Дорноговь аймгийн Сайншанд, Улаанбадрах, Мандах, Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций сумдын Засаг дарга нартай байгуулсан “Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээ” зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд зэвсэгт хүчний ангиуд болон ААН-үүд ТТАМ олборлож, төслийн бүтээн байгуулалтад нийлүүлсэн байна.

Хүснэгт 24. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад ашигласан ТТАМ-ын хэмжээ, ордын нөхөн сэргээлт хийсэн судалгаа

Үйл ажиллагаа, тоо хэмжээ	Аймгууд		Нийт
	Өмнөговь	Дорноговь	
Нийт ашигласан орд	89	110	199
Хүлээлгэж өгсөн орд	88	89	177
Ажлын хэсэгт шалгуулсан, актаар баталгаажуулахад бэлэн болсон ордын тоо	-	12	12
Нөхөн сэргээлт дууссан, ажлын хэсэг ажиллахыг хүлээж байгаа ордын тоо	1	7	8
Нөхөн сэргээлт хийж, хүлээлгэж өгөх ордын тоо	-	2	2
Олборлосон материалын хэмжээ, шоо метр	11,000,245.40	8,723,452.04	19,723,697.44

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

2.18. Өмнөговь аймгийн нутгаас 89, Дорноговь аймгийн нутгаас 110 талбай нийт 199 талбайгаас 19.7 сая шоо метр түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласнаас 2 талбайд нөхөн сэргээлт хийгээгүй байна.

Б. Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн талаар:

2.19. Монгол Улс нь Зэрлэг амьтадын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенцод¹¹ нэгдэн орсон бөгөөд гишүүн орны хувьд нутаг дэвсгэртээ цагаан зээр, хулан адуу, хар сүүлт зээр, монгол бөхөн, хавтгай тэмээ, цоохор ирвэс, аргаль хонь зэрэг нүүдэллэдэг зүйл амьтадын нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг чөлөөтэй байлгах, нүүдлийн замыг хааж саад болохуйц аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх үүргийг олон улсын өмнө хүлээсэн байна.

2.20. Зэрлэг амьтадын нүүдэлд учирч болох эрсдэлийг бууруулах үүднээс “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтадад зориулсан гарц” MNS 6515:2015 стандартыг боловсруулж, батлуулсан байна.

¹¹ International Convention of Conservation of the Migratory Species of Wild Animals, CMC

2.21. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трасс нь цагаан зээрийн үндсэн идээшил цөм нутгийг, харин монгол хулан болон хар сүүлт зээрийн идээшил тархац нутгийг дамжин өнгөрдөг байна.¹²

2.22. Манай улсын хэмжээнд одоо байгаа болон 2025 он хүртэлх хугацаанд төлөвлөж буй төмөр замаас зэрлэг амьтадын байршил, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд үзүүлэх сөрөг нөлөөг үнэлсэн ажлын тайланд¹³ дурдсанаар цагаан зээрийн сүрэг 9, хулангийн сүрэг 5, хар сүүлтийн сүрэг 7, монгол бөхөнгийн сүрэг 2 жижиг хэсэгт тус тус таслагдан хуваагдах эрсдэл үүссэн байна.

2.23. Иймд эдгээр туруутан амьтадын амьдрах орчныг хэсэгчлэн хувааж болзошгүй байгаа тул цаашид төмөр зам дагуу байгуулсан нүхэн болон гүүрэн гарцыг зэрлэг амьтад ашиглаж байгаа эсэхийг нарийвчлан судлах, жилийн дөрвөн улиралд мониторинг хийх шаардлагатай байна.

2.24. БОАЖЯ-ны 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 06/2084 дугаартай албан бичгээр Монголын төмөр зам ТӨХК-д дараах зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг хамгаалалтын торгүй барих, хамгаалалтын тор барих зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зөвхөн “Төмөр замын аюултай бүс” буюу төвлөрсөн суурин, өртөө, зөрлөг орчимд тор татах, бусад хэсгийг торгүй байлгах;
- Зэрлэг амьтанд зориулсан гарцыг 10 км тутамд төлөвлөн барих;
- Зэрлэг амьтад ихээр байршиж, нүүдэллэн өнгөрдөг халуун цэгүүдэд нэмэлт гарц байгуулах;
- Зэрлэг амьтанд зориулсан гарц барихдаа “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтадад зориулсан гарц” MNS 6515: 2015 стандартыг хатуу баримтлах.

2.25. БОАЖЯ-ны 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 06/4101 дүгээр албан бичгээр төмөр замын трассын дагуух зэрлэг амьтадын нүүдлийн шилжилт хөдөлгөөний мэдээлэл болон 9 нэмэлт гарц барих саналыг Монголын төмөр зам ТӨХК-д хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.

2.26. Төслийн бүтээн байгуулалтын хүрээнд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуу мал, зэрлэг амьтадыг нэвтрүүлэх 12 давуулах гарц хийсэн ба 2.0 метрээс өндөртэй 27 гүүр, 145 хоолой байршуулсан байна.

2.27. Зүүнбаян төмөр замын трассын дагуу 2022 оны 6 дугаар сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд хийсэн бүртгэл, судалгаагаар 5 удаа бод мал, 1 удаа бог мал дайрагдсан ба 1 хүн, 22 бод мал, 5 бог малыг дайрагдахаас сэргийлсэн байна.

2.28. Цаашид төмөр замын хөдөлгөөний эрчим нэмэгдэх үед дайрагдах малын тоо өсөх эрсдэлтэй учраас төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдал, малыг дайрагдахаас сэргийлэх арга хэмжээг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын ТЭЗҮ-ийг тодотгох ажлыг бүтээн байгуулалтын ажилтай зэрэгцүүлэн хийжээ

2.29. Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 53 дугаар захирамжаар байгуулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгээс боловсруулсан нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор дэд ажлын хэсгүүдийг байгуулж, удирдамжаар өгсөн үүргийг хуваарилсан байна. Үүнд:

- ЗТХС-ын 2019 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн “Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр замын төслийн талаар авах арга хэмжээний тухай” 141 дүгээр тушаалаар төмөр замын бүтээн

¹² Байгаль экологи ХХК Байгаль орчны хяналт шинжилгээний тайлан 2021 он


¹³ B.Lkhagvasuren, B.Chimeddorj and D.Sanjmyatav. 2011. Barriers to migration: Case study in Mongolia. Analysing the Effects of Infrastructure on Migratory Terrestrial Mammals in Mongolia

байгуулалтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах, барилгын ажлыг эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг;

- Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийг тус тус байгуулж, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын чигийг шинэчлэн тогтоох, бүтээн байгуулалт эхлэх эхний хэсгийн ТЭЗҮ, инженерийн тооцоо, өртгийн төсөв, холбогдох бусад зураг төсвийг магадлуулах ажлыг яаралтай зохион байгуулахыг даалгасан байна.

2.30. Монголын төмөр зам ТӨХК-ийн дэд захирлаар ахлуулсан дээрх Ажлын хэсгээс боловсруулсан Шинэ төмөр зам төслийн ТЭЗҮ-ийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хэсэгт хийсэн тодотголыг Зам, тээврийн салбарын ШУТЗ-өөр хэлэлцэж, 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдөр дэмжсэн шийдвэр гаргажээ.

Зураг 1. Тавантолгой-Сайншанд болон Тавантолгой-Зүүнбаян трассын харьцуулалт



Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК-аас ирүүлсэн мэдээлэл

2.31. Монголын төмөр зам ТӨХК-ийн боловсруулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын зураг нь Nirron Koei LLC-ийн боловсруулсан Тавантолгой-Сайншанд чиглэлийн төмөр замын трассын 300 дахь км-ээс чиглэл нь өөрчлөгдөж Зүүнбаян өртөөтэй холбогдож, трассын урт 9.4 км-ээр богиноссон байна.

2.32. Тавантолгой-Зүүнбаян чиглэлд төмөр замын трассыг холбосноор газар шороо, далангийн ажлын тоо хэмжээг 20.3 сая шоо метр, ухмалын ажлын тоо хэмжээг 1.9 сая шоо метрээр багасгаж, зардлын төсвийг 35.0 тэрбум төгрөгөөр хэмнэх тооцооллыг хийсэн байна.

2.33. Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн “Төмөр замын шугамын чигийг тогтоох тухай” 232 дугаар тогтоолоор Зүүнбаян төмөр замын чигийг өөрчилж, холбогдох цэгийг “Сайншанд” гэснийг хасаж, Зүүнбаян өртөөтэй холбосноор бүтээн байгуулалтын ажлын зардлыг хэмнэсэн мэт харагдаж байгаа ч Зүүнбаян өртөөний нэвтрүүлэх хүчин чадал нь тээвэрлэлтийн хэмжээг хязгаарлаж, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Төмөр замын байгууламжийн зураг төсөл, төсвийг боловсруулж, эрх бүхий байгууллагууд магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргасан боловч зарим ажлын төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй байна

2.34. Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т заасан зураг төсөлд тавигдах шаардлагад “эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх”-аар заасан байна.

2.35. Аудитад Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трасс, эрчим хүч, барилга болон дохиолол холбооны зураг төсөл, төсөв болон магадлалын ерөнхий дүгнэлтүүдийг хамруулсан бөгөөд төмөр замын бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө дээрх зураг төсөл, төсөвт иж бүрэн магадлал хийгдээгүй байна.

Төмөр замын трассын зураг, төсөл:

2.36. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын зураг төслийг ЗТХЯ-ны ТНБД-ын 2019 оны 5 дугаар сард баталсан “Дорноговь аймгийн Сайншанд суман дахь Зүүнбаян өртөөнөөс Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний орд хүртэлх төмөр замын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар”-т нийцүүлэн боловсруулсан байна.

Хүснэгт 25. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуух төмөр замын зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан байдал

№	Магадлалын ерөнхий дүгнэлтийн		Зураг төсөл гүйцэтгэгчийн нэр	Объектын нэр	Хүчин чадал (км)	Төсөвт өртөг (сая төгрөг)
	Огноо	Дугаар				
1	2019.05.17	53/2019	Монголын төмөр зам ТӨХК	240 дэх км-ээс 290 дэх км-ийн төмөр замын зураг төсөл	50 км	Төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй
2	2019.08.22	107/2019	Монголын төмөр зам ТӨХК	370 дахь км-ээс 388 дахь км-ийн төмөр замын зураг төсөл	18 км	Төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй
3	2019.10.21	147/2019	Монголын төмөр зам ТӨХК	4 дэх км-ээс 188 дахь км, 345 дахь км-ээс 370 дахь км-ийн төмөр замын зураг төсөл	209 км	Төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй
4	2019.11.28	173/2019	УБТЗ ХНН	290 дэх км-ээс 345 дахь км-ийн төмөр замын зураг төсөл	55 км	Төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй
5	2020.01.03	02/2020	Монголын төмөр зам ТӨХК	4 дэх км-ээс 290 дэх км, 345 дахь км-ээс 416 дахь км-ийн төмөр замын зураг төслийн өөрчлөлт	357.165 км	Төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй
6	2020.06.03	89/2020	Монголын төмөр зам ТӨХК	373 болон 403 км-т байрлах гүүрүүдийг тойрох түр замын зураг төсөл	0.408 км	Төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй
7	2020.06.16	105/2020	Монголын төмөр зам ТӨХК	361 болон 369 км-т байрлах гүүрүүдийг тойрох түр замын зураг төсөл	2.151 км	Төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй
8	2020.06.16	104/2020	Монголын төмөр зам ТӨХК	0-4 дэх км-ийн төмөр зам, Өртөөнд хүлээн авах, явуулах 10 замын (урт 1732-1840м)ажил	4 км	Төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй

Эх сурвалж: ЗТХТ-ийн баталгаажуулсан магадлалын ерөнхий дүгнэлтүүд

2.37. Монголын төмөр зам ТӨХК нь дээрх зураг төслөөс нийт 185.2 сая төгрөгийн ажлыг бусдаар гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 26. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлсэн зураг, төслийн ажлын зардлын гүйцэтгэл, сая төгрөг

№	ААН	Гүйцэтгэсэн ажлын нэр, төрөл	Гэрээний			Гүйцэтгэл
			Дугаар	Огноо	Үнийн дүн	
1	Мөнгөн зөрлөг ХХК	4-44, 124-154, 188-219.5 км-ийн зураг төсөл боловсруулах	АГГ-19/279 249/112	2019.12.05	65.8	65.8

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2	УБТЗ ХНН, зураг төслийн төв	369, 374, 403 дахь км-ийн түр замын зураг төсөл боловсруулах	АГГ-19/187175/73	2019.08.30	27.0	27.0
		290-345 дахь км-ийн 55 км төмөр замын зураг төсөл	АГГ-19/240211/91	2019.10.11	36.6	36.6
3	Максималь ХХК	44-84, 84-124, 219.5-240 дэх км-ийн 100.5 км төмөр замын зураг төсөл	АГГ-19/282251/113	2019.12.05	55.8	55.8
Нийт дүн					185.2	185.2

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК-ийн байгуулсан гэрээнүүд

Эрчим хүчний байгууламжийн зураг, төсөл:

2.38. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын эрчим хүчний барилга, байгууламжийн зураг, төслийг УБТЗ ХНН-ийн Эрчим хүч, ус хангамжийн төвийн 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03/2020, 2020 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 07/2020 дугаартай техникийн нөхцөлийн дагуу боловсруулжээ.

Хүснэгт 27. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын эрчим хүчний барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан байдал, сая төгрөг

№	Магадлалын ерөнхий дүгнэлтийн		Зураг төсөл гүйцэтгэгчийн нэр	Объектын нэр	Хүчин чадал	Төсөвт өртөг (сая төгрөг)
	Огноо	Дугаар				
1	2020.04.14	083/2020	ЭХЭЗХ ТӨААТҮГ	Цахилгаан хангамжийн 35/6кВ-ын Зүүнбаян дэд станцын 35кВ-ын ИХБ, 220/22кВ-ын Цагаансуварга дэд станцын 22кВ-ын ИХБ, 220/110/35 кВ-ын Тавантолгой дэд станцын 35кВ ИХБ-ийн өргөтгөл, 35/10кВ, 35/0.4кВ-ын 1,2,3,4,5,6 дугаар зөрлөгийн дэд станц зураг төсөл	35/0.4кВ-ын Зөрлөг – 1,2,3,4,5,6 дэд станц	13,179.0
2	2020.09.14	382/2020	УБТЗ ХНН	Төмөр замын дагуу байрлах 59 дэх км-ийн 1-ээс 6 дугаар зөрлөгийн парк, перрон, зам сумын гэрэлтүүлгийн ажлын зураг төсөв	Тус бүр нь108 Вт	595.3
3	2020.10.13	455/2020	УБТЗ ХНН	Төмөр замын дагуу байрлах 59 дэх км-ээс 6 дугаар зөрлөгийн автозамын гармын гэрэлтүүлэг, гармын гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төсөв	Тус бүр нь108 Вт	420.1
4	2022.08.11	449/2022	ЭХЭЗХ ТӨААТҮГ	Төмөр зам дагуу байрлах бааз станц-1-ийн цахилгаан хангамжийн 34/0.4 кВ-ын 2х30 кВА чадалтай дэд өртөө, 0.4 кВ-ын КШ-ын ажлын зураг	2х30 кВА	1,442.0
5	2019.12.16	548/2019	Бодит чадал ХХК	Дорноговь аймгийн Зүүнбаян тосгонд байрлах тус төмөр замтай огтлолцож байгаа цэгүүдэд цахилгаан дамжуулах 10кВ, 22кВ-ын агаарын шугамуудыг кабель шугамаар солих ажлын зураг төсөл	10кВ, 22кВ-ын агаарын шугам	182.1
НИЙТ						15,818.5

Эх сурвалж: ЭХХТ-ийн баталгаажуулсан магадлалын ерөнхий дүгнэлтүүд

Хүснэгт 28. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуух эрчим хүчний байгууламжийн зураг төслийг боловсруулсан зардлын гүйцэтгэл, сая төгрөг

№	Гүйцэтгэгч нэр	Гэрээний			Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт
		Дугаар	Огноо	Үнийн дүн	
1	ЭХЭЗХ ТӨААТҮГ	АГГ-21/33-33/06	2021.03.01	4.6	4.6
2	ЭХЭЗХ ТӨААТҮГ	19/167157/61	2019.08.05	224.1	212.9
3	Бодит чадал ХХК	АГГ-19/246-215/95	2019.10.14	13.3	13.3
НИЙТ				242.0	230.8

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК-ийн байгуулсан гэрээнүүд

Өртөө, зөрлөгийн барилга, байгууламжийн зураг, төсөл

2.39. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын Өртөө, зөрлөгийн удирдлагын болон ажилчдын орон сууцны барилгын зураг, төслийг Өмнөговь аймгийн Ерөнхий архитекторын баталсан 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 89, 90, 91, 92 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, Дорноговь аймгийн ГХБХБГ-ын даргын 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн АТД-44/2019 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаварт нийцүүлэн боловсруулсан байна.

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хүснэгт 29. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуу өртөө, зөрлөгийн барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан байдал, сая төгрөг

№	Магадлалын ерөнхий дүгнэлтийн		Зураг төсөл гүйцэтгэгчийн нэр	Объектын нэр	Хүчин чадал (км)	Төсөвт өртөг
	Огноо	Дугаар				
1	2020.10.09	1887/2020	Эрчим төсөл ХХК	Зөрлөг 1-ийн удирдлагын байр болон ажилчдын орон сууцны барилга	Удирдлагын байр 1 давхар, 18.0мх12.0м, ажилчдын орон сууц 30.0мх12.0м, 2 давхар	2,322.1
2	2020.10.09	1888/2020	Эрчим төсөл ХХК	Зөрлөг 2-ын удирдлагын байр болон ажилчдын орон сууцны барилга	Удирдлагын байр 1 давхар, 18.0мх12.0м, ажилчдын орон сууц 30.0мх12.0м, 2 давхар	2,208.5
3	2020.10.09	1889/2020	Эрчим төсөл ХХК	Зөрлөг 3-ын удирдлагын байр болон ажилчдын орон сууцны барилга	Удирдлагын байр 1 давхар, 18.0мх12.0м, ажилчдын орон сууц 30.0мх12.0м, 2 давхар	2,278.0
4	2020.10.02	1864/2020	Эрчим төсөл ХХК	Зөрлөг 4-ийн удирдлагын байр, ажилчдын орон сууц, амралтын барилга	Удирдлагын байр 1 давхар, 18.0мх12.0м, ажилчдын орон сууц 30.0мх12.0м, 2 давхар, амралтын байр 18.0мх14.5м, 1 давхар	2,727.1
5	2020.10.02	1865/2020	Эрчим төсөл ХХК	Зөрлөг 5-ын удирдлагын байр болон ажилчдын орон сууцны барилга	Удирдлагын байр 1 давхар, 18.0мх12.0м, ажилчдын орон сууц 30.0мх12.0м, 2 давхар	2,264.0
6	2019.09.16	1479/2099	Эрчим төсөл ХХК	Зөрлөг 6-ын удирдлагын байр болон ажилчдын орон сууцны барилга	Удирдлагын байр 1 давхар, 18.0мх12.0м, ажилчдын орон сууц 30.0мх12.0м, 2 давхар	1,973.4
7	2021.08.23	1206/2021	Молонгоо ХХК	Зүтгүүрт түлш зэхэх байгууламж	Технологийн хоолой, босоо ган сав, насосны байр, бетон арал, тос хадгалах хэвтээ ил сав, вагон цистерн рүү гарах эстакад, насос станцын барилга, гадна ИШС	2,219.7
8	2020.10.16	1966/2020	Эрчим төсөл ХХК	Депо барилга, засварын төв, уурын зуух, цэвэрлэх байгууламж	Депо барилга 66.0мх61.0м, 2 давхар, засварын төв 54.0х28.0м, 1 давхар, уурын зуух 19.0мх15х0м, 1 давхар	13,620.0
9	2020.10.16	1967/2020	Эрчим төсөл ХХК	Өртөөний барилга, ажилчдын орон сууц А-1, А-2, А-3, уурын зуухны барилга, цэвэрлэх байгууламжийн зураг төсөл	Ажилчдын орон сууц А-1, А-2, А-3 38.0мх13.0м, 1 давхар, өртөөний барилга 32.0мх16.5м, 2 давхар, уурын зуухны барилга 19.0мх15.0м, 1 давхар	13,924.5
10	2021.07.09	987/2021	Эрчим төсөл ХХК	Депо барилга	Депо, засварын цех, уурын зуухны барилга, гадна ИШС	12,948.2
11	2022.03.24	384/2022	Манлайн ундарга ХХК	Депо барилга өөрчлөлтийн зураг төсөл	60.0мх44.0м, давхар	-

Эх сурвалж: ЭХХТ-ийн баталгаажуулсан магадлалын ерөнхий дүгнэлтүүд

Холбоо, дохиолол, шилэн кабелийн зураг, төсөл:

2.40. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын холбоо дохиолол, шилэн кабель, антен суурилуулах ажлын зураг төслийг Монгол төмөр зам ТӨХК-ийн 2019 оны 8 дугаар сарын 01, 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн ажлын даалгаврууд, 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “төмөр замын дохиолол холбооны системийн техникийн ерөнхий шаардлага”, 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн “шилэн кабелийн ажилд тавигдах техникийн шаардлага”, ЗТХЯ-ны ТНБД-ын баталсан 2020 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн ажлын даалгаварт нийцүүлэн боловсруулсан байна.

Хүснэгт 30. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын холбоо дохиолол, шилэн кабелийн зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан байдал, сая төгрөг

Төсөлөөс болж, хэрэгсэлгүй болон байсан, хэрэгсэл						
№	Магадлалын ерөнхий дүгнэлтийн		Зураг төсөл гүйцэтгэгчийн нэр	Ажлын нэр	Хүчин чадал (км)	Төсөвт өртөг
	Огноо	Дугаар				
Аудитын код: ГНАГ-2022/23-ШТА-ГА						Хуудас 49

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

1	2019.12.06	179/2019	Арбэл Алтай ХХК	Шилэн кабель суурьлуулах ажил	Зүүнбаян өртөөнөөс Цогтцэций өртөө хүртэлх 416.4 км төмөр замын дагуу 830 км (нөөц цагариг сүлжээтэй)	1,743.3
2	2022.07.27	261/2022	Топкад ХХК, Бёксан пауэр ХХК	Өртөө, зөрлөгийн дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн зураг төсөл	Цогтцэций өртөө, Хонгор толгой, Ар хонгилдог, Баянбулаг, Хунхар заг, Бор хошуу, Хулангийн шанд зөрлөг, Зүүнбаян өртөө, гарам-3, гарам -7, гарам-10	=
3	2022.08.29	318/2021	Топкад ХХК, Бёксан пауэр ХХК	Өртөө, зөрлөгийн дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн ажлын төсөв болон холбооны төсөв	Цогтцэций өртөө, Хонгор толгой, Ар хонгилдог, Баянбулаг, Хунхар заг, Бор хошуу, Хулангийн шанд зөрлөг, Зүүнбаян өртөө, гарам-3, гарам -7, гарам-10	121,802.9
4	2022.09.23	352/2022	Топкад ХХК, Бёксан пауэр ХХК	Өртөө, зөрлөгийн радио холбооны системийн зураг төсөл	Цогтцэций өртөө, Хонгор толгой, Ар хонгилдог, Баянбулаг, Хунхар заг, Бор хошуу, Хулангийн шанд зөрлөгүүдийг холбоно.	=
5	2022.08.05	Дугааргүй	Кёнжин архитектор номад ХХК	Монголын төмөр зам ТӨХК-ийн цамхагт антен байрлуулах	30м өндөр цамхаг	1,693.9

Эх сурвалж: ЗХХТ, БХТ-ийн баталгаажуулсан магадлалын ерөнхий дүгнэлтүүд

2.41. Дээрх магадлалын ерөнхий дүгнэлтүүдэд “*зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн замын трассын төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашгийн үнэлэлт, дүгнэлт өгсөн ба ТЭЗҮ, зураг төсөлд зайлшгүй нэмж тусгах, хасах, өөрчлөх асуудлын талаар тодорхой тусгасан*” гэж зураг төсөлд үнэлгээ өгсөн байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр Зэвсэгт хүчний жанжин штаб ажилласан байна

2.42. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах арга хэлбэрийг сонгох явцад дараах шийдвэрүүд гарч, төслийг төрийн нууцад хамруулжээ.

Дүрслэл 3. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх явцад гарсан зөвлөмж, шийдвэр, бусад хэлцлүүд



2.43. Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий дэд ажлын хэсгийг ЗГХЭГ-ын даргын болон ЗТХС-ын тушаал, Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулж (*Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт 6-аас харна уу*), дээрх ажлын хэсгийн хурлаас нийт 178 зөвлөмжийг Төслийн захиалагч болон ерөнхий гүйцэтгэгч нарт хүргүүлсэн байна. Үүнд:

- ЗГХЭГ-ын даргын 2019.05.31-ний өдрийн 44 дүгээр тушаалаар байгуулсан дэд ажлын хэсгийн хурлаар 58 зөвлөмж;
- ЗТХС-ын 2019.10.11-ний өдрийн 315 дугаар тушаалаар байгуулсан дэд ажлын хэсгийн хурлаар 120 зөвлөмж гаргасан.
- Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2019.06.03-ны өдрийн А/43 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан бөгөөд гүйцэтгэх захирлын 2019.11.08-ны өдрийн А/82 дугаар шинэчлэн зохион байгуулсан.
- Зөвлөмжийг ангилбал, машин, техник, тоног төхөөрөмж болон бусад бараа материал худалдан авах талаар 68, ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах 110 зөвлөмж тус тус гаргажээ.

2.44. ЗГХЭГ-ын даргын тушаалаар байгуулсан Дэд ажлын хэсгийн 2019 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг угсрах, доод бүтцийг барих ажлын туслан гүйцэтгэгчээр ажиллах санал ирүүлсэн материалуудыг судлан үзэж шаардлага хангасан компаниудыг дотооддоо сонгон шалгаруулж байх талаар 41 дүгээр зөвлөмжийг хүргүүлж, шалгарсан компаниудыг туслан гүйцэтгэгчээр ажиллуулах асуудлыг дэд ажлын хэсгийн хуралдаанаар оруулж, хэлэлцүүлж ажиллахыг ЗХЖШ-т даалгажээ.

2.45. ЗТХС-ын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 315 дугаар тушаалыг үндэслэн Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/82 дугаар тушаалаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг шинэчлэн байгуулжээ.

2.46. Төслийн худалдан авах ажиллагааг дараах дарааллаар зохион байгуулсан байна. Үүнд:



1. Холбогдох төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт гаргуулах;
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд компанийн танилцуулга болон 8 шалгуураар мэдээлэл ирүүлэх хүсэлт явуулах. Үүнд:
 - Компанийн гэрчилгээ;
 - Тусгай зөвшөөрөл;
 - Хүний нөөцийн чадавч;
 - Тоног төхөөрөмжийн мэдээлэл;
 - Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;
 - Ижил төстэй ажил гүйцэтгэсэн талаарх мэдээлэл;
 - Шүүхийн лавлагаа, шийдвэр гүйцэтгэлийн лавлагаа;
 - Татварын тодорхойлолт.
3. Ирүүлсэн мэдээлэлтэй танилцаж дүгнэх;
4. Шалгарсан ААН-үүдийг ажлын даалгавартай танилцуулж, үнийн санал болон гүйцэтгэх хугацааг графикаар гаргуулж авах;
5. Шаардлагатай тохиолдолд уулзалт зохион байгуулж, тодруулга авах;
6. Ирүүлсэн саналын эцсийн үнэлгээ хийж, гүйцэтгэгчийг сонгон дэд ажлын хэсгийн хуралд танилцуулж, зөвлөмж гаргуулах;
7. Зөвлөмжийн дагуу гэрээ байгуулах.

2.47. Дээрх шийдвэрүүдийн дагуу төслийн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгчээр Монголын төмөр зам ТӨХК, ерөнхий гүйцэтгэгчээр ЗХЖШ, УБТЗ ХНН ажиллаж шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа дээр дурдсан дарааллын дагуу санал авч, ажлын даалгавраа боловсруулан үнийн санал авах урилгын хамт хүргүүлж, санал ирүүлсэн ААН-ийн мэдээлэл, үнийн саналыг Дэд ажлын хэсэгт танилцуулж, тухайн ажлын хэсгээс гэрээ байгуулахыг зөвлөмж болгосон этгээдтэй гэрээ байгуулан ажилласан байна. Үүнд:

- Монголын төмөр зам ТӨХК Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх 2019.06.12-ны өдрийн АГГ-Н/1901 дугаартай гэрээг ЗХЖШ-тай байгуулж, тус газар нь 85 туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласан.
- МУЕС-ын 2019 оны 53 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийг 2019.10.10-ны өдрийн 12 дугаар ээлжит хуралдаан, ЗТХС-ын 2020.01.23-ны өдрийн 83 дугаар зөвлөмжийг үндэслэн Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтэц, дохиолол холбоо, эрчим хүч, гүүр хоолойн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх 2020.02.05-ны өдөр АГГ-20/21-20/06 дугаартай гэрээг УБТЗ ХНН-тэй байгуулсан байна.

2.48. Дэд ажлын хэсгүүдээс туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлснээс өөрөөр бусад нэгдсэн удирдлага зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлсэн байдал нь баримтаар нотлогдохгүй байна.

2.49. Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөл төрийн нууцад хамаарч, Ажлын хэсгийн зөвлөмжид үндэслэн бүтээн байгуулалтад оролцсон ихэнх аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулж, ТБОНӨХБАҮХАТХ, холбогдох журмыг мөрдөгдөөгүйгээс худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулсан эсэхийг нотлох боломжгүй байна.

Төслийн бүтээн байгуулалтад оролцсон зарим туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, давуу байдал олгосон байж болзошгүй байна

2.50. Төслийн бүтээн байгуулалтад оролцсон зарим туслан гүйцэтгэгчид төмөр замын доод бүтэц барих тусгай зөвшөөрлийг ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас хойш авсан нь Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн (2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс хүчингүй болсон) 5 дугаар зүйлийн 5.4-т “Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрхлэх эрх энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг авсан өдрөөс үүснэ” гэж заасныг зөрчсөн, Дэд ажлын хэсгээс тусгай зөвшөөрөлгүй зарим ААН-тэй гэрээ байгуулахыг зөвлөсөн нь давуу байдал олгосон байж болзошгүй байна. Тухайлбал,

Дэд ажлын хэсгээс тусгай зөвшөөрөлгүй ААН-тэй гэрээ байгуулахыг зөвлөж, гэрээ байгуулснаас хойш тусгай зөвшөөрөл олгосон:

- Бридж бюлдинг ХХК нь 2020.04.03-ны өдөр төмөр бетон гүүрүүдийн барилга угсралтын ажлын ПК239+300 дахь 76.1 м урттай гүүр, ДК246+775 дахь 76.1 м урттай гүүр, ПК249+320 дэх 76.1 м урттай гүүр, нийт 3 багцын 228.3 у/м төмөр бетон гүүр барих ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ЗТХС-ын 2021.10.27-ны өдрийн А/173 дугаар тушаалаар;
- Гангүүр ХХК нь 2019.08.22-ны өдөр Зүүнбаян талаас 15 км-т 57.32 у/м гүүр барих ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ЗТХС-ын 2022.01.21-ний А/18 дугаар тушаалаар;
- Велдедлайн монголиа ХХК нь 2019.12.06-ны өдөр төмөр замын шугамын доод бүтцийн бүрэлдэхүүн хэсэг далан, хоолой зэрэг хиймэл байгууламжийг барих ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ЗТХС-ын 2020.07.01-ний өдрийн А/114 дүгээр тушаалаар;
- Говийн төмөр зам ХХК нь 2019.09.13-ны өдөр Зүүнбаян талаас 15 км-т 57.32 у/м гүүр барих ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ЗТХС-ын 2020.02.06-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар;
- Арц суварга ХХК нь 2019.09.12-ны өдөр төмөр замын суурь бүтцийн зураг төслийн 369.0 км-т 132.38 у/м гүүр барих ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ЗТХС-ын 2020.03.26-ны өдрийн А/68 дугаар тушаалаар;
- Тэргүүн саруул зам ХХК нь 2020.04.03-ны өдөр 264.76 у/м 3 ширхэг төмөр бетон гүүр барих ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ЗТХС-ын 2021.09.21-ний өдрийн А/151 дүгээр тушаалаар;
- Үндэсний хөгжлийн бүтээмж ХХК 2020.03.31-ний өдөр далан, хоолой зэрэг хиймэл байгууламжийг барих ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан боловч ЗТХС-ын 2020.04.15-ны өдрийн А/80 дугаар тушаалаар;
- Цүүрдэн ХХК нь 2020.05.30-ны өдөр далан, хоолой зэрэг хиймэл байгууламжийг барих ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан боловч ЗТХС-ын 2020.09.21-ний өдрийн А/180 дугаар тушаалаар;
- Шагайн жим ХХК нь 2019.12.06-ны өдөр өдөр далан, хоолой зэрэг хиймэл байгууламжийг барих ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан боловч ЗТХС-ын 2020.04.15-ны өдрийн А/80 дугаар тушаалаар тус тус тусгай зөвшөөрөл олгосон байна.
- ЗМЗ ХХК-тай гэрээ байгуулж, төмөр замын доод бүтцийн ажил гүйцэтгүүлэхийг 2020.03.14-ний өдөр зөвлөсөн боловч ЗТХС-ын 2021.03.15-ны өдрийн А/35 дугаар тушаалаар;
- Рапид констракшн ХХК-тай гэрээ байгуулж, төмөр замын доод бүтцийн ажил гүйцэтгүүлэхийг 2020.03.14-ний өдөр зөвлөсөн боловч ЗТХС-ын 2021.04.20-ны өдрийн А/55 дугаар тушаалаар;
- Говийн төмөр зам ХХК-тай гэрээ байгуулж, төмөр замын доод бүтцийн ажил гүйцэтгүүлэхийг 2019.08.22-ны өдөр зөвлөсөн боловч ЗТХС-ын 2020.02.06-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар;
- Тэргүүн саруул зам ХХК-тай гэрээ байгуулж, төмөр замын доод бүтцийн ажил гүйцэтгүүлэхийг 2020.03.16-ны өдөр зөвлөсөн боловч ЗТХС-ын 2021.09.21-ний өдрийн А/151 дүгээр тушаалаар;
- Зэвсэгт хүчний 340, 7780 дугаар ангитай гэрээ байгуулж, төмөр замын доод бүтцийн ажил гүйцэтгүүлэхийг 2019.11.01-ний өдөр зөвлөсөн боловч ЗТХС-ын 2019.11.29-ний өдрийн А/358 дугаар тушаалаар;
- Зэвсэгт хүчний 345, 339 дүгээр ангитай гэрээ байгуулж, төмөр замын доод бүтцийн ажил гүйцэтгүүлэхийг 2019.12.09-ний өдөр зөвлөсөн боловч ЗТХС-ын 2020.01.06-ны өдрийн А/03 дугаар тушаалаар тус тус тусгай зөвшөөрөл олгожээ.

Дэд ажлын хэсгээс гэрээ байгуулахыг зөвлөөгүй компанитай гэрээ байгуулж, тусгай зөвшөөрөл олгосон:

- Монгол технологи интернэйшнл ХХК-тай 2019.07.01-ний өдөр ХХАГ-20/174-171/36 дугаартай худалдах, худалдан авах гэрээг байгуулж, 2019.07.31-ний өдөр ЗТХС-ын СБҮ 1/091-2020 дугаартай “төмөр замын суурь бүтэц үйлдвэрлэх, замын дээд бүтэц үйлдвэрлэх (төмөр бетон дэр) тусгай зөвшөөрөл олгосон.

2.51. Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцох санал ирүүлсэн хуулийн этгээдийн бүрдүүлсэн баримт материалаас харахад ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16 дугаар зүйлд заасан ерөнхий нөхцөл, санхүү, техникийн чадавх, ажлыг туршлагыг үнэлэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс тусгай зөвшөөрөлгүй 33, татвар хураамж төлбөрөө төлөөгүй 46, техникийн чадавх, ажлын туршлагаа тодорхойлж чадаагүй 13, ажил гүйцэтгэх болон мэргэжлийн инженер техникийн ажилтангүй 13 ААН-ийг сонгон шалгаруулсан байна. Тухайлбал,

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй, 14.1.2-т заасан татвар хураамж, төлбөрөө төлөөгүй” гэж заасныг зөрчиж:

- Татварын 16.6 сая төгрөгийн өртэй Гагнуур ХХК-ийг 57.32 у/м гүүр барих ажлын гүйцэтгэгчээр;
- Татварын 77.6 сая төгрөгийн өртэй Арц суварга ХХК-ийг 132.38 у/м гүүр барих ажлын гүйцэтгэгчээр;
- Татварын 545.5 сая төгрөгийн өртэй Говь инфрастраткчер партнерс ХХК-ийг 246 у/м 2 ширхэг төмөр бетон гүүр барих ажлын гүйцэтгэгчээр;
- 141.5 сая төгрөгийн өртэй Тэргүүн саруул зам ХХК-ийг 246 у/м 2 ширхэг төмөр бетон гүүр барих ажлын гүйцэтгэгчээр;
- 1,026.4 сая төгрөгийн өртэй Аж роуд ХХК-ийг далан, хоолойн хиймэл байгууламж барих ажлын гүйцэтгэгчээр;
- 2,446.7 сая төгрөгийн өртэй Асартайн говь ХХК-ийг үерийн ус өнгөрүүлэх хоолойн барилгын болон хиймэл байгууламж барих ажлын гүйцэтгэгчээр;

- 279.5 сая төгрөгийн өртэй Велдедлайне Монголиа ХХК-ийг далан, хоолойн хиймэл байгууламж барих ажлын гүйцэтгэгчээр;
- 73.2 сая төгрөгийн өртэй Гашууны гол групп ХХК-ийг далан, хоолойн хиймэл байгууламж барих ажлын гүйцэтгэгчээр;
- 173.5 сая төгрөгийн өртэй Грейт рөүд констракшн ХХК-ийг үерийн ус өнгөрүүлэх хоолойн барилгын болон хиймэл байгууламж барих ажлын гүйцэтгэгчээр;
- 65.1 сая төгрөгийн өртэй Их харгуйн зам ХХК-ийг далан, хоолойн хиймэл байгууламж барих ажлын гүйцэтгэгчээр;
- 96.3 сая төгрөгийн өртэй Намобридж ХХК-ийг далан, хоолойн хиймэл байгууламж барих ажлын гүйцэтгэгчээр;
- 209.9 сая төгрөгийн өртэй Түм арвижих ХХК-ийг далан, хоолойн хиймэл байгууламж барих ажлын гүйцэтгэгчээр;
- 1,787.5 сая төгрөгийн өртэй Хишиг арвин индустриал ХХК-ийг далан, хоолойн хиймэл байгууламж барих ажлын гүйцэтгэгчээр;
- 10.2 сая төгрөгийн өртэй Шаргын зам ХХК-ийг далан, хоолойн хиймэл байгууламж барих ажлын гүйцэтгэгчээр тус тус шалгаруулсан байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 16 дугаар зүйлд заасныг зөрчиж, ажил гүйцэтгэх техник, тоног төхөөрөмж, ажлын туршлагаа мэдээлээгүй:

- Үндэсний хөгжлийн бүтээмж ХХК-ийг 6,810.6 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Ширхэнцэг хараа ХХК-ийг 2,463.3 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Амьус ХХК-ийг 2,914.0 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Асартайн говь ХХК-ийг 2,740.5 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Цүүрдэн ХХК-ийг 2,105.6 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр тус тус шалгаруулжээ.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 16 дугаар зүйлд заасныг зөрчиж, ажил гүйцэтгэх боловсон хүчингүй, мэргэжлийн инженер, техникийн ажилтангүй:

- Ширхэнцэг хараа ХХК-ийг 2,463.3 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- ОДНД ХХК-ийг 2,343.8 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Үндэсний хөгжлийн бүтээмж ХХК-ийг 748.9 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Мадимос групп ХХК-ийг 8,694.7 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Могойн гол Эм Жи ХХК-ийг 4,117.1 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Арц суварга ХХК-ийг 24,535.3 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Өвөр залаат ХХК-ийг 5,388.2 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Сидар голд ХХК-ийг 12,332.1 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Тэнгэр уул констракшн ХХК-ийг 4,323.6 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Шаргын зам ХХК-ийг 2,342.4 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Грейт рөүд констракшн ХХК-ийг 5,974.2 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр;
- Зэвсэгт хүчний 017 дугаар ангийг 3,726.4 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэгчээр тус тус шалгаруулсан байна.

2.52. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.11¹⁴, Төмөр замын тээврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7¹⁵-д тусгай зөвшөөрөл эзэмшигчээр гүйцэтгүүлэхээр заасан төмөр замын дээд бүтцийн буталмал чулуу (балласт)-г үйлдвэрлэх ажилд Дэд ажлын хэсгийн 32, 71, 89, 117, 129, 146 дугаар зөвлөмжүүдээр тусгай зөвшөөрөлгүй Зэвсэгт хүчний анги нэгтгэл болон аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулсан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4¹⁶ зөрчсөн байна. Тухайлбал,

Тусгай зөвшөөрөл авахаасаа өмнө 402376 шоо метр балласт нийлүүлэхээр 17,180.1 сая төгрөгийн гэрээ байгуулсан:

- Санчир инженеринг ХХК нь ЗТХС-ын 2021.04.20-ны өдрийн А/55 дугаар тушаалаар Төмөр замын суурь бүтэц үйлдвэрлэх, Замын дээд бүтэц үйлдвэрлэх /замын чигжээс/ тусгай зөвшөөрлийн гэрчилгээг авч, улмаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ гарахаас өмнө буюу 2019.11.22-ны өдөр 170000 шоо метрийг бэлтгэн нийлүүлэх 7,768.9 сая төгрөгийн үнэтэй гэрээг Монголын төмөр зам ТӨХК-тай байгуулсан;
- Зэвсэгт хүчний 345 дугаар анги нь ЗТХС-ын 2020.05.07-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар Төмөр замын суурь бүтэц үйлдвэрлэх, Замын дээд бүтэц үйлдвэрлэх /замын чигжээс/ тусгай

¹⁴ төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах

¹⁵ Төрийн захиргааны төв байгууллага нь суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг нягтлан шалгаад дүгнэлт, суурь бүтэц ашиглах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан үзэж тусгай зөвшөөрөл олгох, эсхүл олгохоос татгалзсан тухай шийдвэрийн аль нэгийг нь гаргана.

¹⁶ Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрхлэх эрх энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг авсан өдрөөс үүснэ.

зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай авч, улмаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ гарахаас өмнө буюу 2020.02.21, 2020.04.15-ны өдрүүдэд 232376 шоо метрийг бэлтгэн нийлүүлэх 9,411.2 сая төгрөгийн үнэ бүхий гэрээг Монголын төмөр зам ТӨХК-тай байгуулсан.

Тусгай зөвшөөрөлгүй Зэвсэгт хүчний анги, аж ахуйн нэгжүүдтэй 400708 шоо метр балласт нийлүүлэхээр 16,497.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан:

- Зэвсэгт хүчний 339 дүгээр ангиар ажил гүйцэтгүүлэхийг Дэд ажлын хэсгийн хурлаас зөвлөөгүй байхад 24000 шоо метрийг бэлтгэн нийлүүлэх 972.0 сая төгрөгийн үнэ бүхий гэрээг Монголын төмөр зам ТӨХК-тай байгуулсан;
- Зэвсэгт хүчний 7780 /342/ дугаар анги 154000 шоо метрийг 6,237.0 сая төгрөгөөр нийлүүлэх гэрээг Монголын төмөр зам ТӨХК-тай байгуулсан;
- Интернэшнл рөүд 126000 шоо метрийг 5,292.0 сая төгрөгөөр нийлүүлэх гэрээг Монголын төмөр зам ТӨХК-тай байгуулсан;
- Боржигон хос зам ХХК 60000 шоо метрийг 2,400.0 сая төгрөгөөр нийлүүлэх гэрээг Монголын төмөр зам ТӨХК-тай байгуулсан;
- Майнплауэр ХХК 36708 шоо метрийг 1,596.8 сая төгрөгөөр нийлүүлэх гэрээг Монголын төмөр зам ТӨХК-тай байгуулсан ч гэрээний дагуу ажлыг гүйцэтгээгүй.

2.53. Аудитаар худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжийг зөрчиж гэрээ байгуулах эрх олгосон, гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлсэн зэргээр бусдад давуу байдал олгосон байж болзошгүй шийдвэр гаргасан үйл явцыг шалгуулахаар холбогдох байгууллагад шилжүүлээ.

Бүтээн байгуулалтын ажил дуусаж, туршилт тохируулгын ажил хийгдэж байна

2.54. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын тодотгосон ТЭЗҮ-гээр нийт хөрөнгө оруулалтын дүн 2,853.3 тэрбум төгрөг, үүнээс хөдлөх бүрэлдэхүүн худалдан авахад 460.1 тэрбум, төмөр замын бүтээн байгуулалтад 2,393.2 тэрбум төгрөг зарцуулахаар тооцсон, УУХҮС, ЗТХС-ын 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хамтран баталгаажуулсан “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хуваарь”-аар нийт шаардлагатай хөрөнгө оруулалтын дүнг 1,392.3 тэрбум төгрөгөөр хүлээн зөвшөөрч, 2023 оны 7 дугаар сарын байдлаар Монголын төмөр зам ТӨХК, Зүүнбаян төмөр зам ХХК-ууд Эрдэнэс-Тавантолгой ХК-тай нийт 1,325.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийн гэрээ байгуулжээ.

Хүснэгт 31. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээний мэдээлэл, тэрбум төгрөг

Байгуулсан огноо	Гэрээний дугаар	Гэрээний нэр	Гэрээний үнэ
2019.10.24	ХХАГ-19/255-224/93	Үнэт цаас худалдах, худалдан гэрээ	750.0
2020.10.19	ҮҮГ-20/250-247/14	Эхний нэмэлт санхүүжилтийн гэрээ	58.0
2020.12.28	ҮҮГ-20/274-271/80	Төслийн санхүүжилтийн гэрээ	75.0
2021.05.19	ҮҮГ-21/70-70/19	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ	59.3
2021.05.24	ҮҮГ-21/71-71/20	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ	39.5
2021.07.07	ҮҮГ-21/98-98/28	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ	10.0
2021.07.08	ҮҮГ-21/100-100/29	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ	10.0
2021.08.31	ҮҮГ-108-108/32	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ	49.8
2021.11.17	СГ-21/153-152/06	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ	100.4
2021.12.27	СГ-21/176-174/07	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ	1.5
2022.04.13	ХАГ-22/105-105/06	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ	20.0
2022.09.08	22/237-237/49	Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ	100.0
2023.04.14	СГ-2023/01, ЭТТ/189	Санхүүжилтийн урьдчилгаа төлбөр олгох гэрээ	5.0
2023.07.24	НГ-2023/04, ЭТТ-2023/189-01	Санхүүжилтийн урьдчилгаа төлбөр олгох гэрээний нэмэлт өөрчлөлт	27.4
НИЙТ ДҮН			1,325.9

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

2.55. Санхүүжилтийн гэрээгээр 2023 оны 6 дугаар сарыг дуусталх хугацаанд нийт 1,316.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, аудитаар бүтээн байгуулалтын

ажлын бодит гүйцэтгэл 1,238.8 тэрбум төгрөг байна. (Дэлгэрэнгүй гүйцэтгэлийг хавсралт 7-оос харна уу)

2.56. Үлдэх санхүүжилтээс Зэвсэгт хүчнийг техникжүүлэхэд 67.0 тэрбум, Зүүнбаян төмөр зам ХХК-ийн үйл ажиллагааны зардалд 10.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, 107.9 тэрбум төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцоо нийлж, баталгаажуулсан байна.

2.57. Аудитын баг төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай газар дээр нь танилцаж, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх дансдын хуулга, гүйцэтгэлийн баримт материал, өр, авлага бүрээр тулган баталгаажуулахад ажлын гүйцэтгэлд ЗТХЯ-ны ХШҮДАГ, Мэргэжлийн хяналтын болон хөндлөнгийн мэргэжлийн байгууллагууд чанарын хяналт хэрэгжүүлж, ажилласан ч зарим гүйцэтгэлийг илүү, дутуу тайлагнасан, зэргээр дараах зөрчлүүд илэрч байна. Тухайлбал,

Инженерийн хийцтэй худгуудад усны тоолуур суурилуулаагүйгээс хэрэглээнд хяналт тавих боломжгүй, дагалдах хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, хэрэглээний ус агууламжийн хувьд ундны усанд шууд хэрэглэхэд тохиромжгүй байхад цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулаагүй нь ажиллагсдад эрүүл мэндэд эрсдэл үүсгэхээр байна. Үүнд:

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын усны хэрэглээг газрын доорх усаар буюу гүний худгаас хангахаар тооцож, ажлын хэмжээ, түүнд шаардагдах усны нөөц, худгийн ундарга, хүчин чадалд тохируулан төмөр замын трассын дагуу 10 км тутамд нэг худаг, мөн өртөө, зөрлөг дээр худаг гаргаж ашиглахаар төлөвлөж, нийт 44 ширхэг инженерийн хийцтэй худаг гаргажээ. Эдгээр худгийн цооногуудад тоолуур суурилуулаагүй нь Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4¹⁷-д заасныг зөрчиж, усны хэрэглээнд хяналт тавих боломжгүй байна.
- Мөн дээрх худгуудын усны чанарыг авч үзвэл хлорын ангийн, натрийн бүлгийн, чанарын хувьд давсархаг, зөөлөн ус гэж тодорхойлсон бөгөөд агууламжийн хувьд ерөнхий эрдэсжилт, хлор, натрийн ион нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018”-д заасан хэмжээнээс их байгаа тул хүний унданд тохиромжгүй, цэнгээжүүлж хэрэглэх шаардлагатай боловч төмөр замын өртөө, зөрлөгүүдэд байнгын 5, ээлжийн 314, нийт 319 хүн ундны усаар хэрэглэж байх тул зориулалтын тоног төхөөрөмж суурилуулж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай байна.
- Монголын төмөр зам ТӨХК нь инженерийн хийцтэй 44 худгийн гаднах тохижилтод зориулсан сандвичэн барилга (3х3 хэмжээтэй), усны нөөцийн сав (50 тонн), цахилгаан үүсгүүр (30 кВт-ын генератор) тус бүр 36 ширхгийг борлуулах зорилготой эргэлтийн хөрөнгөөр буюу ангилал зөрүүтэй бүртгэн, тухайлбал, Гантулга трейд ХХК-д усны нөөцийн сав 6 ширхгийг 68.3 сая төгрөгөөр худалдсан нь, нийт 0.9 тэрбум төгрөгийн хөрөнгө үргүйдэх эрсдэлтэй байна.

Зарим барилга угсралтын ажлыг материал сольж гүйцэтгэсэн:

- Зэвсэгт хүчний 017, 110, 338, 339 дүгээр ангиуд нэгтгэлүүд өртөө зөрлөг, уурын зуухны барилгын угсралтын ажлыг гүйцэтгэхдээ өнгөлгөөний тоосгоор өнгөлөхөөр ажлын зураг, төсөвт тусгаж магадлалаар баталгаажсан байхад энгийн тоосгоор орлуулан гүйцэтгэсэн материалын үнийн зөрүүгээр 142.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр илэрсэн зөрчлийг арилгасан эсэх нь баримтаар нотлогдоогүй:

- Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбогдох хууль, тогтоомж, олон улсын стандарт, чанарын шаардлагад нийцүүлэн барьж байгуулах” гэж заасны дагуу ЗТХС-ын 2020.05.21-ний өдрийн А/100 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулж, төмөр замын дээд бүтцийн буталмал чулуу буюу балласт үйлдвэрлэж буй ААН-үүдийн бүтээгдэхүүний дээжид шинжилгээ хийхэд стандартаас жижиг хэмжээтэй эсвэл хэтэрхий том ширхэглэлүүдтэй байгаа нь буцах конвьер болон ангилан ялгах технологийн шийдлийг нэвтрүүлээгүй, бохирдол ихтэй, цахилгаан дамжуулах үзүүлэлт өндөр байх магадлалтай гэсэн дүгнэлт гарсан байна.
- Ажлын хэсгээс балластад тавигдах стандарт шаардлагад нийцүүлэн сайжруулах албан шаардлагыг хүргүүлсэн боловч хэрэгжилт нь баримтаар нотлогдохгүй байна.

Төмөр замын дохиолол, холбооны ажлын гүйцэтгэл:

2.58. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын тодотгосон ТЭЗҮ-ээр дохиолол, холбооны ажлыг 80.0 тэрбум төгрөг байхаар төлөвлөж, Монголын төмөр зам ТӨХК-аас холбоо, дохиоллын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр УБТЗ ХНН-ийг сонгон 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр ОГ/20/042 АГГ-20/21-20/06 дугаартай гэрээг байгуулсан байна.

¹⁷ ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах

Уг гэрээний 4.4-т гүйцэтгэгч нь гуравдагч этгээдээр ажлыг бүхэлд нь гүйцэтгүүлж болох, ийм тохиолдолд гуравдагч этгээдтэй санхүүжилтийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийг олгохоор заажээ.

2.59. УБТЗ ХНН-ээс ажлын хэсэг байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим урилгыг 9 орны 21 компанид хүргүүлснээс хүснэгтэд дурдсан 5 компаниас үнийн санал ирүүлсэн байна.

Хүснэгт 32. Компаниудаас ирүүлсэн үнийн санал, сая төгрөг

№	Компанийн нэр	Харьяалах улс	Үнийн санал
1	CRSC Research and Design institute group	БНХАУ	208,623.3
2	Siemens mobility	ОХУ	134,304.1
3	Consen an CUEC	БНХАУ	131,441.8
4	Korean National Railway	БНСУ	121,587.1
5	Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо	БНХАУ	83,779.6

2.60. ЗТХС-ын 2019 оны 315 дугаар тушаалаар байгуулсан Дэд ажлын хэсгийн 2020 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 153 дугаар зөвлөмжөөр Korea National Railway компаниар “Дохиолол холбооны системийн зураг төсөл, программ хангамж боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилуулалт гүйцэтгэх багц ажил”-ыг 121,587.1 сая төгрөгөөр холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгүүлэхийг Монголын төмөр зам ТӨХК, УБТЗ ХНН-ийн удирдлагуудад зөвлөсөн байна.

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

2.61. Зөвлөмжийн дагуу 2021 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Монголын төмөр зам ТӨХК болон БНСУ-ын яамны бус статустай улсын салбарын байгууллага болох Солонгосын үндэсний төмөр замтай СГ-21/110-109/05 дугаартай “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дохиоллын холбооны системийн зураг төсөл, програм хангамж боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилуулалтын цогц ажлын гэрээ”-г байгуулжээ.

2.62. Гэрээний 2.5 дахь хэсэгт захиалагч гэрээний үнээс нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн импорт, гааль, НӨАТ-ын төлбөр, захиалагчийн хяналтын болон удирдлагын зардалд 16,316.9 сая төгрөгийг суутган авч үлдэхээр заасны дагуу 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр УБТЗ ХНН болон Солонгосын үндэсний төмөр зам компаниар захиалагчийн хяналтын ТХН-АУГ/2021/004 дугаартай гэрээг байгуулсан байна.

2.63. Дохиолол холбооны ажлын гүйцэтгэл 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 96.2 хувийн гүйцэтгэлтэй, 76,070.8 сая төгрөгийн буюу гэрээний үнийн 62.6 хувийг олгосон ба ажлын гүйцэтгэлд дараах зөрчлүүд илэрч байна. Тухайлбал,

Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбооны техникийн өрөөнд тавигдах шаардлага MNS 6869:2020 стандартын 8.1.1-т “техникийн ердийн болон том өрөө нь 24 цагийн ажиллагаатай ердийн болон зохиомол агаар сэлгэлтийн системээр тоноглогдсон байна”, 8.1.3-т “Агаар сэлгэлтийн системийн хүчин чадал нь өрөөний төрөлд тохирсон байх шаардлагатай. Агаар сэлгэлтийн системийн хүчин чадалын тооцоог нь өрөөний агаарыг дор хаяж нэг цагийн турш бүрэн хэмжээгээр сэлгэж байхаар хийнэ”, 7.5-т “Бүх төрлийн техникийн өрөө нь цонхгүй байна. Хэрвээ цонхтой өрөөнд техник, тоног төхөөрөмжийг суурилуулах зайлшгүй шаардлагатай бол тоос шороо, ус нэвтрүүлэхгүйгээр цонхыг холбогдох стандартын дагуу битүүмжилсэн, цонхны гадна талаас нарны тусгалаас хамгаалсан, нарны гэрлээс хаах хөшигтэй байна” гэснийг зөрчсөний улмаас:

- 2 өртөө, 6 зөрлөгт суурилуулсан 32.4 тэрбум төгрөгийн өртөгтэй серверийн компьютер, сүлжээний болон бусад тоног төхөөрөмжүүд хэт халах, эд ангиуд эвдрэх, цонх онгойлгож агаар сэлгэлт хийснээс тоос шороонд дарагдан ашиглалтын хугацаа богиносх, нөөц цахилгаан тэжээлийн үүсгүүрийн өрөөнүүдэд суурилагдсан батарейнууд нь агаар сэлгэлтийн системгүйгээс хэт халалтын улмаас ашиглалтын баталгаат хугацаанд хүрэхгүй болж чанар аюулгүй байдлын горим алдагдсан байна.



Жишг оорын төхөөрөмжөөр цо онгойлгож агаар сэлгэлт хийж байгаа нь Сэсн ашиглаж агаар сэлгэлт хийж байгаа нь

- 6 зөрлөгийн техникийн өрөө хаягжилтгүй, зөвшөөрөлтэй ажилтнуудыг таньж баталгаажуулах хамгаалалтын төхөөрөмж суурилуулаагүй, тэмдэг тэмдэглэгээний стандартыг хангахгүй;
- Зөрлөг 6 буюу Хулангийн шад зөрлөгийн холбоо дохиоллын өрөө нь зориулалтын өргөгдсөн шалгүй цементэн шалан дээр тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулсан.

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3¹⁸, 14.6¹⁹-д заасан зүгшрүүлэх, тохируулах, баталгаат хугацааны шаардлагад нийцэхгүй:

- Dell брэндийн сервер компьютер тоног төхөөрөмжүүдийн үйлдвэрлэгчийн баталгаат хугацаа нь гүйцэтгэгчийн гэрээнд заасан улсын комисст хүлээлгэн өгснөөс хойш тооцогдох баталгаат хугацааг хангахгүй, сервер ашиглагдаж байгаа газарзүйн байршил нь БНСУ-ыг зааж байгаа нь үйлдвэрлэгчийн зүгээс тавигддаг эцсийн хэрэглэгчийн шаардлагыг хангахгүй байгаа нь цаашид тус тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг үзүүлэхэд хүндрэлтэй байдал үүсгэхээр байна.

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.2-т заасан Онц чухал дэд бүтэцтэй байгууллагын хүлээх үүргийг биелүүлээгүй:

- Монголын төмөр зам ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023.01.19-ний өдрийн “Компанийн албан тушаалын жагсаалт, орон тоо, цалингийн сүлжээг шинэчлэн батлах тухай” А/01 дугаар тушаалаар баталсан бүтцэд кибер аюулгүй байдлыг хариуцсан нэгж, албан тушаалтан байхгүй байгаа нь цаашид тус компанийн ашиглалтад оруулсан системийн аюулгүй байдал алдагдах, холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангах боломжгүй байдалд хүргэхээр байна.
- Мөн мэдээллийн аюулгүй байдлын дотоод журам боловсруулж, батлаагүй, мэдээллийн аюулгүй байдлын стандарт нэвтрүүлээгүй, мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн, найдвартай, тасралтгүй байдлыг хангах, гэмтэл саатлын үед сэргээн ажиллуулах төлөвлөгөөгүй байгаа нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1²⁰, 19.2.2²¹, 19.2.3²², 19.2.4²³-т заасныг тус тус зөрчсөн байна.

2.64. Иймд аудитаар БНСУ-ын Солонгосын үндэсний төмөр замтай байгуулсан дохиолол холбооны багц ажлын импортын гаалийн, НӨАТ-ын төлбөр, захиалагчийн хяналтын болон удирдлагын зардлын зарцуулагдаагүй үлдэгдэлд дахин хяналт хийж, зориулалт бусаар зарцуулсан дүнгээр Эрдэнэс-Тавантолгой ХК-аас олгох санхүүжилтийн дүнг бууруулах албан шаардлага хүргүүлсэн.

Эрчим хүчний барилга, байгууламжийн ажлын гүйцэтгэл:

2.65. ЗГХЭГД-ын тушаалаар байгуулсан дэд ажлын хэсгийн 2019 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 15 дугаар зөвлөмжийн дагуу 2019 оны 8 дугаар сарын 05-ны өдөр 19/167157/61 дугаартай 224.1 сая төгрөгийн гэрээг Монголын төмөр зам ТӨХК, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнтэй байгуулж төслийн зураг, төслийн ажлыг гүйцэтгүүлжээ.

¹⁸ Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна

¹⁹ Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна

²⁰ кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам батлах

²¹ кибер халдлага, зөрчлийн үед дагаж мөрдөх төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх

²² мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар стандартыг нэвтрүүлэх

²³ кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хариуцсан нэгж, эсхүл албан тушаалтантай байх

2.66. Зураг төсөл боловсруулах гэрээ байгуулагдсанаас хойш 2 сарын дараа ЗТХС-ын тушаалаар байгуулсан Дэд ажлын хэсгээс зөвлөмж болгосны дагуу 2019-2020 онд нийт 19 ААН-тэй 53,012.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, ЦДАШ болон дэд станц барих ажлыг гүйцэтгүүлсэн байна.

2.67. Ажлын гүйцэтгэлээр нийт 352.7 сая төгрөгийн зураг, төсөвт ажлын тоо хэмжээг дутуу тооцсон, ЦДАШ-ын трассыг өөрчлөх шаардлага үүссэнээр дараах ажлыг магадалшгүй ажлын зардлаар гүйцэтгүүлсэн нь зураг төсөл боловсруулах ажлыг бүтээн байгуулалтын ажилтай зэрэгцүүлж эхэлсэн, ЭХХТ зураг төслийн алдааг залруулалгүй баталгаажуулсантай холбоотой бөгөөд зураг, төсөл зохиогч байгууллагатай хариуцлага тооцоогүй, магадалшгүй ажлын гүйцэтгэлийн баримт материалын иж бүрдэл хангагдаагүй байна.

Хүснэгт 33. Эрчим хүчний чиглэлээр хийсэн магадалшгүй ажлын жагсаалт, сая төгрөг

№	Ажлын хамрах хүрээ	Гүйцэтгэсэн компанийн нэр	Магадалшгүй ажлын батлагдсан төсөв	Гэрээний үнийн дүн	Магадалшгүй зардлаар хийгдсэн ажлын тойм
1	Зөрлөг 3-аас зөрлөг 5 хүртэлх ЦДАШ татах ажил	Биндэгноров ХХК	149.4	76.2	Намгийн хамгаалалтын тулгуурыг дутуу тооцсон, трасс өөрчлөгдсөний улмаас газар шороо, кабель татах нэмэлт ажил гарсан
2	Зөрлөг 1-ээс зөрлөг 2 хүртэлх ЦДАШ татах ажил	Да хот ХХК	98.4	80.4	Трас өөрчлөгдсөний улмаас бетон тулгуурыг анкер тулгуур болгож өөрчилсөн
3	СКААДА систем бүхий аянгын трасс	Ноекрафт ХХК	95.5	63.0	Ажлын зураг болон материалын түүвэрт 12 ш тоолуур, 54 гүйдлийн трансформатор, 18 ш Sateo 130 plus олон үйлдэлт тоолуурыг орхигдуулсан.
4	Зөрлөг 2-оос зөрлөг 3 хүртэлх ЦДАШ татах ажил	Цагаан хорол ХХК	86.2	50.3	Ажлын зурагт завсрын тулгуурууд ригельгүй, кольцо хийхээр зурагдсан боловч материалын түүвэр, төсөвт тусгагдаагүй.
5	Цагаан суварга дэд станцын өргөтгөлийн ажил	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	35.9	35.7	А/Б2 гаргалгааны гүйдлийн трансформаторын коэффициентийг алдаатай тооцсон.
6	Зөрлөг 6-аас Зүүнбаян дэд станц хүртэлх ЦДАШ татах ажил	ДМТМ ХХК	47.1	47.1	ЦДАШ нь "Айл баян" нүүрсний уурхайн 110 кВ-ын шугамтай огтлолцсон тул огтлолцож байгаа хэсгийн анкер тулгуурын байрлалыг өөрчилсөн.
НИЙТ ДҮН			512.5	352.7	

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

Магадалшгүй ажил, бусад зардлын гүйцэтгэл:

2.68. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслийн хүрээнд магадалшгүй ажилд зориулан 26,947.3 сая төгрөгийг төсөвлөж, 2023 оны 6 дугаар сарын байдлаар магадалшгүй ажлын зардалд 8,859.3 сая төгрөгийг ТЭЗҮ, зураг төсөлд тусгагдаагүй ажил болон нэмэлт ажлуудын гүйцэтгэлд олгосон байна. Тухайлбал,

Дэд ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу Монголын төмөр зам ТӨХК төмөр замын трассын элсэнд дарагдсан хэсгийг цэвэрлүүлсэн:

- ПК04+00-ПК150+000 хүртэлх элсэнд дарагдсан хэсгийг дэд ажлын хэсгийн 170 дугаар зөвлөмжөөр Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах МСҮТ-ээр 191.7 сая төгрөгийн төсөвт багтаан гүйцэтгүүлэхийг зөвлөсөн ч Зэвсэгт хүчний 167 дугаар ангитай Ажил гүйцэтгэх АГГ-21/78-78/15 дугаартай гэрээ байгуулж, гүйцэтгүүлжээ.
- ПК04+000-ПК55+000 хүртэлх элсэнд дарагдсан хэсгийг 168 дугаар зөвлөмжийн дагуу 70.8 сая төгрөгт багтаан Зэвсэгт хүчний 7782 дугаар ангиар гүйцэтгүүлсэн.

ТЭЗҮ, зураг төсөлд тусгагдаагүй дараах нэмэлт ажлыг гүйцэтгэсэн:

- Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтэцтэй холбох холболтын 22 орчим км төмөр замын барилга байгууламж хийгдээгүй учраас Тавантолгой нүүрсийг ачиж, буулгах талбай (гаалийн хяналтын талбай) бэлтгэх шаардлага бий болсон.
- Иймд Монголын төмөр зам ТӨХК-аас 2021.12.24-ны өдрийн 01/1565 дугаар албан бичгээр ЗТХС-д магадалшгүй ажлын зардлаар дээрх ажлыг гүйцэтгэх хүсэлт хүргүүлсэн бөгөөд ЗТХС-ын

2022.01.10-ны 01/104 дугаар албан бичгээр ирүүлсэн хариуд ТЭЗҮ, зураг төсөлд нэмэлт өөрчлөлт оруулж, гаалийн хяналтын талбай байгуулахыг дэмжиж байгаа тул ЗГХЭГД-ын ахалсан Ажлын хэсэгт хандаж, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлэхийг мэдэгдсэн байна.

- ЗГХЭГД-аар ахлуулсан ажлын хэсгийн 175 дугаар зөвлөмжөөр зураг төсөл, төсвийг Гео зураглал ХХК-аар 69.0 сая, 200 тонн хүртэлх даацтай статик вагон жин нийлүүлэх, суурилуулах ажлыг Эталон хэмжүүр ХХК-аар 318.5 сая, нүүрсний тоосжилт болон салхинаас хамгаалах хашааг Цэнгийн зам ХХК-аар 678.0 сая, гадна торон хашааны материалыг Дээрхийн гол ХХК-аар 170.3 сая төгрөгт багтаан гэрээ байгуулж, гүйцэтгүүлэхийг даалгасны дагуу Эталон хэмжүүр ХХК-аас бусад ААН-ээр гүйцэтгүүлсэн байна.
- Харин Эталон хэмжүүр ХХК-ийн 318.5 сая төгрөгийн 200 тонн хүртэлх даацтай статик вагон жин нийлүүлэх үнийн санал ирүүлсэн боловч Би Би Эф ХХК-тай 250.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулан гүйцүүлсэн байна.
- Гаалийн хяналтын талбайн ажлыг магадалшгүй ажлын зардлаар санхүүжүүлэхээр шийдвэрлэж, 3,175.7 сая төгрөгийг зарцуулсан.

2.69. Мөн Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын төсөвт өртөгт багтсан норм, нормативын санд төвлөрүүлэх нийт 2,286.6 сая төгрөгийг санд төвлөрүүлээгүй нь Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5²⁴, 5.7.1²⁵, Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1²⁶ дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн тул холбогдох санд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

2.70. Аудитаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд байгуулсан нийт гэрээ болон гүйцэтгэлээрх зөрүү 51,027.7 сая төгрөг байх тул хөрөнгийн зарцуулалтад дахин хяналт хийж, зориулалт бусаар зарцуулсан дүнгээр төслийн нийт гүйцэтгэлд Эрдэнэс-Тавантолгой ХК-аас олгох санхүүжилтийн дүнг бууруулах албан шаардлагыг Монголын төмөр зам ТӨХК-д хүргүүлсэн.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал хангалтгүй байна

2.71. Монголын төмөр зам ТӨХК-д Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл, Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 231 дүгээр тогтоолоор Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон байна.

2.72. Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 117 дугаар тогтоолоор Монголын төмөр зам ТӨХК, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хамтарсан Зүүнбаян төмөр зам ХХК байгуулж, Монголын төмөр зам ТӨХК-д олгосон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг цуцалж, мөн зөвшөөрлийг Зүүнбаян төмөр зам ХХК-д 3 жилийн хугацаагаар олгосон байна.

2.73. ЗТХС-ын зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэлээр Тавантолгой төмөр зам ХХК-аар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн захиалагчийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхийг дэмжиж, холбогдох ажлын хэсэгт танилцуулж, шийдвэрлүүлэхийг Монголын төмөр зам ТӨХК-д даалгажээ.

2.74. Монголын төмөр зам ТӨХК болон Тавантолгой төмөр зам ХХК-ийн хооронд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн барилгын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг 2019 оноос эхлэн байгуулж ажилласан байна.

2.75. Тавантолгой төмөр зам ХХК Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын захиалагчийн хяналтын зардалд 10.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

2.76. Мөн Тавантолгой төмөр зам ХХК-д Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг

²⁴ Энэ хуулийн 5.1-д заасан барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлах, сурталчлах зэрэг үйл ажиллагааны зардлыг улсын төсөв болон Барилга байгууламжийн норм, нормативын сангаас санхүүжүүлнэ.

²⁵ Барилга байгууламжийн төсөвт өртгөөс 0.18 хувиар авсан орлого

²⁶ авто замын барилга, засвар, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгийн 0.4 хувиар тооцсон орлого; хувиар тооцож, холбогдох норм, нормативын санд төвлөрүүлэх

олгоогүй байхад дээрх бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Бодь интернэшнл ХХК-аас 2019-2022 онд нийт 33.1 тэрбум төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг суутган авсан байна.

Хүснэгт 34. Тавантолгой төмөр зам ХХК-ийн санхүүгийн зарим үзүүлэлт, техник хяналтын зардлын бүрдүүлэлт, сая төгрөг

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	НИЙТ ДҮН
Тавантолгой төмөр зам ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлангаар						
Үйл ажиллагааны зардлын дүн	3,065.0	7,380.1	1,899.7	10,239.5		22,584.3
Орлогын дүн	10,244.0	6,570.2	2,026.4	8,071.3		26,911.9
Үүнээс, хүүгийн орлого	858.0	1,482.9	409.1	1,184.8		3,934.8
Тавантолгой төмөр зам ХХК-ийн дансны хуулга, аудитаар бүрдүүлсэн нотлох баримтаар						
Захиалагчийн хяналтын зардал	10,244.0	6,570.2	11,303.6	24,304.8		
Үүнээс	Тавантолгой-Зүүнбаян хяналт	2,689.5	6,570.2	856.6		10,116.3
	Тавантолгой-Гашуунсухайт хяналт	7,554.5		8,427.3	17,125.5	33,107.4
	Холбох төмөр зам			4,842.3		
	Ложистик		2,019.7	2,462.5		
Арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хадгаламжийн гэрээгээр						
	Хадгаламжид байршуулсан		5,000.0	3,651.5	35,960.6	20,521.9
	Хүүгийн орлогыг хадгаламжид байршуулсан хугацаагаар тооцвол		250.7	343.4	1,142.0	1,331.1
						3,067.2

Эх сурвалж: Тавантолгой төмөр зам ТӨХК

2.77. Дээрх тооцооллоос харахад Тавантолгой төмөр зам ХХК захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээ байгуулж, ногдох зардлуудыг авсан ч захиалагчийн хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаагүй байна.

2.78. Захиалагч болох Монголын төмөр зам ТӨХК нь захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн гэрээний үүргийг гүйцэтгэгчээр хангуулах, зөрчил дутагдлыг арилгах ажил хийгээгүй, гэрээний хугацааг жил дараалан сунгаж ирсэн нь захиалагчийн хяналт үр дүнгүй байх, гүйцэтгэл удаашрахад нөлөөлсөн байна.

2.79. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн зардлын зарим гүйцэтгэл нь БХБС-ын 2019 оны 85 дугаар тушаалаар Барилга захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах зардлын нэр төрөлд хамаарахгүй байна.

2.80. БХБС-ын 2018 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 218 дугаар тушаалын хавсралтаар “барилга, байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлыг тогтоох дүрэм”-ийг баталсан. Энэхүү дүрмээр төмөр зам, түүний барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг тогтоогоогүй байна. Харин дээрх сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 211 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам”-ын 5.26 дахь хэсэгт зааснаар төмөр зам, түүний барилга, байгууламж, төмөр замын туннель нь Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн ангилалд хамаарч байна.

2.81. Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д “зөвлөх үйлчилгээ гэж барилгын үе шатны ажил гүйцэтгэх, норм, нормативын баримт бичиг боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн сонголт, механик-автоматжуулалт, тохируулга, зүгшрүүлэх, чанар аюулгүй байдлын түвшин, төлөв байдлыг тогтооход шаардлагатай мэргэжил, тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг”, 37 дугаар зүйлийн 37.1.4-д “барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж

ажиллах”, 37 дугаар зүйлийн 37.2.3-д “захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно”, 42 дугаар зүйлийн 42.2-т “энэ хуулийн 10.1.4, **10.1.5-д** заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээг заавал авна”, Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2.7-д “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана” гэж заасныг хэрэгжүүлээгүй, онцгой төвөгшилтэй байгууламжийн захиалагчийн хяналт үр нөлөөгүй байна гэж үзэхээр байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажил гүйцэтгэгчийн удирдлагын зардлын 30 хувийг суутган авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна

2.82. Монголын төмөр зам ТӨХК болон ЗХЖШ-ын хооронд 2019 оны 6 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх АГГ-Н/1901 Н/387 дугаартай, УБТЗ ХНН-тэй 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтэц, дохиолол холбоо, эрчим хүч, гүүр, хоолойн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх” ОГ/20/042 АГГ-20/21-20/06 дугаартай гэрээгээр ЗХЖШ, УБТЗ ХНН нь гүйцэтгэгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхээр байна.

2.83. Гэтэл Зэвсэгт хүчний жанжин штаб нь “ажил гүйцэтгэгч”-ийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэггүй, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Зэвсэгт хүчний бүтээн байгуулалтын дэмжлэгийн газрыг байгуулан ажиллуулсан, УБТЗ ХНН нь холбоо дохиолол, шилэн кабель, эрчим хүчний ажлуудыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж, өөрөө захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.9-д “барилга байгууламжийн суурь, хана, хучилт, шат, араг бүтээц, дээврийн ажлуудыг бие даан гүйцэтгэх”, 40.1.23-д “гүйцэтгэгч барилгын ажлын захиалагчийн үүргийг хэрэгжүүлсэн тохиолдолд энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

2.84. ЗХЖШ-ын Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар, БИЦУГ УТҮГ нь 79 ААНБ, Зэвсэгт хүчний 9 анги нэгтгэлтэй төмөр замын далан, хоолойн ажил гүйцэтгэх, УБТЗ ХНН 29 ААНБ, Зэвсэгт хүчний 1 ангитай гүүр, эрчим хүч, шилэн кабель, дохиолол холбооны ажлын гэрээг тус тус байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

2.85. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын дээр дурдсан гэрээт ажлын төсөвт өртөгт батлагдсан гүйцэтгэгчийн удирдлагын зардлын 30 хувийг “**төслийн үйл ажиллагаатай холбоотой удирдлага зохион байгуулалтыг хангах**” нэрээр Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар, БИЦУГ УТҮГ 8,951.6 сая, УБТЗ ХНН 6,462.8 сая төгрөгийг тус тус суутган авч, үйл ажиллагаандаа зарцуулжээ.

Хүснэгт 35. Зэвсэгт хүчний анги, нэгтгэл болон ААНБ-ын хяналтын төсвийн удирдлагын зардлаас 30 хувиар тооцож суутгасан дүн, сая төгрөг

Ажлын нэр, төрөл	Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүд		ААНБ-ын	
	Гэрээгээр гүйцэтгэсэн ажлын дүн	Удирдлагын зардлаас суутгасан дүн	Гэрээгээр гүйцэтгэсэн ажлын дүн	Удирдлагын зардлаас суутгасан дүн
Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүд				
Далан	77,498.2	1,743.9	228,235.3	4,396.0
Хоолой	48,439.3	1,327.1	51,526.1	1,484.6
Дүн	125,937.5	3,071.0	279,761.4	5,880.6
УБТЗ ХНН				
Гүүр	3,726.4	127.5	124,783.0	3,932.2

Эрчим хүч	50,125.4	273.3
Шилэн кабель	9,605.5	129.8
Холбоо, дохиолол	121,587.1	2,000.0
Дүн	3,726.4	127.5
НИЙТ	129,663.9	3,198.5
	306,101.0	6,335.3
	585,862.4	12,215.9

Эх сурвалж: ЗХЖШ-ын БИЦУГ УТУГ, УБТЗ ХНН

2.86. Төмөр замын далан, хоолой, гүүр, эрчим хүч, шилэн кабель, холбоо дохиоллын ажил гүйцэтгэсэн ААНБ-ын гэрээний үнээс 12,215.9 сая, зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн ажлын гүйцэтгэлээс 3,198.5 сая, нийт 15,414.4 сая төгрөгийг суутган авч үйл ажиллагаандаа зарцуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглоно”, 15.2-т “хууль тогтоомжоор болон засгийн газар, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлбөр авахаар тогтоосон бол нэмэлт төлбөр авахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, Барилгын тухай хууль, норм ба дүрэмд заасан Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг алдагдах эрсдэлтэй байна.

Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна

2.87. Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1-д “Захиалагч нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргээс гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ”, 3.1.4-т “Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээг байгуулж, барилгын ажлын үед шатанд зохиогчийн техник хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах”, БХБС-ын 2016 оны 178 тушаалаар баталсан “Барилгын ажилд зохиогчийн хяналт тавих дүрэм(БНБД 11-04-16)”-ийн 3.1-д “Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина” гэж заажээ.

2.88. Дэд ажлын хэсгийн хуралдаанаар дараах ААНБ-уудаар зураг төсөл, зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх зөвлөмжийг Монголын төмөр зам ТӨХК-д хүргүүлж, гэрээ байгуулан ажилласан байна.

Хүснэгт 36. Зураг төсөл зохиогчийн хяналт ажлын зардлын гүйцэтгэл, сая төгрөг

№	ААНБ-ын нэр	Гэрээ				Гүйцэтгэл		
		Чиглэл	Огноо	Дугаар	Дүн	Баталгаа 5%	Олгосон	Үлдэгдэл
1	Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ	ЦДАШ, дэд станц	2020.05.01	АГГ-20/134-131/36	344.4	17.2	344.4	-
2	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ	Цахилгаан хангамж	2020.07.27	АГГ-20/186-183/54	492.0	24.6	419.3	72.7
			-	ҮҮГ-2013-12/03				
3	ГБЭТ ХХК	Гүүр	2019.10.25	АГГ-19/261 280/100	441.1	22.1	447.8	6.6
4	Гео зураглал ХХК	Хоолой	2019.04.17	АГГ-20111	80.0	4.0	80.0	-
5	Ти Ай Би ХХК	Хоолой	2019.04.16	АГГ-20110-1	80.0	4.0	84.1	4.1
			2020.05.21	АГГ-20/181-178/52				
6	Эрчим төсөл ХХК	Барилга байгууламж, уурын зуух	2020.03.31	АГГ-20/84-82/24	361.8	18.1	252.1	109.7
			2019.10.01	АГГ-19/2582 27/99				
Нийт дүн					1,799.3	90.0	1,627.7	193.1

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

2.89. Монголын төмөр зам ТӨХК дээр дурдсан 6 ААНБ-тай 1,799.4 сая төгрөгийн үнийн дүн бүхий зохиогчийн хяналт хийх гэрээг байгуулан гэрээний гүйцэтгэлд 1,627.7 сая төгрөгийг шилжүүлж, 171.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 37. Зураг төсөл зохиогчийн хяналтаар өгсөн зарим зөвлөмжүүд

№	ААНБ	Хэрэгжүүлсэн зохиогчийн хяналт		
		Чиглэл	Хугацаа	Зарим үүрэг даалгавар
1	ГБЭТ ХХК	Төмөр бетон гүүрүүдийн барилга угсралт	2020.04.29-2021.07.09	1.Шон суурийн өрөмдлөгийг сөөлжилж өрөмдсөн; 2.Шон суурийн арматурыг бүгдэд нь цэгэн гагнуур хийсэн; 3.Бүх бүтээцэд ажлын аргачлал гаргасан; 4.Бетоны арчилгааг зураг төсөл зохиогчийн зөвлөснөөр хэрэгжүүлсэн; 5.Дам нурууны бетон цутгахад аргачлал гаргасан; 6.Бетоны шон бат бэх техникийн шаардлага хангасан.
2	Гео зураглал ХХК	Хоолой	2020.04.21-2020.04.26 2020.07.27 2020.07.31	1.Зарим хэсэгт арматурын хамгаалалтын үеийг зураг төслийн дагуу хийгээгүй; 2.Арматурчлалтын зай баригч техникийн шаардлага хангаагүй; 3.Бетон нь арчилгаа муу хийснээс хялгасан хагарал үүссэн; 4.Орон, гарах амсрын чулуун бэхэлгээ болон далангийн хажуу налуугийн бэхэлгээ зураг төсөлд заасан хэмжээнд хүрээгүй.
3	Эрчим төсөл ХХК	Барилга угсралт	-	1.Барилга угсралтын ажлын чанар сайн түвшинд хийгдсэн;
4	Ти Ай Би ХХК	Хоолой	2020.07.28	1.Хоолойн тулц бетоныг зураг төсөлд заасан түвшин ухаж суурийг нягтруулах шаардлагатай; 2.Бетон цутгалтын ажилд ажилчдын тусгайлан бэлтгэж заавар өгөх; 3.Хэв хашмалыг ашиглах бүрд цэвэрлэж тослох зэрэг зөвлөмжүүдийг хүргүүлжээ.

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

2.90. Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, зохих зөвлөмжүүдийг өгч ажиллан, алдаа дутагдлыг засуулж, зохиогчийн хяналтын тайланг Монголын төмөр зам ТӨХК-д хүргүүлсэн байна.

Бүтээн байгуулалтын ажилд зарцуулах хөрөнгөөс 67.0 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмж бэлтгэсэн нь Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасантай нийцэхгүй байна

2.91. Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлийн 16.3-т “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн худалдан авалтын санхүүжилтийн талаар БХС танилцуулж, үүнтэй холбогдуулан бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу үргэлжлүүлэн зохион байгуулж ажиллах”-ыг БХС, ЗТХС болон Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ-д тус тус даалгасан байна.

2.92. Техник, тоног төхөөрөмж худалдан авах ажлын хүрээнд ЗГХЭГ-ын даргын 2019 оны 44 дүгээр тушаал, ЗТХС-ын 2019 оны 315 дугаар тушаалаар байгуулсан Дэд ажлын хэсгүүд нийт 109.4 тэрбум төгрөгийн худалдан авалтын зөвлөмж гаргаснаас 38.6 тэрбум төгрөгийн худалдан авалтыг хүчингүй болгож, 70.8 тэрбум төгрөгийн худалдан авалт хийхийг зөвлөмж болгосны дагуу 67.0 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авсан байна.

Хүснэгт 38. Төмөр замын бүтээн байгуулалтын ажилд зориулж худалдан авсан техник, тоног төхөөрөмжийн жагсаалт, сая төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	Мөнгөн дүн	Тайлбар
Аудитын код: ГНАГ-2022/23-ШТА-ГА		
		Хуудас 64

Санхүүжүүлсэн	Монголын төмөр зам ТӨХК	21,417.6	2019.06.24-нд шилжүүлсэн
	Монголын төмөр зам ТӨХК	45,600.0	2019.08.29-нд шилжүүлсэн
	НИЙТ ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ	67,017.6	
Зарцуулалт	2019 онд худалдан авсан 187 техник	44,336.5	ЗГХЭГ-ын даргын 2019.05.31-ний өдрийн 44, ЗТХС-ын 2019.10.11-ний өдрийн 315 дугаар тушаалаар байгуулсан Дэд ажлын хэсгийн 08, 09, 36, 37, 38, 39, 54, 73, 80, 92 дугаар зөвлөмжөөр
	2020 онд худалдан авсан 102 техник	19,065.8	
	2019 онд худалдан авсан цахилгаан үүсгүүр /30 кв, 10 кв, 8 кв/	32.0	ЗТХС-ын 2019 оны 93 дугаар тушаал
	2019 онд худалдан авсан геодези, лабораторийн багаж, бутлуурын үйлдвэрийн шинэчлэл	456.6	Дэд ажлын хэсгийн 01, 02, 52, 53, 93 дугаар зөвлөмж
	2019 онд худалдан авсан төслийн ажлыг эхлүүлэхэд шаардлагатай материал, хэрэгсэл	501.2	ЗХЖШ-ын даргын 2019.06.27-ны өдрийн н/478, 2019.06.27-ны өдрийн н/480, 2019.09.25-ны өдрийн н/663, 2019.09.25-ны өдрийн н/657, 2019.09.25-ны өдрийн н/656, 2019.10.17-ны өдрийн н/715
	2020 онд худалдан авсан чулуу бутлуурын үйлдвэр	870.0	Дэд ажлын хэсгийн 2020.01.28-ны өдрийн 84 дүгээр зөвлөмж
	2020 онд худалдан авсан бетон зуурмагийн узель	1,700.0	Дэд ажлын хэсгийн 2020.02.21-ний өдрийн 93 дугаар зөвлөмж
	НИЙТ ЗАРЦУУЛСАН	66,962.1	
Үлдэгдэл	2022.12.30-ны өдрийн байдлаар	55.5	

Эх сурвалж: ЗХЖШ-ын БИЦУГ

2.93. БИЦУГ УТУГ нь 2019 онд 187 техникийг 44.3 тэрбум, 2020 онд 102 техникийг 19.1 тэрбум, нийт 289 техникийг 63.4 тэрбум төгрөгөөр, мөн 2019 онд геодезийн багаж, тоног төхөөрөмжийг 0.46 тэрбум, дизель цахилгаан үүсгүүрийг 0.03 тэрбум, зөөврийн орон сууцыг 0.5 тэрбум төгрөгөөр, 2020 онд чулуу бутлуур, бетон зуурмагийн үйлдвэр, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг 2.57 тэрбум төгрөгөөр буюу нийт 3.56 тэрбум төгрөгөөр тоног төхөөрөмж, үйлдвэр худалдан авсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 8-аас харна уу.)

2.94. Эрдэнэс-Тавантолгой ХК болон Монголын төмөр зам ТӨХК-ийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны ЭТТ-2019/731 дугаар гэрээний хоёрдугаар хавсралт Өрийн бичиг гаргаж, татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө-нд Машин механизм, техник худалдан авалтад 66.0 тэрбум төгрөгийг тусгажээ.

2.95. Харин УУХҮС, ЗТХС-ын 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хамтран баталгаажуулсан “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хуваарь”-аар нийт шаардлагатай хөрөнгө оруулалтын дүн 1,392.3 тэрбум төгрөг, үүнээс Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн санхүүжүүлэхийг зөвшөөрөөгүй буюу санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй хөрөнгө оруулалт, санхүүжилтийн дүн 67.0 тэрбум төгрөг гэж тодотгосон байна.

2.96. Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүд 2019 оны 5 дугаар сараас төмөр замын бүтээн байгуулалтад оролцож, суурь, далангийн ажлыг эхлүүлсэн боловч машин техник, тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийг УИХ-аас шийдвэрлээгүй,

мэргэжлийн боловсон хүчний хувьд бэлтгэл хангах эрх зүйн орчин бүрдээгүй байхад²⁷ Засгийн газрын хуралдааны 36 дугаар тэмдэглэлээр техник, тоног төхөөрөмж худалдан авахыг БХС, ЗТХС болон Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ-д тус тус даалгасан нь санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах нөхцөл болжээ.

2.97. Аудитаар Батлан хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ”, Зэвсэгт хүчний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ”, 18¹ дугаар зүйлийн 18^{1.1}-д “Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгслийг шинэчлэх, ...зорилго бүхий Зэвсэгт хүчний хөгжлийн сантай байна”, 18^{1.4}-д “Энэ хуулийн 18^{1.2.6}-д заасан эх үүсвэрээр улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг Зэвсэгт хүчний хэрэгцээнд худалдан авч болно, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйл.Төрийн өмчийн талаарх УИХ-ын бүрэн эрхийн 8.1-д “УИХ бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх”, 8.2-т “...төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх хэмжээг тогтоох” гэж заасантай нийцүүлж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх албан шаардлагыг БХС-д, санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 55.5 сая төгрөгийг Монголын төмөр зам ТӨХК-д буцаан төвлөрүүлэх төлбөрийн актыг Зэвсэгт хүчний БИЦУГ УТҮГ-т тус тус хүргүүлсэн.

Монголын төмөр зам ТӨХК төлбөрийг дотоодын аж ахуйн нэгжтэй валютаар төлөхөөр байгуулсан нь ханшийн алдагдал үүсгэж байна

2.98. Дэд ажлын хэсгийн 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 131 дүгээр зөвлөмжөөр төслийн хүрээнд төмөр бетон дэр үйлдвэрлэж, нийлүүлэх ажлыг 1 ширхгийг 84.7 долларын өртгөөр Монгол Улсын дэр бетон үйлдвэрлэгчдийн нэгдлээр гүйцэтгүүлэхийг Монголын төмөр зам ТӨХК-д зөвшөөрсөн байна.

2.99. Монголын төмөр зам ТӨХК төмөр бетон дэр нийлүүлэх ажилд Улаанбаатар БҮК ХК, Дорнод Ган хийц ХХК, Улаанбаатар төмөр зам ХНН-ийг сонгох боломжтой талаар Дэд ажлын хэсэгт 2019 оны 7 дугаар сарын 17, 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдрүүдэд танилцуулж, 19, 57 дугаар бүхий зөвлөмжийг гаргуулан, дараах гэрээг байгуулсан байна.

Хүснэгт 39. Төмөр бетон дэр нийлүүлэх гадаад валютаар байгуулсан гэрээний мэдээлэл, ам.доллар

Компанийн нэр	Гэрээний				Гүйцэтгэлээр			
	Огноо	Дугаар	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Мөнгөн дүн	Тоо ширхэг	Мөнгөн дүн	Баталгааны 5%
Улаанбаатар БҮК ХК	2019.07.24	ХХАГ-19/144137/18	84.7	46,000	10,377.8	46,000.0	9,974.1	518.9
	2020.01.22	ХХАГ-20/14-13/02	84.7	252,000	58,667.4	252,000.0	56,258.7	2,933.4
	2020.07.27	ХХАГ-20/183-179/37	84.7	125,497	30,210.5	125,497.0	28,699.9	1,510.5
	2020.09.23	ХХАГ-20/233-230/44	84.7	4,881	1,180.1	4,881.0	1,120.2	59.0
	2021.01.08	ХХАГ-20/182-179/37-01	84.7	54,800	13,191.8	54,800.0	12,532.2	659.6
	2021.02.25	ХХАГ-21/20-20/05						
	ДҮН			483,178	113,627.7	483,178.0	108,585.1	5,681.4
Ганхийц ХК, Дорнод Ган хийц ХХК	2019.01.06	ХХАГ-20/0101/01	84.7	150,000	34,739.7	95,200.0	21,115.0	1,737.0
	2019.07.24	ХХАГ-19/145138/19	84.7	46,000	10,377.8	46,000.0	10,127.4	518.9

²⁷ Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр Засгийн газрын шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно” гэж заасан, хуульд 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн 6 дугаар зүйл.Зэвсэг хүчний чиг үүргийн 6.2.11-д “бүтээн байгуулалтын ажилд оролцох”, 13 дугаар зүйл.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн 13.1.13-т “улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална” гэж заасан байна.

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

	2020.06.22	ХХАГ-20/169-166/35	84.7	49,560	11,835.8	49,560.0	11,100.0	591.8
	ДҮН			245,560	56,953.3	190,760.0	42,342.4	2,847.7
Монгол технологи Инвестмент ХХК	2020.07.01	ХХАГ/20/174-171/36	84.7	116,640	28,136.5	116,640.0	0.0	1,406.8
	НИЙТ ДҮН			845,378	198,717.4	790,578.0	150,927.5	9,935.9

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

2.100. Зөвлөмжөөр нийт 291,697 ширхэг төмөр бетон дэрийг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор үйлдвэрлэж нийлүүлэх гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Монголын төмөр зам ТӨХК-д даалгасан боловч гэрээг ам.доллараар байгуулахыг зөвлөсөн, Монголын төмөр зам ТӨХК зөвлөмж гарахаас өмнө гэрээг байгуулсан нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1²⁸-т гэж заасныг зөрчиж, ханшийн алдагдал үүсгэн бусдад давуу байдал олгосон байж болзошгүй байна.Тухайлбал,

- Төмөр замын дээд бүтцэд шаардлагатай төмөр бетон дэр нийлүүлэх гэрээг УБТЗ ХНН болон ААН-үүдтэй ам.доллараар байгуулснаас шалтгаалж, 8.9 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал үүссэн бөгөөд 2022.12.31-ний өдрийн байдлаар 19.5 тэрбум төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй, цаашид ханшийн зөрүүгийн алдагдал нэмэгдэх эрсдэлтэй байна.
- Ам.доллараар байгуулсан гэрээнүүдэд нийтлэг байдлаар төмөр бетон дэрний багцын (арматур, бэхлэгээ, металл бэлдэц, химийн нэмэлт бүтээгдэхүүн зэрэг) нэгжийн нийт үнийг 84.7 ам.доллар байхаар, үүнээс 31.6 ам.долларыг Монгол банкны тухайн өдрийн зарласан албан ханшаар, 53.1 ам.долларыг гэрээ байгуулсан өдрийн Монгол банкны албан ханш буюу 2,734.33 төгрөгийн тогтмол ханшаар төлөхөөр, үлдэх төлбөрийг гэрээ байгуулсан өдрийн Монгол банкнаас зарласан албан ханшаар тооцож төлөхөөр, мөн гэрээний үнийн дүнгийн 30.0 хувийг урьдчилж олгох, урьдчилгаа төлбөрийг сар бүрийн төлбөрөөс 20.0 хувиар суутган тооцож байхаар байгуулжээ.

Хүснэгт 40. Монголын төмөр зам ТӨХК-ийн ам.доллараар хийсэн гэрээнээс үүсэх 2023 оны ханшийн алдагдлын тооцоо, 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөр тасалбар болгон тооцсон, сая төгрөг

Гэрээгээр нийлүүлсэн бетон дэр	Гэрээний нэгжийн үнэ, ам.доллар	Төлбөрийг хийсэн бетон дэр	Гэрээ байгуулсан өдрийн ханшаар тооцсон дүн	Төлбөр төлсөн өдрийн ханшаар тооцсон дүн	Ханшийн зөрүүний ашиг, алдагдал (+/-)	Төлбөр тооцоо хийгээгүй бетон дэрийн тоо	Гэрээ байгуулсан өдрийн албан ханш	Гэрээ байгуулсан өдрийн ханшаар тооцсон дүн	Төлбөр төлөх /2023 оны 8 дугаар сарын 16-ны/ өдрийн ханшаар тооцсон дүн	Ханшийн зөрүүний ашиг, алдагдал (+/-)	Ханшийн зөрүүний нийт ашиг, алдагдал (+/-)
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Улаанбаатар БҮК ХК-тай хийсэн төмөр бетон дэр худалдах, худалдан авах гэрээнүүдээс үүсэх ханшийн зөрүүгийн тооцоолол											
46,000	84.7	43,700.0	9,858.9	9,974.1	(115.1)	2,300.0	2,663.6	518.9	676.2	(157.3)	(272.4)
52,000	84.7	239,400.0	55,734.1	56,258.7	(524.6)	12,600.0	2,748.6	2,933.4	3,282.8	(349.4)	(874.0)
80,297	84.7	136,377.0	32,829.6	32,896.6	(67.0)	43,920.0	2,842.1	10,572.7	11,633.1	(1,060.3)	(1,127.4)
4,881	84.7	4,637.0	1,121.1	1,120.2	0.9	244.0	2,854.5	59.0	64.8	(5.8)	(4.9)
83,178		424,114.0	99,543.7	100,249.6	(705.8)	59,064.0		14,084.0	15,656.9	(1,572.8)	(2,278.7)
Дорнод ган хийц ХХК-тай хийсэн төмөр бетон дэр худалдах, худалдан авах гэрээнүүдээс үүсэх ханшийн зөрүүгийн тооцоолол											
6,000	84.7	43,700.0	9,858.9	10,127.4	(268.5)	2,300.0	2,663.6	518.9	676.2	(157.3)	(425.7)
5,200	84.7	90,440.0	20,945.7	21,115.0	(169.3)	4,760.0	2,734.3	1,102.4	1,213.2	(110.8)	(280.1)
9,560	84.7	47,082.0	11,244.0	11,345.4	(101.4)	2,478.0	2,819.6	591.8	642.8	(51.0)	(152.4)
90,760		181,222.0	42,048.7	42,587.8	(539.1)	9,538.0		2,213.1	2,532.2	(319.1)	(858.2)

Эх сурвалж: Аудитын тооцоолол

2.101. Улаанбаатар БҮК ХК болон Дорнод ган хийц ХХК-тай хийсэн төмөр бетон дэр худалдах, худалдан авах ам.доллараар байгуулсан гэрээнүүдээс (2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн Монгол банкны ам.долларын зарласан ханшаар тооцоход) 1,245.0

²⁸Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.

сая төгрөгийн бодит ханшийн алдагдал үүсэж, төлбөр тооцоо хийгээгүй төмөр бетон дэрний үлдэгдэл төлбөрт 1,891.2 сая төгрөгийн ханшийн алдагдал хүлээхээр байна.

2.102. Мөн Монголын төмөр зам ТӨХК болон БНСУ-ын Яамны бус статустай улсын салбарын байгууллага болох Солонгосын үндэсний төмөр зам нарын хооронд 2021 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр СГ-21/110-109/05 дугаартай “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дохиоллын холбооны системийн зураг төсөл, программ хангамж боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсралт суурилуулалтын цогц ажлын гэрээ”-г байгуулсан байна.

2.103. Гэрээний 2.5-д нийт үнээс 16,316.9 сая төгрөгийг Захиалагч суутган авч үлдэх ба энэ “Дохиолол холбооны багц ажил”-ын хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн импортын гаалийн болон НӨАТ-ын төлбөр, захиалагчийн хяналтын болон удирдлагын зардал байхаар заасан, гэрээний үнээс үлдэх 105,270.3 сая төгрөг гүйцэтгэгчид ноогдох, гэрээний 2.2-т “Сонгон шалгаруулалтад ам.доллараар өгсөн үнийн саналыг тухайн өдөр буюу 2020 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн Монгол банкны албан ханш болох 2849.35 төгрөгөөр тооцон хөрвүүлсэн ба энэ ханшийг цаашдаа тогтмол мөрдөж, ам.долларын ханшийн өсөлт, бууралт гэрээний үнэд нөлөөлөхгүй гэдгийг Талууд харилцан тохиролцсон болно” гэж заасан боловч гэрээний гүйцэтгэлийг гүйцэтгэгчид ам.доллараар шилжүүлж байгаагаас ихээхэн хэмжээний ханшийн зөрүү үүсэхээр байна.

Хүснэгт 41. Korea National Railway ХХК-ийн гүйцэтгэлд ам.доллараар ханшийн зөрүүгээс үүсэх алдагдлын болзошгүй эрсдэлийн тооцоо

Үзүүлэлт	Гэрээ байгуулсан огноо	Ам.долларын ханш		Гэрээний үнэ		Ханшийн зөрүүгээр хүлээсэн алдагдал, ам.доллар
		Гэрээ байгуулах үе	Төлбөр төлөх үе	Төгрөг	Ам.доллар	
Гэрээний нийт үнэ	2021.09.24	2,849.35		121,587,141,223.00	42,671,887.00	
Гааль, НӨАТ, захиалагчийн, удирдлагын зардал суутган тооцсон		2,849.35		16,316,888,256.00	5,726,530.00	
Гүйцэтгэгчид гэрээгээр олгох дүн		2,849.35		105,270,252,967.00	36,945,357.00	
Техникийн хяналтын зардалд олгосон дүн	2021.12.01	2,849.35		2,000,000,000.00	701,914.47	
Гүйцэтгэгчид олгох дүн				103,270,252,967.00	36,243,442.53	
Ажлын гүйцэтгэлд олгосон санхүүжилт	2022.12.01	2,849.35	2,849.50	30,001,579,319.46	10,528,717.08	554.3
	2022.09.19	2,849.35	3,278.20	37,815,021,225.00	11,535,300.23	1,736,155.1
	2023.07.27	2,849.35	3,455.00	20,000,000,000.00	5,788,712.01	1,230,432.7
	2023.07.31	2,849.35	3,458.53	7,430,000,000.00	2,148,311.57	459,300.7
Нийт олгосон санхүүжилт				95,246,600,544.5	30,001,040.89	3,426,442.8
Гэрээний үлдэгдэл				8,023,652,422.5	6,242,401.64	
Монгол банкнаас зарласан 2023.08.15-ны өдрийн ханш 3,470.99 төгрөгөөр тооцвол хүлээх алдагдлын тооцоо	Төгрөгөөр					13,643,661,235.86
	Ам.доллараар					3,930,769.39

Эх сурвалж: Аудитын тооцоолол

2.104. БНСУ-ын Яамны бус статустай улсын салбарын байгууллага болох Солонгосын үндэсний төмөр замтай байгуулсан гэрээгээр тайлант хугацаанд 3.9 сая ам.долларын ханшийн зөрүүгийн алдагдал хүлээсэн ба цаашид гэрээний үлдэгдэл төлбөрийг барагдуулахад ихээхэн хэмжээний алдагдал хүлээхээр байна.

Улсын болон техникийн комиссоос өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, баримт бичгийн иж бүрдлийг хангах ажил хийгдэж байна

2.105. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг ашиглалтад оруулахад ЗТХС, ЭХС болон Өмнөговь аймгийн Засаг даргын захирамж, тушаалаар нийт 12 удаагийн комисс ажиллаж, дараах барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулсан байна. Үүнд:

- Дорноговь аймгийн Мандах сумын нутагт баригдсан Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын Зөрлөг 4-ийн удирдлагын байр, амралтын байр, ажилчдын орон сууцны барилга, байгууламжийг Дорноговь аймгийн Засаг даргын 2020 оны А/585 дугаар захирамжаар байгуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй комиссын 2020.12.31-ний өдрийн УҚД-104/2020 дугаартай актаар;
- Дорноговь аймгийн Улаанбудрах сумын нутаг дэвсгэрт байрлах Зөрлөг 6-ийн удирдлагын байрны зориулалттай барилгыг Дорноговь аймгийн Засаг даргын 2018 оны А/871 дүгээр захирамжаар байгуулсан 16 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2020.06.22-ны өдрийн УҚД-26/2020 дугаартай актаар;
- Дорноговь аймгийн Улаанбудрах сумын нутаг дэвсгэрт байрлах Зөрлөг 6-ийн 13 айлын ажилчдын орон сууцны барилгыг Дорноговь аймгийн Засаг даргын 2018 оны А/871 дүгээр захирамжаар байгуулсан 16 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2020.06.22-ны өдрийн УҚД-27/2020 дугаартай актаар;
- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт баригдсан Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын ПК00-д байрлах Тавантолгой өртөөний ажилчдын 120 айлын орон сууцны А3 блок барилгыг Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны А/780 дугаар захирамжаар байгуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2021.09. 27-ны өдөр У-2021/27 дугаартай актаар;
- Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг дэвсгэрт баригдсан удирдлагын байрны зориулалттай барилгыг Өмнөговь аймгийн Засаг даргын 2020 оны А/1341 дүгээр захирамжаар байгуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2021.02.24-ний өдрийн У-2020/158 дугаартай актаар;
- Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг дэвсгэрт баригдсан 14 айлын орон сууцны барилгыг Өмнөговь аймгийн Засаг даргын 2020 оны А/1341 дүгээр захирамжаар байгуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2021.02.24 -ний өдрийн У-2020/159 дугаартай актаар;
- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт баригдсан Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын ПК00-д байрлах Тавантолгой өртөөний ажилчдын 120 айлын орон сууцны А1 блок, цэвэршүүлэх байгууламж, гадна бохирын шугамын барилгыг Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны А/780 дугаар захирамжаар байгуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2021.09. 27-ны өдрийн У-2021/26 дугаартай актаар;
- Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг дэвсгэрт баригдсан Зөрлөг 2-ийн орон сууц болон удирдлагын байрны барилгыг Өмнөговь аймгийн Засаг даргын 2020 оны А/1341 дүгээр тушаалаар байгуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2021.03.23-ны өдрийн У-2021/04 дугаартай актаар;
- Өмнөговь аймгийн Манлай сум, Жаргалант баат баригдсан Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын ПК59+200-д байрлах Зөрлөг 1-ийн Удирдлагын байр болон орон сууцны барилгыг Өмнөговь аймгийн Засаг даргын 2020 оны А/1341 дүгээр тушаалаар байгуулсан 12 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2021.03.23-ны өдрийн У-2021/03 дугаартай актаар;
- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт баригдсан Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын ПК00-д байрлах Тавантолгой өртөөний ажилчдын 120 айлын орон сууцны А2 барилгыг Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны А/780 дугаар захирамжаар байгуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2021.10. 21-ний өдрийн У-2021/37 дугаартай актаар;
- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт баригдсан Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын ПК 1+00-д баригдсан 300м.кв хүчин чадал бүхий Монголын төмөр зам ТӨХК-ийн өртөөний удирдлагын байр болон уурын зуух, гадна ИШС, гадна тохижилтын ажлыг Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны А/780 дугаар захирамжаар байгуулсан 20 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2021.10.07-ны өдрийн У-2021/31 дугаартай актаар тус тус ашиглалтад оруулжээ.

2.106. Доорх чиглэлээр техникийн болон улсын комисс ажилласан бөгөөд үүрэг даалгаврын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

Хүснэгт 42. Улсын болон техникийн комиссын шийдвэрээр өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн мэдээлэл

Ангилал	Комисс байгуулсан		Комиссын чиглэл	Өгсөн үүрэг, даалгаврын тоо	Биелэлт		
	Шийдвэр гаргагч	Дугаар			бүрэн хангагдсан	бүрэн хангагдаагүй	Хангагдаагүй
Замын доод, дээд бүтэц	ЗТХС	A196	Техникийн комисс	67	62	2	3
	ЗТХС	A152	Техникийн комисс	94	91	2	1
Дохиолол холбооны байгууламж	ЗТХС	A334	Техникийн комисс	85	83	1	1

Эрчим хүчний байгууламж	ЭХЯ-ны ТНБД	A27	Техникийн комисс	49	49	
	ЭХЯ-ны ТНБД	A145	Техникийн комисс	72	68	4
ДҮН				367	353	9
						5

Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК

2.107. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад техникийн комиссоос нийт 367 үүрэг даалгавар өгснөөс 353 нь хэрэгжиж, 14 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Тухайлбал,

ЗТХС-ын 2021.12.23-ны өдрийн А/196 дугаар тушаалаар байгуулсан техникийн комиссын гишүүн:

- С.Майдар, С.Сумъяадорж нарын өгсөн: Өртөө зөрлөгийн замууд хооронд балласт дүүргэлт хийж, ашиглалтын үеийн ажилчдын аюулгүй зорчих нөхцөлийг хангах үүрэг санхүүжилт шаардлагатай шалтгаанаар хэрэгжээгүй;
- Б.Батзоригийн өгсөн: ТТАМ-ын үлдэгдэл төлбөрийг барагдуулах үүрэг санхүүжилт шаардлагатай шалтгаанаар хэрэгжээгүй;

ЗТХС-ын 2022.06.06-ны өдрийн А/152 дугаар тушаалаар байгуулсан техникийн комиссын гишүүн:

- Б.Батзоригийн өгсөн: ТТАМ-ын үлдэгдэл төлбөрийг барагдуулах үүрэг санхүүжилт шаардлагатай шалтгаанаар хэрэгжээгүй;

ЗТХС-ын 2022.12.23-ны өдрийн А/334 дүгээр тушаалаар байгуулсан техникийн комиссын гишүүн:

- Д.Мөнхбатын өгсөн: Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хажуугийн илрүүлэх системийн асуудлыг шийдвэрлэх үүрэг хугацаа болоогүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.

2.108. Дорноговь аймгийн Сайншанд, Улаанбадрах, Мандах, Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций сумдын нутаг дэвсгэрт баригдсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд, доод бүтэц, гүүр, хоолой, хиймэл байгууламж, дохиолол холбоо, зөрлөгүүдийн зам сумын барилга, байгууламжийг ашиглалтад оруулах БХБС-ын 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 126 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс дараах үүрэг даалгаврыг өгч, биелэлтийг 2023 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн дотор ирүүлэхийг үүрэг болгожээ. Үүнд:

- Бичиг баримтын бүрдлийг ханган архивд хүлээлгэн өгөх;
- Ерөнхий болон туслан гүйцэтгэгч нараар чанарын баталгаа гаргуулах;
- Техникийн комиссын үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, баталгаажуулан улсын комисст хүргүүлэх;
- Гүйцэтгэгч компаниудын 5 хувийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлэх;
- Төмөр замын ашиглалтыг сайжруулах;
- Дохиолол төвлөрүүлэлт, холбооны дутуу ажлыг гүйцээх;
- Төслийн хүрээнд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг орон нутагт хүлээлгэн өгөх;
- Өртөө, зөрлөгийн замууд хооронд балласт дүүргэлт хийх;
- Цамхгийн металл хийцийг шинжилгээ, туршилтад хамруулах;
- Цогтцэций өртөө болон зөрлөгүүдийн дизель генераторууд, газардуулга, гэрэлтүүлгийн угсралтыг бүрэн хийж дуусгах;
- Дизель генераторуудыг түлшээр цэнэглэх үед зөөврийн газардуулгыг холбох нөхцөлийг бүрдүүлэх;
- Холбоо дохиоллын байгууламжид хэрэглэгдэж буй тэжээлийн тавиурыг газардуулах;
- Холбоо дохиоллын тоног төхөөрөмжийн хэвийн ашиглалт, зүгшрүүлэлтийн хугацаанд гүйцэтгэгчээс инженер, техникийн ажилчдын төлөөллийг байлгах;
- Ерөнхий гүйцэтгэгчийн гэрээ, тусгай зөвшөөрлийн асуудлыг нөхөн үзүүлэх.

2.109. Монголын төмөр зам ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/08 дугаар тушаалаар “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.0 км төмөр замын суурь бүтэц барих төслийн хүрээнд хийгдсэн ажлуудыг хүлээн авах, төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтыг Улсын комисст хүлээлгэн өгөх үед шаардлагатай төслийн иж бүрэн бичиг баримтыг бүрдүүлэх, нэгтгэх, ажлын төлөвлөгөө боловсруулж, үр дүнг тайлагнах” үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан байна.

2.110. Ажлын хэсгээс төмөр замын бүтээн байгуулалтын баримт бичгийг цаасан болон цахим хэлбэрээр хадгаламжийн нэгж үүсгэх ажлын хүрээнд Архивын ерөнхий газраас мэргэжлийн заавар зөвлөгөө авч, 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар нийт 1773 архивын нэгж үүсгэж, баримт материалын иж бүрдэл 90.0 хувьтай байна.

2.111. Үүрэг даалгаврын биелэлтээс харахад техникийн комиссоос үүрэг болгосон хэрэгжсэнээр тайлагнасан зарим үүргийг улсын комисс үүрэг болгон өгснөөс харахад техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй байхад улсын комисс ажилласан эсвэл техникийн комиссын үүрэг даалгаврын биелэлтийг алдаатай тайлагнасан байдал ажиглагдаж байна.

2.112. Аудитаар Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилга байгууламжийн чанар байдалд хийсэн хяналтаар илэрсэн зөрчил, барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах үүрэг бүхий ажлын хэсгүүдээс өгсөн үүрэг, даалгаварт тусгагдаагүй нь техникийн болон улсын комиссын чадамжийг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Тухайлбал,

- Монголын төмөр зам ТӨХК-ийн боловсруулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын зураг нь Nippon Koei компанийн боловсруулсан Тавантолгой-Сайншанд чиглэлийн төмөр замын трассын 300 дахь км-ээс чиглэл нь өөрчлөгдөж Зүүнбаян өртөөтэй холбогдож, трассын урт 9.4 км-ээр богиноссон. Трассыг өөрчилснөөс үүссэн эерэг болон сөрөг үр дагаврын талаар комиссын шийдвэрт тусгагдаагүй;
- Төмөр замын өртөө, зөрлөгийн барилгууд холбоо дохиолол төвлөрүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулах зориулалтын өрөө тасалгаагүй;
- Төмөр замын Цогтцэций өртөөний барилга, уурын зуухны барилга, 120 айлын орон сууцны гаднах материалыг төсөвлөсөн дүнгээс хямд үнэтэй материалаар сольж гүйцэтгэсэн зэргийг дурдаж болохоор байна.

БҮЛЭГ 3. ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ХИЛ ХОЛБОЛТЫН ЦЭГИЙГ ТОХИРООГУЙ, ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУД БҮРЭН ХИЙГДЭЭГҮЙГЭЭС ОЙРЫН ХУГАЦААНД ЭДИЙН ЗАСАГТ ҮР АШИГ, ҮР НӨЛӨӨГӨӨ ҮЗҮҮЛЭХЭЭРГҮЙ БАЙНА

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд байгаль орчны төлөв байдалд байгаль орчны аудит хийх бэлтгэл ажил хийгдэж байна

3.1. Энержи ресурс ХХК-тай байгуулсан гэрээний дагуу ЕНКО ХХК 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн БОЯ-ны 2008/E111 дугаар бүхий Ерөнхий үнэлгээний мэдэгдэлтэй “Ухаа худаг-Гашуун сухайтын чиглэлд 256 км төмөр зам барих” төслийн БОННУ-ний тайланг БОЯ-ны Үнэлгээний комиссоор хэлэлцүүлэн баталгаажуулж, хүлээлгэн өгсөн байна.

3.2. ЕНКО ХХК-ийн боловсруулсан БОННУ-нд Энержи ресурс рэйл ХХК-ийн зүгээс 2009 онд ЖЭМР ХХК-аар, Тавантолгой төмөр зам ХХК 2019 онд Газар-Лха ХХК-аар тодотгол хийлгэн, 2021 онд “Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төсөл”-ийн БОННУ-ний тодотгосон тайланг хүлээн авсан байна.

3.3. Газар-Лха ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 245.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий АГ-01/164/13 дугаартай гэрээг байгуулж БОННУ-ний тодотгол тайланг бэлтгүүлсэн байна.

3.4. ЕНКО ХХК-ийн боловсруулсан БОННУ-ний тайлангаар 34 үзүүлэлтийг сонгон авч төслийн бүтээн байгуулалтын болон ашиглалтын үеийн эерэг, сөрөг нөлөөллийг тогтоосон бөгөөд эдгээр үнэлгээ ЖЭМР ХХК-ийн үнэлгээтэй харьцуулахад зөрүүтэй байна.

Хүснэгт 43. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн матриц

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл ЕНКО ХХК		ЖЭМР ХХК
		Барилгын үе	Ашиглалтын үе	
1	Усны гидробионт	бага	нөлөөгүй	их
2	Хөрсний жижиг амьтан, шавж хорхой	бага	нөлөөгүй	
3	Зэрлэг амьтадын амьдрах орон	бага	бага	их
4	Ундны ус	бага	бага	их
5	Агаарын тоосжилт	бага	бага	бага
6	Хөрсний бохирдол	дунд	нөлөөгүй	дунд
7	Дуу чимээ	дунд	бага	
8	Бэлчээр	бага	бага	дунд
9	Байгалийн үзэмж доройтох	бага	нөлөөгүй	
10	Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	бага	нөлөөгүй	

Эх сурвалж: БОННУ тайлан ЕНКО ХХК 2008 он, ЖЭМР ХХК 2009 он

3.5. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд шинээр төмөр зам барих трасс нь Монгол Улсын Улаан номд орсон, нэн ховор ангилалтай говийн тууртан болох хар сүүлт, хулан адууны тархац байршлын цөм нутгуудаар дайрч байгаа ч БОННУ-ний тайлангаар нөлөөлөл бага²⁹, харин ЖЭМР ХХК-ийн тайланд “дунд” гэж эрсдэлийг тодорхойлжээ.

3.6. Төмөр замын трассын дагуу өргөст тор хийж хамгаалсан нь “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтадад зориулсан гарц” MNS 6515:2015 стандартын шаардлагад нийцэхгүй байна.

3.7. ЕНКО ХХК-ийн тайлангаар төслийн бүтээн байгуулалтын ажлыг БОМТ-ний дагуу хяналттайгаар хэрэгжүүлбэл байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай гэж дүгнэсэн ба

²⁹ Ухаа худаг-Гашуунсухайтын чиглэлд төмөр зам барих төслийн БОННУ-ний тайлан ЕНКО ХХК 2008 он 44 дүгээр тал

Тавантолгой төмөр зам ХХК нь БОМТ-г 2021 оны 7 дугаар сард байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, баталгаажуулан 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн н/31 дугаартай албан бичгээр Бодь интернэшнл ХХК-д хүргүүлсэн байна. Бодь интернэшнл ХХК агаарын чанар, орчны тоосжилт, хөрс ба ургамалан нөмрөг, мал амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүх, соёлын өвийг хамгаалах, орчны шинжилгээний хөтөлбөрийн биелэлт зэрэг чиглэлүүдээр хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнаж ажилласан байна.

3.8. Тавантолгой төмөр зам ХХК Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дугаар зүйлийн 10^{1.1}-д *“Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ”* гэж заасны дагуу 2023 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 1/1376 дугаартай албан бичгээр Байгаль орчны аудитын холбоо ТББ-д хандаж, байгаль орчны аудит хийлгэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Төмөр замын ТЭЗҮ-г төлөвлөлтийн шаардлага, мөрдөгдөж буй стандарт, норм ба дүрмийн дагуу боловсруулсан гэж холбогдох төрийн байгууллага дүгнэжээ

3.9. Австрали Улсын AECOM Asia компани Энержи ресурс рэйл ХХК-ийн хүсэлтээр Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлд жилд 30.0 сая тонн ачаа тээвэрлэх төмөр замын шугамын нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2013 онд боловсруулсан байна.

3.10. МУЕС-ын 2018 оны 176 дугаар захирамж, ЗТХС-ын 2019 оны 33 дугаар тушаал, Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 5 дугаар тогтоолоор *“Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг тодотгох”* ажлыг Тавантолгой төмөр зам ХХК-д даалгасны дагуу 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Dong Myeong engineering consultants and architecture компанитай АГГ-01/15/03 дугаартай Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын ТЭЗҮ-д тодотгол хийх зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан байна.

3.11. ТЭЗҮ-ийг тодотгох гэрээний үнэ 1,065.0 сая төгрөг бөгөөд Dong Myeong engineering consultants and architecture компани нь ажлын даалгаврын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдаар дайран өнгөрч буй 240 орчим км урттай Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗҮ-ийг холбогдох хууль тогтоомж, стандарт, норм болон бусад баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэн зохих аргачлалын дагуу боловсруулах ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр эхэлж, 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдөр дуусгах үүрэг хүлээсэн байна.

3.12. Мөн Тавантолгой төмөр зам ХХК 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Dong Myeong engineering consultants and architecture компанитай АГГ-01/15/06-НГ-01/16/02 дугаартай *“Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглуулах гэрээ”*-г байгуулсан байна.

3.13. Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн *“Гэрээний хэрэгжилтийг хангаж, хяналт тавих тухай”* А/12 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажилласан байна.

3.14. Dong Myeong engineering consultants and architecture компани нь ТЭЗҮ-ийн тодотголыг AECOM Asia компанийн боловсруулсан ТЭЗҮ-ээр санал болгосон техникийн шийдэлд тулгуурлан боловсруулсан бөгөөд өөрчлөгдсөн шийдлүүдийг тухай бүрд үндэслэл, тайлбартайгаар оруулсан байна. ТЭЗҮ-д оруулсан өөрчлөлтүүдээс дурдвал,

Трассын төлөвлөлтийн хувьд:

- Төмөр замын трассын дагуу далангийн ажил хийгдсэн төгсгөлийн цэг буюу ПК208+500-с цааш үргэлжлүүлэн БНХАУ-ын хил хүртэлх төмөр замын трассыг төлөвлөсөн;
- Ачилтын тойргийн байршил Энержи ресурс ХХК-ийн Ухаа худагт байсныг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн санал болгосон байршлаар өөрчилж, хос замтай байхаар төлөвлөсөн;
- Трассыг өөрчилсний дагуу нэмэлтээр хийгдэх ул шороо, шуудуу, гүүр, хоолойн ажлын тоог хэмжээг нэмж төлөвлөсөн;

Өртөө, зөрлөгийн хувьд:

- 1 дүгээр зөрлөгт хүлээн авах 1, явуулах 1 зам нэмсэн, 6 дугаар зөрлөгийг 3 замтай болгож нэмсэн;
- Өртөө дэх зам, барилга, депогийн төлөвлөлтийг өөрчилсөн;

Цахилгаан хангамж:

- Цахилгаан хангамжийн систем холбогдоогүй байдлаар төлөвлөгдсөнийг төвийн цахилгаан хангамжид холбох техникийн шийдлийг боловсруулсан;

Тээвэр зохион байгуулалт:

- Ачилтын тойрогт ачигдсан ачааг Гашуунсухайт өртөөнд буулгахаар төлөвлөснийг БНХАУ-ын Ганц мод боомт болгож өөрчилсөн.

3.15. Dong Myeong engineering consultants and architecture компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийн тодотголыг ЗТХТ-ийн 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 75/2020 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулж, Зам, тээврийн салбарын ШУТЗ-ийн 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 01 дүгээр шийдвэрээр дэмжсэн байна.

3.16. Магадлалын ерөнхий дүгнэлтэд дурдсанаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-г:

- Монгол Улсын төмөр замын тээврийн тухай хууль, багц дүрэм;
- MNS 6229:2010 -1520 мм царигтай төмөр замын техникийн шаардлага;
- MNS 6060:2010 - Төмөр замын зурвас газарт тавигдах шаардлага;
- MNS 5833:2010 - Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ;
- MNS 3084:1198 -Ачилт буулгалт ба сэлгээний ажлын үед вагоны бүрэн бүтэн байдлыг хангах шаардлагад нийцүүлэн боловсруулсан гэж дүгнэжээ.

3.17. Dong Myeong engineering consultants and architecture компанийн төлөөлөлтэй Тавантолгой төмөр зам ХХК-ийн удирдлага ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах ажлын эцсийн үнэлгээг нийт 945.1 сая төгрөгөөр харилцан зөвшилцөж шилжүүлсэн байна.

3.18. Тавантолгой төмөр зам ХХК-аас өгсөн ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулах ажлын даалгаврын 2.3.2.22-т “MNS 6060:2010 Төмөр замын зурвас газарт тавих шаардлага” стандартын дагуу зэрлэг амьтадын амьдрах орчин, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байх нөхцөлийг хангасан гүүрэн, нүхэн гарц, гармын төмөр замыг төсөллөх” гэж зааснаас шалтгаалан Dong Myeong engineering consultants and architecture компанийн боловсруулсан тодотгосон ТЭЗҮ-д зэрлэг амьтадын нүүдэл шилжилтийн гарц гармыг хангалттай төлөвлөөгүй, зөвхөн өндөр давтамж бүхий хамгаалах систем, аюулгүйн торон хашааг төлөвлөсөн байна.³⁰

3.19. Зүй нь “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтадад зориулсан гарц” MNS 6515:2015 стандартыг баримтлахыг ажлын даалгавраар даалгасан бол эрсдэлээс сэргийлэх боломжтой байсан байна.

3.20. Төмөр замын хил холболтын цэгийг төр засгийн түвшинд БНХАУ-ын талтай урьдчилан тохироогүй нь УИХ-аас 2010 онд баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 2.1.2-т “ОХУ, БНХАУ-ын төмөр замын тээврийн сүлжээг ашиглан гуравдагч зах зээлд хүрэх худалдаа, тээврийг хөнгөвчилсөн шинэ замнал /маршрут/-ыг бий болгон далайн боомтуудад гарцтай болох” гэсэн заалт хэрэгжихгүй байх нөхцөл болжээ.

³⁰ Dong Myeong engineering consultants and architecture Ltd, 2020 зөвлөх үйлчилгээний тайлангийн С4-8-9 дэх тал

3.21. Dong Myeong engineering consultants and architecture компанийн боловсруулсан ТЭЗҮ-д тодотгол хийх зөвлөх үйлчилгээний тайланд хил холболтын асуудлыг 4 чиглэлээр боловсруулан тусгасан боловч хил холболтын асуудал шийдэгдээгүйгээс шалтгаалан ашиглаагүй байна.

Төрийн захиргааны байгууллагууд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг хэлбэр төдий зохион байгуулжээ

3.22. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, гүйцэтгэгчийг сонгох явцад дараах санал, шийдвэрүүд гарсан байна. Үүнд:

Дүрслэл 4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх явцад гарсан зөвлөмж, шийдвэр, бусад хэлцлүүд



2019.02.27-ны өдрийн н05/05 дугаар зөвлөмж: 6-д Засгийн газарт: Газрын тос боловсруулах үйлдвэр болон зэсийн баяжмал боловсруулах, алт цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл, Тавантолгой – Гашуунсухайт болон Тавантолгой – Цагаансуварга – Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.8 заалтад хамаарч байх тул мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын дагуу төрийн нууцад хамааруулах асуудлыг шийдвэрлэхийг зөвлөсөн.



2019.04.16-ны өдөр СБ-01/05/001 СБ 19-08 дугаартай Харилцан ойлголцлын санамж бичгийг Бодь интернэшнл ХХК-тай Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх, төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, цаашдын хамтын ажиллагааны хэлбэрийг тодорхойлох зорилгоор байгуулсан.



2019.07.24-ний өдрийн "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" 304 дүгээр тогтоол:
2-т Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-д зөвшөөрч, УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргад тус тус даалгасан;
4-т "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2019.08.15-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах"-ыг ЗТХС, УУХҮС нарт тус тус үүрэг болгосон.



Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-ийн 2019.08.16-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-тай санхүүжилтийн гэрээ байгуулах, бусад гэрээ, хэлцэл хийхийг зөвшөөрсөн.



Засгийн газрын 2018 оны 242, 2019 оны 304 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ЗТЯ, УУХҮЯ, Эрдэнэс-Тавантолгой ХК, Монголын төмөр зам ТӨХК, Тавантолгой төмөр зам ХХК хамтран төрийн болон төрийн өмчит 17 байгууллага, арилжааны 11 банк, олон улсын санхүүгийн байгууллага болон БНХАУ-ын зам, дэд бүтцийн 8 байгууллага, ТББ, компаниудын төлөөлөл оролцсон "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт" сэдэвт уулзалт зохион байгуулсан.



2019.09.02-ны өдрийн 01/1208 дугаар албан бичиг: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслийн ажил нь Засгийн газрын 2019 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор баталсан "ЗГХЭГ-ын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-ын 32, "Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-ын 11, "Зам, тээврийн салбарын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-ын 10-т заасан "үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил ..."-д тус тус туссан нь төрийн нууцад хамаарна гэж зөвлөсөн.



2019.09.02-ны өдрийн 01/152 дугаар албан бичгээр Бодь интернэшнл ХХК: төмөр замын суурь бүтэц шинээр барих төсөлд барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр оролцох сонирхлоо илэрхийлсэн.

3.23. УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргын хамтарсан 2019 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн "Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай" А/184,284,А/239 дугаар тушаалын 1.3 дахь хэсэгт "ТЕГ-ын 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 01/1208 дугаар албан бичгийг үндэслэн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулж, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ болон Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-өөр хэлэлцүүлэн Засгийн газарт танилцуулсны үндсэн дээр зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчийн гэрээг (ЕРС) байгуулж ажиллах"-ыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн Гүйцэтгэх захиралд даалгасан байна.

3.24. Мөн Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн Ерөнхий гүйцэтгэгчийг сонгосон талаар Гүйцэтгэх захирал Н.Удаанжаргал гишүүдэд танилцуулж, улмаар ЕРС гэрээг ТЭЗҮ (AECOM Asia co.ltd)-д заасан дүнгээр Бодь интернэшнл ХХК-тай хэлцэл хийж, гэрээ байгуулахыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр дэмжиж, тогтоол гаргахаар шийдвэрлэжээ.

3.25. Тухайн өдөртөө Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ 16 дугаартай тогтоол гаргаж, ТЭЗҮ (АЕСОМ Asia со.Итд)-д заасан дүнгээр ЕРС гэрээ байгуулах асуудлыг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-өөр хэлэлцүүлэн, Засгийн газарт танилцуулж, барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн байна.

3.26. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн “Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” 47 дугаар тогтоолын 1.1 дэх хэсэгт Тавантолгой төмөр зам ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасны дагуу 110.0 сая ам.доллартой тэнцэх төгрөгийг 2019 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Тавантолгой төмөр зам ХХК-д шилжүүлэх, 1.2 дахь хэсэгт “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗҮ-ийг тодотгосны үндсэн дээр уг төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах санхүүжилтийн хэмжээг тогтоож, нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх саналыг боловсруулан ТУЗ-д танилцуулах”-ыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн Гүйцэтгэх захиралд зөвшөөрчээ.

3.27. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 20-2 дугаар хурлын тэмдэглэлд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төслийн ТЭЗҮ-д заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэх, санхүүжилтийн гурван талт гэрээ байгуулах саналыг боловсруулан ТУЗ-д танилцуулахыг Эрдэнэс-Тавантолгой ХК болон Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлуудад даалгасан байна.

3.28. Улмаар Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 48 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын төсвийг 293.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 426.2 тэрбум төгрөг болгон компанийн 2019 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн баталжээ.

3.29. Засгийн газрын хуралдааны 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 43 дугаар тэмдэглэлд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явцын талаар УУХҮС Засгийн газрын гишүүдэд танилцуулж, үүнтэй холбогдуулан Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэлх төмөр замын зураг төсөл, худалдан авалт, суурь бүтцийн технологийн иж бүрдэл зэрэг төмөр зам, төмөр замын барилга байгууламжийн ажлыг цогцоор гүйцэтгэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг УУХҮС-дад өөрт нь даалгасан байна.

3.30. УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргын А/184,284,А/239 дугаартай 2019 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн хамтарсан тушаалаар “ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулах” буюу 5 хоногийн дотор сонгохоор заасан нь үнийн санал авах, үнийн санал ирүүлэгчийн чадварыг үнэлэх ямар ч боломжгүй хугацаа байна.

3.31. Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс буюу тогтоол гарснаас хойш ажлын 16 хоногт багтаан эхлүүлэхийг даалгасан, УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргын 2019 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн А/184,284,А/239 дугаартай хамтарсан тушаалаар “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг 5 хоногийн дотор сонгохоор заасан нь төслийн гүйцэтгэгчийг сонгох, чадамжийг үнэлэх боломжгүй хугацаа бөгөөд Төрийн захиргааны байгууллагууд гүйцэтгэгчийг сонгох ажлыг хэлбэржүүлсэн төдий шийдвэрүүд гаргажээ.

3.32. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгох тухай” 449 дүгээр тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хэрэгжүүлж байгаа Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажил болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтэц, дохиолол холбоо, эрчим хүч, гүүр, хоолойн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх ажлын холбогдох гэрээг төрийн нууцаас гаргаж, ил болгожээ.

Дотоодын аж ахуйн нэгж хооронд олон улсын фидик гэрээний мөнгөлөг загвараар гэрээ байгуулахдаа зарим харилцааг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлээгүй байна

3.33. Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 9 дүгээр сарын 09-ний 31 дүгээр тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчийн (ЕРС буюу фидик) гэрээг ТЭЗҮ (AECOM Asia co.ltd)-д заасан дүнгээр Бодь интернэшнл ХХК-тай хэлцэл хийж, гэрээ байгуулахыг гүйцэтгэх удирдлагад зөвшөөрсөн байна.

3.34. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлыг санхүүжүүлэх гуравласан гэрээг Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой төмөр зам ХХК, Бодь интернэшнл ХХК-ийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулж, нэмэлт гэрээгээр дараах өөрчлөлтүүд оржээ.

Хүснэгт 44. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн үндсэн болон нэмэлт гэрээний дүн, оруулсан өөрчлөлт, мянган ам.доллар

№	Ажлын нэр төрөл	Үндсэн ЕРС гэрээний дүн	Гэрээний нэмэлтээр хийгдэх ажлуудын дүн	Нийт гэрээний дүн	Ажлын даалгаврын өөрчлөлтөөр		Ажлын даалгаврын өөрчлөлтийг тооцсон нийт дүн	Хийгдээгүй ажлын нийт дүн
					Нэмэгдсэн ажил	Хасагдсан ажил		
1	Төмөр замын дээд, доод бүтцийн зураг төсөл	4,800.0		4,800.0	410.7		5,210.7	
2	Төмөр замын дээд, доод бүтэц	322,879.2	125,041.2	447,920.4	27,842.8	(23,309.0)	452,454.2	17,601.4
3	Гүүрийн ажил	21,449.4		21,449.4			21,449.4	
4	Дохиолол холбооны ажил	72,532.6	4,397.7	76,930.3	5,994.0		82,924.3	
5	Өртөө, зөрлөгийн барилга байгууламж	48,892.0	7,892.0	56,784.0	7,890.7		64,674.7	
6	Эрчим хүч хангамж	20,000.0		20,000.0	970.4		20,970.4	
7	Хөдлөх бүрэлдэхүүн	203,738.4		203,738.4			203,738.4	
8	Хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмж	13,036.4	1,000.0	14,036.4			14,036.4	
9	Зам засварын машин механизм		5,019.3	5,019.3	5,667.2		10,686.5	
10	Суурьшлын бүсийн барилга байгууламж		45,030.1	45,030.1		(44,784.3)	245.8	
11	Хил дагуу камер суурилуулах ажил		350.0	350.0		(350.0)	-	
12	Бусад			-	2,066.1		2,066.1	

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Захиалагчийн хяналтын зардал, НӨАТ ороогүй дүн	707,328.0	188,730.3	896,058.3	50,841.9	(68,443.3)	878,456.9	17,601.4
Захиалагчийн хяналтын зардал	12,853.4	5,297.6	18,151.0			18,151.0	
НӨАТ	72,018.1	19,402.8	91,420.9	5,084.2	(6,844.3)	89,660.8	1,760.1
БҮГД ДҮН	792,199.5	213,430.7	1,005,630.2	55,926.1	(75,287.6)	986,268.7	19,361.5

Эх сурвалж: Бодь интернэшнл ХХК

3.35. Олон Улсын инженерүүдийн холбооноос гаргасан фидик гэрээний загвар нь ялгаатай хуулийн зохицуулалт бүхий харилцааг зохицуулах зорилготой байхад фидик гэрээний “мөнгөлөг” загварыг ашиглан дотоодын аж ахуйн нэгж хооронд гэрээ байгуулахдаа зарим заалтыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжид нийцүүлээгүй зэргээс харахад гэрээг харилцан ашигтай байх нөхцөлөөр байгуулсан гэж үзэхээргүй байна. Тухайлбал,

Фидик гэрээний “мөнгөлөг” загварын үндсэн зарчимтай нийцээгүй:

- Гэрээний 13.2 дахь нөхцөлд гүйцэтгэгчийн санал болгосон инженерчлэлийн өөрчлөлтийн улмаас зардал хэмнэгдэж, гэрээний үнэд өөрчлөлт орох, хугацаанаас өмнө ажлын үр дүнг хүлээлгэн өгсөн гэх 2 тохиолдолд гүйцэтгэгч хэмнэгдсэн зардлын 50 хувийн урамшуулал авахаар заасан нь фидик гэрээний “мөнгөлөг” загварын “ажил гүйцэтгэгч бүх эрсдэлийг өөрөө хариуцах зарчмын дагуу гэрээний үнэд өөрчлөлт оруулахгүй байх” зарчимтай нийцээгүй;
- Загварын дагуу захиалагчийн төлбөр төлөх үүрэг нь гуравдагч этгээдээс хамааралтай байж болохгүй бөгөөд ийм тохиолдолд гэрээний загварыг хэрэглэхгүй байхыг зөвлөдөг боловч гуравласан гэрээ байгуулсан.

Захиалагч, гүйцэтгэгч хоорондын маргааныг шийдвэрлэх:

- Гэрээний 1.1.6.5-д “...энэхүү гэрээг байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Монгол Улсын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөгдөх дүрэм, журам болон Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулж тайлбарлана” гэж заасан боловч Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлыг санхүүжүүлэх гуравласан гэрээг олон улсын гэрээ гэж үзэхээргүй, Олон Улсын фидик гэрээний “мөнгөлөг” загварын дагуу англи-америкийн зохицуулалтыг авч хэрэглэх эсэх нь маргаан үүсгэхээр байна.

Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой:

- Олон Улсын фидик гэрээний “мөнгөлөг” загварын 8.7 дахь “гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ хугацаа хэтрүүлсэн тохиолдолд алданги төлөх” үүрэг Монгол Улсын Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6 дахь хэсэгт зааснаар зохицуулахаар байхад гэрээнд тусгаагүй нь үүргийн хэрэгжилтийг хугацаа хоцроох эрсдэл үүсгэсэн;
- Мөн дээрх гуравласан гэрээний 9.2-т заасан “хугацааг хэт удаашруулсан, хойшлуулсан” гэх ойлголт нь агуулгын хувьд тодорхойгүй хугацааг зааж байгаагаас маргаан үүсгэх магадлалтай байна.

Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн санхүүжилтээр 100 хувь гүйцэтгэсэн байна

3.36. Тавантолгой-Гашуунсухайтын төмөр зам нь Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэл I зэрэглэлийн 233.6 км урт гол замтай, нийт дэлгэмэл урт нь 324.5 км, 2 өртөө, 6 зөрлөгтэй, Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын нутгаар дайран өнгөрдөг, жилд 30.0-50.0 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай, өргөн царигтайгаар баригдсан байна.

3.37. БХБС-ын 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 211 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам”-ын Зам, тээврийн барилга байгууламжийн ангиллын 5.26-д “Төмөр зам, түүний барилга байгууламж, төмөр замын туннель”-ийг мөн л онцгой төвөгшилтэй барилга, байгууламжийн ангилалд хамрагдаж байна.

3.38. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн эхний ЕРС гэрээгээр Бодь интернэшнл ХХК ажиллаж дараах 6 багц ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд захиалагчаар Тавантолгой төмөр зам ХХК ажилласан байна. Үүнд:

- Дээд, доод бүтцийн барилга угсралт;
- Дохиолол холбоо;

3. Барилга угсралт;
4. Эрчим хүч;
5. Хөдлөх бүрэлдэхүүн;
6. Хөдлөх бүрэлдэхүүн засварын тоног төхөөрөмж.

3.39. Захиалагч гэрээний хугацааг EPC гэрээний нөхцөлийн 8.4-т “ажил дуусах хугацааг сунгах” хэсэгт зааснаар дараах байдлаар баталгаажуулсан байна. Үүнд:

- Гүйцэтгэгч Ажил гүйцэтгэх мастер төлөвлөгөөний шинэчилсэн хувилбарыг захиалагчид 2020.05.14-ний өдөр BI-TTGS-LTR-0546 дугаар албан бичгээр хүргүүлж, гүйцэтгэгч 2020.07.22-ны өдрийн TTZ-TTGS-REP-0060 дугаар санал бүхий албан бичгээр зөвшөөрч, гүйцэтгэгч саналыг тусган 2020.09.14-ний өдрийн BI-TTGS-LTR-1055 дугаартай албан бичгийг хүргүүлснээр мөрдөж эхэлсэн.
- Гүйцэтгэгч Ажил гүйцэтгэх мастер төлөвлөгөөний өөрчлөлтийн саналыг захиалагчид 2021.06.10-ны өдөр BI-TTGS-LTR-2136 дугаар албан бичгээр хүргүүлж, гүйцэтгэгч 2021.07.05-ны өдрийн TTZ-TTGS-REP-1/575 дугаар албан бичгээр гүйцэтгэгчид зөвшөөрчээ.

3.40. Талууд Ажил гүйцэтгэх мастер төлөвлөгөөний гүйцэтгэлийг 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн BI-TTGS-CLIENT ACT-001 дугаартай актаар дүгнэсэн байна.

Хүснэгт 45. Ажил дуусах хугацааг сунгаж, мастер төлөвлөгөөгөөр өөрчилсөн ажлын хуваарь

№	Барилгын ажил	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх TTZ-H19/01, TTGS-CONT-0001 дугаар гэрээгээр	№ BI--TTGS-WBS-0001-02 дугаартай Ажил гүйцэтгэх мастер төлөвлөгөө	TTZ-TTGS-REP-0060 Ажил гүйцэтгэх мастер төлөвлөгөө	BI-TTGS-LTR-2136 Ажил гүйцэтгэх мастер төлөвлөгөө	BI--TTGS-CLIENT ACT-001
		2019.10.29	2019.12.25	2020.07.22	2021.07.05	2022.7.01
		сар	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	Багц 1. Дээд, доод бүтцийн барилга угсралтын ажил	23	2019.11.01	2021.10.01	2019.12.01	2022.03.15
2	Багц 2. Дохиолол холбоо	23	2019.11.01	2021.10.01	2019.12.01	2022.02.01
3	Багц 3. Өртөө, зөрлөгийн барилга угсралт	22	2019.11.01	2021.09.01	2019.12.01	2021.12.01
4	Багц 4. Эрчим хүч хангамж	13	2019.11.01	2020.12.01	2019.12.01	2021.12.01
5	Багц 5. Хөдлөх бүрэлдэхүүн	32	2019.12.01	2022.08.01	2019.12.01	2022.03.01
	Зүтгүүр	32	2019.12.01	2022.08.01	2019.12.01	
	Вагон	31	2019.12.01	2022.07.01	2019.12.01	
6	Багц 6. Хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмж	32	2019.12.01	2021.11.01	2019.12.01	2021.10.01
					2021.11.01	2022.03.01
						2022.11.25

Эх сурвалж: Тавантолгой төмөр зам ХХК

3.41. МҮХАҮТ-аас Бодь интернэшнл ХХК-ийн 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн Давагдашгүй хүчин зүйл гэрчлүүлэх тухай BI-TTGS-LTR-2658 дугаар албан бичгээр хүргүүлсэн хүсэлтийн дагуу Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (Force majeure) мөн болохыг тодорхойлж, 2022 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 02/374 дугаартай гэрчилгээ олгосон байна.

Хүснэгт 46. Давагдашгүй хүчин зүйлийн ажлын хуваарьт нөлөөлсөн байдал

№	Ажлын нэр	Гэрээгээр тохиролцсон хугацаа	Давагдашгүй хүчин зүйлийн улмаас хойшилсон хугацаа	
			Огноо	Хоног
1	Багц 2. Дохиолол холбоо, шилэн кабель	2022.07.01	2022.12.01	153
2	Багц 3. Өртөө, зөрлөгийн барилга байгууламж	2022.06.01	2022.11.30	182
3	Багц 4. Эрчим хүч хангамж	2022.05.01	2022.08.25	116
4	Багц 5. Хөдлөх бүрэлдэхүүн	2023.04.30	2023.07.20	290
	Зүтгүүр		2023.08.10	102
	Вагон		2023.06.30	293
5	Багц 6. Хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмж	2022.03.01	2022.11.25	269

Эх сурвалж: МҮХАҮТ-ын гэрчилгээ

3.42. МҮХАҮТ-аас олгосон дээрх гэрчилгээнд “...дээр дурдсан 2023 оны 8 дугаар сарын 10-нд нийлүүлэгдэх нөхцөл байдал үүссэн нь зөвхөн одоогийн байдлаар мэдэгдэж байгаа хугацаа байх бөгөөд үүссэн нөхцөл байдал хэдий хүртэл үргэлжлэх нь тодорхойгүй, Тавантолгой төмөр зам ХХК-ийн өмнө ЕРС гэрээний дагуу Бодь интернэшнл ХХК-ийн зүтгүүр нийлүүлэх үүрэг хойшлогдож буй хугацаагаар биелэгдэх боломжгүй нөхцөл байдал бий болсон байна” гэж дурджээ.

Гүйцэтгэгчийн илчит тэрэг нийлүүлэх хугацаа давагдашгүй хүчин зүйлийн улмаас хойшилж, захиалагчид илчит тэрэг төлбөртэй ашиглуулж байна

3.43. Dong Myeong engineering consultants and architecture компанийн 2020 оны 4 дүгээр сард боловсруулсан ТЭЗҮ-ийн тодотголд тооцоноор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын шугамын тээх чадварыг хоногт 100 вагоной 12 хос галт тэрэг (ES44AC серийн хос зүтгүүртэй) аялна гэж үзвэл 31.68 сая тонн, хоногт 19 хос галт тэрэг аялуулж, жилд 330 хоног тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулна гэвэл 50.16 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай байхаар байна.

3.44. Жилийн тээх хүчин чадлыг 31.68 сая тонноор тооцоход Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн гол замд зүтгүүрийн эргэлт 15.6 цаг, хэрэгцээт зүтгүүр 9 хос буюу 18 зүтгүүр, нөөц 2 зүтгүүр, харин Гашуунсухайт-Ганцмод хооронд зүтгүүрийн эргэлтийг 4 цагаар тооцон 2 хос 4 зүтгүүр, сэлгээний 2, нийт 26 гол замын болон сэлгээний зүтгүүр, $1,526 ((\text{нийт хэрэгцээт вагоны тоо})=12 \times 100=1,200 \times 1.2 (\text{вагон эргэлтийн хоног } 1.2)=1,440 \times 1.06 (\text{вагоны нөөцийн хэмжээ})=1,526)$ вагон тус тус шаардлагатай гэж тооцсон байна.

3.45. Харин Тавантолгой төмөр зам ХХК болон Бодь интернэшнл ХХК хооронд байгуулсан 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн Багц-5 дахь ажлын гэрээнд гэрээнд зааснаар хөдлөх бүрэлдэхүүнд АНУ-ын Progress Rail Locomotive компанид үйлдвэрлэсэн SD-70Ace/Lw загварын 16 зүтгүүр, ОХУ-ын Тихвины үйлдвэрт үйлдвэрлэсэн 810 вагон (12-9853, 13-6724, 13-6851, 11-6878) багтаж байна.

3.46. Захиалагч нийлүүлэх вагоны төрлийг 2021 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 1/736 дугаар албан бичгээр гүйцэтгэгчид нэр төрөл, загварыг хүргүүлж, баталгаажуулсан байна.

3.47. Талуудын давагдашгүй хүчин зүйлийн улмаас хойшилсон хугацаагаар 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр баталгаажуулсан TTZ-TTGS-CLIENT ACT-004 дугаартай актаар зүтгүүр нийлүүлэх хугацааг 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, TTZ-TTGS-CLIENT ACT-001 дугаартай актаар вагон нийлүүлэх хугацааг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр болгон тус тус шинэчлэн тогтоож, 2023 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 710 вагон нийлүүлэгдсэн байна.

3.48. Бодь интернэшнл ХХК-аас ирүүлсэн мэдээллээр “зүтгүүрийн зураг төсөл, эд анги болон бусад материалын нийлүүлэлт, татан авалт 100 хувь хийгдэж, үйлдвэрлэлийн явцын мэдээллээр 3 ширхэг зүтгүүр эцсийн угсралтад буюу 80.0 хувийн гүйцэтгэлтэй, 6 ширхэг зүтгүүрийн үндсэн рамын угсрагдаж, 70.0 хувийн гүйцэтгэлтэй, үлдсэн 7 зүтгүүрийн рам угсралтын өмнөх шатанд буюу 60.0 хувийн гүйцэтгэлтэй” байна.

Хүснэгт 47. Бодь интернэшнл ХХК-ийн нийлүүлсэн вагоны нэр төрөл, тоо

№	Вагоны нэр төрөл	Загвар	Хэмжих нэгж	Вагоны тоо	Тайлбар
				Нийлүүлэх	Нийлүүлсэн
1	Битүү вагон	11-6874	ширхэг	8	8

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2	Хагас вагон	12-9853	ширхэг	400	300	100	Үйлдвэрлэл дуусаж, тээвэрлэлт хийгдэж байна
3	Тавцант вагон	13-6851-01	ширхэг	390	390		
		13-6851-02	ширхэг	11	11		
4	Зорчигчийн вагон	61-4527	ширхэг	1	1		
Нийт дүн				810	710	100	

Эх сурвалж: Тавантолгой төмөр зам ХХК

3.49. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажил дуусаж, үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн ч дээрх шалтгааны улмаас зүтгүүрүүд нийлүүлэгдээгүйгээс УБТЗ ХНН, Бодь интернэшнл ХХК-ийн зүтгүүрүүдээр тээвэрлэлт хийж, түрээсийн төлбөрт 2022 оны 7 дугаар сараас 2023 оны 6 дугаар сарын хооронд 2,215.9 сая төгрөгийг төлсөн байна.

Хүснэгт 48. Тавантолгой төмөр зам ХХК-ийн илчит тэрэг түрээсэлсэн зардлын дэлгэрэнгүй, сая төгрөгөө

№	Хугацаа сараар	Ажилласан хоног	Илчит тэрэг нийт тоо	Хоногийн тариф	Гэрээгээр төлөх түрээсийн төлбөр	Үүнээс:				Нийт зардал	Үүнээс илчит тэргэнд зарцуулсан зардал
						Ажиллаагүй хоног	Ажиллаагүй хугацаанд ногдох зардал	Зам ашигласны төлбөр	Сэлбэг, тос тосолгооны материалын зардал		
1	2022.07	9	2	5.42	97.6					97.6	97.6
2	2022.08	31	2	5.42	336.1	4.6	49.7	13.8	6.6	306.8	293.0
3	2022.09	30	2	5.58	335.0				8.6	343.6	343.6
4	2022.10	32	1	5.96	190.8	0.3	2.0		7.7	196.5	196.5
5	2022.11	29	1	4.54	131.6	1.1	5.3		3.8	130.1	130.1
6	2022.12	31	1	4.24	131.4	0.7	2.9		2.0	130.5	130.5
7	2023.01	31	1	4.24	131.4	2.3	9.9		1.4	122.9	122.9
8	2023.02	28	1	4.24	118.7	2.8	11.7	13.5	0.8	121.3	107.8
9	2023.03	29	1	4.24	123.0	0.7	2.9		0.9	121.0	121.0
10	2023.04	25	1	4.24	106.0	1.0	4.4	13.6	0.7	115.9	102.3
11	2023.05	31	1	4.24	131.4	2.3	9.9	12.4	2.7	136.6	124.2
12		10	1	8.64	86.4	0.9	7.8			78.6	78.6
13	2023.06	26	1	4.24	110.2	0.2	0.7		3.3	112.8	112.8
14		30	1	8.64	259.3	0.5	4.3			255.0	255.0
Нийт дүн		372	17		2,288.9	21.9	111.5	53.3	38.5	2,269.2	2,215.9

Эх сурвалж: Тавантолгой төмөр зам ХХК

3.50. Түлхүүр гардуулах төслийн инженеринг, худалдан авалт болон барилгын ЕФС гэрээний нөхцөлийн 8.7 дахь “Хугацаа хожимдуулсны хохирол хэсэгт, хэрэв Гүйцэтгэгч 8.2 [Ажил дуусгах хугацаа] дахь хэсгийг биелүүлж чадаагүй бол 2.5 [Захиалагчийн нэхэмжлэл] дахь хэсэгт заасны дагуу хугацаа хожимдуулсны хохирлыг Гүйцэтгэгч энэхүү зөрчил гаргасны улмаас Захиалагчид төлнө. Ийнхүү төлөх хугацаа хожимдуулсны хохирол Тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн байх бөгөөд түүнийг Ажил дуусгах хугацаа болон Ажил хүлээн авсан гэрчилгээнд заасан өдрийн хоорондох хугацааны хоцорсон хоног тутам ногдуулна. Гэхдээ, энэхүү хэсгийн дагуу төлөх нийт дүн нь Тусгай нөхцөлд заасан хугацаа хожимдуулсны хохирол (хэрэв байгаа бол)-ын дүнгийн дээд хэмжээнээс хэтрэхгүй” гэж заасан байна.

3.51. Хугацаа хожимдуулсны хохирлыг Гүйцэтгэгчийн зөвхөн дээр дурдсан зөрчлийн улмаас ногдуулах бөгөөд гэрээг Ажил дуусгахаас өмнө 15.2 [Захиалагч дуусгавар болгох] дахь хэсэгт заасны дагуу дуусгавар болгох тохиолдол үүнд хамаарахгүй. Эдгээр хохирол нь Гүйцэтгэгчийг Ажил дуусгах, гэрээний дагуу түүний хүлээж болох бусад үүрэг, болон хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж тус заасан байна.

3.52. Гэтэл Тавантолгой төмөр зам ХХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх ТТЗ-Н19/01, ВІ-ТТGS-CONT-0001 дугаартай гэрээний 2.(ІІ) Гэрээний тусгай нөхцөл 8.7 Хугацаа хэтэрсний хохирол. Гэрээний ерөнхий нөхцөлийн энэ хэсгийг хэрэглэхгүй гэж заасан нь Захиалагчтай алданги тооцох боломжгүй болгосон байна.

3.53. Энэ нь Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6-д “Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ”, 232.7-д “Үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд анз төлөхөөр гэрээнд

заагаагүй бол үүрэг гүйцэтгүүлэгч анз шаардах эрхгүй бөгөөд харин учирсан хохирлоо арилгуулахыг шаардах эрхтэй” гэж заасны дагуу Захиалагч гүйцэтгэгчээс болон УБТЗ ХНН-ээс зүтгүүр түрээсэн тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж, зүтгүүр түрээсийн зардал байгаа энэ хуулийн дээрх заалттай нийцэхгүй байна.

Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах гүйцэтгэгчийг хэрхэн сонгосон нь тодорхойгүй, боловсруулсан ТЭЗҮ-ийг хуульд заасны дагуу баталгаажуулаагүй байна

3.54. Тавантолгой төмөр зам ХХК Соёолон интернэшнл ХХК-ийн хооронд 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдөр СБ-01/29/02 дугаартай харилцан ойлголцлын санамж бичгийг:

- Түүхий нүүрс ачих нэгдсэн төвийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг Соёолон интернэшнл ХХК-д шилжүүлэх, мэдээлэл, чиглэл өгөх;
- Соёолон интернэшнл ХХК нь ажлын даалгавар болон тус компаниас ирүүлсэн мэдээлэл, чиглэлд үндэслэн Тавантолгойн нүүрс ачих нэгдсэн төвийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай суурь судалгаа, бэлтгэл ажлыг хийхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор байгуулжээ.

3.55. Тавантолгой төмөр зам ХХК Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн ТЭЗҮ, БОННУ боловсруулан мэргэжлийн байгууллагаар батлуулах “Ажил” гүйцэтгэх АГГ-01/33/10 дугаартай 1,378.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2021 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр Соёолон инженеринг ХХК-тай байгуулж, гэрээнд ажил гүйцэтгэх хугацааг гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш ТЭЗҮ болон БОННУ-г холбогдох байгууллагаар батлуулж, хүлээлгэн өгөх хүртэл байхаар, мөн өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан гэрээний үнийн 60.0 хувь буюу 826.9 сая төгрөгийг урьдчилгаа төлбөр болгон олгохоор заасан байна.

3.56. Дээрх АГГ-01/33/10 дугаартай гэрээнд 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж байгуулахдаа гэрээний үнийг 192.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нэмэгдсэн дүнгийн 65.0 хувь болох 124.4 сая төгрөгийг нэмж урьдчилгаа болгон олгохоор зааж, гэрээний хугацааг үндсэн гэрээнд зааснаар, харин Гүйцэтгэгчийн боловсруулсан ТЭЗҮ нь мэргэжлийн байгууллагаар батлуулах шаардлагыг бүрэн хангасан, холбогдох тоо хэмжээ, тооцоо судалгааг хавсаргасан байх ба Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны 01/2779 дугаартай албан бичигт заасан ажлын цар хүрээнд гүйцэтгэх гэсэн нөхцөлийг нэмж тусгасан байна.

3.57. Гэрээний төрлийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.11³¹-д заасан “ажил гүйцэтгэх” нөхцөлтэй байгуулсан нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.15³², Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29³³-т заасантай нийцэхгүй байна.

3.58. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн ТЭЗҮ, БОННУ боловсруулах гэрээг Соёолон инженеринг ХХК-тай сонгон шалгаруулалтгүйгээр байгуулахдаа Соёолон интернэшнл ХХК-тай гэрээ байгуулах харилцааг санамж бичгээр урьдчилан баталгаажуулсан, гэрээний үнийг хэрхэн тооцсон нь тодорхойгүй зэргээс харахад энэ нь Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3³⁴, 3.1.4³⁵-т зааснаар албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгосон байж болзошгүй байна.

³¹ ажил гэж барилга байгууламжийн ажил, барилгын тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил, түүнчлэн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа нийлүүлэлтийг...

³² зөвлөх үйлчилгээ гэж гүйцэтгэгчээс төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг

³³ зөвлөх үйлчилгээ гэж барилгын үе шатны ажил гүйцэтгэх, норм, нормативын баримт бичиг боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн сонголт, механик-автоматжуулалт, тохируулга, зүгшрүүлэх, чанар аюулгүй байдлын түвшин, төлөв байдлыг тогтооход шаардлагатай мэргэжил, тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг

³⁴ албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг

³⁵ давуу байдал гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг

3.59. Мөн дээрх гэрээний үр дүнд багтаан бэлтгэсэн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн ТЭЗҮ-д Эрдэс, баялгийн мэргэжлийн зөвлөл Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.9³⁶-д заасныг зөрчин 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Т/21-16-07 дугаартай дүгнэлт гаргаж, уг дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн Т/11 дүгээр тушаалаар Барилга, байгууламжийн ажлын ТЭЗҮ-ийг Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4³⁷ дэх буюу огт хамааралгүй буюу ашигт малтмалын орд газар хайгуулын ТЭЗҮ хийх, шинжээч томилж, ТЭЗҮ-д 90 хоногийн дотор дүгнэлт гаргуулж ашигт малтмалын нөөцийг бүртгэх заалтаар хууль зөрчиж хүлээн авсан байна.

3.60. Иймд Соёолон инженеринг ХХК-ийн боловсруулсан Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн ТЭЗҮ, БОННУ-ний хувьд Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.1³⁸, 25.2.2³⁹, 25.2.3⁴⁰, 25.2.4⁴¹-т заасны дагуу магадлал хийх зураг төслийг жагсаалтад багтсан, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.4⁴²-т магадлал хийлгээгүй бол барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгохыг хориглосон байхад магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй байна.

3.61. Соёолон инженеринг ХХК-тай байгуулсан гэрээний нийт дүн 1,570.7 сая төгрөг бөгөөд уг ажлын санхүүжилтэд Эрдэнэс-Тавантолгой ХК-аас 2021 онд 2,221.7 сая төгрөгийг олгосон байна. Иймд аудитаар Эрдэнэс-Тавантолгой ХК-аас олгосон санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 651.0 сая төгрөгийг санхүүжүүлэгч компанид буцаан төвлөрүүлж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дүнг бууруулах төлбөрийн акт тогтоолоо.

Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн ажлыг техник, эдийн засгийн үндэслэлийн дүнгээр баталгаажсан зураг төсөвгүйгээр эхлүүлсэн байна

3.62. Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн “Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай 89 дүгээр тогтоолоор:



1-д Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулан хянан баталгаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, барилгын ажлыг 2021 оны II улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг УУХҮС, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-д, барьж байгуулах ажиллагаа нь төмөр замын хөдөлгөөний болон техникийн аюулгүй ажиллагаа, барилга байгууламжийн технологийн горим, стандарт, шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг ЗТХС, БХБС-д;

2-т Гашуунсухайт-Ганцмод төмөр замын боомтын хил нэвтрэх цэг, шилжүүлэн ачих байгууламжийг барих асуудлаар Хятадын талтай 2021 оны 4 дүгээр сард багтаан тохиролцох, уг боомтын асуудлыг “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-т энэ онд багтаан нэмж тусгах арга хэмжээ авахыг ГХС, ЗТХС-д;

³⁶ Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайлан, ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-д дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий ...

³⁷ Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 48.3-т заасан тайлан, 48.6.1-д заасан техник-эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилуулж, 90 хоногт багтаан хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана. 48.3-т хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайланг ашигт малтмал эрэх, хайх үйл ажиллагааны журам, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалд нийцүүлэн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргуулан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө. 48.6-д ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь мэдээ, тайланг дор дурдсан хугацаанд төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:

48.6.1.тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор;

³⁸ газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт

³⁹ газар хөдлөлтийн долоогоос доош баллын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөвт

⁴⁰ барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд

⁴¹ инженер-геологийн дүгнэлт, геодезийн зураглалд

⁴² Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно.

3-т Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв (салбар төмөр, ачих байгууламж)-ийг ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжүүлэхээр тооцож, тус компанийн хөрөнгөд бүртгүүлэх арга хэмжээ авахыг УУХҮС, ТӨБЗГ, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-д;

4-т Нүүрс ачих байгууламж, боомтын төмөр замын барилгын ажилд шаардлагатай орон нутгаас олгох зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу тухай бүр нь шуурхай олгож ажиллахыг Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус үүрэг болгосон байна.



3.63. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн “Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв байгуулах тухай”

20 дугаар тогтоолоор:

1-д төвийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, хянан баталгаажуулах, магадлуулах, барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хүлээлгэн өгөх ажлыг төмөр замын тусгай зөвшөөрөл бүхий өөрийн охин компани болох Тавантолгой төмөр зам ХХК-аар үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах гэрээ, хэлцлийг хууль тогтоомжид нийцүүлэн байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Удаанжаргал)-д даалгасан.

2-т Компанийн 2021 оны хөрөнгө оруулалтын төсвөөр батлагдсан Төмөр замын нүүрс ачих байгууламж буюу Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвд төсөвлөсөн 217.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг холбогдох гэрээний дагуу Тавантолгой төмөр зам ХХК-д үе шаттай шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Ганхуяа)-д зөвшөөрсөн.

3-т Энэ тогтоолын 1-д заасан ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн 2022 оны II улиралд багтаан гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Н.Удаанжаргал)-д даалгасан.

4-т Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг ТУЗ-ын Аудитын хороо (Ү.Амарбат)-нд даалгасан байна.



3.64. УУХҮС-аас хүргүүлсэн 2021 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн хуралд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч гишүүдийн баримтлах 21/14 дугаартай удирдамжаар “...төмөр замд нүүрс ачилтын байгууламж байгуулах тухай асуудлыг холбогдох хууль, тогтоомж, тооцоо судалгаанд нийцүүлэн судалж, хэлэлцэн шийдвэрлэх”-ийг даалгажээ.

3.65. Бодь интернэшнл ХХК нь 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр BI-TCTS-LTR-1797 дугаар албан бичгээр “Тавантолгой нүүрс ачилтын логиستيкийн төв”-ийн бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгчээр ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байна.



3.66. Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаартай тэмдэглэлээр:

1-д Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийн эхний үе шатыг 2022 оны эхний хагаст багтаан ашиглалтад оруулах, ... тус төвийн ерөнхий гүйцэтгэгч Бодь интернэшнл ХХК-аар гүйцэтгүүлэхээр захирлын зөвлөлийн гишүүд санал нэгтэй дэмжиж, шийдвэрлэв.

2-т Тус төсөл нь Засгийн газрын 2019 оны 196 дугаар тогтоолын дагуу төрийн нууцад хамаарах эсэх талаар дүгнэлт гаргуулахыг Төслийн удирдлага хариуцсан дэд даргад даалгав.

3-т Тагнуулын байгууллагаар төрийн нууцад хамаарсан гэж үзвэл холбогдох хуулийн дагуу гэрээ байгуулахыг гишүүд санал нэгтгэжээ тогтов.

4-т Төрийн нууцад орохгүй бол ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа удирдлага хариуцсан дэд захиралд даалгав.

5-д Энэхүү шийдвэр гарсантай холбогдуулан Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийн ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах асуудлыг ТУЗ-д танилцуулан шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж захирлын зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэлээ гэжээ.



3.67. Тавантолгой төмөр зам ХХК-аас 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдөр “Хүсэлт хүргүүлэх тухай” Н/2004 дугаартай албан бичгийг ТЕГ-т хүргүүлсэн байна. Албан бичигт “...Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын салшгүй нэг хэсэг болох Нүүрс ачих байгууламжийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах зэрэг ажил нь төрийн нууцад хамаарах эсэх талаар дүгнэлт ирүүлэхийг хүсээд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн I зэрэглэлийн төмөр замын Ерөнхий гүйцэтгэгч болох Бодь интернэшнл ХХК-аар гүйцэтгүүлэх нь үр дүнтэй” гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байна.



3.68. Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн “гэрээ байгуулах эрх олгох тухай” 15 дугаар тогтоолоор:

- 1-д Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, хянан баталгаажуулах, магадлуулах, хүлээлгэн өгөх гэрээг Эрдэнэс Тавантолгой ХК-тай байгуулахыг;
- 2-т Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 20 дугаар тогтоолын 2-т заасан санхүүжилтээр Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв (салбар төмөр, ачих байгууламж)-ийн зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээг гүйцэтгэгч компанитай байгуулахыг тус тус Гүйцэтгэх захирал (Н.Удаанжаргал)-д зөвшөөрсөн;
- 3-т Төвийн ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн 2022 оны II улиралд багтаан гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Н.Удаанжаргал)-д даалгасан;
- 4-т Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, тухай бүр нь танилцуулж ажиллахыг Аудитын хороонд даалгасан байна.



3.69. Тавантолгой төмөр зам ХХК-д ТЕГ-аас 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдөр “Зөвлөмж хүргүүлэх тухай” 1113 дугаартай албан бичгээр “Тавантолгой нүүрс ачих логиستيкийн төвийн барилга байгууламж барих төслийн ажил нь “үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил...”-д хамаарна. Иймд Тавантолгой нүүрс ачих логиستيкийн төвийн барилга байгууламжийг барих төслийн ажилтай холбоотой худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасны дагуу зохион байгуулах боломжтой” гэсэн байна.

3.70. Тавантолгой төмөр зам ХХК Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх ТТЗ-МН22/04, ВІ-NANT-CONT-0001 дугаартай гэрээний ерөнхий хэлэлцээрийг 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Бодь интернэшнл ХХК-тай хийж, 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

3.71. Бодь интернэшнл ХХК нь Тавантолгой нүүрс ачилтын логиستيкийн төвийн бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгчээр ажиллах сонирхолтой байгаагаа 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр илэрхийлж, захиалагч болох Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар дээрх ажлыг Бодь интернэшнл ХХК-аар гүйцэтгүүлэхээр захирлын зөвлөлийн гишүүд санал нэгтэй дэмжиж, шийдвэрлэсэн байна.

3.72. Мөн хуралдаанаар төслийг Засгийн газрын 2019 оны 196 дугаар тогтоолын дагуу төрийн нууцад хамаарах эсэх талаар дүгнэлт гаргуулахыг Төслийн удирдлага хариуцсан дэд даргад даалгаж, хүсэлтийг 2021 оны 6 дугаар сарын 21-нд ТЕГ-т хүргүүлж, 2021 оны 8 дугаар сарын 16-нд хариу ирсэн байхад Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 15 дугаар тогтоолоор Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 20 дугаар тогтоолын 2-т заасан санхүүжилтээр Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв (салбар төмөр, ачих байгууламж)-ийн зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээг гүйцэтгэгч компанитай байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Удаанжаргал)-д зөвшөөрсөн байна.

3.73. Соёолон инженеринг ХХК-ийн боловсруулсан Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн ТЭЗҮ-ээр тоног төхөөрөмжийн үнийг нийлүүлэгчээс ирүүлсэн үнийн саналыг тээвэрлэлтийн зардал 10.0 хувь, гаалийн татвар 5.5 хувиар нэмэгдүүлэн, барилга, байгууламжийн угсралтын зардлыг төсөв бодох аргачлалын дагуу, цахилгаан хангамжийн өртгийг 2020 оны жишиг үнийн дагуу, төслийн магадалшгүй ажлын зардлыг онцгой төвөгшилтэй объект гэж үзээд төсөвт зохиох шинэчилсэн дүрмээр 10 хүртэл хувиар тооцно гэж заасны дагуу 8.0 хувиар, тоног төхөөрөмж угсралт суурилуулалтын зардлыг цар тахлаас улбаалсан үнийн өсөлтийг харгалзан төхөөрөмжийн үнийн 20.0

хувь байхаар тус тус тооцсон гэж тэмдэглэжээ. ТЭЗҮ-д төслийн эхний шатны хөрөнгө оруулалтыг хэрхэн тооцсоныг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 49. Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн хөрөнгө оруулалтын зардлын ангилал, сая нэгж

№	Зардлын нэр, төрөл	Мөнгөн дүн	
		Ам.доллар	Төгрөг
1	Тоног төхөөрөмж	56.1	160,006.1
2	Угсралт, суурилуулалтын зардал	10.7	30,606.3
3	Барилга байгууламж	7.1	20,119.3
4	Цахилгаан, автоматжуулалт	6.4	18,167.3
5	Зураг төсөл, ТЭЗҮ, БОНҮ	2.2	6,270.0
6	Магадалшгүй ажлын зардал 8 хувь	6.6	18,813.5
Өртгийн дүн		89.1	253,982.4
7	ЕРС гэрээний менежмент	8.9	25,398.6
8	Захиалагчийн хяналт 2 хувь	2.0	5,587.6
9	НӨАТ	10.0	28,496.8
НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		110.0	313,465.5

Эх сурвалж: Тавантолгой төмөр зам ХХК

3.74. Соёолон инженеринг ХХК-ийн 2022 оны 2 дугаар сард боловсруулж, хүлээлгэн өгсөн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрс ачилтын логиستيкийн төвийн ТЭЗҮ-ийг эх сурвалж болгон тооцсон гэрээ байгуулсан үнийг (LUMP SUM) хүснэгтээр харуулбал, (гэрээгээр гүйцэтгэх ажлын өртгийн задаргааг хавсралт 9-өөс харна уу)

Хүснэгт 50. Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн гэрээгээр гүйцэтгүүлсэн зардлын ангилал, сая нэгж

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн, НӨАТ-тай	
		Ам.доллар	Төгрөг
1	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын өртөг	107.0	304,829.3
2	ТЭЗҮ, БОННУ	0.8	2,221.7
3	Захиалагчийн хяналтын зардал	2.2	6,141.0
НИЙТ ДҮН		109.9	313,192.0

Эх сурвалж: Тавантолгой төмөр зам ХХК

3.75. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.16-д “түлхүүр гардуулах гэрээ гэж барилга байгууламжийн зураг төсөл, инженерийн тооцоо, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбогдсон хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн ажил, бараа, үйлчилгээг бүхэлд нь хамарсан нэг гэрээг хэлнэ” гэж заасан байхад Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТҮЗ-ийн 2021 оны 20 дугаар тогтоолын 2-т заасан санхүүжилтийн 217.5 тэрбум төгрөгийг ямар зураг төсөл, төсөвт үндэслэж Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн барилга байгууламжийн зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий хэлэлцээр байгуулсан нь тодорхойгүй байна.

3.76. Энэ нь Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30-д “зураг төсөл гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг”; 7 дугаар зүйлийн 7.4-д “Барилга байгууламжийн зураг төсөл, байр зүйн дэвсгэр зураг зэрэг мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байна” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэлгүйгээр гэрээ байгуулжээ.

3.77. Мөн Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д Барилгын зураг төсөл дараахь шаардлагыг хангасан байна: Үүнд: 12.1.1-д “эрх бүхий байгууллагаас олгосон

газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх”, 12.1.3-т “барилга байгууламжаас хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэх дуу чимээ, доргио, утаа, хорт хий, өндөр үелзлэл, хог хаягдал, цацраг идэвхт бодис, хөрсний бохирдол зэргээс хамгаалагдсан байх”, 12.1.5-д “хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг техникийн болон галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн, гамшиг, аюулт үзэгдлийн үед нүүлгэн шилжүүлэх нөхцөлийг хангасан байх”; 12.1.7-д “барилгын ажилд аюулгүй ажиллагааг хангах хөдөлмөр зохион байгуулалтын зураг боловсруулсан байх” гэсэн шаадлагыг хангаж боловсруулсан эсэх нь нотлогдохгүй байна.

3.78. Аудитаар ажил нь дууссан Тавантолгойн нүүрс ачилтын логистикийн төв барих төслийн магадалшгүй ажлын 13.4 тэрбум төгрөгийн зардлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу баталгаажуулаагүй, зардлын үлдэгдэл болох 5.4 тэрбум төгрөгийг акт, баримтгүйгээр олгосон зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын ажлыг байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгүйгээр гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн нь байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах боломжийг хязгаарласан байна



3.79. Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн “Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай” 112 дугаар тогтоолоор:

- 1-д Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр холбох төмөр замын шугамын чигийг хавсралтаар баталсан.
- 2-т Энэ тогтоолоор баталсан төмөр замын шугамын чигийг газрын кадастрын улсын мэдээллийн санд бүртгэхийг ГЗБГЗЗГ-т даалгасан.
- 3-т Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2019 оны 232 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Тавантолгойн уурхайгаас Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян баг хүртэлх чиглэлийн төмөр замын шугамын чигийн “-22” дахь км-ээс “-1” дэх км хүртэлх солбицлыг хүчингүй болсонд тооцож шийдвэрлэсэн байна.



3.80. Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн “Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай” 113 дугаар тогтоолоор:

- 1-д Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын барилгын ажлын зөвшөөрлийг Тавантолгой төмөр зам ХХК-д олгосон.
- 2-т Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгээсний үндсэн дээр барилгын ажлыг 2020 онд багтаан эхлүүлэх арга хэмжээ авахыг ЗТХС, УУХҮС-д;
- 3-т Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын зураг төсөл боловсруулах, суурь бүтцийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-д;
- 4-т Төмөр замын инженерийн байгууламж, эрчим хүч, усан хангамж, өртөө, зөрлөг, дохиолол холбоо, мэдээллийн болон бусад барилга байгууламж барихтай холбоотой орон нутгаас зайлшгүй олгох зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу тухай бүр нь шуурхай олгож ажиллахыг Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус даалгаж, үүрэг болгосон байна.

3.81. Тавантолгой төмөр зам ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр зам”-ын ТЭЗҮ боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан байна. Ажлын хэсгийн боловсруулсан ТЭЗҮ-ээр:



- ✓ Төмөр замын доод бүтэц, гүүр, хоолойн төсвийг 1:3000 масштабтай дэвсгэр зураг, 1:200 хөндлөн огтлолын зургийг үндэслэн авто замын төсөв тооцдог RBC ESTIMATOR программ хангамж ашиглан боловсруулсан.
- ✓ Төмөр замын дээд бүтцийн төсвийг төсөв зохиох норм боловсруулах ажлын хэсгийн судалгааг ашигласан бөгөөд 1 ширхэг бетон дэрний үнийг 145,000.0 төгрөг, 1 тонн зам төмрийг 2,565,000.00 төгрөгөөр тооцсон.
- ✓ Төслийн нийт хөрөнгө оруулалт 229.6 тэрбум төгрөг. Үүнээс төсөлтэй холбоотойгоор авто замын чиг өөрчлөх ажилд 10.3 тэрбум, хөдлөх бүрэлдэхүүн авахад 50.4 тэрбум төгрөг.
- ✓ Нийт төслийн төмөр замын дэлгэмэл урт 27.3 км, 1 км замын өртөг 5.97 тэрбум төгрөг, үүнийг ам.долларт шилжүүлбэл 1.88 сая доллар (2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн ханш 2,849.26 төгрөг/ам.доллар) гэсэн байна.

Хүснэгт 51. Холболтын төмөр замын ТЭЗҮ-д заасан хөрөнгө оруулалтын зардал, сая төгрөг

№	Зардлын зүйлс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт дүн
1	Зураг, төслийн ажил			2,857.2
1.1	ТЭЗҮ боловсруулах			432.1
1.2	Нарийвчилсан зураг, төсөл			2,425.1
2	БОННУ, геодези, гидрогеологи, геологи			308.0
3	Төмөр замын доод бүтцийн ажил	км	27.3	18,979.1
4	Төмөр замын дээд бүтцийн ажил	км	27.3	60,501.7
5	Төмөр бетон гүүр	ширхэг	3	6,388.2
6	Хоолойн ажил	ширхэг	26	7,787.9
7	Авто зам барих	км	1.874	10,263.7
8	Дохиолол, холбоо, шилэн кабелийн ажил	багц	1	12,530.2
9	Эрчим хүч гэрэлтүүлгийн ажил	багц	1	4,804.4
10	Хөдлөх бүрэлдэхүүн			56,350.0
11	Барилга угсралтын ажлын нийт дүн			180,770.4
12	ЕРС гэрээний удирдлага, менежментийн зардал			1,952.7
13	Магадалшгүй ажлын зардал			5,400.9
14	Ерөнхий гүйцэтгэгчийн ашиг	хувь	10	18,033.8
15	Барилга угсралтын ажлын дүн (11+12+13+14)			206,157.9
16	НӨАТ			19,478.3
17	ЕРС Захиалагчийн хяналтын зардал+НӨАТ	хувь	2	3,976.9
НИЙТ ДҮН				229,613.1

Эх сурвалж: Тавантолгой төмөр зам ХХК



3.82. ЗТХС, УУХҮС нарын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн “Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” А/217/А-293 дугаар тушаалаар:

- 1-д Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Тавантолгой төмөр зам ХХК (Н.Удаанжаргал)-д үүрэг болгосон байна. Үүнд:
 - 1.1 Суурь бүтцүүдийг холбох төмөр замын ТЭЗҮ, БОНУ боловсруулан холбогдох байгууллагаар батлуулсны үндсэн дээр санхүүжилтийг батлуулах;
 - 1.2 Суурь бүтцүүдийг холбох төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж эрх бүхий байгууллагаар магадлуулах;
 - 1.3 Суурь бүтцүүдийг холбох төмөр замын барилгын ажлыг магадлуулсан зураг төсөлд үндэслэн 2020 онд эхлүүлэх ажлыг зохион байгуулах;
 - 1.4 Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ТЕГ-ын 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 01/208 дугаартай албан бичгийг үндэслэн зохион байгуулах;
- 2-т Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах ажилд Авто зам болон төмөр замын огтлолцлын түвшинг тодорхойлох, техникийн нөхцөлд дэмжлэг үзүүлж ажиллахыг ЗТХЯ-ны Авто замын бодлогыг хэрэгжүүлэх газарт;
- 3-т Энэхүү суурь бүтцүүдийг холбох төмөр замын чигийн дагуух ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлэх, тус чиглэлийн төмөр замын зурвас газрын хэмжээг Засгийн газраар тогтоох хүртэлх хугацаанд сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгохгүй байх, бичил уурхайн зориулалтаар болон түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талаар дүгнэлт гаргахгүй байхыг АМГТГ-т;

- 4-т Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын судалгааг боловсруулахтай холбогдуулан шаардлагатай тооцоо судалгаа, мэдээллээр хангаж ажиллахыг Эрдэнэс-Тавантолгой ХК, Монголын төмөр зам ТӨХК-д;
- 5-д Төслийн барилга угсралтын ажлыг 2020 онд багтаан эхлүүлж, 2021 онд ашиглалтад оруулахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-д;
- 6-д Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газарт, УУХҮЯ-ны Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосон байна.

3.83. ЗТХТ ТӨҮГ Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэсэн “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холболтын төмөр замын ТЭЗҮ-ийн судалгааны ажлын тайланг 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 06/2021 дүгнэлтээр магадалсан байна.

3.84. Барилгын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-д “Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ”, 39.5-д “Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ” БХБС-ын 2019 оны 213 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам”-ын 7.2-д “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээд нь тухайн зураг төсөлд өөрийн холбогдох хэсэгт магадлалын холбоотой зөрчилд мэргэжлийн хариуцлага хүлээнэ”, 7.3-д “Экспертийн эрх бүхий иргэн нь тухайн зураг төслийн өөрт холбогдох хэсгийн магадлалын дүгнэлтэд, хуулийн этгээд нь иж бүрэн зураг төслийн магадлалын дүгнэлтэд мэргэжлийн хариуцлага хүлээнэ” гэж тус тус заасан байна.

3.85. ЗТХТ-ийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Экспертийн ажлын хэсэг томилох тухай А/138 дугаар тушаалаар Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын ТЭЗҮ-ийн тайланд магадлалын ажил гүйцэтгэх экспертийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн болох Г.Вандандагва /Төмөр зам, замын байгууламжийн зураг төсөлд/ Д.Гэрэлмаа, Г.Хоролмаа нар /Байгаль орчны үнэлгээний тайланд/ экспертийн дүгнэлт гаргасан байна. Үүнээс Д.Гэрэлмаа, нь ЗТХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Г.Хоролмаа нь БОАЖЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн байна.

3.86. Хөндлөнгийн хараат бус шинжээчийн гаргах дүгнэлтийг төрийн захиргааны төв байгууллагын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий албан хаагч гаргасан нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-д “албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах”, 37.1.17-д “үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх”, 38.1.7-д “хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх зэргээр орлого олох”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана”, 18.5.3-д “ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг”. гэж заасныг тус тус зөрчиж байгаагаас гадна гүүр, хоолой,

дохиолол, холбоо, шилэн кабель, эрчим хүч, гэрэлтүүлэг, хөдлөх бүрэлдэхүүн, автозам барих зэрэгт хэрхэн экспертийн дүгнэлт гаргасан нь тодорхойгүй байна.

3.87. ЗТХЯ-ны ШУТЗ-ийн 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 01 дүгээр хурлаас:

1-д Тавантолгой төмөр зам ХХК-ийн боловсруулсан ЗТХТ ТӨҮГ-ын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 06/2021 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр магадалсныг үндэслэн Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын ТЭЗҮ-ийг дэмжиж;

2-т Ажлын нарийвчилсан зураг, төсвийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагаар хянан магадлуулах арга хэмжээ ажиллах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна.

3.88. Тавантолгой төмөр зам ХХК-аас 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 1/502, 6 дугаар сарын 21-ний өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 1/523 дугаар албан бичгүүдийг ТЕГ-т хүргүүлсэн байна. Албан бичигт “...Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын салшгүй нэг хэсэг болох холболтын төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах зэрэг ажил нь төрийн нууцад хамаарах эсэх талаар дүгнэлт ирүүлэхийг хүсээд, ерөнхий гүйцэтгэгчээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн I зэрэглэлийн төмөр замын Ерөнхий гүйцэтгэгч болох “Бодь интернэшнл” ХХК-ийг гүйцэтгүүлэх нь үр дүнтэй” гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байна.



3.89. Бодь интернэшнл ХХК нь Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох Цогтцэций-Тавантолгой өртөө хоорондын төмөр замын барилгын ажлыг гүйцэтгэх сонирхлоо 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Тавантолгой төмөр зам ХХК-д илэрхийлжээ.

3.90. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, УУХҮС-аас 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн хуралд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч гишүүдийн баримтлах 21/16 дугаартай удирдамжаар “...Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын барилгын ажлын тухай асуудлыг компанийн аудитын хорооны зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн ...холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хэлэлцэж шийдвэрлэх” гэжээ.

3.91. ТӨБЗГ-аас 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн хуралд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч гишүүдэд “Удирдамж өгөх тухай” А-1/1090 дугаартай албан бичгээр “... Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын холболтын барилгын ажилд шаардагдах Эрдэнэс Тавантолгой ХК-ийн төсөвт туссан дүн 218.1 тэрбум төгрөгийг Тавантолгой төмөр зам ХХК-д шилжүүлэх асуудлыг хэлэлцэн Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт зөвшөөрөл олгон шийдвэр гаргах” гэжээ.



3.92. Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын барилгын ажлын тухай” 33 дугаар тогтоолоор:

1-д Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох холболтын төмөр замын төслийг санхүүжүүлэхээр 2021 оны хөрөнгө оруулалтын төсөвт туссан дүн болох 218.1 тэрбум төгрөгийг Тавантолгой төмөр зам ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлэхийг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн.

2-т Энэ тогтоолын 1-д заасан Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох холболтын төмөр замын барилгын ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2021 оны хөрөнгө оруулалтын төсөвт багтаан шийдвэрлэхийг Гүйцэтгэх захиралд;

3-т Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг ТУЗ-ын Аудитын хороонд даалгасан байна.

3.93. Тавантолгой төмөр зам ХХК Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх BI-TTZB-LONT-0001, TT3-H21/01 дугаар гэрээний “ерөнхий хэлэлцээр”-ийг Бодь интернэшнл ХХК-тай 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан байна.

3.94. Энэхүү гэрээний “ерөнхий хэлэлцээр”-ийн 6-д “...гэрээний нийт үнэ нь НӨАТ орсон, нийт үнэд үндэслэсэн (LUMP SUM) 218.1 тэрбум төгрөг байна. Гэрээний нийт үнээс гүйцэтгэгчид төлөх Ажлын нийт төлбөр нь Захиалагчийн хяналтын зардал, ТЭЗҮ, БОННУ, геодези, гидрогеологи, геологийн зардлыг хассан дүн байх бөгөөд Захиалагч гэрээт ажлын төлбөрийг Гэрээнд заасан нөхцөлөөр Гүйцэтгэгчид бүрэн төлөх үүрэг хүлээнэ. Төсөлд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бусад этгээдээс санхүүжүүлэхтэй холбоотой аливаа гэрээ, хэлцэл нь Захиалагчийг гэрээний төлбөр төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна.

3.95. Эрдэнэс-Тавантолгой ХК “Тавантолгой-Гашуунсухайт болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр зам”-ын ЭТТ-2022/13 дугаар гэрээг Тавантолгой төмөр зам ХХК-тай 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан байна.

3.96. Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор ЗТХС, УУХҮС нарт Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл, БОНУ-г хийлгэж, барилгын ажлыг 2020 онд багтаан эхлүүлэхийг даалгасан боловч хэрэгжүүлж ажиллаагүй, тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр А217/А293 дугаартай хамтарсан тушаал баталж, “...холбох төмөр замын ТЭЗҮ, БОНУ боловсруулан холбогдох байгууллагаар батлуулсны үндсэн дээр санхүүжилтийг батлуулах, суурь бүтцийг холбох төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, эрх бүхий байгууллагаар магадлуулах, ажлыг магадлуулсан зураг төсөлд үндэслэн 2020 онд эхлүүлэх ..., уг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ТЕГ-ын 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 01/208 дугаартай албан бичгийг үндэслэн зохион байгуулах” зэргийг даалгасан боловч мөн л хэрэгжүүлэлгүйгээр гэрээ байгуулсан байна.

3.97. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6⁴³ дугаар зүйлд заасан үйл ажиллагааны зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан өндөр болон онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн ажлын зураг төсөлд магадлал хийгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно гэж заасныг зөрчсөн байна.

3.98. Аудитаар холболтын төмөр замын магадлалгүй ажлын зардалд олгох 5.1 тэрбум төгрөгөөс 2.4 тэрбум төгрөгийн зардлыг хянаж, баталгаажуулалгүй олгосон, 2.7 тэрбум төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Гашуунсухайт шилжүүлэн ачих терминалын ТЭЗҮ-д хийсэн магадлалын нэгдсэн дүгнэлтийг төмөр зам, замын байгууламжийн зураг төслийн эксперт дангаар баталгаажуулсан байна

⁴³ 6.1-д албан тушаалтан нь хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны ёс зүйг сахина, 6.2-т албан тушаалтан нь хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээнэ, 6.3-т албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна, 6.4-т албан тушаалтан иргэний болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэй нь зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ, 6.5-д албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.

3.99. ЗТХЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 15 дугаартай тушаалаар “Тавантолгой логистикийн төв, Гашуунсухайт орчимд байгуулах ачааны терминалын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар”-ыг баталж, Эрдэнэс-Тавантолгой ХК-д 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 03/4770 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

3.100. Тавантолгой төмөр зам ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/60 дугаар тушаалаар Гашуунсухайт шилжүүлэн ачих терминалын ТЭЗҮ боловсруулах ажлын хэсгийг байгуулж, боловсруулсан ТЭЗҮ-ийг ЗТХТ ТӨҮГ-ын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 20/2022 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр магадалж, ЗТХЯ-ны ШУТЗ-ийн 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцэн дэмжиж “...шилжүүлэн ачих терминалыг цаашид хил холболтын төмөр зам ашиглалтад орох үед өргөн царигаас нарийн царигт ачаа шилжүүлэн ачихаар зай, талбайг тооцоолон тусгаж хэрэгжүүлэх”-ийг Тавантолгой төмөр зам ХХК-д даалгажээ.

3.101. Мөн ТЭЗҮ-ийг ЗТХЯ-ны ШУТЗ болон Төмөр зам далайн тээвэр, авто зам, автотээврийн салбарын дэд зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 15, 21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, гарсан дүгнэлт, санал, зөвлөмжийг 04/1392 дугаар албан бичгээр Тавантолгой төмөр зам ХХК-д хүргүүлсэн байна.

3.102. ЗТХТ ТӨҮГ-ын ТЭЗҮ-ийг 20/2022 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр хянаж, баталгаажуулахдаа тус төвийн захирлын 2020 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Экспертийн ажлын хэсэг томилох тухай А/53 дугаар тушаалаар томилсон ажлын хэсгийн гишүүн С.Майдар дээрх ТЭЗҮ-д бүхэлд нь экспертийн дүгнэлтийг бие даан гаргасан нь Барилгын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4⁴⁴-т заасныг зөрчиж, магадлалын дүгнэлтийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт болон архитектур төлөвлөлт, техникийн шийдэл, тооцоололд үндэслээгүй, мэргэжил, техникийн шийдлийн алдаатай дүгнэлт гаргасан байх эрсдэлтэй байна.

Шилжүүлэн ачих терминалын ажлыг гэрээгүйгээр гүйцэтгүүлж, баталгаажуулсан байна

3.103. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дугаартай албан даалгаврын 9.4-т “Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх ачаа тээврийн терминалыг байгуулах арга хэмжээ авах”, 9.5-д “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын голлох боомтод чингэлэгт тээврийн терминал, ачиж буулгах, шилжүүлэн ачих терминал, логистикийн төв байгуулах санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэх”-ийг ЗТХС-д даалгажээ.

3.104. Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр:

1. Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын зураг төслийг Хятадын талаас санал болгосон компаниар гүйцэтгүүлэх саналыг хүлээн авч, хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ТУЗ, гүйцэтгэх захиралд;
2. БНХАУ-ын Чайна Энержи компанитай урьдчилгаа төлбөрийн нөхцөлтэйгээр нүүрс нийлүүлэх гэрээг байгуулахыг Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ТУЗ, гүйцэтгэх захиралд;
3. Төмөр замын төслийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээг хууль тогтоомжийн хүрээнд байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ЗТХС, Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ, гүйцэтгэх захиралд;
4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд технологийн бус, нийгмийн шинж чанартай барилга байгууламж барих зэрэг зарим ажлыг хойшлуулах замаар зохицуулалт хийж, ТЭЗҮ-д заасан дүнгээр Гашуунсухайт өртөөнд вагоноос

⁴⁴ Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээнэ.

автомашин руу шилжүүлэн ачих терминалын барилгын ажлыг яаралтай эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ, гүйцэтгэх захиралд;

5. Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын хил холболтын асуудлаар хоёр улсын Засгийн газар хооронд харилцан ноот бичиг солилцох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэхийг ГХС-д тус тус даалгасан байна.

3.105. Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 09 дүгээр тогтоолоор:

- 1-д Гашуунсухайт өртөөнд баригдах шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтын ажлыг магадлагдсан ТЭЗҮ-д заасан 42.6 сая ам.долларын дүнгээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ"-нд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захиралд олгосон;
- 2-т Энэ тогтоолын 1-д заасан дүнгээр гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын технологийн бус, нийгмийн шинж чанартай барилга байгууламж барих зэрэг зарим ажлыг хойшлуулах, зарим багц ажлын төлөвлөгдсөн мөнгөн дүнгийн зориулалтыг өөрчлөх замаар шийдвэрлэх эрхийг Тавантолгой төмөр зам ХХК-ийн Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн;
- 3-т Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн Гүйцэтгэх захирлын баталсан Тавантолгой төмөр зам ХХК-ийн ТУЗ-ийн хуралд баримтлах 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 06 дугаар удирдамжийн 1, 2, 3 дахь заалтад заасан гүүрэн кран ашиглан шууд шилжүүлэн ачих, техникийн шийдэлтэй холбоотой мэргэжлийн байгууллагаас дүгнэлт гаргуулах болон хөрөнгө оруулалт, санхүүжилтийн тооцоог нарийвчлан гаргаж, ТУЗ-өөр хэлэлцүүлж, шийдвэрлэхийг гүйцэтгэх захиралд үүрэг болгосон байна.

3.106. Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/60 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн боловсруулсан ТЭЗҮ-ээр Гашуунсухайт шилжүүлэн ачих терминалын ажилд 133.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэж тооцсон байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 10-аас харна уу)

3.107. Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн Зааварчилгаа хүргүүлэх тухай 1/590 дугаартай албан бичгийн хариуд Бодь интернэшнл ХХК шилжүүлэн ачих байгууламжийн ажлыг гүйцэтгэх үнийн саналыг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн BI-TTGS-LTR-3570 дугаар албан бичгээр ирүүлэхдээ "...гэрээний нийт үнийг өөрчлөхгүйгээр Гашуунсухайт болон Цогтцэций суурьшлын бүсүүд, хилийн холболтын хэсгийн төмөр замын ажлын тодорхой дүнгээр шилжүүлэн тооцож гүйцэтгэх" нөхцөлтэйгөөр Гашуунсухайт өртөөнд байрлах шилжүүлэн ачих байгууламжийн ажлын тоо хэмжээ, гүйцэтгэх үнийн саналыг Тавантолгой төмөр зам ХХК-д хүргүүлсэн байна.

3.108. Саналын хариуд Тавантолгой төмөр зам ХХК 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 1/672 дугаар албан бичгээр:

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээний (ЕРС) Ерөнхий нөхцөлийн 3.5-д заасны дагуу Гашуунсухайт өртөөнд байрлах шилжүүлэн ачих байгууламжийн барилгын ажил эхлүүлэх мэдэгдэж;
- ТЭЗҮ-д заасан үнийн дүнгээр хийх ажлын даалгавар, ажлын тоо хэмжээ;
- Хувийн жингийн тохируулгыг талуудын хооронд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ"-ий хавсралт №2-д заасан Хүснэгт 1.1 Гэрээний үнэ-ийн 5.7-д заасан суурьшлын бүсийн барилга байгууламжийн багц ажлын хувийн жингээс шилжүүлэн тооцно" гэжээ.

3.109. Дээрх тохиролцооны дагуу шилжүүлэн ачих терминалын ажлыг шинээр гүйцэтгэх, суурьшлын бүсийн ажлыг хасах талаар үндсэн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, шилжүүлэн ачих терминалын ажил ямар нэгэн гэрээгүйгээр хийгдэж, ажлын гүйцэтгэлийг "суурьшлын бүс" нэршлээр баталгаажуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн зарчмыг тус тус зөрчсөн байна.

3.110. Тавантолгой төмөр зам ХХК нь барилга, байгууламжийн угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг компанийн албан бичгээр олгохдоо “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээний дагуу хийхийг зөвшөөрсөн” нь Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д “барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл (цаашид “барилгын ажлын зөвшөөрөл” гэх) гэж энэ хуульд заасны дагуу барилгын ажлыг гүйцэтгэхийг зөвшөөрч, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг”, 25 дугаар зүйлийн 25.4-д “Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно”, ЗТХС-ын 2018 оны 49 дүгээр тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын холбогдох заалтыг тус тус зөрчсөн байна.

Их хэмжээний урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид гуравдагч этгээдийн баталгаагүйгээр олгожээ

3.111. Бодь интернэшнл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн “Гүйцэтгэлийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” 17 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай гүйцэтгэлийн баталгааг өөрийн хөрөнгөөр гаргахаар шийдвэрлэжээ.

3.112. Дээрх шийдвэрийн дагуу “...Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг зохих ёсоор гүйцэтгэхээр амлаж, хэрэв энэхүү үүргийн гүйцэтгэлийн зөрчил болон гэрээтэй холбоотой аливаа бусад асуудлын улмаас захиалагчид ямар нэгэн төлбөр төлөх үүрэг үүссэн тохиолдолд 17.6 сая ам.доллар түүнтэй тэнцэх мөнгөн дүнгээс хэтрэхгүй хэмжээгээр уг төлбөрийг захиалагч Тавантолгой төмөр зам ХХК-д зохих ёсоор, бүрэн дүүрэн төлж барагдуулна гэдгийг бид эргэлт, буцалтгүй, нөхцөл болзолгүйгээр баталж байна. ...Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна” гэх баталгааг 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Бодь интернэшнл ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Амундра, Тавантолгой төмөр зам ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Удаанжаргалд гаргаж, тэр өдрөө талууд баталгаажуулсан байна.

3.113. Мөн дор нэр бүхий гэрээгээр ажил гүйцэтгүүлэхдээ үүргийн гүйцэтгэлийн баталгаагүйгээр захиалагч, гүйцэтгэгчийн гарын үсгээр өөрийн хүлээсэн үүрэгт өөрөө баталгаа гаргаж, их хэмжээний урьдчилгаа төлбөрийг олгосон байна. Үүнд:

- Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой төмөр зам ХХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн ЭТТ-2019/825, ТТЗ-Н19/01-01, BI-TTGS-CONT-0002, Тавантолгой төмөр зам ХХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх ТТЗ-Н19/01, BI-TTGS-CONT-0001 дугаар гэрээгээр талууд гэрээний үнийн дүнгийн 10.9 хувь болох 110.0 сая ам.долларын;
- Эрдэнэс-Тавантолгой ХК болон Тавантолгой төмөр зам ХХК-ийн хооронд байгуулсан ЭТТ-2021/503, СХГ-01/19/01 дугаар Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн барилга байгууламжийг барьж байгуулах ажлын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээ, Тавантолгой төмөр зам ХХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх АГГ-01/35/10, BI-NANT-CONT-0001 дугаартай гэрээнд 78.8 тэрбум төгрөгийн;
- Эрдэнэс-Тавантолгой ХК болон Тавантолгой төмөр зам ХХК-ийн хооронд байгуулсан ЭТТ-2022/13 дугаар Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудын холболтын төмөр замын санхүүжилтийн гэрээ, Тавантолгой төмөр зам ХХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх ТТЗ-Н21/01, BI-NANT-CONT-0001 дугаартай гэрээгээр урьдчилгаа төлбөр олгохоор тус тус заасан байна.

Хүснэгт 52. Гэрээгээр олгосон урьдчилгаа төлбөрийн баталгааны мэдээлэл, тэрбум төгрөг

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

№	Гэрээний нэр	Гэрээний дугаар	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дүн	Хэмжих нэгж	Шилжүүлсэн урьдчилгаа төлбөрийн дүн					
						Эрдэнэс-Тавантолгой ХХК-аас Тавантолгой төмөр зам ХХК-руу			Тавантолгой төмөр зам ХХК-аас Бодь интернэшнл ХХК-руу		
						огноо	ам. доллар	төгрөг	огноо	ам. доллар	төгрөг
1	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ	ТТЗ-Н19/01, BI-TTGS-CONT-0001	2019.10.29	1,005.6	ам. доллар	2019.10.11	53.9	143.9			-
						2019.10.23	56.1	150.0	2019.11.13	107.9	286.3
		Төслийн дүн	мөнгөн дүн			110.0	293.9		107.9	286.3	
			гэрээний дүнд эзлэх хувь			10.9			10.7		
2	Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ	ТТЗ-Н21/01, BI-TTGS-CONT-0001	2021.08.20	218.1	тэрбум төгрөг	2022.03.21		17.9	2022.04.01		17.5
						2022.04.07		15.0	2022.04.11		14.7
						2022.04.15		17.1	2022.04.19		16.8
						2022.05.17		68.0	2022.05.24		60.1
						2022.06.07		100.0	2022.06.16		80.0
		Төслийн дүн	мөнгөн дүн			218.0		189.1			
			гэрээний дүнд эзлэх хувь			100.0		86.7			
3	Тавантолгойн нүүрс ачих логикийн төвийн барилга байгууламжийн зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ	АГГ-01/35/10, BI-NANT-CONT-0001	2021.08.20	304.8	тэрбум төгрөг	2021.09.09		63.0	2021.09.10		63.0
						2021.11.24		15.8	2021.12.01		10.7
		Төслийн дүн	мөнгөн дүн			78.8		73.7			
			гэрээний дүнд эзлэх хувь			25.9		24.2			
			Нийт дүн				590.7			549.2	

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой төмөр зам ХХК

3.114. Мөн Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой төмөр зам ХХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн ЭТТ-209/825, ТТЗ-Н19/01/01, BI-TTGS-CONT-0002 гэрээний 3.2.3-т “Хэрэв урьдчилгаа төлбөрийг Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлэх үед ам.доллар, төгрөгийн ханшийн зөрүүний улмаас алдагдал үүсвэл Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын Техник эдийн засгийн үндэслэлд тодотгол хийх үед, эсхүл энэхүү гэрээний Хавсралт В болох Нүүрс нийлүүлэх гэрээний дагуу Эрдэнэс-Тавантолгой ХК нь Гүйцэтгэгчид нийлүүлэх нүүрсний хэмжээнд тохируулга хийх замаар уг ханшийн зөрүүний алдагдлыг арилгаж, хохиролгүй болгоно” гэсэн заалтыг үндэслэж Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой төмөр зам ХХК, Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан санхүүжилтийн нэмэлт, өөрчлөлтийн ТТЗ-Н19/01/03, BI-TTGS-CONT-0002-01 дугаартай гэрээний 1.4-т “2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Гүйцэтгэгчид төлсөн урьдчилгаа төлбөрийн дүнгээс /Тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцож төгрөгөөр төлсөн/ үүссэн ханшийн зөрүүний алдагдал 1,248,922.48 ам доллар болж энэхүү төлбөрийн Эрдэнэс-Тавантолгой ХК нь нүүрсний анхны суурь үнэ 60 ам.доллараар тооцож, нүүрсээр төлж барагдуулах”-ыг талууд зөвшөөрсөн байна.

3.115. Гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг хуульд нийцүүлээгүй, урьдчилж олгосон 110.0 сая ам.долларт хугацаа хожимдуулсны ханшийн зөрүүд алдагдал тооцож, 1.2 сая ам долларыг олгохоор баталгаажуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.8-д “урьдчилгаа төлбөрийн баталгаа гэж захиалагч урьдчилгаа төлбөр төлөх тохиолдолд уг төлбөрийг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах үүргээ баталгаажуулж гүйцэтгэгчээс захиалагчид ирүүлсэн банкны баталгаа, даатгаагчийн баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг”, 5.1.17-д “гүйцэтгэлийн баталгаа гэж гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангахыг баталгаажуулж, гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлсэн банкны баталгаа, даатгаагчийн баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг” Иргэний хуулийн 234 дүгээр зүйлийн 234.1-д “Үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар гуравдагч этгээд үүрэг гүйцэтгүүлэгчид

баталгаа гаргаж болно”, 234.4-д “Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг баталгаа гаргаагчаас үл маргах журмаар шаардана”, 234.5-д Үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө үүрэг хүлээсэн баталгаа гаргаагч үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрхгүй, 234.6-д “Банкны баталгааг энэ хуулийн 457 дугаар зүйлд заасан журмаар зохицуулна” гэж заасныг тус тус зөрчиж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д “нэгдмэл сонирхолтой этгээд гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

3.116. Аудитаар урьдчилгаа төлбөрт ханшийн зөрүү тооцож, нүүрсээр барагдуулсан 1.2 сая ам.долларын алдангийн тооцоог хүчингүй болгох, гуравдагч этгээдийн баталгаагүйгээр урьдчилгаа төлбөр олгохгүй байх албан шаардлага хүргүүллээ.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслүүдийн ажлын бодит гүйцэтгэлээс давсан санхүүжилт олгосон байна


3.117. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын бодит гүйцэтгэл захиалагчийн баталгаажуулснаар 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 787.1 сая ам.доллар буюу 78.3 хувьтай, гүйцэтгэгчээс 2022 оны 9 дүгээр сараас хойших хугацаанд ирүүлсэн 24, 25, 26, 27, 28, 29 дэх гүйцэтгэлийг баталгаажуулаагүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 11-ээс харна уу)

3.118. Талуудын хооронд байгуулсан ЕРС гэрээний тусгай нөхцөлийн 14.6-д “Захиалагч явц дундын төлбөрийн холбогдох маргаантай эсхүл тодруулах шаардлагатай хэсгийг...саатуулах мэдэгдлийг холбогдох үндэслэл, баримтын хамтаар 28 хоногийн дотор Гүйцэтгэгчид хүргүүлээгүй бол тухайн хугацаанаас хойш зохих төлбөрийг төлөх үүрэг үүссэнд тооцно” гэж заасан, захиалагчаас гүйцэтгэгчид хариу мэдэгдэл хүргүүлээгүйгээс харахад, 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр ирүүлсэн 24 дүгээр гүйцэтгэлээс хойших 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн 29 дүгээр гүйцэтгэлийн нэхэмжилсэн дүнгээр ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлж тооцвол 898.5 сая ам.доллар буюу 89.3 хувьтай байна.

3.119. Эрдэнэс-Тавантолгой ХК нь тус компани болон Тавантолгой төмөр зам ХХК, Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн ЭТТ-2019/825, ТТЗ-Н19/01-01, ВІ-ТТGS-CONT-0002, Тавантолгой төмөр зам ХХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх ТТЗ-Н19/01, ВІ-ТТGS-CONT-0001 дугаар гэрээний дагуу гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр болгон 110.0 сая, нүүрсээр төлсөн 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 675.3 сая, нийт 785.3 сая ам.доллар буюу гэрээний үнийн дүнгийн 78.1 хувийг төлсөн байна.

График 1. Бодь интернэшнл ХХК-д нүүрсээр олгох болон олгосон санхүүжилтийг хугацааны дарааллаар харуулбал, сая ам.доллар

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой төмөр зам ХХК, <http://en.sxcoal.com/>

Хүснэгт 53. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажлын гүйцэтгэлээр Бодь интернэшнл ХХК-д олгосон санхүүжилт, сая нэгж

Он	Нийлүүлсэн нүүрс, тонн	Мөнгөн дүн, сая ам.доллар	Мөнгөн дүн, түүхэн ханш, сая төгрөг	Тайлбар
2019		110.0	293,872.7	Урьдчилгаа төлбөр
2019	1,200,000.00	72.0	196,802.1	
2020	3,686,768.00	183.5	521,317.4	
2021	1,982,351.20	122.1	348,057.9	
2022	1,242,409.30	126.9	412,790.8	
2023.06.30	1,724,659.90	170.8	599,047.2	
НИЙТ ДҮН	9,836,188.40	785.3	2,371,888.1	

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК

3.120. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслүүдэд ажлын бодит гүйцэтгэлээс 16.0 сая ам.доллар, 56.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна. (Төслүүдийн ажлын гүйцэтгэлийг хавсралт 11, 12, 13-аас харна уу)

Хүснэгт 54. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн замын бүтээн байгуулалтын ажилд олгосон санхүүжилт, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар, тэрбум төгрөг

Төслийн нэр	Мөнгөний нэгж	Төсөвт өртөг	Төсөлд олгосон санхүүжилт		Баталгаажуулсан ажлын гүйцэтгэл		Санхүүжилт, гүйцэтгэлийн зөрүү, илүү (+), дутуу(-)
			Мөнгөн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Мөнгөн дүн	Нийт дүнд эзлэх хувь	
Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл	сая ам.доллар	1,005.6	804.7	80.0	788.7	78.4	16.0
Тавантолгой нүүрс ачих логикийн төвийн төсөл	тэрбум төгрөг	313.2	217.0	69.3	193.8	61.9	23.2
Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын холболтын төсөл	тэрбум төгрөг	218.0	218.0	100.0	184.6	84.7	33.4
НИЙТ ДҮН	сая ам.доллар	1,005.6	804.7	80.0	788.7	78.4	16.0
	тэрбум төгрөг	531.2	435.0	81.9	378.4	71.2	56.6

Эх сурвалж: Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой төмөр зам ХХК

3.121. Энэ нь дараах хүчин зүйлсээс шалтгаалсан байна. Үүнд:

- Эрдэнэс-Тавантолгой ХК, Тавантолгой төмөр зам ХХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх ТТЗ-Н19/01, ВІ-ТТGS-CONT-0001 дугаартай гэрээний ерөнхий хэлэлцээрийн Хавсралт 6-д заасан ажлын хуваариар 32 сар буюу 2022 оны 8 дугаар сарын 01-нд бүрэн дуусгахаар байсан боловч талууд гэрээнд өөрчлөлт оруулж хугацааг удаа дараа сунгасан.
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажлын санхүүжилтийн гэрээний “ХАВСРАЛТ В” болох Эрдэнэс-Тавантолгой ХК болон Бодь интернэшнл ХХК-ийн хооронд 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан нүүрс нийлүүлэх ЭТТ-2019/784, ВІ-ТТGS-CONT-0003 дугаартай гэрээгээр төлбөрийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оныг дуустал 5 жилд тэнцүү хэмжээгээр нүүрсээр барагдуулахаар байсныг 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдөр гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт №1-ээр тухайн оны 12 дугаар сардаа багтаан 1.5 сая тонн 90.0 сая ам.долларын нүүрсийг олгож, 2024 онд нийлүүлэх нүүрсний хэмжээнээс хасах өөрчлөлт оруулсантай холбоотой байна. (График 1-ээс харна уу)
- Тавантолгой нүүрс ачих логиستيкийн төв, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын холболтын төсөлд нийт ажлын бодит гүйцэтгэлээс 56.6 тэрбум төгрөгийн санхүүжилт илүү олгосон нь их хэмжээний урьдчилгаа төлбөр олгосон, дээрх ажлуудын гэрээний ерөнхий хэлэлцээрт Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил (2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Анхны гэрээ”-ний дагуу гүйцэтгэсэн)-ын Явц дундын төлбөрийн хүсэлтийг баталгаажуулахдаа Урьдчилгаа төлбөртэй тэнцүү хэмжээний мөнгөн дүнг Захиалагч суутган барьж үлдэхээр, өөрөөр хэлбэл нэг гэрээний ажлын гүйцэтгэлийг нөгөө гэрээний гүйцэтгэлд шилжүүлж тооцсонтой холбоотой байна.

3.122. Засгийн газраас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр шийдвэрлэснээр Эрдэнэс-Тавантолгой ХК 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд олгосон 8.1 сая тонн нүүрсийг өрсөлдөөний журмаар борлуулах бус, хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжилтэд олгосноос ойролцоогоор 57.4 сая ам.долларын орлого олох боломжийг алджээ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалт

3.123. Төслийн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч Тавантолгой төмөр зам ХХК-аас Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын Засаг дарга нартай 2020 оны 6 дугаар сараас 2022 оны 8 дугаар сарын хооронд “Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах” 8 гэрээ байгуулан ажилласан байна.

3.124. Тавантолгой төмөр зам ХХК-аас 2021 онд ашиглалт дууссан ТТАМ-ын 63 ордыг стандарт шаардлагын дагуу техникийн нөхөн сэргээлт хийж Өмнөговь аймгийн Засаг даргын 2016 оны А/519 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн байна.

3.125. Харин 2022 онд ашиглалт дууссан 33 ордод техникийн нөхөн сэргээлт хийж орон нутгийн ажлын хэсэгт шалгуулсан ба нөхөн сэргээлт хийгээгүй 8 ордоос Эсто ХХК, Юм дэлгэр ХХК-ууд “А” лиценз гаргуулан нөхөн сэргээлтийг хариуцахаар болсон байна. Тавантолгой төмөр зам ХХК-аас 2023 онд нөхөн сэргээлт хийх шаардлагатай 6 орд үлдсэнээс 4 ордын нөхөн сэргээлтийг хийж, үлдсэн 2 орд нь шилжүүлэн ачих терминалын барилга угсралтын ажилд ашиглагдаж байна.


3.126. Бүтээн байгуулалтын ажилд 6.6 сая шоо метр түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож нийлүүлсэн ба 2021 онд нөхөн сэргээлт хийсэн 26 карьерын 0.4 сая га талбайг орон нутагт хүлээлгэн өгч, орон нутгийн төсөвт 2020-2022 онд нийт 837.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Хил орчмын төмөр замын зурвас газрын эзэмшлийг хуульд нийцүүлэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна

3.127. Засгийн газрын 2020 оны 92 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын 207+000 дахь км-ээс Монгол Улсын урд хил болох төгсгөлийн цэг 30+895 км хүртэлх төмөр замын шугамын чигийг баталсан байна. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13-т “үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл хэрэгжүүлэх газар тусгай хэрэгцээний газар байна” гэж заасан боловч тус төмөр замын чигийн дагуух болон Гашуунсухайт шилжүүлэн ачих терминал байгуулах нийт 966 га газрын:

- ✓ 471 га газар нь УИХ-ын 2022 оны мн/81 дүгээр тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан улсын хилийн зурвас газартай давхцалтай;
- ✓ 495 га газар нь УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авсан Говийн бага /Б/ Дархан цаазат газрын хил заагт хамаарч байна.

Зураг 2. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт хийгдэж буй улсын хилийн зурвас болон Говийн бага дархан цаазат газарт хамаарч буй газрыг зургаар харуулбал,



Эх сурвалж: Монголын төмөр зам ТӨХК, Тавантолгой төмөр зам ХХК

3.128. Энэ нь тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Дархан цаазат газарт энэ хуулийн 10,11 дүгээр зүйлд зааснаас өөр зориулалтаар дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. 1-д газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, геологийн судалгаа хийх, металл хайгч, химийн хорт болон тэсрэх бодис авч явах, ашиглах, элс, хайрга чулуу авах, мод, зэс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.129. Иймд Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “улсын тусгай хамгаалалттай газар”, 16.1.2-т “улсын хилийн зурвас газар”...улсын тусгай хэрэгцээний газарт хамаарна, 17 дугаар зүйлийн 17.1.3-т “энэ хуулийн 16.1.1-16.1.4-т заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох” нь УИХ-ын бүрэн эрх байх тул хуульд нийцүүлэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд техникийн комиссоос өгсөн зарим үүрэг, даалгавар нь хэрэгжих боломжгүй байна

3.130. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад БХБС, ЗТХС, ЭХС-ын тушаал, Өмнөговь аймгийн Засаг даргын захирамжаар техникийн 9, улсын 7 комисс ажиллаж, холбогдох үүрэг, даалгаврыг өгч ажилласан байна.

Хүснэгт 55. Техникийн комиссоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн мэдээлэл

Ангилал	Комисс байгуулсан		Өгсөн үүрэг, даалгаврын тоо	Хэрэгжилт		
	Шийдвэр гаргасан	Огноо, дугаар		бүрэн хэрэгжсэн	хэрэгжилт дутуу	хэрэг-жээгүй
Замын доод, дээд бүтэц	ЗТХС	2021.12.23-ны А/196	22	19	-	3
	ЗТХС	2022.04.21-ний А/106	54	53	-	1
	ЗТХС	2022.06.06-ны А/152	96	96	-	-
	ЗТХС	2022.08.31-ний А/239	38	38	-	-
	ЗТХС	2022.12.23-ны А/333	39	38	-	1
	ЗТХЯ-ны ТНБД	2023.02.10-ны А/25	-	-	-	-
Дохиолол холбооны байгууламж	ЗТХЯ	2023.04.17-ны А/119	23	21	-	2
Эрчим хүчний байгууламж	ЭХЯ-ны ТНБД	2022.07.01-ний А/103	61	61	-	-
	ЭХЯ-ны ТНБД	2022.02.10-ны А/187	53	53	-	-
ДҮН			386	379	0	7

Эх сурвалж: Тавантолгой төмөр зам ХХК

3.131. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад техникийн комиссоос нийт 386 үүрэг даалгавар өгснөөс 379 нь бүрэн хэрэгжиж, Тавантолгой төмөр зам ХХК-д өгсөн 7 үүрэг, даалгавар хэрэгжээгүй буюу хэрэгжүүлэх боломжгүй байна. Үүнд:

ЗТХС-ын 2021.12.23-ны өдрийн А/196 дугаар тушаалаар байгуулсан техникийн комиссын гишүүн:

- БХТ-ийн Хяналт-шинжилгээ, хуулийн албаны дарга Я.Мөнх-Эрдэнийн өгсөн: Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу шаардлагатай **норм, дүрэм стандартыг нийцүүлэх арга хэмжээ** авч ажиллах;
- ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Энх-Өлзийгийн өгсөн: Стандартчлал, техникийн зохицуулах үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 27.2.2-д заасан уулзваргүй зам төмрийг угсрах, суурилуулах, ашиглах техникийн **стандартыг санаачлан боловсруулж, батлуулах арга хэмжээг** зохион байгуулах;
- ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Ганболдын өгсөн: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нийт 233.6 км төмөр замын 63 км буюу 26.9 хувийн гүйцэтгэлийн техникийн комиссын шалгалтад бүрдүүлж буй 25 нэр төрлийн баримт бичиг холбогдох эрх зүйн баримт **хуульд нийцэж байвал** Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6.1.1-д заасан **гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх**, 6.1.2-т заасан Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх;

ЗТХС-ын 2022.04.21-ний өдрийн А/106 дугаар тушаалаар байгуулсан техникийн комиссын гишүүн:

- ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Артурын өгсөн: Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу холбогдох **норм, дүрмийн төсөл боловсруулж, батлуулах**;

ЗТХС-ын 2022.12.23-ны өдрийн А/333 дугаар тушаалаар байгуулсан техникийн комиссын гишүүн:

- ЗТХЯ-ны Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын мэргэжилтэн Б.Нарантунгалагийн өгсөн: 2021 оны А196 тушаал Б.Энх-Өлзий (ЗТХЯ) мэргэжилтний өгсөн **уулзваргүй зам төмөр угсрах суурилуулах, ашиглах техникийн стандарт боловсруулж батлуулах, 2022 онд ажилласан 5 техникийн комиссын үүрэг даалгаврын биелэлтийг шинэчлэн нэгтгэж дутуу биелэлтийн тайланг нэгтгэх**

3.132. Техникийн комиссын гишүүд нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журамд зааснаар тухайн барилга, байгууламж, төмөр замын суурь бүтэц нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм, нормативд нийцэж байгаа эсэх, учирч болох эрсдэлээс хамгаалах үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн эсэхэд дүгнэлт гаргах ёстой атал хийсэн ажилтайгаа нийцүүлж норм, стандарт боловсруулах, үнэлгээ хийх үүрэг өгсөн нь техникийн комиссын гишүүдийн бүрэлдэхүүн, гишүүдийн мэдлэг, мэргэшилд анхаарах шаардлагатайг харуулж байна. Хууль, журамд стандарт, норм, нормативыг

ашиглах болон техникийн комиссын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн:

6.1-д Монгол Улсын барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр зохицуулаагүй асуудлыг олон улсын байгууллага, гадаадын барилга, байгууламжийн норм, дүрэм, стандартаар зохицуулж болно.

Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 6 дугаар зүйлд Техникийн комиссын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ:

6.1.1-д барилгын ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай инженерийн хангамжийн шугам сүлжээний туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдлыг дүгнэх;

6.1.2-т барилгын инженерийн хангамжийн эх үүсвэр, түүний дагалдах сүлжээ, туслах барилга байгууламжийн найдвартай байдлыг дүгнэх;

6.1.3-т барилгын зориулалтаас хамаарсан технологи, дамжлага түүний тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, тохирлын гэрчилгээ, туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдлыг дүгнэх.

ЗТХС-ын 2020 оны А/154 дүгээр тушаалаар баталсан “Төмөр замын аюултай бүс, төмөр замын зурвас газар, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам”-ын

1.3-т Төмөр замын болон бусад объект, барилга байгууламжийн зураг төсөл, хийц загвар, үйл ажиллагаа нь Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын нийтлэг дүрэм, журам, үндэсний стандарт, норм, нормативын шаардлагуудад нийцсэн байна.

2.2.3-т төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг нь өргөдөл гаргагчийн ирүүлсэн баримт бичгийг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм, нормативт нийцэж байгаа эсэхийг хянаж, шинээр баригдах төмөр замын суурь бүтэц зохион байгуулалтын талаар техникийн дүгнэлт гаргана.

2.6.5-д техникийн комисс нь ашиглалтад оруулах эсэх тухай шийдвэрийг гаргахдаа доорх үзүүлэлтийг харгалзан үзнэ. 1-д тухайн төмөр замын суурь бүтэц болон байгууламжуудын батлагдсан зураг төсөл болон түүнд оруулсан өөрчлөлтүүд нь зохих журмын дагуу хийгдсэн, энэхүү журамд заасан нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэхэд дүн шинжилгээ өгөх; 2-т гүйцэтгэлийн зураг төсөл болон бусад гүйцэтгэлийн баримтуудад хийсэн дүн шинжилгээ; 3-т автоматжуулсан зам хэмжилтийн болон сэтгэлгээний хэмжилтийн үр дүн, байгууламжуудын бүрэн хэмжээний ажиллагаа болон хэсэгчлэн туршсан байдлын хэмжилтийн үр дүн гэжээ.

3.133. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд улсын комиссоос нийт 191 үүрэг, даалгавар өгснөөс бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 56. Улсын комиссоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн мэдээлэл

Ангилал	Комисс байгуулсан		Өгсөн үүрэг, даалгаврын тоо	Хэрэгжилт		
	Шийдвэр гаргасан	Огноо, дугаар		бүрэн хэрэгжсэн	хэрэгжилт дутуу	хэрэг-жээгүй
Барилга байгууламж	Өмнөговь аймгийн Засаг дарга	2022.06.17-ны А/779	33	33	-	-
		2022.07.25-ны А/999	28	28	-	-
		2022.09.19-ний А/1278	37	37	-	-
		2022.10.13-ны А/1457	31	31	-	-
		2022.11.14-ний А/1649	11	11	-	-
Эрчим хүчний байгууламж	ЭХС	2023.03.31-ний А/85	38	38	-	-
Замын доод, дээд бүтэц, дохиолол холбооны байгууламж	БХБС	2023.05.29-ний А/125	13	13	-	-
ДҮН			191	191		

Эх сурвалж: Тавантолгой төмөр зам ХХК

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, хийсэн дүн шинжилгээ аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, хэрэгжилтэд оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлоогүй, хэрэгжилтийг бодитой үнэлээгүй, хэрэгжилтийг хангах холбогдох арга хэмжээг авч ажиллаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.
- Төмөр замын салбарын хэмжээнд бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх шийдвэрүүд удаа дараалан гаргаж байсан ч хэрэгжүүлэх төслүүдийг эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөгөөр эрэмбэлж цогц байдлаар төлөвлөөгүйгээс ихээхэн хэмжээний үргүй зардал гарчээ.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар цааш дамжуулах өртөөдийн тээх, нэвтрүүлэх хүчин чадал, тээвэрлэлт хийх хөдлөх бүрэлдэхүүн хүрэлцээгүйгээс суурилагдсан хүчин чадлынхаа 18.6 хувийг ашиглахаар, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын хувьд хил холболтын цэгийг урьдчилан тохиролцоогүйгээс төмөр замаар хил дамжуулан тээвэрлэлт хийх боломжгүй зам болсон байна.
- Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын нэгж километр ногдох өртөг ялгаатай байгаа нь замуудын зэрэглэл өөр (Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн зам I зэрэглэл, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн зам III зэрэглэл), өртгийг бүрдүүлэх хөдөлмөрийн хөлс, түүхий эдийн үнэ, чанар харилцан адилгүй байсантай холбоотой байна.
- Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дотоодын хөрөнгө оруулалтаар амжилттай хэрэгжүүлсэн ч зарим үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт дутмаг, нууцын зэрэглэлд хамаарч байсан шалтгаанаар холбогдох хууль зөрчсөн, үргүй зардал гаргасан, зориулалт бусаар зарцуулсан зөрчлүүд илэрсэн нь залилангийн эрсдэл өндөр байх магадлалтай байна.
- Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслүүдийг ажил бүрэн дуусаагүй, төлөвлөгдөөгүй нэмэлт ажлаас санхүүжилтийн хэрэгцээ нэмэгдэж, суурь бүтэц эзэмшигч Монголын төмөр зам, Тавантолгой төмөр зам компаниуд төлөвлөсөн хэмжээний орлого олох боломжгүй болж их хэмжээний өр төлбөр, дамжуулан зээлийн эргэн төлөлт хойшилжээ.
- Хөрөнгө оруулагч Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьд 2 төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 100 хувь санхүүжүүлж, Тавантолгой төмөр зам ХХК, Зүүнбаян төмөр ХХК-д хувь эзэмшлээсээ илүү хөрөнгө оруулсан, Зүүнбаян төмөр зам ХХК-ийг татан буулгаж Монголын төмөр зам ТӨХК-д нэгтгэсэн, санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээ жил бүр нэмэгдэж, оруулсан хөрөнгөд үнэлгээ хийгээгүй, үр ашиг хүртэх боломжгүй, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад оруулсан 566.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг хэрхэх талаар шийдвэрт хүрээгүй зэрэг нь компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцэхгүй байна.
- Төмөр замын доод бүтцэд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын 1 шоо метрт ногдох төлбөрийг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлд 1 төгрөг, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 125 төгрөгөөр буюу харилцан адилгүй тогтоож, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бууруулсан байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ажил:

- Төмөр замын байгууламжийн зураг төсөл, төсвийг боловсруулж, эрх бүхий байгууллагууд баталгаажуулсан ч зарим ажлын төсөвт өртөг, ажлын гүйцэтгэлийг бодитой хянаж, баталгаажуулаагүй, хууль тогтоомжийн дагуу ногдуулах татвар, хураамжийг төлөөгүй, гэрээний үнийн дүнгээс татварыг хасаж байгуулсан зэргээр хууль зөрчсөн байна.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг төрийн нууцад хамааруулан худалдан авах ажиллагааг нээлттэй зохион байгуулахгүйгээр дэд ажлын хэсгийн зөвлөмжөөр холбогдох хууль, тогтоомжоор тавигдах шаардлагыг хангаагүй хуулийн этгээдтэй шууд гэрээ байгуулж, давуу байдал олгосон байж болзошгүй байна.
- Ирээдүйн өв санд төвлөрүүлэх 750.0 тэрбум төгрөгөөр Эрдэнэс-Тавантолгой ХК хаалттай өрийн бичиг худалдан авч бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлсэн, дээрх хөрөнгөнөөс Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдэд 67.0 тэрбум төгрөгөөр тоног төхөөрөмж, техник хэрэгсэл бэлтгэхдээ тухайн жилийн төсөвт тусгаж Улсын Их Хурлаас шийдвэр гаргуулаагүй нь хуульд заасан төрийн өмчийн талаарх Улсын Их Хурлын бүрэн эрхийн 8.1-д “УИХ бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх”, 8.2-т “...төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх хэмжээг тогтоох” гэж заасныг зөрчсөн байна.
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд бэлтгэл хангагдаагүй зэвсэгт хүчний анги, нэгтгэлийг дайчилснаас ажлын гүйцэтгэлд олгох санхүүжилтийн 67.0 тэрбум төгрөгийг зориулалт бусаар зарцуулж техник хэрэгсэл, тоног төхөөрөмж бэлтгэсэн нь дээрх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд төсөвт дарамт учруулахаар байна.
- Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Улаанбаатар төмөр зам ХНН нь өөрт олгогдоогүй эрх мэдлийг хэрэгжүүлж, төмөр замын далан, хоолой, гүүр, эрчим хүч, шилэн кабель, холбоо дохиоллын ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн удирдлагын зардлын 30 хувийг суутган авч, нийт 15.4 тэрбум төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан нь барилга, байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг бүрэн хэрэгжихгүй байх, алдагдах эрсдэлтэй байна.
- Төмөр замын трассын дагуу баригдсан инженерийн хийцтэй худгуудаас ахуйн хэрэглээнд ашиглаж буй ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын стандартыг хангахгүй байгаа нь иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажил:

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлаагүй, төслүүдийн техник эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр фидик гэрээг дотоодын аж ахуйн нэгж хооронд байгуулсан ч гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн зарим заалтууд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжид нийцээгүй, харилцан ашигтай байхаар тохиролцоогүй байна.
- Тавантолгой, Гашуунсухайт өртөөдийн ажилтан албан хаагчдын амьдрах суурьшлын бүс байгуулах 45.0 сая ам.долларыг Гашуунсухайт өртөөнд баригдах шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтад зарцуулснаар орон сууц барих хөрөнгийн эх үүсвэргүй болжээ.
- Нүүрс ачих логистикийн төвийн техник эдийн засгийн үндэслэлийг хууль, журамд нийцүүлэн баталгаажуулаагүй, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-

Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгээгүй байхад гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

- Гашуунсухайт-Ганц мод хил дамнасан төмөр замын холболтын ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулаагүйгээс Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл ойрын хугацаанд эдийн засаг, нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээргүй байна.
- Тавантолгой төмөр зам ХХК-ийн удирдах албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж, гуравдагч этгээдийн баталгаагүйгээр их хэмжээний урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид олгосон байна.
- Засгийн газраас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр шийдвэрлэснээр Эрдэнэс-Тавантолгой ХК -ийн 2022 оны жилийн эцсийн байдлаар олгосон нийт 8.1 сая тонн нүүрсийг өрсөлдөөний журмаар борлуулах бус, хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжилтэд олгосноос ойролцоогоор 57.4 сая ам.долларын орлого олох боломжийг алджээ.
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт хийгдэх талбайн 471 га нь улсын хилийн зурваст, 495 га нь улсын тусгай хамгаалалтай Говийн бага Дархан цаазат газарт хамаарч байхад холбогдох байгууллагаар шийдвэр гаргуулалгүй бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явуулж байна.
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажил гүйцэтгэх гэрээ, санхүүжүүлэх гэрээг тусад нь байгуулсан, ажлын гүйцэтгэл удааширсан, санхүүжилтийн гэрээнд төлбөрийг нүүрсээр 60 сарын хугацаанд ижил хэмжээгээр барагдуулахаар байсныг өөрчилсөн зэргээс Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд гүйцэтгэлээс 56.6 тэрбум төгрөгөөр илүү санхүүжилт олгожээ.

ЗӨВЛӨМЖ

УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар бодлогын баримт бичигт тавигдах шаардлагад нийцээгүй, суурь түвшин, хүрэх үр дүн нь хэмжигдэхүйц байдлаар боловсруулагдаагүй, хэрэгжилтэд оролцогч талуудын эрх үүргийг оролцоог тодорхойлоогүй, санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүйгээс хэрэгжилтийг үнэлэх боломжгүй;
- Ирээдүйн өв санд төвлөрүүлэх хөрөнгийг Улсын Их Хурлын шийдвэргүйгээр төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулах, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр тоног төхөөрөмж, техник хэрэгсэл бэлтгэх зэргээр Монгол Улсын төсөв нэгдсэн байх суурь зарчмыг алдагдуулж, хууль тогтоох дээд байгууллага төрийн өмчийн өмчлөгч байх, эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэм хэмжээг зөрчсөн;
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажил хийгдэж буй Монгол Улсын урд хил хүртэлх төмөр замын шугамын чигийн дагуух нийт 966 га газар нь улсын хилийн зурвас болон дархан цаазат газарт хамаарч, тусгай хэрэгцээнд авах асуудлыг Улсын Их Хурлаас шийдвэрлэхээр байгаа зэрэгт анхаарлаа хандуулна уу.

Аудитын илрүүлэлт, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд:

- Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын үр дүнг бодитой үнэлж, цаашид бүтээн байгуулалт хийх эрх зүйн орчныг бүрдүүлж, зөрчил давтагдан гарах эрсдэлээс сэргийлэх;
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын хил орчмын бүтээн байгуулалт хийгдэх улсын хилийн зурвас болон тусгай хамгаалалтай газарт харьяалагдаж буй газрын хэмжээ, заагийг нарийвчлан тогтоож, хуульд нийцүүлэн шийдвэрлүүлэх;
- Тавантолгой-Зүүнбаян, Зүүнбаян-Сайншанд чиглэлийн төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах;
- Эрээн-Замын-Үүд боомтын дамжуулан өнгөрүүлэх өртөө, зөрлөгүүдийн тээх, нэвтрүүлэх хүчин чадал, солилцох галт тэрэгний тоог нэмэгдүүлэх талаар холбогдох талтай хэлэлцээр хийж Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг богино хугацаанд дуусгах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод:

- Төмөр замын бүтээн байгуулалтын ажил хийх хууль, тогтоомжийн нийцлийг хангаж, шаардлагатай хууль, журмын өөрчлөлтийн санал, норм ба дүрэм, стандартуудыг боловсруулж, батлуулах, мөрдөж ажиллах;
- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг хязгаарлаж буй Зүүнбаян-Сайншанд чиглэлийн суурь бүтэц, Эрээн-Замын-Үүд боомтын дамжуулан өнгөрүүлэх өртөө, зөрлөгүүдийн тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх ажлын төлөвлөгөөг гаргах, хэрэгжилтийг хангах;
- Төслүүдийн төмөр замын суурь бүтцийн галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалтад харилцан адилгүй тохируулга бүхий программ хангамжийг ашиглаж байгаа нь цаашид үндэсний нэгдсэн сүлжээ үүсгэхэд нэмэлт зардлууд

шаардах эрсдэлтэйг анхаарч, дунд хугацаанд хөгжүүлэх зөөлөн дэд бүтцийн уялдааг хангах;

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэд:

9. Улсын хэмжээнд шинээр баригдсан болон төлөвлөж буй төмөр зам нь туруутан амьтадын амьдрах орчныг хэсэгчлэн хувааж болзошгүй байгаа тул төмөр зам дагуу байгуулсан нүхэн болон гүүрэн гарцыг зэрлэг амьтад ашиглаж байгаа эсэхийг нарийвчлан судалж, мониторинг хийх;
10. Бүтээн байгуулалт хийгдсэн газар нутагт ашиглагдсан түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын нөхөн сэргээлтийг дутуу хийх, орхигдуулах тохиолдлууд гарч байгаа тул нөхөн сэргээлтийн талбайд мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгэж, үр дүнг тайлагнах;
11. Төмөр замын трассын дагуу өргөст тор татсан нь мал, зэрлэг амьтад эндэх эрсдэлийг үүсгэж байгаад анхаарч, хөдөлгөөний аюулгүй байдлыг нэгдсэн нэг стандарт, нэг шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэлд:

12. Төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалт, хөрөнгийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулж, компанийн ашигт ажиллагааг дээшлүүлэх, өр авлагыг барагдуулах, дамжуулан зээлийн төлбөрийн эргэн төлөлтийн хугацааг компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулах арга хэмжээ авах;

Эрдэнэс-Тавантолгой ХК-д:

13. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд төслүүдэд хөрөнгө оруулах, оруулсан хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, өгөөж хүртэх нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлж ажиллах;

Монголын төмөр зам ТӨХК, Тавантолгой төмөр зам ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

14. Төмөр замын суурь бүтэц эзэмшигчийн хувьд төмөр замын ашиглалтын үйл ажиллагааг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
15. Компанийн засаглалыг сайжруулж, үйл ажиллагааны цар хүрээтэй нийцсэн бүтэц, орон тоогоор ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авах;
16. Галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалтыг хангах кибер аюулгүй байдал хариуцсан бүтцийн нэгж, орон тоог бий болгох;

Монголын төмөр зам ТӨХК-д:

17. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дагуух инженерийн хийцтэй худгуудад тоолуур суурилуулж, хэрэглээнд хяналт тавих, ундны усны стандарт, шаардлагыг хангуулах;
18. Бүтээн байгуулалтын ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын нөхөн сэргээлтийн бүрэн хийлгэж, орон нутагт хүлээлгэн өгөх;
19. Зүүнбаян төмөр зам ХХК-аас шилжүүлэн авсан хөрөнгөд үнэлгээ хийлгэж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;
20. Өртөө, зөрлөгүүдийн серверийн тоног төхөөрөмж суурилагдсан өрөө тасалгааг стандартын шаардлагад нийцүүлэх;
21. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд үнэлгээ хийлгэж, хөрөнгө оруулалтын тогтоосон хувь хэмжээгээр бүртгэж, зөрүүг хэрхэн шийдвэрлэх талаар холбогдох байгууллагаар шийдвэр гаргуулах;

Тавантолгой төмөр зам ХХК-д:

22. Бүтээн байгуулалтын ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг бүрэн нөхөн сэргээлгэж, орон нутагт хүлээлгэн өгөх;
23. Зүтгүүргүйгээс шалтгаалан вагоны ашиглалт буурч, гэрээний талууд хугацааг удаа дараа сунгаснаас зүтгүүрийн түрээсэнд төлөвлөөгүй зардал гарч байгаад анхаарч, нийлүүлэлтийг түргэвчлэх арга хэмжээ авах;
24. Гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр олгохдоо хууль, журамд нийцүүлэн гуравдагч этгээдээр баталгаа гаргуулж байх;
25. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт хийгдэж буй улсын тусгай хамгаалалтай болон Говийн бага Дархан цаазат газрыг тусгай хэрэгцээнд авах асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;
26. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд үнэлгээ хийлгэж, хөрөнгө оруулалтын тогтоосон хувь хэмжээгээр бүртгэж, зөрүүг хэрхэн шийдвэрлэх талаар холбогдох байгууллагаар шийдвэр гаргуулах;
27. Өртөөдийн ажилтан албан хаагчдын амьдрах орон сууц барих санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж хэрэгжилтийг хангах

Өмнөговь, Дорноговь аймгийн Засаг даргад:

28. Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын дагуух өртөө, зөрлөгт ашиглаж байгаа ундны усыг эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангуулах, бүтээн байгуулалтад ашиглаж байгаа усны нөөцийг тоолууржуулах, хэрэглээнд байнгын хяналт тавих;
29. Төмөр замын бүтээн байгуулалтад ашиглуулсан түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг бүрэн нөхөн сэргээлгэн хүлээн авах;

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Монголын төмөр зам ТӨХК-аас ирүүлсэн санал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний аудитын газраас "Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө үр дүн" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасны дагуу саналыг гарган хүргүүлж байна.

Хавсралт 14 хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ОТГОНСҮХ

2023081608

Тайлбар 1-
ыг харна уу

А. Зөвлөмжид оруулах саналууд:

1. Монгол Улсын Засгийн газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт

а. Дамжуулан зээлтэй холбоотой асуудлын талаар:

Монгол Улсын Засгийн газар ба БНХАУ-ын Экспорт-Импорт банкны хооронд 2008 оны 12 сарын 31-ний өдрийн зээлийн хэлэлцээрийн дагуу тус Банк нь Монгол Улсад 300,000,000.00 ам.доллартой тэнцэх зээл олгохыг зөвшөөрсөнтэй холбоотойгоор тус зээлийн хөрөнгөөс "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн хэсгийн парк шинэчлэл төсөл"-ийг хэрэгжүүлэхэд зориулан Сангийн яам, Зам тээвэр хөгжлийн яамны хооронд 2012 оны 02 дугаар сарын 07-ны өдөр "Дамжуулан зээлдүүлэх гэрээ" байгуулан 64,280,560 ам.долларыг дамжуулан зээлдүүлсэн байдаг.

Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээг мөн доорх хугацаануудад Монголын төмөр зам ТӨХК-ийг эцсийн зээлдүүлэгч болгож шилжүүлсэн:

- 201015122 CNR "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн /зүтгүүр, вагон, калмар/-ий паркийг нэмэгдүүлэх төсөл"-ийн 35,692,160.00 ам.долларын зээл, хуримтлагдсан хүүгийн төлбөл зохих дүн 3,962,507.53 ам доллар бүгд 39,654,667.5 ам долларын хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээг 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан.
- OL201124175, CSR "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн/ Машин механизм/ нийлүүлэх төсөл" 21,441,300.00 ам долларын зээл, хуримтлагдсан хүүгийн төлбөл зохих дүн 7,147,100.0 ам доллар, хуримтлагдсан хүүгийн төлбөл зохих дүн 3,546,433.66 ам доллар бүгд 32,134,833.66 ам долларын хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх нэмэлт гэрээг 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан.
- OL-2719-MON "Бүс нутгийн логистик төвийг хөгжүүлэх төсөл"-ийн 35,469,977.05 ам.долларын зээл, хуримтлагдсан хүүгийн төлбөл зохих дүн 3,042,676,485.12 төгрөгийн дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээг 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр тус тус байгуулсан байна.

Дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээнд 2019-2021 он хүртэлх ашиглаагүй зээлийн хуримтлагдсан хүүгийн төлбөр 7,508,941.19 ам доллар мөн 3,042,676,485.12 төгрөг тус тус байна. 2019-2022 онд төлөх зээл хүүгийн төлбөрт 28.3 тэрбум төгрөг, 1,810,864.64 ам долларыг тус тус төлж, гадаад валютын ханшийн зөрүүгийн хуримтлагдсан алдагдал 66.7 тэрбум төгрөгт хүрээд байна.

2022 онд нийт 56.7 тэр бум төгрөгийн авлагатай, 1,694.1 тэр бум төгрөгийн өр төлбөртэй, 48.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Мөн зүтгүүр, вагон шийдэгдээгүй, ачаа эргэлт бага/5 сая.тн-с бага/ үед алдагдал үргэлжлэхээр байна.

Тус компани нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 98.2 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажилласны 67.9 хувь буюу 66.7 тэрбум төгрөг нь дээрх дамжуулан зээлдүүлэх гэрээнээс үүссэн ханшийн зөрүүгийн хуримтлагдсан алдагдал байна.

Ийнхүү Дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээний зээлийн төлөлт, хуримтлагдсан хүүгийн төлбөр, гадаад валютын ханшийн зөрүүгийн хуримтлагдсан алдагдал зэрэг нь "Монголын төмөр зам" ТӨХК-ийн эдийн засаг, санхүүгийн чадварыг ноцтой хүндрүүлж, байгаагаас шалтгаалж, Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Монголын төмөр зам ТӨХК хооронд байгуулсан Дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээгээр хүлээсэн зээлүүдийн төлбөр, хүүгийн төлбөр хугацаандаа бүрэн төлөхгүй байдалд хүргэжээ.

Дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээгээр хүлээсэн зээлийн эргэн төлөлт, хуримтлагдсан хүү, гадаад валютын ханшийн зөрүүгийн хуримтлагдсан алдагдлын эцсийн

хугацаа /2032-2037 он/-нд төлөх бололцоог олгохын тулд "Монголын төмөр зам" ТӨХК-ийн цаашдын үйл ажиллагааг төр, засгаас доорх арга хэмжээ авч дэмжиж өгөхийг **уламжилж байна**. Үүнд:

- Дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээгээр хүлээн авсан хөрөнгүүд нь эдийн засгийн эргэлтэд орж үр ашгаа өгөх боломж хараахан бүрдээгүй эхлэлтийн байдалтай байгааг харгалзан үзэж Дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээний зээлийн эргэн төлөлт, хуримтлагдсан хүү, гадаад валютын ханшийн зөрүүгийн хуримтлагдсан алдагдлыг төлөх төлөлтийн **хугацаанд өөрчлөлт оруулах;**
- 2019 оноос өмнөх хугацааны Дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээний зээл, хуримтлагдсан **хүүгийн төлөлтөөс чөлөөлөх;**
- Монголын төмөр зам ТӨХК нь дамжуулан зээлдүүлэх гэрээнээс үүссэн ханшийн зөрүүгийн алдагдал 66.7 тэрбум төгрөгт хүрч байгаа нь жил тутам өсөж байгаа валютын ханшийн өөрчлөлттэй уялдаж байгаа тул дамжуулан зээлийн гэрээний валютын нөхцөлийг төгрөгт **хөрвүүлэн шинэчлэн өөрчлөх;**

МТЗ ТӨХК нь ойрын болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөтэй уялдуулан үр ашгийн тооцоог боловсруулан холбогдох газруудад танилцуулах нь зүйтэй байна.

Тайлбар 2-ыг
харна уу

б. Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийг техникжүүлсэн 67.0 тэрбум төгрөгтэй холбоотой асуудлын талаар:

Монгол Улсын их хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг эхний үе шатанд барих, Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 2-т: Улсын эдийн засаг, нийгэмд ач холбогдол бүхий төмөр замын суурь бүтцийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар цогцоор нь барьж байгуулах зорилгоор энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төмөр замын суурь бүтцийг барих **тусгай зөвшөөрлийг** "Монголын төмөр зам" ТӨХК-д олгосон байна.

Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолоор "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗҮ-д тулгуурлан шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн хүүгүй, 20 хүртэл жилийн хугацаатай 750.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнээр хаалттай хүрээнд гаргажээ.

"Монголын төмөр зам" ТӨХК болон "Зэвсэгт хүчний жанжин штаб"-ын хооронд 2019.06.12-ны өдөр "Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулан тухайн төслийн бүтээн байгуулалтын ажилд гүйцэтгэгчээр Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдэд оролцсон байна.

Эдгээр нэгтгэлүүд нь төмөр замын ажлыг богино хугацаанд, өртөг багатай гүйцэтгэхийн тулд өөрийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан хүн хүчний нөөцийг бэлэн болгосон бөгөөд техник, хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүсэж худалдан авах техник, хэрэгслийн тооцоо, судалгааг гаргаж Засгийн газрын Хэрэг зрхлэх газрын даргын тушаалаар байгуулагдсан Дэд ажлын хэсэгт танилцуулжээ.

Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар төмөр замын доод бүтцийн барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн тооцоо, санхүүжилтийн асуудлыг танилцуулсан бөгөөд хуралдаанаас бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Батлан хамгаалахын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Монголын төмөр зам ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус даалгасан шийдвэр гарсан байна.

Дээрх шийдвэрийн дагуу Монголын төмөр зам ТӨХК-иас техник, хэрэгслийн худалдан авалтад зориулж 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдөр 21,417,603,000.00 төгрөг, 2019 оны

08 дугаар сарын 19-ний өдөр 45,600,000,000.00 төгрөгийг Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газрын дансанд шилжүүлжээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 44 дүгээр тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу Зэвсэгт хүчинд 24 нэр төрлийн 66,9 тэрбум төгрөгийн 296 нэгж техник, материал, хэрэгслийг худалдан авч, 2019-2022 онуудад төмөр замын доод, дээд бүтэц, өртөө, зөрлөг, гүүрийн барилга угсралт, төмөр замын шугамын нэгдүгээр үеийн балласт тээвэрлэх, дэвсэх, зам төмөр, уулзварын бэхэлгээ угсрах, балласт ангиллын чулуу бутлах, бетон зуурмаг үйлдвэрлэх, тээвэрлэх ажлуудыг хийжээ.

Төслийн захиалагч Монголын төмөр зам ТӨХК болон ерөнхий гүйцэтгэгч Зэвсэгт хүчний Жанжин штаб хооронд байгуулсан гэрээний дагуу 2019-2021 онуудад Зэвсэгт хүчний ангиуд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын доод бүтцийн барилгын ажлыг гүйцэтгэж дуусгасан байна.

Хүснэгт 1

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн ерөнхий мэдээлэл-2023.08.15

№	Гүйцэтгэний утга	Нийт санхүүжилтийн дүн,төг	Үүнээс		Тайлбар
			750 тэрбум төгрөгийн бондоос	ЭТТ ХК-иас шилжүүлсэн санхүүжилт,төг	
	ЭТТ ХК-с төсөлд бонд болон хөрөнгө оруулалтаар оруулсан дүн	1,316,123,253,693			
	Үүнээс зарцуулалт:				
1	<u>Төслийн суурь бүтцийн бүтээн байгуулалтын санхүүжилтэд</u>	<u>1,238,817,704,249</u>	<u>682,982,397,000</u>	<u>555,835,307,249</u>	
2	Зэвсэгт хүчний Барилгын цэргийн удирдах газарт тоног төхөөрөмж худалдан авч өгсөн	67,017,603,000	67,017,603,000		
3	Зүүнбаян төмөр зам ХХК-н үйл ажиллагааны зардал	10,287,946,444		10,287,946,444	ЭТТ ХК-с ЗБТЗ ХХК-руу санхүүжүүлсэн дүн
	Нийт дүн	1,316,123,253,693	750,000,000,000	566,123,253,693	

Хүснэгт 1-ээс харахад: Эрдэс таван толгой ХК-иас өнөөдрийн байдлаар 1,316 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Үүнээс:

- **1,238** тэрбум төгрөгийг төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтад,
- **67.0** тэрбум төгрөгийг ЗХЖШ-г техникжүүлэхэд /Засгийн газрын хуралдааны 36 дугаар тэмдэглэлээр ЗХЖШ-д зориулан техник, тоног төхөөрөмжийг худалдан авах тухай тэмдэглэл болон дэд ажлын хэсгийн зөвлөмжид тулгуурлан олгосон/,
- **10.28** тэрбум төгрөг “Зүүнбаян төмөр зам” ХХК-ны үйл ажиллагааны зардал, тоног төхөөрөмжийн зардалд /ЭТТ ХК-иас шууд ЗБТЗ ХХК-д шилжүүлсэн/ тус тус зарцуулсан байна

Төслийг санхүүжүүлэгч Эрдэнэс таван толгой ХК-с Засгийн газрын хуралдааны 36 дугаар тэмдэглэл, ЗХЖШ-д зориулан техник, тоног төхөөрөмжийг худалдан авах тухай тэмдэглэл болон дэд ажлын хэсгийн зөвлөмжид тулгуурлан олгосон **67.0** тэрбум төгрөгийг Монголын төмөр зам ТӨХК-д нэмж санхүүжүүлэх асуудлыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Энэ нь төслийн суурь бүтцийн бүтээн байгуулалтын санхүүжилт тэр хэмжээгээр дутагдаж төслийн ажил зогсох эрсдэлтэй байдлыг бий болгож байна.

Ийнхүү **67.0** тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй уг төслийн суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг тасралтгүй үргэлжлүүлэхийн тулд Монголын төмөр зам ТӨХК-ийн цаашдын үйл ажиллагааг төр, засгаас доорх арга хэмжээ авч дэмжиж өгөхийг уламжилж байна.Үүнд:

- Үндэсний компани болох Монголын төмөр зам ТӨХК-ийн хэрэгжүүлж байгаа

төслийн суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардлагатай 67.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж өгнө үү?

Ингэснээр Тавантолгой-Зүүнбаян төмөр замын төслийн суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд бүрэн хийгдэж дуусах ба төслийн үр өгөөжийг хүртэх нөхцөл боломж бүрдэх болно.

Тайлбар 3-
ыг харна уу

в. Төмөр замын үйл ажиллагааг төрөөс дэмжих талаар:

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 1.1.1 "Төрөөс төмөр замын тээврийн талаарх баримтлах бодлого"-ын зорилго нь төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, ирээдүйд өсөн нэмэгдэх тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг үр дүнтэй хангахад чиглэсэн **үр ашигтай үндэсний төмөр замын** дотоодын нэгдсэн сүлжээг өргөжүүлж, улмаар улс орны дамжин өнгөрүүлэх чадавхыг дээшлүүлэн, салбарын эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ашигт малтмалын томоохон ордуудыг ашиглах, тэдгээрийн бүтээгдэхүүнийг экспортлох болон боловсруулан экспортолж улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, **ирээдүйн тогтвортой хөгжлийг** хангахад оршино", 6.1.1 "Бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бодлого, зохицуулалтаар хангана" гэж заасан байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "энэ хуулиар өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагааг зохицуулна" гэж заасны дагуу Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж болон дээрх Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого нь өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замын тээврийн бүх төрлийн үйл ажиллагаанд нэгэн адил үйлчлэхээр байна.

Иймд Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд нэгэн адил эрх үүрэгтэй Монголын төмөр ТӨХК-ыг Улаанбаатар төмөр зам ХНН-ийн адил түвшинд Төрөөс татварын талаар дэмжиж өгөх нь зүйтэй байна. Тухайлбал, Төслийн бүтээн байгуулалтын хүрээнд бий болсон 1.3 их наяд төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг үл хөдлөх хөрөнгийн албан татвар, НӨАТ, хөдлөх бүрэлдэхүүний худалдан авалтыг гааль, татвараас тус тус чөлөөлөх нь зүйтэй байгааг **уламжилж өгнө үү.**

Ингэснээр Монголын төмөр ТӨХК-ийн санхүүгийн чадавх, үр ашиг сайжирч үйл ажиллагаа тогтворжиж, Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах нэгдсэн бодлого, зорилтыг ханган ажиллах нөхцөл боломж бүрэн бүрдэх болно.

2. "Монголын төмөр зам" ТӨХК-д:

Зөвлөмжид өгөх санал

а. Өр авлагын талаар:

"Монголын төмөр зам" ТӨХК нь гэрээний дагуу 2022, 2023 онд өрийн бичгийн буцаан төлөлтийг хийгээгүй, санхүүгийн тайланд 1,611.1 тэрбум төгрөгийн урт хугацаат өр төлбөр, 83.7 тэрбум төгрөг богино хугацаат **өр төлбөртэй** байна. Нийт урт хугацаат өр төлбөрийн 20.1 хувь буюу 337.1 тэрбум төгрөг нь дамжуулан зээл, 79.9 хувь буюу 1,274.0 тэрбум төгрөг нь Тавантолгой-Зүүнбаян төслийн санхүүжилтийн эх үүсвэр эзэлж байна.

- Санхүүгийн тайланд тусгагдсан урт болон богино хугацаат өр төлбөрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар шийдвэр гаргах түвшинд танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

- Цаашид Төмөр замын тээврийн үйл ажиллагаа жигдрүүлж, компанийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд өр авлагын зохистой харьцааг хадгалан, санхүүгийн сахилга батыг хангаж ажиллах шаардлагатай байна.

Мөн “Монголын төмөр зам” ТӨХК нь Монгол улсын холбогдох хуулийг зөрчин **Монгол улсын хуулийн этгээдтэй** гадаад валютаар гэрээ байгуулж, ханшийн зөрүүгийн алдагдалд орж, өр төлбөрийг нэмэгдүүлсэн нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байгаа тул энэ асуудлыг хугацаа алдалгүйгээр хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

- Цаашид харилцагч байгууллагуудтай гэрээ байгуулахдаа Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах нь зүйтэй.

Тайлбар 5-ыг
харна уу

Албан шаардлага болгох санал

“Монголын төмөр зам” ТӨХК нь 2022.12.31-ний байдлаар богино болон урт хугацаат зээлийн төлбөр ихтэй хэрнээ өөрийн ажил үйлчилгээний **авлагыг** барагдуулахад арга хэмжээ аваагүйгээс “Монголиан транс лайн” ХХК, “Монголиан транс ложистик” ХХК зэрэг компаниудаас их хэмжээний авлагатай байгаа нь компанийн санхүүгийн үйл ажиллагааг доголдуулахад шууд нөлөөлж, цаашлаад үндэсний компани болон тогтвортой ажиллахад хүндрэл учруулах эрсдэлтэй байгаа тул хоорондын тооцоог барагдуулж, шаардлагатай бол дараагийн арга хэмжээг авч ажиллах тухай албан шаардлагыг хугацаатай ирүүлж өгнө үү.

Тайлбар 6-г
харна уу

Б. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах талаар

Монголын төмөр зам ТӨХК нь “Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж болон Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд үндэсний төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээг өргөжүүлж, улс орны дамжин өнгөрүүлэх чадавхыг дээшлүүлэн, нийгмийн хөгжлийг хурдасгах, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангахын тулд санхүүгийн үр ашигтай ажиллах нөхцөлийг судлан үзэж төрөөс бодлогоор дэмжүүлэх саналаа холбогдох шийдвэр гаргах түвшинд уламжлан ажиллах нь зүйтэй.

Ингэснээр Монголын төмөр зам ТӨХК-ийн санхүүгийн чадавх, үр ашиг сайжирч үйл ажиллагаа нь тогтворжин, цаашлаад улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангахад үр нөлөөгөө өгөх болно.

Тайлбар 7-г
харна уу

Б. Тайлангийн төсөлд оруулах саналууд:

1. Тайлангийн төслийн 1.38 дахь заалтад дараах тайлбар саналыг гаргаж байна.

“Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн 416.1 км төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл боловсруулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэсэн. Эхний үе шатны ажлын хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 50 км буюу 240-290-р км-ийн ажлын зураг төслийг боловсруулж баталгаажуулан ЗХЖШ-ын бүтээн байгуулалтын дэмжлэгийн газарт өгсөн. Бүтээн байгуулалтын газар шорооны ажил 2019 оны 05 дугаар сарын 24-нд эхэлсэн. Уг **50км** зургийн **10.807км** болох **280-290.807км** хэсгийн зургийг **2019.06.06**-ны өдөр ЗХЖШ-т барилга угсралтын ажил гүйцэтгүүлэхээр акт үйлдэн хүлээлгэн өгсөн.

Монголын төмөр зам ТӨХК болон ЗХЖШ-ын хооронд 2019 оны 06 сарын 12-ны өдөр “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх АГГ-Н/1901, Н/387 дугаар гэрээг байгуулж, **2019.08.01-ны өдөр 188-219.5км, 219.5-240км, 401-416.165км, 386-401км-ийн** хэсэгчилсэн зургийг, **2019.10.21-ны өдөр 345-370км, 84-124км, 124-154км, 4-44км, 44-84км, 154-188км** хэсэгчилсэн зургийг тус тус үе шаттайгаар гүйцэтгэж, магадлалаар баталгаажуулж дууссан. Үүний дараа магадлуулсан зургуудыг тухай бүрт нь ЗХЖШ-д хүлээлгэн өгсөн, 2023.05.15-ны өдөр зохиогчийн дүгнэлтийг хийж дуусгаж, 2023.08.01-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн.

Уг ажил дууссан тул тайлангийн төслийн 1.38 дахь асуудлыг эргэн харж өгнө үү.

Тайлбар 8-
ыг харна уу

2. Тайлангийн төслийн 2.35 дахь заалтад өгсөн дүгнэлтэд дараах тайлбар саналыг гаргаж байна.

Тайлангийн төсөлд "Төмөр замын байгууламжийн зураг төсөл, төсвийг боловсруулж, эрх бүхий байгууллагууд магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргаж ажилласан боловч төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулаагүй байна." гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй байна. Учир нь төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулсан болно./нотлох баримт хавсаргав/

Иймд уг дүгнэлтийг "Төмөр замын байгууламжийн зураг төсөл, төсвийг боловсруулж, эрх бүхий байгууллагууд магадлалын ерөнхий дүгнэлтийг доод бүтцийн ажил тус бүрд гаргаж магадлалаар баталгаажуулсан байна" гэж өөрчлүүлэх саналтай байна.

Тайлбар 9-
ийг харна уу

3. Тайлангийн төслийн 2.37 дахь заалтад дурдсан "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын трассын дагуух төмөр замын зураг төслийг боловсруулж, баталгаажуулсан байдал" гэсэн хүснэгт 26-ын "төсөвт өртөг"-баганад тэмдэглэсэн утгыг тайлангийн 2.35-д оруулсан саналтай уялдуулан өөрчлөх өөрөөр хэлбэл хүргүүлж байгаа тайлбар хүснэгтийн дагуу засаж өөрчлүүлэх саналтай байна. /хавсралтаар хүргүүлж байна./

Тайлбар 10-
ыг харна уу

4. Тайлангийн төслийн 1.68 дахь заалтын дээр бичигдсэн "Бүтээн байгуулалтын зарим ажлыг санхүүжүүлэх зорилгоор авсан дамжуулан зээлийн зээл, хүүгийн төлбөр хугацаандаа бүрэн төлөгдөөгүй байна." гэсэн дүгнэлтийг дараах байдлаар өөрчилж өгнө үү

"МТЗ ТӨХК-ийн үндсэн тээвэр, логистикийн үйл ажиллагаанд зориулан эцсийн зээлдүүлэгчээр шилжүүлэн авсан зээлүүдийн зээл, хүүгийн төлбөр нь хугацаандаа бүрэн төлөгдөөгүй байна" гэж засуулах саналтай байна.

Учир нь төслийн бүтээн байгуулалтын ажилд дамжуулан зээл нь ямар ч холбогдолгүй тусдаа асуудал болно.

5. Тайлангийн төсөлд ЗХБИЦУГ-аас ирүүлсэн саналын албан тоотыг бүрэн эхээр нь хавсарган хүргүүлж байна.

Тайлбар 11-
ийг харна уу

В. Тайлангийн ерөнхий дүгнэлтэд дараах саналыг гаргаж байна.

Тайлангийн төслийн ерөнхий дүгнэлт "ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛҮҮДИЙГ ЦОГЦ БАЙДЛААР ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС ШАЛТГААЛАН ОЙРЫН ХУГАЦААНД ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛД ЗААСАН ҮР АШГАА ӨГӨХӨӨРГҮЙ МУХАР ЗАМ БОЛСОН БАЙНА" гэснийг дараах байдлаар өөрчлөн тусгуулах саналтай байна. Үүнд:

"ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛҮҮДИЙГ ҮР ӨГӨӨЖТЭЙ БОЛГОХЫН ТУЛД ЦОГЦ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГДСЭН ТӨМӨР ЗАМТАЙ БАЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА."

Учир нь Төмөр замын техник ашиглалтын дүрэмд зааснаар мухар зам гэдэг ойлголтыг дараах байдлаар тодорхойлсон байна.

Барих мухар зам- Сунгуу уруу дээр явж байгаа галт тэрэг жолоодлого алдсан, өртөөний замаас зүтгүүргүйгээр өөрөө хөдөлсөн хөдлөх бүрэлдэхүүнийг оруулах зориулалттай мухар зам

Иймд тайлангийн ерөнхий дүгнэлтийг дээрх байдлаар өөрчилж өгнө үү. Ингэснээр шийдвэр гаргах түвшин болон олон нийтэд зохистой зөв ойлголт хүрэх болно.

Монголын төмөр зам ТӨХК-ийн ирүүлсэн саналд өгөх тайлбар:

- Тайлбар 1. Дамжуулан зээлийн их хэмжээний өр төлбөр үүссэн талаар тайланд тусгасан бөгөөд саналыг хүлээн авч зөвлөмжид өөрчлөлт оруулав.
- Тайлбар 2. Санал өгсөн агуулга тайланд бүрэн хэмжээгээр тусгагдаж, албан шаардлага өгч байгаа тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
- Тайлбар 3. Санал ирүүлсэн асуудал аудитын хамрах хүрээнд ороогүй бөгөөд Монголын төмөр зам ТӨХК-ийн үл хөдлөх хөрөнгийн албан татвар, НӨАТ, гааль болон бусад татвараас чөлөөлөгдөх, хөнгөлөлт үзүүлэх асуудал нь хуулиар зохицуулагдах үйл ажиллагаа тул холбогдох байгууллагаар дамжуулан шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.
- Тайлбар 4. Саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан.
- Тайлбар 5. Дурдсан үйл ажиллагаа аудитад хамрагдаагүй тул саналыг хүлээн аваагүй.
- Тайлбар 6. Санал аудитын зорилготой уялдаагүй, аудитад хамрагдаагүй тул саналыг хүлээн аваагүй.
- Тайлбар 7. Тухайн асуудал нотлох баримтаар бүрэн дэмжигдэж байх тул тайлангаас хасах шаардлагагүй гэж үзлээ.
- Тайлбар 8. Нотлох баримтаар бүрэн дэмжигдэж байх тул тайланд өөрчлөлт оруулаагүй.
- Тайлбар 9. Тайлбар 8-д дурдсан асуудал тул тайланд өөрчлөлт оруулаагүй.
- Тайлбар 10. Саналыг хүлээн авч найруулгын өөрчлөлт оруулав.
- Тайлбар 11. Саналыг хүлээн авч найруулгын өөрчлөлт оруулав.

Тавантолгой төмөр зам ТӨХК-аас ирүүлсэн санал



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК

14230 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Нарны зам 62, Юнион Бюлдинг Б блок, 11 дүгээр давхар
Утас: 7777 7727, 7777 7877,
И-мэйл: info@ttz.mn, Вэбсайт: www.ttz.mn

2023.08.18 № 111472
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.НАРАНЧИМЭГ ТАНАА

Тайлангийн төсөлд санал өгөх тухай

Үндэсний Аудитын газраас хийсэн “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн Аудитын талбарын ажил дуусаж, “Төрийн аудитын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18-ны 1 дэх хэсэгт заасан дагуу тайлангийн төсөлд санал авахаар 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1421 тоот албан бичиг ирүүлсэн байна. Энэ дагуу бид дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч тайлан, түүний дүгнэлт хэсгүүдтэй газар, хэлтсийн дарга, инженерүүдийг нэг бүрчлэн танилцуулж зарим дүгнэлтэд хариу санал, тайлбаруудыг бэлтгүүлж 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн “Union building” дэх оффисын хурлын танхимд төслийн гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-ийн төлөөллийг байлцуулан уулзалт зохион байгуулж Аудитын ажлын хэсгийнхэнд танилцуулж хамтран ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй урт хугацааны бодлогын баримт бичиг болох “Алсын хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтуудын нэг болох хөрш зэргэлдээ орнуудтай холбогдож буй хилийн Боомтуудын нэвтрэх чадварыг сайжруулж, төмөр замын ачаа тээврийг нэмэгдүүлэхэд манай компаниас хэрэгжүүлж буй төслүүд чухал үүрэгтэй юм. Иймд “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хэрэгжүүлж буй төслүүдийг бүрэн дуусган ашиглалтад хүлээн авахтай холбоотой хууль эрх зүйн болон бодлого зохицуулалтын зарим арга хэмжээнүүдийг шуурхай авч шийдэл гарцуудыг тодорхойлох дараах саналуудыг Төрийн Аудитын байгууллагын тайлангийн зөвлөмж хэсэгт дэлгэрэнгүй тусгаж, УИХ, Засгийн Газар болон Монгол улсын Ерөнхий сайдын анхааралд хандуулж өгнө үү хэмээх хүсэлтийг гаргаж байна. Үүнд:

Тайлбар 1-
ыг харна уу

1. Шилжүүлэн ачих терминалын төсөл, хил холболтын ажлыг шуурхай зохион байгуулахад хууль эрх зүйн хувьд анхаарч тус төслийг хэрэгжүүлэх газар нутаг нь БНХАУ, Монгол улс хоёр орны хилийн онцгой бүсэд хамаарч байгаагаас гадна, улсын тусгай хамгаалалттай газар нутаг, улсын дархан цаазтай газрын ангилалд багтаж байгаад анхаарч, Засгийн газраас санал боловсруулж асуудлыг УИХ-д өргөн барьж холбогдох шийдвэр гаргуулан “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Тайлбар 2-
ыг харна уу

2. Мөн тус компанийн хэрэгжүүлж буй өөр нэг төсөл болох “Түүхий нүүрс ачих логистик төв”-ийн зам, барилгын ажлын талбарын тодорхой хэсэг /нүүрс ачилтын

11230051759

Тайлбар
3-ыг харна
уу

тойргийн 1 км орчим газар/ нь тус бүс нутагт нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулдаг “Энержи Ресурс” ХХК-ийн эзэмшлийн талбай дээгүүр дайран өнгөрч байгаа нь цаашид “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн суурь бүтцийн эзэмшил, ашиглалтад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байгаа тул хоёр компанийн хэрэгжүүлж буй төслийн талбайн газрын эзэмшил ашиглалтын талаар ирээдүйд гарч болзошгүй маргаанаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах талаар салбарын асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад чиглэл өгөх.

3. Төмөр замын “Гашуунсухайт” өртөөнд ажиллаж буй ажилтан албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилт хангагдаагүй, албан хаагчдын орон сууц нийтийн эзэмшлийн байгууламж барихад зарцуулагдах хөрөнгийг өөр бүтээн байгуулалтын ажилд шилжүүлэн зарцуулснаас шалтгаалан албан хаагчид оффисын зориулалтын байранд амарч, амьдардаг тул “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулалтын ажлын нэг хэсэг болох нийтийн эзэмшлийн суурьшлын бүсийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар салбарын яамнаас тодорхой чиглэл гаргуулж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах талаар зөвлөмжид тусгаж өгөх.

Тайлбар
4-ийг
харна уу

4. “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын гэрээ /ЕРС/-д заасан Багц-5 буюу хөдлөх бүрэлдэхүүн болох 16 ширхэг зүтгүүр болон сэлбэг хэрэгслийг BI-TTGS-WBS-0004-00 дугаар бүхий Мастер төлөвлөгөөний дагуу 2020 оны 8 дугаар сарын 01-нээс 2023 оны 09 дүгээр сарын 20-ны хооронд нийлүүлэхээр тохиролцсон боловч одоог хүртэл нийлүүлэгдээгүй байгааг холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын анхааралд хандуулж зөвлөмж болгож өгөх зэрэг асуудлууд болно.

Жич: Аудитын тайлангийн холбогдох хэсгүүдэд тусгуулахаар бэлтгэсэн 23 саналыг нотлох баримтын шаардлага хангасан гэж үзэж буй албан бичиг, санхүүгийн баримтын хуулбаруудыг хавсаргав.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.БУДБАЯР



Тавантолгой төмөр зам ТӨХК-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар 1. Аудитын тайланд шилжүүлэн ачих терминал болон хил холболтын төмөр зам барих газрын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа талаар тусгаж, уг асуудлыг УИХ-ын анхааралд хандуулж, Монгол Улсын Ерөнхий сайдад зөвлөмж өгсөн болно.

Тайлбар 2. Тайлангийн төсөлд ирүүлсэн санал нь нотлох баримтаар дэмжигдэхгүй байх тул саналыг хүлээн аваагүй.

Тайлбар 3. Саналыг хүлээн авч тайланд нэмэлт оруулсан.

Тайлбар 4. Ирүүлсэн санал мэдээллийн чанартай тул тайланд тусгаагүй.

Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газраас ирүүлсэн санал



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗАР

Газарчин 2, 24 дүгээр хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13291
Утас: 26 59 17, 92114837,
Цахим шуудан: bbdg_demjleg@mil.gov.mn,
Цахим шуудан: www.gsmf.gov.mn

2023.08.15 № 1087

танай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Аудитын тайлангийн төсөлд тайлбар,
санал хүргүүлэх тухай

Танай байгууллагаас "Монголын төмөр зам" ТӨХК-д хүргүүлсэн 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1418 дугаартай аудитын тайлангийн төсөлд санал авах тухай албан бичиг, тайланг 08 дугаар сарын 11-ний өдөр цахимаар хүлээн авч, танилцан дараах тайлбар, саналыг хүргүүлж байна.

Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.11 дэх заалт, 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр зарлиг, 2021 оны 208 дугаар зарлигаар батлагдсан "Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам", Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны мн/05/05 дугаар шийдвэр, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2019 оны 134 дүгээр тушаалыг үндэслэн Тагнуулын Ерөнхий газрын 2019 оны 01/174 дүгээр зөвлөмжийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4-т дахь заалтыг баримтлан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн "Шинэ төмөр зам" төслийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэсэн.

Аудитын тайлангийн төслийн дор дурдсан асуудлуудад дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

- Аудитын тайлангийн төслийн 1.34 дүгээр зүйлд "Зэвсэгт хүчний анги, нэгтгэл, БИЦУГ УТҮГ-ыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулах хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдээгүйгээс тэдний гүйцэтгэсэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтэц барих далан, ус зайлуулах хоолой, гүүр, өртөө зөрлөгийн барилгын ажлын төсөвт өртөгт төсвийн норм, жишиг үнэлгээгээр тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийн 3,072.5 сая, ашгийн 15,568.6 сая, НӨАТ-ын 14,999.2 сая төгрөгийг тайлагнаж баталгаажуулаагүй байна" гэсэн байна.

Нэмэгдсэн өртөгийн албан татварын талаарх тайлбар:

Тус бүтээн байгуулалтын ажлын доод бүтцийн ерөнхий гүйцэтгэгч Зэвсэгт хүчний Жанжин штаб нь дээрх ажлыг гүйцэтгэхийн тулд "Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар" УТҮГ (хуучин нэрээр)-ыг 2019 онд байгуулж, тус газрын чиг үүрэг, үйл ажиллагаанд шаардлагатай зардлууд тухайн жилийн төсөвт тусгагдаагүй, төмөр замын доод бүтцийн барилгын ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн.

2019-2021 онуудад төслийн ажлын хэрэгцээт бараа материал, хэрэгслийг үндэсний аж ахуйн нэгжүүдээс НӨАТ-тэй худалдан авалт хийж (И-баримт) цахим татварын тайлангийн системд 16,965,854,233.81 төгрөгийг бүртгүүлсэн бөгөөд энэ хөрөнгө Монгол Улсын төсөвт төвлөрсөн.

1316037073

Тайлбар 1-ийг харна уу

“Монголын төмөр зам” ТӨХК-аас 12,074,977,586.00 төгрөгийн НӨАТ-ын авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан.

Тайлбар 2-ыг
харна уу

Төсөвт тусгагдсан Нийгмийн даатгалын шимтгэлийн талаарх тайлбар.

Бүтээн байгуулалтын ажилд оролцсон цэргийн алба хаагчдад Батлан хамгаалахын сайд, Сангийн сайдын 2020 оны А/39/28 дугаар хамтарсан тушаалд Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцож буй Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардал буюу хээрийн нэмэгдлийг бүтээн байгуулалтын ажлын төсөвт өртөгтэй уялдуулан хоногийн 70,000.00 хүртэл төгрөгөөр тогтоож, тушаалд нийцүүлэн нарийвчилсан журмыг баталж, мөрдүүлэхийг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргад үүрэг болгосны дагуу ЗХЖШ-ын даргын 2020 оны А/187 дугаартай “Томилолтын зардал олгох журам батлах тухай” тушаал гарч цэргийн алба хаагчдад 2019-2021 онд 36,182,981,013.94 төгрөгийн томилолт, хээрийн нэмэгдэл олгосон.

Харин нарийн мэргэжлийн, нэг удаагийн үйлчилгээ авахаар хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулсан иргэдэд 6,058,089,599.13 төгрөгийн хөдөлмөрийн хөлс олгож нийгмийн даатгалын шимтгэлд 439,529,385.02 төгрөгийг төлж, тухай бүр харьяалах дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст тайлагнасан.

Тайлбар 3-ыг
харна уу

Төсөвт тусгагдсан ашгийн талаарх тайлбар.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн (газар шороо, хиймэл байгууламжийн ажил)-ын инженерийн нарийвчилсан зураг, хяналтын төсвийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 256 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” ЗЗБНБД 81-013-2019-ийн дагуу зохиож, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ хянан Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулж, баталгаажсан ажлын тоо хэмжээг гэрээнд хавсаргаж, гэрээний салшгүй хэсэг болсон.

Дээрх нормын 4 дүгээр бүлгийн 4.3-д ашгийн тооцоо тусгагдсан бөгөөд 4.3.1-д “Замын барилгын ажлын төсөвт ашиг нь ажил гүйцэтгэх үеийн байгууллагын нийт зардлыг нөхөх, үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааны хөрөнгө оруулалтад зарцуулагдана” гэж, 4.3.2-т “ашиг нь замын барилгын бүтээгдэхүүний үнийн нормативын хэсэг бөгөөд ажлын өөрийн өртөгт хамаарахгүй” гэж, 4.3.2-т “ашгийн хэмжээг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2007 оны 187 дугаар тушаалын дагуу төсвийн тооцооны нийт цалингийн сангаас 71,8 хувиар тооцож төсөвт тусгана” гэж, барилга угсралтын ажилд Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаалын хавсралт “БАРИЛГЫН ТӨСӨВ ЗОХИОХ ДҮРЭМ”-ийн 4 дүгээр бүлгийн 4.51-д “төсөвт ашгийн эх үүсвэрээр байгууллага аж ахуйн нэгж ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, үйлдвэрлэлээ хөгжүүлэх зорилгоор хийгдэх хөрөнгө оруулалтын зардал, үндсэн хөрөнгийн шинэчлэлт, эргэлтийн хөрөнгийн өсөлт, тэтгэвэр тэтгэмж, шагнал урамшуулал олгох, мэргэжилтэн бэлтгэх, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг төлөх зэрэг зардлыг санхүүжүүлнэ” гэж заасан.

- Аудитын тайлангийн төслийн 1.40 дүгээр зүйлд “БИЦУГ нь төмөр замын далан хоолойн ажил гүйцэтгэсэн ААНБ-аас 5.9 тэрбум, Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдийн ажлын гүйцэтгэлээс 3.1 тэрбум, нийт 9.0 тэрбум төгрөгийг барилга байгууламжийн ажил гүйцэтгэх төсвийн удирдлагын зардлаас 30 хувийн суутган авч 2019-2022 оны үйл ажиллагаандаа зарцуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “албан тушаалтан албан үүргээ

гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглоно", 15.2-д "хууль тогтоомжоор болон засгийн газар, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлбөр авахаар тогтоосон бол нэмэлт төлбөр авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна" гэсэн байна.

Төслийн ажлын хүрээнд төмөр замын доод бүтцийн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаалаар байгуулагдсан "Дэд ажлын хэсэг"-ээс сонгон шалгаруулж, гэрээ байгуулах тухай зөвлөмж, Монгол Улсын Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1-т заасан гэрээний чөлөөт байдлын зарчмыг үндэслэн гэрээ байгуулж, тус гэрээгээр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 256 дугаар тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм"-д заасан удирдлагын зардлаас 30 хувийн суутгал 5,880,638,825.00 төгрөгийг төвлөрүүлж, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын үйл ажиллагаа, бие бүрэлдэхүүн, төслийн талбайд ажилласан Шуурхай удирдлагын 3 бүлгийн цалин, томилолт, материал хэрэгслийн зардал, туслан гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих, удирдлага, зохион байгуулалтаар хангах зардлуудад зарцуулсан.

Төслийн ажлын үлдэгдлийг Зэвсэгт хүчний тухай хуулийн 18¹ дугаар зүйлийн 18¹.2.6-т заасны дагуу Зэвсэгт хүчний хөгжлийн санд төвлөрүүлсэн бөгөөд тус сангийн зарцуулалт, тайлагналт Тусгай сангийн тухай хууль, холбогдох журмын дагуу зарцуулагддаг.

Монгол Улсын Иргэний хууль (2002 он)-ийн 1 дүгээр зүйлийн 1.2-т иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, гэрээний эрх чөлөөт байдлын зарчмуудыг хуульчилж өгсөн. Мөн хуулийн 7 дугаар зүйлд иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдыг тодорхойлж, 25 дугаар зүйлийн 25.3-д хуулийн этгээдийн өмчийн хэлбэрийг тогтоосон.

Талуудын хооронд байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээ бол талуудын гэрээний чөлөөт байдал, оролцогчдын эрх тэгш, бие даасан байдлын зарчимд үндэслэн байгуулсан гэрээний харилцаа юм. Монгол Улсын Иргэний хуульд заасны дагуу төрийн байгууллага иргэн, хуулийн этгээдтэй нэгэн адил иргэний эрх зүйн харилцаанд оролцож, эрх эдэлж, үүрэг хүлээдэг.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан зорилго бол нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүргийн хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албан үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад оршдог. Иймээс нийтийн албан тушаалтан гэж Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан тодорхой төрлийн албан тушаалтнууд буюу субъектэд чиглэсэн хуулийн үйлчлэх хүрээтэй хууль гэж үзэж байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явцад худалдан авсан техник, тоног төхөөрөмж болон санхүүжилтийн талаар.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоол, 2018 оны 73 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоол, 2019 оны 231 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн барилгын ажлыг 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр эхлүүлсэн.

Тайлбар 4-ийг харна уу

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийг удирдлагаар хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 53 дугаар захирамжаар төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг удирдан, зохион байгуулах ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулан байгуулсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 44 дүгээр тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаалаар "Монголын төмөр зам" ТӨХК-аас олгосон санхүүжилтэд багтаан Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн "Шинэ төмөр зам" төслийн бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулж, явуулах ажлын хүрээнд техник, хэрэгслийг худалдан авах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих үүрэг бүхий ЗХЖШ-ын даргаар ахлуулсан, Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн төлөөллөөс бүрдсэн "ДЭД АЖЛЫН ХЭСЭГ"-ийг байгуулсан.

Зэвсэгт хүчин төмөр замын ажлыг богино хугацаанд, өртөг багатай гүйцэтгэхийн тулд өөрийн техник, хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн бөгөөд худалдан авах техник, хэрэгслийн тооцоо, судалгааг гаргаж Батлан хамгаалах яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулагдсан "Дэд ажлын хэсэг"-т танилцуулсан.

Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар төмөр замын доод бүтцийн барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн тооцоо, санхүүжилтийн асуудлыг Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын гишүүдэд танилцуулсан бөгөөд хуралдаанаас бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Батлан хамгаалахын сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус даалгасан шийдвэр гарсан.

Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн "Монголын төмөр зам" ТӨХК-аас техник, хэрэгслийн худалдан авалтад зориулж 2019 оны 06, 08 дугаар саруудад 67,017,603,000.00 төгрөгийг Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газрын дансанд шилжүүлсэн.

"ДЭД АЖЛЫН ХЭСЭГ"-ийн ирүүлсэн зөвлөмжийн дагуу Зэвсэгт хүчний хэрэгцээнд 297 нэгж техник, тоног төхөөрөмж, үйлдвэрийг худалдан авч Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусган, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Зэвсэгт хүчин 2019-2022 онд "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн 416,1 км төмөр зам, 2022-2023 онд "Зүүнбаян-Ханги" чиглэлийн 226,3 км төмөр зам, Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамын (багц-4) барилга угсралтын ажлуудыг амжилттай дуусгаж, "Богдхан төмөр зам" төслийн талбайд шилжин байрлаж, дараагийн томоохон төсөл, хөтөлбөрүүдэд оролцох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аудитын дүгнэлтээр дараах асуудлыг уламжлуулан шийдвэрлүүлэх санал

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явцад Зэвсэгт хүчинд худалдан авсан техник, тоног төхөөрөмжийн асуудлыг Зам, тээврийн хөгжлийн яам, Батлан хамгаалах яам хамтран Засгийн газрын хуралдаанд танилцуулж, санхүүжилтийг нийгмийн хариуцлагын хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХХК-ийн төрийн мэдлийн хувьцааны цэвэр ашгаас өглөг, авлага үүсгэхгүйгээр хуримтлагдсан ашиг, зардлын хэмнэлтээс тооцон

санхүүжүүлэх эсхүл тус төслийн нийт төсөвт өртгийн хэмжээнд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлүүлэх;

- Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтын ажил, аж ахуйн ажлуудад үүрэг гүйцэтгүүлэх бие даасан хууль тогтоомжтой болгохоос гадна Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчныг сайжруулах талаар холбогдох төрийн байгууллагад санал хүргүүлэх;

- Цаашид бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдэд Зэвсэгт хүчинг оролцуулсан тохиолдолд мөрдөх норм, норматив, төсөв бодох аргачлал боловсруулах, цэргийн алба хаагчдын нийгмийн баталгааг хэрхэн хангах, тэдний цалин, хангамжийг хэрхэн тооцох талаар, холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлэх;

Зэвсэгт хүчин улсын төсвөөс санхүүждэг байгууллагын хувьд өөрт учрах аливаа эрсдлийг нөхөх санхүүгийн эх үүсвэргүй тул урт хугацааны санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг.

Иймд дээрх бүтээн байгуулалтын ажилд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн шийдвэр, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг бүтээн байгуулалтын ажилд татан оролцуулсан байдал, төсөл хэрэгжиж эхэлсэн тухай цаг үед эрх зүйн орчин дутмаг, хууль тогтоомжийн уялдаа холбоогүйгээс үүссэн дээрх асуудлуудыг харгалзан үзэж нааштай хүлээн авна гэдэгт итгэлтэй байна.

Хувийг "Монголын төмөр зам" ТӨХК-д.

ГАЗРЫН ДАРГА
ХУРАНДАА



Х.БАТСАЙХАН

Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар 1.Аудитын тайланд тусгасан агуулга нотлох баримтаар бүрэн дэмжигдэж байгаа тул саналыг хүлээн аваагүй.

Тайлбар 2.Аудитын тайланд тусгасан агуулга нотлох баримтаар бүрэн дэмжигдэж байгаа тул саналыг хүлээн аваагүй.

Тайлбар 3.Аудитын тайланд тусгасан агуулга нотлох баримтаар бүрэн дэмжигдэж байгаа тул саналыг хүлээн аваагүй.

Тайлбар 4. Саналд тусгасан агуулга тайланд бүрэн тусгагдсан тул тайланд өөрчлөлт оруулаагүй.

Бодь интернэшнл ХХК-аас ирүүлсэн санал:



БОДЬ ИНТЕРНЭШНЛ

“ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАР”-Т

УБД 9011013143
14241 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Чингисийн өргөн чөлөө 24, “Парк Плэйс” оффис, 3-н давхар
Утас: +976-11-315144
И-мэйл: info@bodigroup.mn, Вэб: www.bodi.mn

2023-08-18 № 01/244
Танай _____-ны № _____-т

Аудитын тайлангийн төсөлд тайлбар, санал гаргах
тухай

Үндэсний аудитын газраас Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06, 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалуудаар баталсан Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөөнд үндэслэн “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийсэн ба аудитын тайлангийн төслийг Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу санал авахаар шалгагдагч этгээд болох “Тавантолгой төмөр зам” ХХК-д хүргүүлсэнтэй танилцлаа.

“Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн” сэдвэд аудитын үйл ажиллагааны явцад Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгч “Бодь Интернэшнл” ХХК нь Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад заасан “аудитад хамрагдагч”-ын статустайгаар, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтад заасан үүргийг хүлээн оролцсон билээ.

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Төрийн аудитын байгууллага аудитын тайлангийн дүнгийн улмаас аудитад хамрагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй тохиолдолд энэ талаар санал, хүсэлт, тайлбар, гомдол гаргах боломжийг олгоно” гэж заасны дагуу аудитад хамрагдагч этгээд болох Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгч “Бодь Интернэшнл” ХХК нь аудитын тайлангийн төсөлд тайлбар, санал гаргах эрхтэй тул “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл”-ийн өөрт хамаарал бүхий хэсэгт гаргаж буй тайлбар, саналыг энэхүү албан бичгийн хавсралтаар хүргүүлж буйг хүлээн авна уу.

Хавсралт 130 хуудастай.

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ДОЛГОРМАА

“Бодь Интернэшнл” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн тогтоот
албан бичгийн хавсралт



**“ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ, ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН
ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, ҮР ДҮНД
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ”-ИЙН ТАВАНТОЛГОЙ-
ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ЦОГЦОЛБОР БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН АЖИЛТАЙ ХОЛБОГДОХ ХЭСЭГТ ГАРГАЖ БУЙ САНАЛ, ТАЙЛБАР**

Тайлбар
харна үү

1-ийг

1. “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл”-ийн 3 дугаар бүлгийн 3.31 дэх хэсэгт холбогдуулан гаргах санал, тайлбар

Тайлангийн төслийн 3.31 дэх хэсэгт “Ерөнхий гүйцэтгэгч нь тодорхой буюу бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэхээр санамж бичиг байгуулсан, улмаар төсөлд оролцох сонирхлоо сонгон шалгаруулалт явуулах шийдвэр гарахаас өмнө илэрхийлсэн байхад УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/184, 284, А/239 дугаартай хамтарсан тушаалд “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулах” гэсэн нь Төрийн захиргааны байгууллагуудын хэлбэржүүлсэн төдий шийдвэр гэж үзэхээр байна” гэжээ. Дээрх дүгнэлтийн “Ерөнхий гүйцэтгэгч нь тодорхой буюу бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэхээр санамж бичиг байгуулсан, улмаар төсөлд оролцох сонирхлоо сонгон шалгаруулалт явуулах шийдвэр гарахаас өмнө илэрхийлсэн байхад ...” гэсэн хэсэгтэй санал нийлэхгүй байгаа тул доорх санал, тайлбарыг гаргаж байна.

Санал:

Тайлангийн төслийн 3.31 дэх хэсгийн “Ерөнхий гүйцэтгэгч нь тодорхой буюу бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэхээр санамж бичиг байгуулсан, улмаар төсөлд оролцох сонирхлоо сонгон шалгаруулалт явуулах шийдвэр гарахаас өмнө илэрхийлсэн байхад ...” гэсэн хэсгийг хасуулж, уг хэсэгт Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын 4 дэх заалтын зохицуулалтын талаарх дүгнэлтийг нэмж тусгуулах саналтай. Мөн хамаарах гарчиг, холбогдох заалтууд уялдаж өөрчлөгдөхөөр байна.

Тайлбар:

“Бодь Интернэшнл” ХХК болон “Тавантолгой төмөр зам” ХХК нарын хооронд 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр байгуулагдсан харилцан ойлголцлын санамж бичиг нь төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ажиллагаа биш бөгөөд “Бодь Интернэшнл” ХХК-ийн хувьд Засгийн газраас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээнийхээ талаар олон нийтэд хандан мэдээлэл хийснээс хойш уг төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах үүднээс “Тавантолгой төмөр зам” ХХК-тай 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулж, төслийн техникийн даалгавар, инженерийн тооцоолол, судалгааны ажлын үр дүн болон бусад шаардлагатай мэдээлэлтэй танилцах, улмаар уг мэдээлэлд үндэслэн төслийн гүйцэтгэгчээр оролцох сонирхлоо илэрхийлэх эсэхээ шийдвэрлэх талаар харилцан тохиролцсон баримт бичиг юм.

Тухайн санамж бичиг үйлдэгдэх үед төслийн ажилтай холбоотой мэдээлэл төрийн нууцад хамрагдаагүй байсан тул төслийн талаар мэдээлэл авах хууль зүйн боломж нээлттэй байсан билээ.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 196 дугаар тогтоолоор “Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил, түүнд оролцуулах зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийн тоо хэмжээ болон ус хангамжийн эх үүсвэр, худалдан авах ажиллагааны

нууцалбал зохих хэсэг"-ийг Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулснаас хойш Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 242, 2019 оны 304 дүгээр тогтоолын хэрэгжилттэй холбогдуулан Зам тээврийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК, "Тавантолгой төмөр зам" ХХК нар 2019 оны 08 дугаар сарын 24-ний өдөр хамтран зохион байгуулсан "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт хөрөнгө оруулалт" сэдэвт төрийн болон төрийн өмчит 17 байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 11 арилжааны банк, олон улсын санхүүгийн байгууллага болон БНХАУ-ын төмөр зам, дэд бүтцийн 8 байгууллага, төрийн бус байгууллага, компаниудын төлөөллийг оролцуулсан танилцуулга уулзалтыг зохион байгуулсан нь тухайн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэгдэж байсны нэг нь <http://www.olloo.mn/n/67390.html> вэбсайт дахь мэдээлэл юм.

Зам тээврийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК, "Тавантолгой төмөр зам" ХХК нар хамтран Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх асуудлаар олон нийт, дотоодын болон гадаадын бизнесийн байгууллагууд, арилжааны банк, олон улсын санхүүгийн байгууллага зэргийг оролцуулан мэдээлэл өгч байсан нь уг төслийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх боломжийг нийтэд нээлттэй тавьж байсны илэрхийлэл бөгөөд Монгол Улсын Засгийн газрын тогтоол шийдвэрүүд, Засгийн газрын зүгээс олон нийтэд хандаж хийсэн мэдээлэл, төслийн талаар олж авсан мэдээ, мэдээлэл, салбарын яамд, төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх төрийн өмчит компаниудын зохион байгуулсан уулзалтаас олж авсан мэдээлэл зэрэгт үндэслэн өөрсдийн санхүүгийн нөөц боломж, төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, бусад шаардлагатай нөхцөл байдлаа дүгнэн тооцсоны эцэст манай компани Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслийн ажлын ерөнхий гүйцэтгэгчээр оролцох сонирхлоо "Тавантолгой төмөр зам" ХХК-д 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр албан ёсоор илэрхийлсэн.

Монгол Улсын Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.1 дэх хэсэгт "Нэг этгээд өөрийн хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй эрх үүргийн хувьд холбогдохоор нэг буюу хэд хэдэн тодорхой этгээдэд хандан хүсэл зоригоо бодитойгоор, хангалттай тодорхой илэрхийлсэн илэрхийллийг гэрээ байгуулах санал гэнэ" гэж заасан бөгөөд дээр дурдсанчлан манай компани төслийн бүтээн байгуулалтад ерөнхий гүйцэтгэгчээр оролцохоор сонирхлоо албан ёсоор илэрхийлсэн үйл явц нь Монгол Улсын Иргэний хуулийн 195 дугаар зүйлд заасан "гэрээ байгуулах санал" гаргах үйл явц болохоос бус төслийн ажлыг манай компаниар гүйцэтгүүлэхээр талууд эцэслэн тохиролцсон тохиролцоо биш юм.

Гэтэл дээрх үйл явцыг аудитын тайлангийн төслийн 3.31 дэх хэсэгт "Ерөнхий гүйцэтгэгч нь тодорхой буюу бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэхээр санамж бичиг байгуулсан, улмаар төсөлд оролцох сонирхлоо сонгон шалгаруулалт явуулах шийдвэр гарахаас өмнө илэрхийлсэн" учраас Ерөнхий гүйцэтгэгчээр сонгогдох нь тодорхой болсон байсан мэтээр дүгнэсэн нь үндэслэлгүй бөгөөд хууль эрх зүйн хувьд алдаатай дүгнэлт болжээ.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн хангах зорилгоор гарсан УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/184, 284, А/239 дугаартай хамтарсан тушаалаар төслийг хэрэгжүүлэх бүтэц, гүйцэтгэгчийг сонгох эцсийн хугацаа зэрэг хэд хэдэн асуудлыг шийдвэрлэсэн байдаг ба уг тушаал гарахаас өмнө хэн нэгэн этгээд төсөлд оролцох сонирхлоо илэрхийлсэн нь төрийн захиргааны байгууллагын тухайн шийдвэрүүдийг гаргахад онцгой ач холбогдолгүй, сонирхол бүхий байсан өөр нэг этгээдийг сонгоход саад болох нөхцөл байдал огтоос биш бөгөөд манай компанийн хувьд төсөлд оролцохоор сонирхлоо илэрхийлсэн явдал нь уг төслийг төрийн нууцад хамааруулсантай холбоотойгоор төслийн гүйцэтгэгчийг хэрхэн ямар журмаар сонгох процесс нь тодорхой бус, бидэнд энэ талын мэдээлэл дутуу байсантай холбоотой юм.

Бидний зүгээс, УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/184, 284, А/239 дугаартай хамтарсан тушаалд "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

Тайлбар
харна уу

2-ыг

зохион байгуулах” гэж заасан буюу гүйцэтгэгчийг сонгох үйл ажиллагааг богино хугацаанд зохион байгуулах болсон шалтгаан нь Монгол Улсын Их Хурлын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 304 дүгээр тогтоолын 4 дэх заалтаар “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам тээврийн хөгжлийн сайд болон уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарт даалгасан”-тай холбоотой гэж үзэж байна.

Учир нь Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн тогтоолоор Засгийн газрын тогтоол гарсан өдрөөс хойш 21 хоногийн дотор барилгын ажлыг эхлүүлэхийг даалгасан нь барилгын ажлыг эхлүүлэхийн өмнөх урт хугацаа шаардагддаг олон ажлыг боломжгүй богино хугацаанд гүйцэтгэхийн тулд арга замыг эрэлхийлэхэд хүргэсэн, үүнтэй холбоотойгоор төслийн гүйцэтгэчийг сонгох ажлыг богино хугацаанд зохион байгуулахаас өөр аргагүй байдлыг бий болгосон байна.

2. “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл”-ийн 3 дугаар бүлгийн 3.32 дахь хэсэгтэй холбогдуулан гаргах санал, тайлбар

Тайлангийн төслийн 3.32 дахь хэсэгт “Тайлангийн төслийн 3.31 дэх хэсэгт заасан нөхцөл байдал нь Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7-д “Төрийн захиргааны байгууллага аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг ... хуульд зааснаас бусад тохиолдолд хориглоно”, Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж, хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг”, 3.1.4-т “давуу байдал гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “хуульд өөрөө заагаагүй бол мэдээлэл ил тод нээлттэй байх” гэсэн зарчимтай тус тус нийцэхгүй байна” гэжээ.

Тайлангийн төслийн 3.31 дэх хэсэгт дурдсан төслийн Ерөнхий гүйцэтгэгчтэй холбоотой дүгнэлт үндэслэлгүй бөгөөд хууль эрх зүйн хувьд алдаатай дүгнэлт болсон талаар өмнө тайлбарласан ба тайлангийн төслийн 3.32 дахь хэсэг нь тайлангийн төслийн 3.31 дэх хэсэгт үндэслэсэн тул энэ хэсгийн дүгнэлттэй мөн санал нийлэхгүй байна.

Санал:

Төслийн ерөнхий гүйцэтгэгчийг богино хугацаанд сонгох шийдвэрийг гаргахад нөлөөлсөн шалтгаан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын 4 дэх заалттай шууд хамааралтай тул тайлангийн төслийн 3.32 дахь хэсэгт хийгдсэн Өрсөлдөөний тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалтуудтай холбоотой дүгнэлтүүдийг хасаж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолын 4 дахь заалттай холбоотой дүгнэлтийг тусгах замаар өөрчлөн найруулах шаардлагатай гэж үзэж байна.

Тайлбар:

Өрсөлдөөний тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалтуудтай холбоотой хийгдсэн дүгнэлтүүдийн талаар дор дурдсан дэлгэрэнгүй тайлбарыг гаргаж байна.

Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7 дахь заалтад заасан “Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа” гэдэгт Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг ойлгоно.

Өөрөөр хэлбэл Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7 дахь заалтад заасан “аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа” нь Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааны аль нэг хэлбэрээр явагдсан байхыг шаардах бөгөөд УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/184, 284, А/239 дугаартай хамтарсан тушаалаар “Тавантолгой-Гашуунсухайт

чиглэлийн төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулах ...-ыг Тавантолгой төмөр зам ХХК-д даалгасан” нь хуульд заасан захиргааны үйл ажиллагааны хэлбэрүүд болох “захиргааны акт”, “захиргааны гэрээ”, “захиргааны хэм хэмжээний акт” гэсэн төрлүүдийн “захиргааны акт”-тай ижил төстэй шинжтэй буюу захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар гаргасан шийдвэр үйл ажиллагаа мэт байгаа боловч Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд заасан захиргааны актын шинжийг дээрх үйл ажиллагаа нь бүрэн агуулахгүй тул Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7 дахь заалтад хамаарах үйл ажиллагаа биш, уг заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл байхгүй юм.

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтад “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно” гэж заасан байна.

УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/184, 284, А/239 дугаартай хамтарсан тушаал нь захиргааны байгууллагаас гарсан, тодорхой нэг тохиолдлыг зохицуулах, захирамжилсан шинжтэй гэдгээрээ Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтад заасан захиргааны актад тавигдах 5 шалгуураас 3 шалгуурыг хангаж байгаа боловч хамгийн гол шалгуур болох “нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн байх”, “эрх зүйн шууд үр дагавар бий болгосон байх” гэсэн шалгууруудыг хангаагүй юм.

“Гадагш чиглэсэн захиргааны акт” гэдэг нь байгууллагын дотоод хүрээндээ биш харин “гуравдагч” гэж болох иргэд, байгууллагад холбогдолтой буюу тэдгээрийн эрх, ашиг сонирхлыг хөндсөн, түүний дотор тэдгээрт эрх олгосон, үүрэг хүлээлгэсэн акт, үйл ажиллагаа хамаардаг.

Өөрөөр хэлбэл тухайн шийдвэр захиргааны дотоод орон зайнаас хальж, захиргааны байгууллагын гадна орших эрх зүйн субъект руу чиглэсэн байхыг шаардах ба харин Захиргааны байгууллага өөрийн дотоод дахь асуудлыг зохицуулсан акт, үйл ажиллагаа нь гадагш чиглэсэн захиргааны акт болж чаддаггүй бөгөөд гадагш буюу захиргааны дотоод орон зайнаас гадна орших иргэн, хуулийн этгээдэд хамаарсан эрх зүйн шууд үр дагавар үүсгэхгүй юм.

УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/184, 284, А/239 дугаартай хамтарсан тушаал нь дотогш чиглэсэн акт бөгөөд төрийн өмчит хуулийн этгээдэд төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг ямар хугацаанд зохион байгуулах асуудлаар үүрэг даалгавар өгсөн шинжтэй тул уг тушаалыг захиргааны акт гэж үзэхгүй, захиргааны акт биш учраас Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан захиргааны үйл ажиллагааны төрөлд хамаарахгүй, захиргааны үйл ажиллагааны төрөлд хамаарахгүй тул Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.7 дахь заалтад хамаарах үйл ажиллагаанд мөн хамаарахгүй.

Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж, хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг ойлгоно” гэж заасан байна.

Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад зааснаар нийтийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан гэж үзэхийн тулд нийтийн албан тушаалтын үйлдэл, үйл ажиллагаанд дараах 3 шинж буюу “нийтийн албан тушаалтан албаны эрх мэдлээ хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд ашигласан байх”, “нийтийн албан тушаалтан хийх ёстой үйлдлийг хийгээгүй байх” “нийтийн албан тушаалтан хийх ёсгүй үйлдлийг хийсэн байх” гэсэн шинжүүд байгаа эсэхийг зайлшгүй тодруулах шаардлагатай.

Аудитын тайлангийн төсөлд УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын дарга нар хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/184, 284, А/239 дугаартай хамтарсан тушаалаар “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулах ...-ыг Тавантолгой төмөр зам ХХК-д даалгасан” гэдгийг юугаар тогтоосон нь тодорхой бус байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 304 дүгээр тогтоолоор “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үргэлжүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Зам тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарт үүрэг болгосон”, уг Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УУХҮС, ЗТХС, ТӨБЗГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/184, 284, А/239 дугаартай хамтарсан тушаалаар “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулах ...-ыг Тавантолгой төмөр зам ХХК-д даалгасан” явдал нь Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад заасан “Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах нийтлэг ажил эрхэлнэ” гэж заасанд нийцсэн байх тул Авилгын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад зааснаар нийтийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан гэж үзэхийн тулд авч үзэх шаардлагатай үндсэн шинж буюу “нийтийн албан тушаалтан хийх ёстой үйлдлийг хийгээгүй байх” “нийтийн албан тушаалтан хийх ёсгүй үйлдлийг хийсэн байх” гэсэн шинжүүд үгүйсгэгдэж байна.

Авилгын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад заасан шинжүүд үгүйсгэгдэж байгаа тохиолдолд Авилгын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад заасан нөхцөл байдал буюу нийтийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн хуулийн этгээдэд давуу байдал олгосон гэх үндэслэл мөн үгүйсгэгдэнэ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад заасан “Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод нээлттэй байх” зарчмын тухайд Монгол Улсын Засгийн газар болон Тавантолгой төмөр зам ХХК-ийн зүгээс Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслийн ажлын талаарх мэдээллийг төслийн үйл ажиллагааг төрийн нууцад хамруулсан 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс өмнө бүрэн хэрэгжүүлж ажиллаж ирсэн гэж бидний зүгээс үзэж байгаа ба Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн тогтоолоор төслийн үйл ажиллагааг төрийн нууцад хамруулсантай холбоотойгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтад “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж заасны дагуу Нийтийн мэдээллийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад заасан зарчим бүрэн дүүрэн хэрэгжих боломжгүй болсон тул төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгох ажлыг зохион байгуулахтай холбоотой харилцаанд хуулийн дээрх зарчим зөрчигдсөн гэж үзэх боломжгүй юм.

Тайлбар
харна уу

3-ыг

3. “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл”-ийн 3 дугаар бүлгийн 3.49-3.52 дахь хэсэгтэй холбогдуулан гаргах санал, тайлбар

Тайлангийн төслийн 3.52 дахь хэсэгт, ЕРС гэрээнд ерөнхий нөхцөлийн 8.7 [Хугацаа хожимдуулсны хохирол] дахь хэсгийг хэрэглэхгүй гэж заасан нь Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6-д “Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ”, 232.7-д “Үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд анз төлөхөөр гэрээнд заагаагүй бол үүрэг гүйцэтгүүлэгч анз шаардах эрхгүй бөгөөд харин учирсан хохирлоо арилгуулахыг шаардах эрхтэй” гэж заасны дагуу Захиалагч Гүйцэтгэгчээс болон УБТЗ ХНН-ээс зүтгүүр түрээслэн тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж, зүтгүүр түрээсийн зардал гаргаж байгаа нь энэ хуулийн дээрх заалттай нийцэхгүй байна гэж үзжээ. Дээрх хэсэгтэй бүхэлд нь санал нийлэхгүй байгаа тул доорх санал, тайлбарыг гаргаж байна.

Санал:

Тайлангийн төслийн 3.49-3.51 дэх хэсгүүдэд ““Тавантолгой төмөр зам” ХХК болон “Бодь Интернэшнл” ХХК-ийн хооронд байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий

болон тусгай нөхцөлийн 4.12 [Урьдчилан мэдэх боломжгүй хүндрэлтэй нөхцөл байдал] дахь хэсгийн (а)-д: Ажилд нөлөөлж болох, эсхүл нөлөөлж байгаа эрсдэл, магадлалгүй зардал болон бусад нөхцөл байдлын талаар шаардлагатай бүх мэдээллийг Гүйцэтгэгч гаргуулж авсан гэж үзнэ; (b)-д: Гэрээнд гарын үсэг зурснаар Гүйцэтгэгч нь Гэрээний 4.25 /ажлын талбайн газрын нөхцлүүд/ дахь хэсэгт дурдсанаас бусад хүндрэлтэй нөхцөл байдал, ажлыг амжилттай дуусгахад гарах зардал болон хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас бий болох эрсдлийг урьдчилан мэдэх бүрэн хариуцлагыг хүлээн зовшоорч байна; (с)-д: Аливаа урьдчилан мэдэх боломжгүй хүндрэлтэй нөхцөл байдал зардлыг тусгах зорилгоор Гэрээний үнэд өөрчлөлт оруулахгүй." гэж заасан"-ыг нэмж тусгуулах;

Тайлангийн төслийн 3.52 дахь хэсгийг "Талууд гэрээгээр ийнхүү тохиролцсоноор Захиалагч "Тавантолгой төмөр зам" ХХК нь төслийн хэрэгжилтийн явцад бий болж болох төслийн зардлын өсөлтийн болзошгүй эрсдлээс хамгаалагдсан бол төслийн Гүйцэтгэгч "Бодь Интернэшнл" ХХК нь төслийн хэрэгжилтийн хугацааны хэтрэлттэй холбоотой үүсээж болох болзошгүй эрсдлээс хамгаалагдсан, харилцан эрх тэгш, талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэнцүү хамгаалсан тохиролцоо болсон байна. "Тавантолгой Төмөр Зам" ХХК нь 2023 онд 5 сая тн ачаа тээвэрлэх төлөвлөгөөтэй байх бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 87,000 тн ачаа тээвэрлэсэн, тус тээвэрт "Бодь Интернэшнл" ХХК-ийн 1 ш зүтгүүрийг төлбөртэй ашиглаж байх бөгөөд зүтгүүр ашиглалтын гүйцэтгэл 48 хувьтай байна. Зүтгүүрийн төлбөрт тооцоологдсон ашиглалтын төлбөр 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 333,560,300.99 төгрөг, түүнээс "Бодь Интернэшнл" ХХК-д 78,623,513.49 төгрөгийг шилжүүлэн төлсөн байна. Талууд зүтгүүрийг төлбөртэй ашиглаж, ашиглуулж байгаа дээрх харилцаа нь ЕРС гэрээний зүтгүүр нийлүүлэх анхны хугацаа хойшлогдсонтой холбоотой үүсээж болох болзошгүй эрсдлийг бууруулсан эерэг үр дүнг үзүүлсэн байна." гэж тус тус өөрчлөх саналтай байна. Мөн хамаарах гарчиг, холбогдох заалтууд уялдаж өөрчлөгдөхөөр байна.

Тайлбар:

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажил 2012 оноос эхэлсэн, бэлтгэл судалгааны ажил, холбогдон гарсан зардлын тухайд 2012 оноос өмнөх хугацаанд эхэлсэн байдаг. 2019 онд захиалагч, гүйцэтгэгч талууд АЕСОМ компанийн гүйцэтгэсэн ТЭЗҮ-д тооцоолсон хөрөнгийн үлдэгдэл дүнд багтаан ТЭЗҮ-д заасан барилга, байгууламжийг иж бүрэн гүйцэтгэхээр гэрээлсэн бөгөөд энэ үед зөвхөн Багц-1 ажлын нэг хэсэг болох газар шорооны дуусаагүй барилгын ажил зохих гүйцэтгэлтэйгээр шилжиж ирсэн. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоолоор, ТЭЗҮ-д заасан дүнгээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг даалгасан тул эдгээр нөхцөл байдалтай холбоотойгоор зардлыг хэтрүүлэхгүй байх, ТЭЗҮ-д тооцоологдоогүй, урьдчилан тооцоолох боломжгүй эрсдлүүдийг зөв хуваарилах шаардлага бодитоор тулгарсан. Мега төслийн хувьд эрсдлийг тэнцвэргүй хуваарилах нь эргээд төслөө амжилтгүй болгох эрсдэл болдог гэж үздэг.

Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.3 дахь заалтад "Анзын гэрээг бичгээр хийнэ", 232.7 дахь заалтад "Үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд анз төлөхөөр гэрээнд заагаагүй бол үүрэг гүйцэтгүүлэгч анз шаардах эрхгүй" гэж заасан, талуудын хооронд байгуулсан гэрээнд анзын талаар тохиролцоогүй тул Захиалагч Гүйцэтгэгчээс алданги шаардах эрхгүй.

Талууд гэрээнд анзын талаар тохиролцоогүй нь мега төслийн онцлогтой холбоотой бөгөөд аудитын тайлангийн төслийн 1.10 дахь хэсэгт дурдагдсан олон улсын түвшинд хэрэгжсэн мега төслүүдийн судалгаанд төмөр замын төслүүдийн хувьд зардал дунджаар 44.7 хувиар нэмэгдэж, орлого 51.4 хувиар буурдаг, 77 хувь нь анх төлөвлөсөн хугацаагаар 40 хувиар сунгадаг гэх судалгааны үр дүн үнэн бодитой. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын хувьд гүйцэтгэгч "Бодь Интернэшнл" ХХК нь төслийг хэрэгжүүлэх явцад төслийн зардлыг нэмэгдүүлэхгүй, төслийн зардлын өсөлттэй холбоотой бүх эрсдлийг өөртөө үүрэх үүргийг гэрээгээр хүлээсэн тул олон улсын түвшний судалгаагаар батлагдсан хугацаа хэтрэлттэй холбоотой болзошгүй эрсдлийг тооцон анзын тохиролцоог гэрээнд тусгаагүй юм.

Талууд гэрээгээр ийнхүү тохиролцсоноор захиалагч "Тавантолгой Төмөр Зам" ХХК нь төслийн хэрэгжилтийн явцад бий болж болох төслийн зардлын өсөлтийн болзошгүй эрсдлээс

хамгаалагдсан бол төслийн гүйцэтгэгч “Бодь Интернэшнл” ХХК нь төслийн хэрэгжилтийн хугацааны хэтрэлттэй холбоотой үүсэж болох болзошгүй эрсдлээс хамгаалагдсан, харилцан эрх тэгш, талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэнцүү хамгаалсан тохиролцоо болсон билээ.

Нөгөө талаар “Бодь Интернэшнл” ХХК нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгасан, Багц-5 [Хөдлөх бүрэлдэхүүн] ажлын нэг хэсэг нь болох зөвхөн зүтгүүр нийлүүлэх ажлын анхны хугацаа тодорхой хугацаагаар хойшлогдон хэтэрсэн байгаа ба энэхүү нөхцөл байдал нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл, илчит тэрэгний үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанаас хамааралтай, Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалаагүй тул Гүйцэтгэгчийг зүтгүүрийн нийлүүлэлттэй холбоотой хугацаа хэтрүүлсэн гэж үзэх үндэслэл болохгүй юм.

Учир нь Монгол Улсын Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.3 дахь заалтад “Хугацаа хэтрэхэд хүргэсэн нөхцөл байдал нь үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугаас болоогүй бол үүрэг гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэн гэж үзэхгүй” гэж заасан ба зүтгүүрийн нийлүүлэлттэй холбоотой хугацааны хэтрэлт гүйцэтгэгч “Бодь Интернэшнл” ХХК-аас шалтгаалаагүй тул “Бодь Интернэшнл” ХХК-ийг хугацаа хэтрүүлсэн гэж үзэхгүй.

Тайлбар
харна уу

4-ийг

4. “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл”-ийн 3 дугаар бүлгийн 3.61 дэх хэсгийн өмнө бичигдсэн гарчиг, 3.70 дахь хэсэгтэй холбогдуулан гаргах санал, тайлбар

Тайлангийн төслийн 75 дугаар хуудсанд гарчгийг “Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн ажлыг магадлалаар баталгаажсан зураг төсөвгүйгээр техник, эдийн засгийн үндэслэлийн дүнгээр гүйцэтгүүлж байна” гэжээ. Тус гарчигт дурдагдсан *магадлалаар баталгаажсан зураг төсөвгүйгээр ажлыг гүйцэтгүүлж байна* гэсэн хэсэгтэй санал нийлэхгүй байна.

Тайлангийн төслийн 3.70-д “Бодь Интернэшнл” ХХК нь Тавантолгой нүүрс ачилтын логиستيкийн төвийн бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгчээр ажиллах сонирхолтой байгаагаа 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр илэрхийлсэн байхад захиалагч болох “Тавантолгой Төмөр Зам” ХХК-ийн гүйцэтгэх захирлын зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар дээрх ажлыг “Бодь Интернэшнл” ХХК-аас гүйцэтгүүлэхээр захирлын зөвлөлийн гишүүд санал нэгтэй дэмжиж, шийдвэрлэсэн байна.” гэжээ.

Дээрх хэсгийн зарим мэдээлэл ташаа байх бөгөөд санал нийлэхгүй байгаа эдгээр асуудалд дараах санал, тайлбарыг гаргаж байна.

Санал:

Тайлангийн төслийн 75 дугаар хуудас дахь дээрх гарчгийг “Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн ажлыг техник, эдийн засгийн үндэслэлийн дүнгээр гүйцэтгүүлж байх бөгөөд техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс, баялгийн зөвлөл баталгаажуулсан байна” гэж өөрчлөх саналтай.

Тайлангийн төслийн 3.70 дахь хэсгийг ““Тавантолгой Төмөр Зам” ХХК-ийн гүйцэтгэх захирлын зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар дээрх ажлыг “Бодь Интернэшнл” ХХК-аас гүйцэтгүүлэхээр захирлын зөвлөлийн гишүүд санал нэгтэй дэмжиж, шийдвэрлэсэн байна.” гэж өөрчлөх саналтай байна. “Тавантолгой Төмөр Зам” ХХК-ийн дотоод үйл ажиллагааг мэдэхгүй, гагцхүү Тайлангийн төсөлд тусгагдсан агуулга тул дээрх саналыг өгч байгаа болно.

Манай компани 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн BI-TTGS-LTR-1197 тоот албан бичгээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн дагалдах байгууламж болох Тавантолгойн нүүрс ачих байгууламжийн ажлыг гүйцэтгэх сонирхлоо илэрхийлсэн (албан бичгийн хуулбарыг хавсаргав) тул Тайлангийн төсөлд тусгагдсан “.. “Бодь Интернэшнл” ХХК нь Тавантолгой нүүрс ачилтын логиستيкийн төвийн бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгчээр

ажиллах сонирхолтой байгаагаа 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр илэрхийлсэн байхад ...” гэх ташаа мэдээллийг хасуулах саналтай байна.

Тайлбар:

“Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн барилга угсралтын ажлыг тоног төхөөрөмжүүдээр нь багцлан төрөлжүүлж, нийт 6 багц ажлыг гүйцэтгэж байна. Тоног төхөөрөмжүүдийн онцлогоос хамаарч нарийвчилсан зураг төслийг хэд хэдэн өөр байгууллагаар хянан магадлуулах шаардлага үүссэн ба явц дараах байдалтай байна. Үүнд:

№	Зураг төсөл	Хянан магадлах байгууллага	Статус
1	Эрчим хүч автоматжуулалт- Гадна цахилгаан хангамжийн зураг төсөл	“Эрчим Хүчний Хөгжлийн Төв” ТӨҮГ	Магадлалын дүгнэлтийг хавсаргав
2	Барилга байгууламж, зам, талбай - Иргэний барилга байгууламжуудын зураг төсөл	“Барилгын Хөгжлийн Төв” ТӨҮГ	Магадлалын дүгнэлтийг хавсаргав
3	Вагонд ачигч-Нүүрс барьцалдуулагч байгууламжийн зураг төсөл	“Барилгын Хөгжлийн Төв” ТӨҮГ	Магадлалын дүгнэлтийг хавсаргав
4	Багц 1-4 ажил тус бүрийн үндсэн тоног төхөөрөмжийн зураг төсөл	“Барилгын Хөгжлийн Төв” ТӨҮГ	Магадлуулах хүсэлтийн дагуу 2023.05.25-ны өдөр гэрээ байгуулагдсан. Зураг хянагдаж дууссан, төсөв хянагдаж байна.

“Барилгын Хөгжлийн Төв” (БХТ) ТӨҮГ-аар хянагдаж байгаа зураг төслийн ихэнх хэсэг нь уул уурхай, хүнд аж үйлдвэрийн тоног төхөөрөмж бөгөөд БХТ-өөс зураг төслийн тоног төхөөрөмжүүдтэй холбоотой хэсгүүдэд мэргэжлийн эксперт хяналт хийх эрх зүйн зохицуулалт хангалтгүй, нарийн мэргэжлийн ажиллах хүчний нөөц, туршлага, чадамж дутмаг зэрэг хүндрэл гарч байгаа талаар бидэнд удаа дараа мэдэгдэж байсан. Одоогоор уул уурхай, хүнд аж үйлдвэр, эрдэс баялгийн чиглэлийн төрийн захиргааны байгууллага (Барилгын хөгжлийн төв шиг) байхгүй байгаа нь дээрх хүснэгтийн 4 дүгээр мөрөнд дурдсан зураг төслүүдийг хянан магадлахад хугацаа алдаж, цаашлаад зураг төслийн зарим хэсэг нь хянан магадлагдахгүй байх магадлалтай байна (холбогдох албан бичгийн хуулбарыг хавсаргав).

Тайлбар
харна уу

5-ыг

5. “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл”-ийн 3 дугаар бүлгийн 3.77 дахь хэсгийн өмнө бичигдсэн гарчиг, 3.91 ба 3.93 дахь хэсэгтэй холбогдуулан гаргах санал, тайлбар

Тайлангийн төслийн 79 дүгээр хуудсанд гарчгийг “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгээгүй гэрээ байгуулж, гүйцэтгэсэн байна.” гэжээ. Тус гарчигт дурдагдсан “... суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл хийлгээгүй гүйцэтгэсэн байна. ...” гэсэн хэсэгтэй санал нийлэхгүй байна.

Тайлангийн төслийн 3.91 дэх хэсэгт “Тавантолгой Төмөр Зам” ХХК Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх BI-TTZB-CONT-0001, TT3-H21/01 дугаар гэрээний “ерөнхий хэлэлцээр”-ийг “Бодь Интернэшнл” ХХК-тай 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан байна.” гэжээ. Мөн өдөр BI-TTZB-CONT-0001, TT3-H21/01 дугаартай гэрээг байгуулсан тул “... BI-TTZB-CONT-0001, TT3-H21/01 дугаар гэрээний “ерөнхий хэлэлцээр”-ийг “Бодь

Интернэшнл” ХХК-тай 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан байна.” гэсэнтэй санал нийлэхгүй байна.

Тайлангийн төслийн 3.93 дахь хэсэгт “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээний Ерөнхий хэлэлцээрийн 4.5 дахь нөхцлийн хавсралт 1 “Захиалагчийн шаардлага”, 4.6 дахь нөхцлийн хавсралт 2 “Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ”-г баталгаажуулаагүй нь уг гэрээг эрх зүйн иж бүрэн баримт гэж үзэх боломжгүй болгохоос гадна гүйцэтгэгчээр ажлын тоо хэмжээ нь тодорхойгүй ажил гүйцэтгүүлсэн байна” гэжээ. Гэрээний иж бүрдэл бүрэн байгаа тул уг дүгнэлтэй санал нийлэхгүй байна.

Санал:

Тайлангийн төслийн 79 дүгээр хуудсанд гарчгийг “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгээгүй гэрээ байгуулж, гүйцэтгэсэн байна.” гэж өөрчлөн дээр дурдсан санал нийлүүлэхгүй хэсгийг хасуулах саналтай.

Тайлангийн төслийн 3.91 дэх хэсгийг “Тавантолгой Төмөр Зам” ХХК Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх BI-TTZB-LONT-0001, TT3-H21/01 дугаартай гэрээг “Бодь Интернэшнл” ХХК-тай 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан байна.” гэж өөрчлөн найруулах саналтай.

Тайлангийн төслийн 3.93 дахь хэсэг таппа мэдээлэл байх тул бүхэлд нь хасуулах саналтай байна.

Тайлбар:

BI-TTZB-CONT-0001, TT3-H21/01 дугаартай гэрээний ерөнхий хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд тус гэрээг бүрдүүлж буй баримт бичгүүдийг жагсааж, эрэмбийг тодорхойлсон бөгөөд тайлангийн төсөлд дурдсан Гэрээний нөхцөлийн хавсралт 1 [Захиалагчийн шаардлага], Гэрээний нөхцөлийн хавсралт 2 [Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ] баримт бичгүүд нь Гэрээний ерөнхий хэлэлцээрийн хамт нэг өдөр хүчин төгөлдөр болсон буюу талуудын эрх бүхий албан тушаалтан 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр гарын үсэг зурж, баталгаажуулсан бөгөөд төрийн аудитын байгууллагад Захиалагчийн зүгээс гаргаж өгсөн баримт дутуу байсан шалтгааны улмаас дээрх дүгнэлт хийгдэх болсон байж болзошгүй байна.

Талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан, Гэрээний ерөнхий хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 4.5-д заасан Гэрээний нөхцлийн хавсралт 1 [Захиалагчийн шаардлага], 4.6-д заасан Гэрээний нөхцлийн хавсралт 2 [Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ] баримт бичиг тус бүрийн хуулбарыг энэхүү албан бичигт хавсаргав.

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр зам нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын үргэлжлэл, төгсгөл хэсэг бөгөөд гүйцэтгэгч “Бодь Интернэшнл” ХХК-тай зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлыг (ЕРС) түлхүүр гардуулах гэрээг байгуулсан. Ийнхүү тусдаа гэрээ байгуулсан нь захиалагчаас төлбөрийг төлөхдөө ТТ-ГС чиглэлийн төмөр замын төслөөс өөр нөхцөлийг санал болгосонтой холбоотой юм.

Гүйцэтгэгч “Бодь Интернэшнл” ХХК-ийн тухайд зураг төсөлгүй ажил гүйцэтгэсэн тохиолдол байхгүй, өнөөдрийн байдлаар ажлын үр дүнг 100 хувь улсын комисст хүлээлгэн өгч, байнгын ашиглалтад оруулаад байна.

6. “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл”-ийн 3 дугаар бүлгийн 3.110 дахь хэсэгтэй холбогдуулан гаргах тайлбар, санал

Тайлангийн төслийн 3.110 дахь хэсэгт “Ажил эхлүүлэх зөвшөөрлийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын

ажил гүйцэтгэх гэрээний дагуу хийхийг зөвшөөрсөн байгаа нь Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д “барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл /цаашид барилгын ажлын зөвшөөрөл гэх/ гэж энэ хуульд заасны дагуу барилгын ажил гүйцэтгэхийг зөвшөөрч эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг”, 25 дугаар зүйлийн 25.4-т “Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно”, ЗТХС-ын 2018 оны 49 дүгээр тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журмыг тус тус зөрчсөн байна” гэжээ. Барилгын ажлын зөвшөөрлийг хуульд заасан журмын дагуу авсан тул дээрх дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

Санал:

Тайлангийн 3.110 дахь хэсгийг бүхэлд нь хасуулах саналтай байна

Тайлбар:

Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалтад “барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл /цаашид барилгын ажлын зөвшөөрөл гэх/ гэж энэ хуульд заасны дагуу барилгын ажлыг гүйцэтгэхийг зөвшөөрч, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг ойлгоно” гэж заасан байна.

Барилгын ажлын зөвшөөрөл буюу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээдүүдийг Барилгын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтад заасан бөгөөд уг этгээдүүдэд Засгийн газар, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нар багтаж байна.

Монгол Улсын Засгийн газрын хувьд Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалтад заасан “цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нисэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть болон хийн хоолой, газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолой зэрэг улсын чанартай барилга байгууламжид барилгын ажлын зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлэх” бүрэн эрхийг, Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтад заасан “онцгой төвөгшилтэй барилга байгууламж”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтад заасан “Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжийн хувьд олгох” бүрэн эрхийг, Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хувьд бусад зөвшөөрлийг олгох бүрэн эрхтэй.

“Бодь Интернэшнл” ХХК-ийн ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд нь Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалтад заасан “... төмөр зам ... зэрэг улсын чанартай барилга байгууламж ...”-д хамаарах тул барилгын ажлын зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэх бүрэн эрх нь Засгийн газарт хадгалагдах бөгөөд Монгол Улсын Засгийн газраас “Тавантолгой төмөр зам” ХХК-д Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 304 дугаар тогтоолын 3 дахь заалтаар “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрөл”-ийг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 113 дугаар тогтоолоор “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл”-ийг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор “Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн барилгын ажлын зөвшөөрөл”-ийг тус тус олгосон.

Иймд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд нь Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалтад заасан барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл буюу барилгын ажлыг гүйцэтгэхийг зөвшөөрч, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрт үндэслэн хэрэгжиж байгаа болно.

Тайлбар 7-г харна уу

7. “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл”-ийн 3 дугаар бүлгийн 3.112 дахь хэсэгтэй холбогдуулан гаргах тайлбар, санал

Тайлангийн төслийн 3.112 дахь хэсэгт “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-нд шилжүүлэн ачих терминалын ажлыг шинээр гүйцэтгэх, суурьшлын бүсийн ажлыг хасах талаар нэмэлт өөрчлөлт хийгээгүй, шилжүүлэн ачих терминалын ажил ямар нэгэн гэрээгүйгээр хийгдэж, ажлын гүйцэтгэлийг суурьшлын бүс гэж баталгаажуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т заасан “үнэн зөв байх” гэсэн зарчмыг тус тус зөрчиж байна” гэжээ. Дүгнэлт дэх шилжүүлэн ачих терминалын ажил ямар нэгэн гэрээгүйгээр хийгдэж, ажлын гүйцэтгэлийг суурьшлын бүс гэж баталгаажуулж байгаа гэсэн хэсэгтэй санал нийлэхгүй байна.

Санал: Тайлангийн төслийн 3.112 дахь хэсгийг бүхэлд нь хасуулах

Тайлбар:

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий нөхцөл буюу Олон улсын зөвлөх инженерүүдийн холбооноос эрхлэн гаргасан “FIDIC Conditions of Contract for EPC/Turnkey Projects /1999/”-ийн 13 [Variation&Adjustments /Өөрчлөлт болон зохицуулалт] дугаар зүйлээр гэрээний дагуу гүйцэтгэх ажлын өөрчлөлттэй холбоотой харилцааг зохицуулсан.

Гэрээний ерөнхий нөхцлийн 13 дугаар зүйлийн 13.1 [Өөрчлөх эрх] дэх хэсэгт “Ажил хүлээн авсан гэрчилгээ олгохоос өмнө өөрчлөлтийг Захиалагч хэдийд ч санаачилж болох бөгөөд энэ тохиолдолд Гүйцэтгэгчид зааварчилгаа өгөх, эсхүл саналаа ирүүлэхийг түүнээс хүсэж болно. Өөрчлөлтөд бусдын гүйцэтгэх ёстой байсан боловч орхигдсон ажил хамаарахгүй. Гүйцэтгэгч нь “(i) Өөрчлөлтөд шаардлагатай Барааг Гүйцэтгэгч бэлэн гаргаж чадахгүй, (ii) Өөрчлөлт нь Ажлын аюулгүй болон тогтвортой байдлыг алдагдуулна эсхүл (iii) Гүйцэтгэлийн үзүүлэлтийг хангахад сөрөг нөлөө үзүүлнэ.” гэсэн мэдэгдэл (холбогдох баримтын хамт)-ийг Захиалагчид нэн даруй өгөөгүй бол Гүйцэтгэгч нь Өөрчлөлт нэг бүрийг гүйцэтгэж хэрэгжүүлэх ёстой” гэж заасан байна.

Өөрөөр хэлбэл, гэрээний дагуу гүйцэтгэх ёстой ажлын төрөл, тоо хэмжээг Захиалагч өөрийн санаачлагаар өөрчлөх бүрэн эрхтэй бөгөөд Гүйцэтгэгч тухайн өөрчлөлтийн дагуу гүйцэтгэх ажлыг гүйцэтгэж чадахгүй, тухайн өөрчлөлт нь ажлын аюулгүй байдал, тогтвортой байдлыг алдагдуулах эсхүл нийт ажлын гүйцэтгэлд сөрөг нөлөөтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд Захиалагчаас өгсөн ажлын өөрчлөлтийн дагуу ажлыг хийж гүйцэтгэх үүргийг хүлээдэг.

Захиалагчийн зүгээс гэрээний дагуу гүйцэтгэх ажилд өөрчлөлт хийх зааварчилгаа өгснийг Гүйцэтгэгч хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй тохиолдолд зааварчилгааг хүлээн зөвшөөрөх бөгөөд ийнхүү хүлээн зөвшөөрсөн бол гэрээний ерөнхий нөхцлийн 13.3 [Өөрчлөлтийн журам] дахь хэсэгт заасан журмын дагуу Захиалагч нь Гэрээний үнэ болон Төлбөрийн хуваарьт хийх тохируулгыг тохиролцож шийдвэрлэх арга хэмжээг гэрээний ерөнхий нөхцлийн 3.5 [Шийдвэр] дахь хэсэгт заасны дагуу авах ёстой.

Гэрээний ерөнхий нөхцлийн 13 дугаар зүйлд заасан Захиалагчийн зааварчилгаа буюу ажлын төрөл, тоо хэмжээнд өөрчлөлт оруулах тухай зааварчилгаа нь Гүйцэтгэгчийн хувьд заавал биелүүлэх ёстой үүрэг бөгөөд дээрх үүргийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын нэг нь Гашуунсухайт өртөөний Шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтын ажил билээ.

Монгол Улсын Иргэний хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1-т зааснаар, “талууд хүсэл зоригоо илэрхийлсэн баримт бичиг үйлдэж, гарын үсэг зурсан” бол, 43.2.2 дахь заалтад “хэлцэл хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захиусдал, цахилгаан, албан бичиг, телефакс, эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг нөгөө тал хүлээн авсан” бол хэлцэл хийсэн гэж үзнэ гэсэн зохицуулалттай бөгөөд Захиалагч болон Гүйцэтгэгч нар ЕРС гэрээний ерөнхий нөхцлийн 13 дугаар

зүйлд заасан журмын дагуу Захиалагчийн зүгээс гэрээний дагуу гүйцэтгэх ёстой ажлын төрөл, тоо хэмжээг өөрчлөхтэй холбогдуулан талууд Гэрээний ерөнхий нөхцөлд заасан журмын дагуу харилцан бичгээр санал солилцсон, зөвшилцсон байдал буюу Захиалагчийн зүгээс Гүйцэтгэгчид тодорхой асуудлуудаар албан бичгээр хандсан, Гүйцэтгэгч тухайн асуудлуудаар Захиалагчтай хариу санал солилцож талууд тохиролцоонд хүрсэн байдал нь Иргэний хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт заасан “хэлцэл хийсэн гэж үзэх” нөхцөл, шаардлагыг бүрэн хангана. Ажлын өөрчлөлтийг баримтжуулах талуудын харилцаанд мөрдөх гэрээнд заасан журмын талаар өмнө тайлбар, мэдээлэл өгч, баримтуудыг хавсарган танилцуулсан болно.

Иймд Гашуунсухайт өртөөний Шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтын ажлыг ямар нэгэн гэрээгүй гүйцэтгэсэн гэж үзэх үндэслэлгүй бөгөөд энэхүү ажил нь “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-ний хүрээнд Захиалагчийн өгсөн зааварчилгын дагуу, гэрээний ерөнхий нөхцлийн 13 дугаар зүйл буюу “Өөрчлөлт болон зохицуулалт”-д заасан журам ба зохицуулалтын дагуу гүйцэтгэгдсэн ажил юм.

Тайлбар
харна уу

8-ыг

8. “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл”-ийн 3 дугаар бүлгийн 3.115 дахь хэсэгтэй холбогдуулан гаргах тайлбар, санал

Тайлангийн төслийн 3.115 дахь хэсэгт “Гүйцэтгэлийн баталгааны 17.6 сая ам.долларыг өөрийн, 538.46 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэж тус тус олгосон, мөн ханшийн зөрүүний алдагдал тооцож, 1.2 сая ам.долларыг олгохоор баталгаажуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8-д “урьдчилгаа төлбөрийн баталгаа гэж захиалагч урьдчилгаа төлбөр төлөх тохиолдолд уг төлбөрийг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах үүргээ баталгаажуулж гүйцэтгэгчээс захиалагчид ирүүлсэн банкны баталгаа, даатгагчийн баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг”, 5.1.17-д “гүйцэтгэлийн баталгаа гэж гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангахыг баталгаажуулж, гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлсэн банкны баталгаа, даатгагчийн баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг”, Иргэний хуулийн 234 дүгээр зүйлийн 234.1-д “Үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар гуравдагч этгээд үүрэг гүйцэтгүүлэгчид баталгаа гаргаж болно”, 234.4-т “Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг баталгаа гаргагчаас үл маргах журмаар шаардана”, 234.5-д “Үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө үүрэг хүлээсэн баталгаа гаргагч үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрхгүй”, 234.6-д “Банкны баталгааг энэ хуулийн 457 дугаар зүйлд заасан журмаар зохицуулна” гэсэн заалтуудыг талууд тус тус зөрчиж өөрөө өөрсдөө баталгаа гаргасан, урьдчилгаа олгосон, алданги тооцож баталгаажуулсан нь Нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д “нэгдмэл сонирхолтой этгээд гэж тухай нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ” гэж заасантай нийцсэн байх эрсдэлтэй байна” гэжээ.

Санал:

Тайлангийн төслийн 3.115 дахь хэсгийн агуулгыг “Гүйцэтгэлийн баталгааны 17.6 сая ам.долларыг өөрийн, 538.46 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэж тус тус олгосон, мөн ханшийн зөрүүний алдагдал 1.2 сая ам.долларыг олгохоор баталгаажуулсан, ТБОНӨХБАҮХАТХ-д зааснаас өөр хэлбэрээр урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулж урьдчилгаа төлбөр олгосон зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтад “Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж заасан, улмаар дээрх хуулийн зохицуулалтын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

12

худалдан авах тухай хуулийн зохицуулалтад хамаарахгүй болсон уг харилцааг тусгайлан зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлээгүйтэй холбоотой байна” гэж өөрчлүүлэх саналтай байна.

Тайлбар:

Тайлбар
харна уу

9-ийг

- Хууль эрх зүйн орчны зохицуулалт дутмаг байгаа асуудлын тухайд

Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой ажил үйлчилгээг худалдан авахтай холбоотой харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулахгүй гэж хуульчилсан нь тухайн ажил, үйлчилгээг төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзсэнтэй холбоо бүхий бодит үндэслэл, шалтгаантай. Гэсэн хэдий ч бусад ердийн бараа, ажил, үйлчилгээнээс илүү онцлогтой, ач холбогдолтой энэхүү төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоо бүхий ажил, үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

Эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа дээрх нөхцөл байдал нь бусад ердийн ажил үйлчилгээнээс илүү онцлог бөгөөд ач холбогдол бүхий тухайн ажил, үйлчилгээний худалдан авалтад ТБОНӨХБАҮХАТХ-д заасан журмыг мөрдөхгүй, ердийн иргэд, аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн хооронд мөрддөг иргэний эрх зүйн нийтлэг хэм хэмжээнүүд үйлчлэх, ингэснээрээ тухайн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх иргэний эрх зүйн зарчим үйлчлэх боломж бүрдсэн байна. Өөрөөр хэлбэл, хуулиар ердийн ажил, үйлчилгээнээс илүү онцлог бөгөөд ач холбогдол бүхий ажил үйлчилгээ гэж тусгайлан авч үзсэн шалтгаан нөхцөл, ийнхүү онцлох болсон үнэ цэн, ач холбогдол нь алдагдсан байна.

Иймд хууль тогтоогчийн зүгээс хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой ажил үйлчилгээг худалдан авахтай холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бий болгох нь тухайн онцлог бүхий харилцаанд төр, төрийн өмчит хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангахад нэн тэргүүний бөгөөд онцгой ач холбогдолтой алхам болох юм.

Тайлбар
харна уу

10-ыг

- Баталгаатай холбоотой асуудлын тухайд

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 196 дугаартай “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” тогтоолоор Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад “Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил”-ыг нэмж оруулсан.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь хэсэгт заасан “мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт оруулах” бүрэн эрхийн хүрээнд Тагнуулын Ерөнхий газар нь 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 01/1208 дугаартай “Хариу хүргүүлэх тухай” албан бичгээр “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг, 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 1114 тоот албан бичгээр Тавантолгой-Гашуунсухайт ба Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох холболтын төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг, мөн өдрийн 1113 тоот албан бичгээр ТНАЛТ төслийн бүтээн байгуулалтын ажлыг тус тус Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 196 дугаар тогтоолоор баталсан жагсаалтын дагуу төрийн нууцад хамаарна” гэдгийг тодорхойлсон.

Үүний дагуу эдгээр бүтээн байгуулалтын ажилтай холбоотой гэрээнүүд нь төрийн нууцад хамрагдсан байсан тул ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтад “Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг

худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж заасны дагуу гэрээний харилцаанд уг хуулийн зохицуулалтад хамаарахгүй болсон.

Нэгэнт төмөр замын бүтээн байгуулалтын төслийн ажил, түүнтэй холбоотой худалдан авалтын ажиллагаа нь төрийн нууцад хамаарч, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохицуулалтад хамаарахгүй болсон тул Захиалагч ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлөхтэй холбоотой харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн “урьдчилгаа төлбөрийн баталгаа”, “гүйцэтгэлийн баталгаа”-тай холбоотой зохицуулалтууд үйлчилжгүй.

Гэрээнд оролцогч талууд буюу “Тавантолгой төмөр зам” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд баталгаа гаргасан гэх асуудлын тухайд төмөр замын бүтээн байгуулалтын төслийн үйл ажиллагаа, түүнтэй холбоотой худалдан авалтын ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтад “Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуульд заасан урьдчилгаа төлбөрийн баталгаа, банкны баталгаа, даатгагчийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа зэрэг баталгааг гаргах шаардлагагүй болсон тул талууд Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх заалтад “Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй” гэж заасны дагуу буюу гэрээний чөлөөт байдлын зарчимд үндэслэн Гүйцэтгэгч нь Захиалагчид өөрийн хөрөнгөөр баталгаа гаргасан нь хуулиар хориглогдоогүй, ямар нэгэн заавал дагаж мөрдөх шинж бүхий хуулийн зохицуулалтыг зөрчөөгүй үйл ажиллагаа юм.

- Ханшийн зөрүүний алдагдалтай холбоотой асуудлын тухайд

“Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Бодь Интернэшнл” ХХК нарын хооронд 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан “Санхүүжилтийн гэрээ”-ний нэмэлт өөрчлөлт нь үндсэн 3 асуудлын хүрээнд хийгдсэн бөгөөд 2020 оны 1-5 дугаар сард Ковид 19 цар тахлын үүдэлтэй хил гаалийн хориг, нэвтрүүлэх чадвар багассаны улмаас хуваарийн дагуу нийлүүлэгдээгүй 51,782,955.40 ам.долларын нүүрсийг нөхөж нийлүүлэхтэй холбоотой асуудал, техник эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдсэнтэй холбоотой 213,430,672 ам.долларын нэмэлт өөрчлөлтийн асуудал, Захиалагчийн зүгээс урьдчилгаа төлбөрийг гэрээнд заасан үнийн дүнгээс бага дүнгээр шилжүүлсэнтэй холбоотой үүссэн төлбөрийн зөрүү 1,248,922.48 ам.долларын асуудлыг уг гэрээний нэмэлт өөрчлөлтийн хүрээнд шийдвэрлэсэн.

Тухайн нэмэлт өөрчлөлтөөр хийгдсэн ханшийн зөрүүнээс үүссэн 1,248,922.48 ам.долларын нэмэлт өөрчлөлтийн асуудал нь аль нэг талд үүссэн давагдашгүй хүчин зүйлтэй огт холбоогүй бөгөөд Захиалагчийн зүгээс урьдчилгаа төлбөрийг гэрээнд заасан үнийн дүнгээс бага дүнгээр шилжүүлсэнтэй холбоотой бөгөөд дараах учир шалтгаантай байсан юм.

Санхүүжилтийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалтад “Тавантолгой төмөр зам ХХК нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхэд шаардагдах урьдчилгаа төлбөр болох энэхүү гэрээний 3.2.1-д заасан мөнгөн хөрөнгийг Гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг хүлээн авсны дараа Гүйцэтгэгчийн холбогдох дансанд гэрээнд заасан хугацааны дотор шилжүүлнэ”, мөн зүйлийн 3.5.1 дэх заалтад “Захиалагч энэхүү гэрээний 3.2.1-д заасан урьдчилгаа төлбөрийг Гүйцэтгэгчид шилжүүлэхдээ уг санхүүжилтийн хүрээнд хийгдэх барилгын ажлын захиалагчийн хяналтын зардал болох 2,827,749.38 ам.долларыг хасаж шилжүүлнэ” гэж тус тус заасны дагуу “Тавантолгой Төмөр Зам” ХХК урьдчилгаа төлбөр болох 110,000,000 ам.доллароос захиалагчийн хяналтын зардал 2,827,749.38 сая ам.долларыг суутган 107,172,250.62 сая ам.долларыг “Бодь Интернэшнл” ХХК-д шилжүүлэх байсан. “Тавантолгой Төмөр Зам” ХХК 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр 286,318,169,588.87 төгрөг шилжүүлснийг тухайн өдрийн Монгол банкны албан ханш 2,703.07 төгрөгөөр тооцон хүлээн авахад

105,923,328.14 ам.доллар байсан буюу “Бодь Интернэшнл” ХХК авах ёстой урьдчилгаа төлбөрөө 1,248,922.48 ам.доллараар дутуу авсан.

Ийнхүү талууд дутуу авсан төлбөрийн дүнгээр урьдчилгаа төлбөрийн дүнг бууруулж, нүүрсээр төлөх төлбөрт шилжүүлэн тооцохоор холбогдох гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Санхүүжилтийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтад “Хэрэв урьдчилгаа төлбөрийг Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлэх үед ам.доллар төгрөгийн ханшийн зөрүүний улмаас алдагдал үүсвэл Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийх үед, эсхүл энэхүү гэрээний “Хавсралт В” болох Нүүрс нийлүүлэх гэрээний дагуу Эрдэнэс Тавантолгой ХК нь Гүйцэтгэгчид нийлүүлэх нүүрсний хэмжээнд тохируулга хийх замаар уг ханшийн зөрүүний алдагдлыг арилгаж хохиролгүй болгоно” гэж заасан гэрээний дагуух харилцаа бөгөөд **төлбөр төлөгч тал** ханшийн эрсдэл гаргах эсэхэд санхүүгээ удирдах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх бүрэн боломжтой билээ.

Тийм учраас санхүүжүүлэгч, захиалагч нарын гэрээгээр хүлээсэн цөөн эрсдлийн нэг нь урьдчилгаа төлбөртэй холбоотой ханшийн эрсдэл, харин гүйцэтгэгчийн тухайд олгосон урьдчилгаа төлбөрийн дүнг хассан гэрээний нийт үнийн дүнгээр ханшийн эрсдлийг хүлээсэн нь гэрээгээр олон эрсдлийг хариуцсаны зөвхөн нэг нь байсан юм.

“Тавантолгой Төмөр Зам” ХХК энэхүү дутуу төлөлтөө санхүүжилтийн эх үүсвэрийн ханшийн зөрүүтэй холбож тайлбарладаг. Тодруулж хэлбэл, үүссэн ханшийн зөрүүний алдагдал нь “Тавантолгой Төмөр Зам” ХХК болон “Бодь Интернэшнл” ХХК нарын хооронд 2019 оны 10 сарын 29-ний өдөр “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ” байгуулагдахаас өмнө “Эрдэнэс Тавантолгой” ХХК болон “Тавантолгой төмөр зам” ХК нарын хооронд үүссэн харилцаатай холбоотой болох нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 47 дугаартай тогтоолын 1.1 дэх заалтаас тодорхой харагдах ба уг заалтад “Тавантолгой төмөр зам ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасны дагуу нийт 110 сая ам.доллартой тэнцэх төгрөгийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д шилжүүлэхийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй” гэсэн байдаг.

Уг заалтаас харвал “Тавантолгой Төмөр Зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигч нарын хооронд байгуулагдсан “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ” гэх эрх зүйн баримт бичгийн дагуу уг 110,000,000 ам.доллар “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас “Тавантолгой Төмөр Зам” ХХК-д шилжсэн тул уг мөнгөн дүн нь “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Бодь Интернэшнл” ХХК нарын хооронд 2019 оны 10 сарын 29-ний өдөр байгуулагдсан “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-ний харилцаанаас тусдаа эрх зүйн харилцааны үндсэн дээр буюу хувьцаа эзэмшигчдийн гэрээний эрх зүйн харилцааны хүрээнд шилжсэн гэж үзнэ.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас “Тавантолгой төмөр зам” ХХК-д хувьцаа эзэмшигчдийн гэрээний эрх зүйн харилцааны хүрээнд төгрөгөөр шилжүүлсэн мөнгөн хөрөнгийн үнэ цэн “Тавантолгой Төмөр Зам” ХХК болон “Бодь Интернэшнл” ХХК нарын хооронд 2019 оны 10 сарын 29-ний өдөр “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ” байгуулагдаж урьдчилгаа төлбөр шилжүүлэх хүртэлх хугацаанд ам.долларын ханшийн өсөлтөөс шалтгаалан буурч манай компанид урьдчилгаа төлбөрийг шилжүүлэх үед урьдчилгаа төлбөрийн хэмжээ гэрээнд заасан үнийн дүнд хүрэхгүй болсон явдалд манай компани буруугүй бөгөөд уг ханшийн зөрүүний алдагдлын улмаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-д үүссэн нэмэлт зардлыг хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу талууд шийдвэрлэх, эсхүл уг эрсдлийг удирдах ёстой байсан этгээд нь хариуцах нь шударга ёсонд нийцнэ.

- Урьдчилгаа төлбөрийн баталгаатай холбоотой асуудлын тухайд

Ажил үйлчилгээтэй холбоотой харилцаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохицуулагдаж байгаа бол уг хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дахь заалтад зааснаар Тендерийн баримт бичигт заагаагүй тохиолдолд захиалагч

урьдчилгаа төлбөр төлөхгүй хуулийн зохицуулалттай ба Тендерийн баримт бичигт заасан тохиолдолд Захиалагч ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлж болох бөгөөд энэ тохиолдолд мөн хуулийн зохицуулалтаар тендерт оролцогчоос тендерийн баталгаа ирүүлэхийг шаарддаг.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажил, төслийн ажлын хүрээнд байгуулсан гэрээ хэлцэл нь төрийн нууцад хамаарч байсан тул өмнө дурдсанчлан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохицуулалт үйлчлэхгүй бөгөөд урьдчилгаа төлбөрийн асуудал нь талуудын тохиролцооны дагуу Иргэний хуулийн зохицуулалтын хүрээнд зохицуулагдана.

Иргэний хуулийн 346 дугаар зүйлийн 346.1 дэх заалтад “Талууд өөрөөр тохиролцоогүй бол ажлыг бүрэн гүйцэтгэж, ажлын үр дүнг хүлээлгэн өгөх үед хөлс төлнө” гэж заасан бөгөөд хуулийн энэ зохицуулалт нь талууд хэрэв гэрээгээр тохиролцсон бол ажлыг бүрэн гүйцэтгэж, ажлын үр дүнг хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын хөлсийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг урьдчилан төлөх боломжийг олгосон байна.

Хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд гэрээний талууд ажлын хөлсний тодорхой хэсгийг урьдчилан төлөхөөр харилцан тохиролцох байдал иргэний эрх зүйн харилцаанд түгээмэл бөгөөд энэ нь ямар нэг байдлаар хуульд харшлахгүй.

- Алдангитай холбоотой асуудлын тухайд

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гаргасан гэрээний үүргийн зөрчлийг давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийн улмаас үүссэн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй тохиолдолд гэрээний үүргийн зөрчилтэй холбогдуулан үүргийн гүйцэтгэлийг хангах хууль ёсны арга хэрэгсэл болох алдангийн асуудлыг ярих нь хууль болон гэрээний дагуух үйлдэл бөгөөд бидэнд 2020 оны 1-5 дугаар сараас бусад хугацааны гэрээний үүргийн зөрчилтэй холбоотой алдангийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас шаардах эрх хууль болон гэрээний дагуу олгогдсон байна.

- Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлын тухайд

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад заасан “нэгдмэл сонирхолтой этгээд” гэдэгт тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг ойлгодог.

Энэ зүйлд заасан “нийтийн албан тушаалтан” гэдэгт Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан этгээдүүдийг ойлгох бөгөөд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан “төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан” гэдэгт “Тавантолгой төмөр зам” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдах болон эрх бүхий албан тушаалтнууд хамаарна.

“Тавантолгой Төмөр Зам” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдах болон эрх бүхий албан тушаалтнууд нь “Бодь Интернэшнл” ХХК-тай ашгийн төлөө үйл ажиллагаагаар буюу компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагаагаар холбоогүй бөгөөд талуудын хооронд байгуулагдсан гэрээний эрх зүйн харилцааны хүрээнд талууд баталгаа гаргах, урьдчилгаа төлбөр олгох, алданги болон ханшийн зөрүүтэй холбоотой үүссэн асуудлыг гэрээний зохицуулалтын хүрээнд шийдвэрлэж байгаа нь тэднийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад заасан “нэгдмэл сонирхолтой этгээд” гэдэгт хамаатуулан ойлгох үндэслэл болохгүй юм.

9. “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөд”-ийн 3 дугаар бүлгийн 3.116 дахь хэсгийн өмнө бичигдсэн гарчиг, 3.116 ба 3.118 дахь хэсэгт холбогдуулан гаргах санал, тайлбар

Тайлбар 11-ийг
харна уу

Тайлангийн төслийн 88 дугаар хуудсанд гарчгийг “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын гүйцэтгэл 78,3 хувь, санхүүжилтийн гүйцэтгэл 80,0 хувьтай байна.” гэжээ.

Тайлангийн төслийн 3.116 дахь хэсэгт “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын бодит гүйцэтгэл 2023 оны 6 дугаар сарын байдлаар 787,1 сая ам.доллар буюу 78,3 хувьтай байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 10-аас харна уу)” гэжээ. Энэ хэсгийн “... барилгын ажлын бодит гүйцэтгэл 2023 оны 06 дугаар сарын байдлаар 787,1 сая ам.доллар буюу 78,3 хувь байна...” гэсэн нь ташаа мэдээлэл тул санал нийлэхгүй байна.

Тайлангийн төслийн 3.118 дахь хэсэгт “Тавантолгой нүүрс ачих логиستيкийн төвийн ажлын бодит гүйцэтгэл 193,8 тэрбум төгрөг (Дэлгэрэнгүйг хавсралт 11-ээс харна уу) байхад 200,8 тэрбум төгрөг, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын холболтын ажлын бодит гүйцэтгэл 180,2 тэрбум төгрөг байхад гүйцэтгэгчид 189,1 тэрбум төгрөгийн (Дэлгэрэнгүйг Хавсралт 12-оос харна уу) санхүүжилт тус тус олгосноос харахад төслүүдэд гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон байна.” гэжээ. Энэ хэсэгтэй бүхэлд нь санал нийлэхгүй байна.

Санал:

Тайлангийн төслийн 88 дугаар хуудсанд гарчгийг “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын гүйцэтгэл 2023 оны 06 дугаар сарын байдлаар буюу гүйцэтгэгчээс захиалагчид ирүүлсэн №29 явц дундын төлбөрийн хүсэлтээр 90 хувь, 2022 оны 08 дугаар сарын байдлаар буюу захиалагчийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурсан №23 явц дундын төлбөрийн хүсэлтээр 78,3 хувь байна. Харин 2023 оны 07 дугаар сарын байдлаарх төлбөрийн санхүүжилтийн гүйцэтгэл 77 хувь байна.” гэж өөрчлөн найруулж тусгуулах саналтай.

Тайлангийн төслийн 3.116 дахь хэсгийг “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын бодит гүйцэтгэл 2023 оны 6 дугаар сарын байдлаар 899,0 сая ам.доллар буюу 90,0 хувь, харин захиалагчийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурсан явц дундын төлбөрийн хүсэлтээрх гүйцэтгэл 787,1 сая ам.доллар буюу 78,3 хувь байна (Дэлгэрэнгүйг хавсралт 10-аас харна уу). Захиалагч “Тавантолгой Төмөр Зам” ХХК нь гүйцэтгэгчээс ирүүлсэн 2022 оны 09 дүгээр сараас хойших ажлын гүйцэтгэлтэй холбоотой №24, 25, 26, 27, 28, 29 дугаар явц дундын төлбөрийн хүсэлтийг гарын үсгээр баталгаажуулаагүй байх бөгөөд энэ нь тодорхойгүй шалтгаантай байна. Ингэснээр талуудын хооронд байгуулсан ЕРС гэрээнд “Захиалагч явц дундын төлбөрийн холбогдох маргаантай эсхүл тодруулах шаардлагатай хэсгийг дээр дурдсан (а), (б) заалтын дагуу саатуулах мэдэгдлийг холбогдох үндэслэл, баримтын хамтаар 28 хоногийн дотор Гүйцэтгэгчид хүргүүлээгүй бол тухайн хугацаанаас хойш зохих төлбөрийг төлөх үүрэг үүссэнд тооцно.” гэсэн заалт хэрэгжих нөхцөл бүрдсэн байна.” гэх агуулгаар өөрчлөн тусгуулах саналтай.

Дээрх саналтай холбогдуулан Тайлангийн төслийн Хавсралт 10 дахь “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн гүйцэтгэл”-ийн шинэчлэн тусгуулахаар хавсаргав.

Тайлангийн төслийн 3.118 дахь хэсгийг “2023 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар, Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв төслийн №5 явц дундын төлбөрийн хүсэлтээр баталгаажсан ажлын гүйцэтгэл 193,8 тэрбум төгрөг, гүйцэтгэлээр олгосон төлбөрийн санхүүжилт 127,0 тэрбум төгрөг, барьцаа хөрөнгөөр баталгаажсан эргэн төлөгдөх нөхцөлтэй 73,7 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид олгосноос эргэн төлөгдөөгүй 26,8 тэрбум төгрөгийн үлдэгдэл байх бөгөөд энэхүү үлдэгдэл нь ЕРС гэрээний нөхцөлийн дагуу ажлын гүйцэтгэлийн төлбөрөөс суутган тооцогдохоор хүлээгдэж буй урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл байна (Дэлгэрэнгүйг Хавсралт 11 болон Хүснэгт 48-аас харна уу), Тавантолгой – Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын мөн хугацааны ажлын гүйцэтгэл 207,5 тэрбум төгрөг, гүйцэтгэлээр олгосон төлбөрийн санхүүжилт 189,1 тэрбум төгрөг байна. Захиалагч 2022 оны 10 дугаар сараас 19-өөс хойших № 09,10,11,12,13 дугаар явц дундын

төлбөрийн хүсэлтүүдийг тодорхойгүй шалтгаанаар гарын үсэг зурж баталгаажуулаагүй байгаатай холбоотойгоор барьцаа хөрөнгөөр баталгаажсан эргэн төлөгдөх нөхцөлтэй 82,1 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг суутган тооцож барагдуулах, барьцаа хөрөнгийг чөлөөлөх ажлууд зогссон, хүлээгдэж байна.” гэж өөрчлөх саналтай байна.

Тайлбар:

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар, “Тавантолгой нүүрс ачих логиستيкийн төв” дэд төслийн ЕРС гэрээний ерөнхий нөхцөлийн 14.2 [Урьдчилгаа төлбөр] дахь хэсэгт заасны дагуу гүйцэтгэгчид төлөх явц дундын төлбөрөөс хувь тэнцүүлэн суутган тооцохоор хүлээгдэж байгаа эргэн төлөгдөх нөхцөлтэй урьдчилгаа төлбөрийн дүн 26,8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тоон дүнгээр өнгөц харвал илүү төлөлт мэт байгаа ч олон улсын жишиг гэрээний нөхцөлийн дагуу ажлын гүйцэтгэлээс хувь тэнцүүлэн суутгах замаар барагдуулах ажиллагаанд гэрээний үүргийн зөрчил үүсээгүй, хэвийн үргэлжилж байна.

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар, ТНАЛТ дэд төслийн захиалагч гарын үсэг зурж баталгаажуулсан № 001 явц дундын төлбөрийн хүсэлтээр 89,769,768 төгрөг, өссөн дүнгээрх №004 явц дундын төлбөрийн хүсэлтээр 5,881,505,464 төгрөг, №005 явц дундын төлбөрийн хүсэлтээр 4,215,288,998 төгрөг, нийт 10,186,564,229 төгрөгийн гүйцэтгэлийн төлбөр төлөгдөөгүй, авлагаар бүртгэгдсэн байдалтай байна.

2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын ЕРС гэрээний ерөнхий нөхцөлийн 14.2 [Урьдчилгаа төлбөр] дэх хэсэгт заасны дагуу гүйцэтгэгчид төлөх явц дундын төлбөрөөс хувь тэнцүүлэн суутган тооцохоор хүлээгдэж байгаа эргэн төлөгдөх нөхцөлтэй урьдчилгаа төлбөрийн дүн 82,0 тэрбум төгрөг байгаа нь мөн олон улсын жишиг гэрээний нөхцөлийн дагуу ажлын гүйцэтгэлээс хувь тэнцүүлэн суутгах замаар барагдуулах ажиллагаанд гэрээний үүргийн зөрчил үүсээгүй, хэвийн үргэлжилж байна.

Холболтын төмөр замын дэд төслийн №013 явц дундын төлбөрийн хүсэлтээр ажлын гүйцэтгэл 207,5 тэрбум төгрөг буюу ажлын бодит гүйцэтгэлийн үзүүлэлт захиалагчаас олгосон санхүүжилтийн дүнгээс 18,4 тэрбум төгрөгөөр илүү байгаа болно. Захиалагч 2022 оны 10 дугаар сараас хойш буюу №008 явц дундын төлбөрийн хүсэлтээс хойш тодорхойгүй шалтгаанаар ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж гарын үсэг зурахгүй хүлээгдэж байна.

Иргэний хуулийн 344.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээ болон хөлс төлөх арга, журам, хугацааг талууд тохиролцон тодорхойлно.” гэж заасан.

ТНАЛТ болон төмөр замуудыг холбох дэд төслүүдэд олон улсын жишиг гэрээний төлбөрийн нөхцөлийг байгаагаар нь ийнхүү шууд хэрэглэсэн нь Иргэний хууль тогтоомжийг зөрчөөгүй, мөн эдгээр гэрээний ажлын гүйцэтгэл, төлбөрийн нөхцөлтэй холбоотойгоор гүйцэтгэгч талаас хамааралтай гэрээний нөхцөл зөрчигдсөн, үүргийн зөрчил үүссэн нөхцөл байдал өнөөдрийн байдлаар үүсээгүй болно.

10. Аудитын тайлангийн төслийн “Дүгнэлт” хэсгийн “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажил”-тай холбоотой дүгнэлтийн 11 дэх хэсэгт холбогдуулан гаргах тайлбар, санал

Тайлангийн төслийн “Дүгнэлт” хэсгийн “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажил”-тай холбоотой дүгнэлтийн 11 дэх хэсэгт “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн гүйцэтгэлд 17 тэрбум, Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн төслийн гүйцэтгэлд 7 тэрбум, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт төмөр замын холболтын ажлын гүйцэтгэлд 9 тэрбум төгрөгийг тус тус илүү олгожээ” гэжээ. Уг дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

Санал:

Тайлангийн төслийн “Дүгнэлт” хэсгийн “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажил”-тай холбоотой дүгнэлтийн 11 дэх хэсгийг “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр

Тайлбар
харна уу 12-ыг

замын төслийн гүйцэтгэлд 17 тэрбум, Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн төслийн гүйцэтгэлд 7 тэрбум, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт төмөр замын холболтын ажлын гүйцэтгэлд 9 тэрбум төгрөгийг тус тус илүү олгосон байх ба энэхүү үнийн дүнгийн зөрүү нь Захиалагчийн зүгээс Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан журмын дагуу баталгаажуулах ажил зогссонтой холбоотой үүссэн, Захиалагчийн зүгээс дээрх үнийн дүнгийн зөрүүг арилгах боломжтой байна.” гэж өөрчлөх саналтай байна.

Тайлбар:

Дээр дурдсан илүү олгосон гэх санхүүжилтийн дүн нь Захиалагчийн зүгээс Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг гэрээнд заасан журмыг зөрчиж зогсоосонтой холбоотой үүссэн бөгөөд Захиалагчийн зүгээс баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийн дүн болон Санхүүжүүлэгч, Захиалагч нарын зүгээс санхүүжүүлсэн нүүрс болон мөнгөн хөрөнгийн санхүүжилтийн дүнг харьцуулсан харьцуулалтаар гарч буй үнийн дүн болохоос бус Захиалагчийн зүгээс Гүйцэтгэгчид гэрээний дагуу төлөх мөнгөн дүнг илүү төлсөн асуудал биш юм.

Аудитын тайлангийн төсөлд ТТ-ГС төмөр замын төслийн гүйцэтгэлд илүү олгогдсон гэх 17 тэр бум ам.долларын тооцооллыг хийхдээ Хүснэгт 5.-ийн 804 дүнгээс тооцсонтой холбоотой байх ба талуудын хооронд байгуулагдсан гэрээний заалтын дагуу баталгаажсанд тооцох дүнгээс тооцож үзвэл Ерөнхий гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийн дүн 781,3 сая ам.доллар, харин гүйцэтгэл 899,0 сая ам.доллар байгаа буюу бодит гүйцэтгэл нь санхүүжилтээсээ 117,7 сая ам.доллараар илүү байгаа болно.

Захиалагчийн зүгээс гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж, Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан журмын дагуу баталгаажуулсан тохиолдолд дээрх зохиомлоор бий болсон үнийн дүнгийн зөрүү арилна.

Тайлбар харна уу 13-ыг

11. Аудитын тайлангийн төслийн дүгнэлт болон зөвлөмж хэсэгт тусгуулах санал

Санал 1:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дахь заалтад “Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж заасан.

Хуулиар төрийн нууцад хамруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой ажил үйлчилгээг худалдан авахтай холбоотой харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулахгүй гэж хуульчилсан нь тухайн ажил, үйлчилгээг төрийн нууцад хамруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзсэнтэй холбоо бүхий бодит үндэслэл, шалтгаантай хэдий ч төрийн нууцад хамруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой, бусад ердийн ажил үйлчилгээнээс илүү онцлог бөгөөд ач холбогдол бүхий гэж үзэж буй ажил үйлчилгээг худалдан авахтай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

Эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа дээрх нөхцөл байдал нь бусад ердийн ажил үйлчилгээнээс илүү онцлог бөгөөд ач холбогдол бүхий ажил үйлчилгээний худалдан авалтын үйл ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмыг мөрдөхгүй, ердийн иргэд, аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдийн хооронд мөрддөг иргэний эрх зүйн нийтлэг хэм хэмжээнүүд тухайн харилцаанд үйлчлэх, ингэснээрээ тухайн харилцаанд иргэний эрх зүйн иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх зарчим үйлчлэх боломж бүрдэж, үүний улмаас хуулиар ердийн ажил үйлчилгээнээс илүү онцлог бөгөөд ач холбогдол бүхий ажил

үйлчилгээ гэж тусгайлан онцлон авч үзсэн шалтгаал нөхцөл, ийнхүү онцлох болсон үнэ цэн, ач холбогдол алдагдах нөхцөл байдлыг бүрдүүлсэн байна.

Иймд хууль тогтоогчийн зүгээс хуулиар төрийн нууцад хамруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой ажил үйлчилгээг худалдан авахтай холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан хууль эрх зүйн орчныг бий болгох нь тухайн онцлог бүхий харилцаанд төр, төрийн өмчит хуулийн этгээдийн эрх хууль ёсны ашиг сонрихлыг хангахад нэн тэргүүний бөгөөд онцгой ач холбогдолтой алхам болох юм.

Иймд аудитын тайлангийн дүгнэлт болон зөвлөмж хэсэгт дээрх нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй тусгуулах саналтай байна.

Бодь интернэшнл ХХК-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар 1. Саналыг хүлээн авч холбогдох засварыг хийв.

Тайлбар 2. Саналыг хүлээн аваагүй бөгөөд холбогдох төрийн болон төрийн өмчип байгууллагад хамааруулж тайланд тусгасан тул өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 3. Саналыг хүлээн авч найруулгын өөрчлөлт хийв.

Тайлбар 4. Саналыг хүлээн авч найруулгын өөрчлөлт хийв.

Тайлбар 5. Саналыг хүлээн авч найруулгын өөрчлөлт хийв.

Тайлбар 6. Саналыг хүлээн аваагүй бөгөөд холбогдох төрийн болон төрийн өмчип байгууллагад хамааруулж тайланд тусгасан тул өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 7. Нотлох баримтаар дэмжигдэж байгаа тул саналыг хүлээн аваагүй.

Тайлбар 8. Нотлох баримтаар дэмжигдэж байгаа тул саналыг хүлээн аваагүй.

Тайлбар 9. Саналын агуулга тайланд тусгагдсан тул өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзсэн.

Тайлбар 10 Саналыг хүлээн аваагүй бөгөөд холбогдох төрийн болон төрийн өмчип байгууллагад хамааруулж тайланд тусгасан тул өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.


Тайлбар 11. Саналыг хүлээн авч найруулгын өөрчлөлт хийв.

Тайлбар 12. Тайлангийн тоон мэдээллийг нягталж, найруулгын өөрчлөлт хийв.

Тайлбар 13. Саналын агуулга тайланд тусгагдсан тул өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзсэн.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын байршлын зураг



Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгөө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хавсралт 2. Монголын төмөр зам ТӨХК-ийн эзэмшилд байгаа хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад хийсэн судалгаа, сая нэгж
1.Зүтгүүр

Үйлдвэр-лэгч улс	Серийн дугаар	Зүтгүү-рийн дугаар	Ашиглалтад орсон огноо	Ашиглах хугацаа, жил	Тоо ширхэг	Үнэ, сая нэгжээр		Хуримтлагдсан элэгдэл, сая төгрөг	Үлдэгдэл өртөг, сая төгрөг	Түрээслэгч		Түрээс-ийн орлого, сая төгрөг	Чанар байдал
						ам.доллар	төгрөг			Байгууллагын нэр	Түрээс-элсэн хугацаа		
АНУ	ES44ACI	2101	2009.07.11	25	1	7.1	8,208.3	1,891.9	6,316.4	УБТЗ ХНН	2009.05-2018.03	4,120.0	2019 оноос хүнд гэмтэлтэй шалтгаанаар зогсоосон
ОХУ	2ТЭ116	MR2001	2011.02.08	25	1	3.1	4,500.0	673.7	3,826.3	УБТЗ ХНН	2011.01-2014.12	1,459.2	Их засварын зүтгүүр худалдан авсан. 2014 оноос хүнд гэмтэлтэй шалтгаанаар зогсоосон.
ОХУ	2ТЭ116	MR2002	2011.02.08	25	1	3.1	4,500.0	565.3	3,934.7	УБТЗ ХНН	2011.02-2014.12	1,238.2	
БНХАУ	СКД4В	MR2301	2012.04.07	25	1	1.8	2,590.9	618.3	1,972.6	УБТЗ ХНН	2016.10-2021.12	1,666.7	2023.05.18-ны өдрөөс хүнд гэмтэлтэй шалтгаанаар зогсоосон.
БНХАУ	СКД4В	MR2302	2012.04.07	25	1	1.8	2,590.9	679.0	1,911.9	УБТЗ ХНН	2016.10-2020.12	1,666.7	2023.02.16-ны өдрөөс хүнд гэмтэлтэй шалтгаанаар зогсоож, 2023.02.24-ний өдөр БНХАУ-д дунд засвар хийлгэхээр явуулсан.
БНХАУ	СКД4В	MR2303	2012.04.07	25	1	1.8	2,590.9	757.6	1,833.3	УБТЗ ХНН	2016.10-2019.12	1,666.7	Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар тээвэрлэлт хийж байна.
БНХАУ	СКД4В	MR2304	2012.04.07	25	1	1.8	2,590.9	778.3	1,812.5	Бодь интернэшнл ХХК	2020.04-2022.08	1,865.3	
БНХАУ	СКД4В	MR2305	2012.04.07	25	1	1.8	2,590.9	705.4	1,885.5	УБТЗ ХНН	2016.10-2017.03	210.0	
НИЙТ					8	22.3	30,162.8	6,669.5	23,493.2			13,892.8	

2.Вагон

Машин тоног, төхөөрөмжийн нэр	Тоо	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
Ачааны тавцант вагон	50	123.7	6,185.6	2,561.9	3,623.7
Ачааны хагас вагон	215	130.7	28,092.3	9,611.5	18,480.8
Ачааны битүү вагон	10	145.0	1,449.5	594.2	855.3
НИЙТ	275		35,727.4	12,767.6	22,959.8

Хавсралт 3. Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн гүйцэтгэсэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн газар шорооны ажлын төсөвт өртгийн нэгтгэл, сая төгрөг

Зардлын нэр	7782 дугаар анги	7781 дүгээр анги	7780 дугаар анги	340 дүгээр анги	НИЙТ ДҮН
Цалин	2,133.5	3,212.5	1,888.5	2,111.0	9,345.4
Нийгмийн даатгалын шимтгэл	309.4	465.8	273.8	306.1	1,355.1
Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт	4,059.9	6,005.6	3,516.1	3,991.2	17,572.8
Материал	37.5	59.6	38.5	23.2	158.8
Тээвэр	5,975.3	8,745.6	5,087.2	4,827.7	24,635.8
Ажлын хувцас, багаж хэрэгслийн элэгдэл	43.6	68.7	40.5	51.2	204.0
Нүүлгэн шилжүүлэх зардал	210.1	200.2	177.4	50.3	638.0
Шууд зардлын дүн	12,769.3	18,758.0	11,022.0	11,360.6	53,909.9
Удирдлагын зардал	1,354.8	2,040.0	1,199.2	1,340.5	5,934.4
Ашиг	1,531.9	2,306.6	1,355.9	1,515.7	6,710.0
ХАБЭА-ын зардал	319.2	469.0	275.5	284.0	1,347.7
Ажиллагсдын хээрийн нэмэгдэл	438.8	587.8	386.8	397.0	1,810.5
Барилга угсралтын ажлын дүн	16,414.1	24,161.3	14,239.4	14,897.8	69,712.5
Захиалагчийн хяналтын зардал	255.4	375.2	220.4	227.2	1,078.2
Магадалшгүй ажил	255.4	375.2	220.4	227.2	1,078.2
НӨАТ	1,641.4	2,416.1	1,423.9	1,489.8	6,971.3
Норм, нормативын сан	65.7	96.6	57.0	59.6	278.9
Нийт төсөвт өртөг	18,631.9	27,424.4	16,161.1	16,901.6	79,119.0

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хавсралт 4. Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн гүйцэтгэсэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн ус зайлуулах хоолойн ажлын төсөвт өртгийн нэгтгэл, сая төгрөг

Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүд	017 дугаар анги	110 дугаар анги	338 дугаар анги	339 дүгээр анги	340 дүгээр анги	345 дугаар анги	7780 дугаар анги	7781 дүгээр анги	7782 дугаар анги	Нийт
Хоолойн тоо, байрлал	29	28	26	33	32	53	28	28	31	288
Батлагдсан төсөв, төгрөг	4,747.4	5,986.9	3,790.1	6,174.4	6,440.3	6,255.3	5,119.3	5,668.8	5,113.4	49,295.8
Гүйцэтгэлийн төсөв, төгрөг	4,559.3	5,839.4	3,693.5	5,953.2	6,391.7	6,114.5	5,103.1	5,629.4	5,089.2	48,373.3
Ажилчдын цалин	481.2	595.2	369.2	643.1	640.8	585.7	502.1	567.5	539.2	4,924.0
Тээврийн жолоочийн цалин	23.9	35.4	26.3	29.3	39.4	55.9	36.5	36.0	25.2	307.9
Машин механизмын операторчдын цалин	7.3	9.5	6.6	6.6	9.7	13.1	8.3	8.6	6.0	75.8
Нүүлгэн шилжүүлэх ажлын цалин	2.1	1.9	1.7	1.5	2.1	2.4	2.2	1.9	1.8	17.6
Ажилчдын нэмэгдэл цалин	77.7	97.0	61.0	102.7	104.5	99.2	82.9	92.7	86.4	804.1
Талбайн ИТА-гийн цалин - 17%	87.1	108.8	68.4	115.4	117.3	111.3	93.0	104.1	97.0	902.3
Нийт цалин	679.4	847.8	533.2	898.6	913.8	867.6	725.0	810.8	755.4	7,031.7
Нийгмийн даатгалын шимтгэл	98.5	122.9	77.3	130.3	132.5	125.8	105.1	117.6	109.5	1,019.6
Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал	77.1	99.7	69.6	68.9	101.8	137.5	87.3	90.6	62.5	795.1
Материал	1,885.7	2,405.0	1,477.2	2,442.8	2,579.3	2,325.1	1,967.1	2,199.6	2,029.6	19,311.4
Тээвэр	251.3	371.6	275.9	307.2	413.1	587.1	383.0	377.6	264.0	3,230.9
Ажлын хувцас, багаж хэрэгслийн элэгдэл - 6.8%	32.7	40.5	25.1	43.7	43.6	39.8	34.1	38.6	36.7	334.8
Нүүлгэн шилжүүлэх зардал	22.3	20.3	18.3	15.4	22.0	24.8	23.2	20.0	18.6	185.0
Шууд зардлын дүн	3,047.1	3,907.8	2,476.8	3,907.0	4,206.1	4,107.8	3,324.8	3,654.8	3,276.4	31,908.5
Удирдлагын зардал 63.5%	431.4	538.4	338.6	570.6	580.3	550.9	460.4	514.9	479.7	4,465.1
Ашиг	487.8	608.7	382.9	645.2	656.1	622.9	520.5	582.2	542.4	5,048.8
ХЭБЭА-н үйл ажиллагааны зардал- 2.5%	76.2	97.7	61.9	97.7	105.2	102.7	83.1	91.4	81.9	797.7
Ажиллагсдын хээрийн нэмэгдэл	101.3	128.7	83.1	133.1	140.2	143.2	113.1	123.5	110.7	1,077.0
Барилга угсралтын ажлын дүн	4,143.8	5,281.3	3,343.3	5,353.6	5,687.8	5,527.6	4,501.9	4,966.7	4,491.1	43,297.1
Захиалагчийн хяналтын зардал 2%	60.9	78.2	49.5	78.1	84.1	82.2	66.5	73.1	65.5	638.2
Магадалшгүй ажил	60.9	78.2	49.5	78.1	84.1	82.2	66.5	73.1	65.5	638.2
НӨАТ	414.4	528.1	334.3	535.4	568.8	552.8	450.2	496.7	449.1	4,329.7
Норм, нормативын сан 0.4%	16.6	21.1	13.4	21.4	22.8	22.1	18.0	19.9	18.0	173.2
ДҮН	4,696.7	5,986.9	3,790.1	6,066.6	6,447.6	6,266.8	5,103.1	5,629.4	5,089.2	49,076.3

Хавсралт 5. Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдийн гүйцэтгэсэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн НӨАТ шингээгүй ажлын өртгийн нэгтгэл, төгрөг

№	Гүйцэтгэсэн ажлууд	Зэвсэгт хүчний 017 дугаар анги	Зэвсэгт хүчний 110 дугаар анги	Зэвсэгт хүчний 338 дугаар анги	Зэвсэгт хүчний 339 дүгээр анги	Зэвсэгт хүчний 340 дүгээр анги	Зэвсэгт хүчний 341 дүгээр анги	Зэвсэгт хүчний 342 дугаар анги	Зэвсэгт хүчний 7780 дугаар анги	Зэвсэгт хүчний 7781 дүгээр анги	Зэвсэгт хүчний 7782 дугаар анги	Нийт дүн
1	Зөрлөг-4 амралтын байр, гадна цэвэр бохир, тохижилт, удирдлагын барилга			1,882,692,000								1,882,692,000
2	Тавантолгой өртөөний депогийн засварын цех, уурын зуух, гадна дулаан, цэвэр усны шугам сүлжээ			5,993,694,060								5,993,694,060
3	Зөрлөг-5 удирдлагын байр, ажилчдын орон сууцны барилга				1,558,889,568							1,558,889,568
4	Цогцэций өртөөний депогийн барилга, түлш зэхэлтийн байгууламж, гадна бохир усны байгууламж, гадна цахилгаан хангамж				8,826,285,609							8,826,285,609
5	Зөрлөг-2 удирдлагын байр, ажилчдын орон сууцны барилга					1,535,974,053						1,535,974,053
6	Зөрлөг-1 удирдлагын байр, орон сууцны барилга, гадна цэвэр бохир усны шугам, цэвэрлэх байгууламж, зам талбайн барилга	1,554,703,059										1,554,703,059
7	Зөрлөг-3 удирдлагын байр, орон сууц, гадна цэвэр бохир усны шугам, цэвэрлэх байгууламж, зам талбайн барилга		1,554,475,812									1,554,475,812
8	Зөрлөг-6 ажилчдын сууцны барилга		1,027,857,133									1,027,857,133
9	Төмөр замын дээд үе угсрах ажил					2,997,332,489			3,392,578,967	2,894,076,320	3,186,321,332	12,470,309,108
10	Зам төмөр, дэр бетон тээвэр					3,122,551,789			3,378,335,408	2,177,554,160	3,484,759,258	12,163,200,615
11	Балласт тээвэр					1,051,427,664			566,144,712	517,139,758	696,560,862	2,831,272,996
12	Балласт тээвэр /2021 он/					122,902,552			120,404,384	50,046,017	37,902,838	331,255,791
13	ЗБ өртөөнд ачилт, буулгалт					152,137,577			204,943,215	223,522,186	162,097,050	742,700,028
14	Технологийн зам засвар, арчлалт					222,862,618			180,699,420	217,386,878	457,634,971	1,078,583,887
15	Балластыг тээвэрлэх, өөрөө буулгагч, хопер вагонд ачих /2022/					502,135,086	389,858,805	136,018,209		20,750,226		1,048,762,326
16	Шороон овоолго сэтлэх						30,948,568					30,948,568
17	Элс цэвэрлэгээ						68,710,459					68,710,459
18	Төмөр замын гүүрний хэсгийн доод бүтцийн засвар									334,588,951		334,588,951
19	Уулын шуудуу, далангийн засвар									12,538,699		12,538,699
	Нийт	1,554,703,059	2,582,332,945	7,876,386,060	10,385,175,177	9,707,323,828	489,517,832	136,018,209	7,843,106,106	6,447,603,195	8,025,276,311	55,047,442,722

Хавсралт 6. ЗГХЭГ-ын даргын 2019 оны 44 дүгээр тушаалаар байгуулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд зохион байгуулах худалдан авах ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

№	Нэрс	Албан тушаал	Ажлын хэсэгт гүйцэтгэх үүрэг	Тайлбар
1	А.Ганбат	Зэвсэгт хүчний жанжин штабын дарга	Ажлын хэсгийн дарга	
2	Д.Ганзориг	Зэвсэгт хүчний жанжин штабын дарга	Ажлын хэсгийн дарга	ЗТХС-ын 2019.10.11-ний өдрийн 315 дугаар тушаалаар зөвшилцсөнөөр
3	Ц.Батзул	Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга	Ажлын хэсгийн гишүүн	
4	М.Энхболд	ЗТХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Ажлын хэсгийн гишүүн	
5	Д.Баясгалан	ТЕГ-ын Эдийн засгийн аюулгүй байдлын газрын дарга	Ажлын хэсгийн гишүүн	
6	Ц.Ням-Очир	ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газрын дэд дарга бөгөөд Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга	Ажлын хэсгийн гишүүн	
7	Н.Цэрэнсамбуу	ТӨБЗГ-ын Мэдээллийн технологийн албаны дарга	Ажлын хэсгийн гишүүн	
8	Э.Батбаяр	Авлигатай тэмцэх газрын ахлах комиссар	Ажлын хэсгийн гишүүн	
9	Р.Бямбаа	Монголын төмөр зам ТӨХК-ийн Хуулийн хэлтсийн дарга	Нарийн бичгийн дарга	
10	Б.Энэрэл		Нарийн бичгийн дарга	ЗТХС-ын 2019.10.11-ний өдрийн 315 дугаар тушаалаар зөвшилцсөнөөр

Хавсралт 7. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, сая төгрөг

№	Зардлын нэр төрөл	Тодотгосон ТЭЗҮ-ийн дүн	Гэрээний үнэ	Ажлын гүйцэтгэлээр олгосон санхүүжилт	Хүлээгдэж гүйцэтгэлийн дүн	Аудитаар хасагдах зардал	ТӨСЛИЙН НИЙТ ГҮЙЦЭТГЭЛ	Гэрээний үнэ, гүйцэтгэлийн зөрүү хэмнэлт /+/ , хэтрэлт /-/
	А	1	2	3	4	5	6=(3+4-5)	7=(2-6)
1	ТЭЗҮ, зураг төсөл	14,773.7	5,583.0	5,462.4	120.6		5,583.0	-
2	Барилга, депо, засварын газар	70,928.9	37,190.9	33,902.7	2,615.8	1,214.1	35,304.4	1,886.5
3	Замын доод бүтэц (хоолой, газар шорооны ажил,худаг)	683,270.4	409,610.7	371,672.8	32,457.0	11,101.8	393,027.9	16,582.8
4	Гүүр	130,480.4	142,903.6	133,602.9	7,403.3		141,006.2	1,897.4
5	Замын дээд бүтэц	1,288,873.9	507,872.0	481,047.2	23,494.3		504,541.6	3,330.4
6	Дохиолол холбоо	80,000.0	121,587.1	103,500.8	18,474.2	8,062.8	113,912.2	7,674.9
7	Эрчим хүч	31,838.4	54,826.0	51,643.9	3,102.5		54,746.4	79.6
8	Магадлашгүй ажил	60,239.6	25,955.5	6,750.8	1,879.3	139.8	8,490.2	17,465.3
9	Хөдлөх бүрэлдэхүүн	460,116.0						-
10	Геологи, геодези	3,959.0						-
11	Төслийн удирдлагын зардал	28,833.2						-
12	Шилэн кабель		9,227.2	8,341.0	457.8		8,798.9	428.3
13	Хориг хашаа		3,433.7	3,104.8	-		3,104.8	328.8
14	Гэрэлтүүлэг		2,858.4	2,192.6	-		2,192.6	665.8
15	Захиалагч болон зөвлөх үйлчилгээний зардал, 4 хувь		51,803.7	35,742.9	15,425.3		51,168.3	635.4
16	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал		2,085.8	1,852.9	225.0		2,077.8	7.9
17	Норм нормативын сан (0.18-0.4 хувь)		2,331.2	-	2,286.6		2,286.6	44.6
	НИЙТ ДҮН	2,853,313.6	1,377,268.6	1,238,817.7	107,941.8	20,518.6	1,326,240.9	51,027.7

Хавсралт 8. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын төсвөөр бэлтгэсэн машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт, сая төгрөг

№	Бэлтгэн нийлүүлэгч, техник хэрэгслийн марк, нэр төрөл	Зориулалт	Бэлтгэсэн он	Тоо ширхэг	Нийт үнэ	Хуримт- лагдсан элэгдэл	Үлдэх өртөг
Машин, техник							
1 СҮЛДЭРХАН МИНЕРАЛС ХХК							
1.1	Dong Feng DFM	Ус шүршигч 12, 20 м.куб	2019	13	1,659.9	925.3	734.6
1.2	HOWO-340 XZ15250	Бетон зуурмаг тээвэрлэгч	2019	4	856.0	463.7	392.4
1.3	NORD	Трайллер чиргүүл	2019	2	495.5	268.4	227.1
1.4	NORD CDW4250A1T5	40 тн трайллер	2019	3	743.2	433.6	309.7
1.5	SINOTRUK HOWO-336	Өөрөө буулгагч	2019	30	4,797.3	2,598.5	2,198.8
1.6	SINOTRUK HOWO-371	Өөрөө буулгагч	2019	50	7,995.5	4,664.0	3,331.5
1.7	XCMG GR2405	Автогрейдр	2019	14	5,360.4	2,967.3	2,393.0
1.8	XCMG LW500 HV	Шанагт ачигч	2019	8	1,470.2	827.0	643.2
1.9	XCMG QY25K5A	Автокран	2019	2	944.5	511.6	432.9
1.10	XCMG TY-160	Бульдозер	2019	4	1,043.0	565.0	478.0
1.11	XCMG XS-183	Далангийн индүү	2019	21	4,256.8	2,348.0	1,908.8
2 УАЗ МЕГА ХХК							
2.1	УАЗ-390945 (Фермер)	Хагас ачааны автомашин	2019	2	69.5	37.6	31.9
2.2	УАЗ-315195 (Хантер)	Суудлын автомашин	2019	2	74.9	40.6	34.3
2.3	УАЗ-374195 /Фургон/	Ачаа суудлын автомашин	2019	3	99.8	55.4	44.3
3 ХАН БОГД ЛОЖИСТИК ХОНГОНГ ХХК							
3.1	SUNWARD SWE-365E	Экскаватор 2 м.куб	2019	26	13,819.0	7,839.6	5,979.4
4 ХЬЮНДАЙ МОТОРС МОНГОЛ ХХК							
4.1	HYUNDAI HD65 Dry Van	Чингэлэгтэй автомашин	2019	1	138.0	74.8	63.3
4.2	HYUNDAI HD65 Ref Van	Хөргүүртэй автомашин	2019	1	148.0	80.2	67.8
4.3	HYUNDAI HD120	Ачааны автокран	2019	1	365.0	197.7	167.3
5 АОДЭ ЛИЗИНГ ХХК							
5.1	QY25K-II	Автокран 25 тн	2020	2	680.0	283.3	396.7
5.2	SD22	Бульдозер	2020	1	359.0	149.6	209.4
5.3	SINOTRUK HOWO-336	Өөрөө буулгагч	2020	23	3,109.2	1,338.7	1,770.5
5.4	SINOTRUK HOWO-336	Миксер	2020	4	646.0	278.2	367.9
5.5	SINOTRUK HOWO-336 /20м3/	Усны машин	2020	6	896.5	386.0	510.5
5.6	SINOTRUK HOWO-371	Чирэгч толгой, трайллер	2020	2	350.0	150.7	199.3
5.7	XCMG GR215	Автогрейдер	2020	8	2,036.8	876.9	1,159.8
5.8	XCMG ZL50GN	Шанагт ачигч	2020	7	948.5	408.4	540.1
5.9	XCMG XS203J	Далангийн индүү	2020	16	2,479.3	1,067.5	1,411.8
6 БАДРАНГУЙ ОРШИХ ХХК							
6.1	LOVOL FR480E	Экскаватор	2020	10	5,927.0	2,551.9	3,375.1
7 МОНМАЧ ХХК							
7.1	ZOOMLION HBT80.1411 74RSU	Зөөврийн бетон шахуургын помп	2020	1	240.3	103.4	136.8
8 ТАВАН БОГД ГРУПП ХХК							
8.1	Land Cruiser-76	Суудлын автомашин	2020	1	116.0	56.4	59.6
9 УАЗ МЕГА ХХК							
9.1	УАЗ-315195 (Хантер)	Суудлын автомашин	2020	4	146.0	66.9	79.1
9.2	УАЗ-374195 (Фургон)	8 хүний суудалтай автомашин	2020	6	199.5	91.4	108.1
9.3	УАЗ-390945 (Фермер)	Бага оврын ачааны автомашин	2020	5	173.8	76.7	97.0
10 ЖИ ДИ ЭЙ ХХК							
10.1	ПАЗ-32053/54	25-30 хүний суудалтай автобус	2020	4	472.0	216.3	255.7
11 ХЬЮНДАЙ МОТОРС МОНГОЛ ХХК							
11.1	HYUNDAI HD65 Dry Van	Чингэлэгтэй автомашин	2020	1	138.0	61.3	76.7
11.2	HYUNDAI HD65 Ref Van	Хөргүүртэй автомашин	2020	1	148.0	65.8	82.2
Хэрэгсэл							
12.1	САН СҮРВЭЙ ХХК	Геодезийн багаж, хэрэгсэл	2019.06.24		68.3		
12.2	САН СҮРВЭЙ ХХК	Геодезийн багаж, хэрэгсэл	2019.08.01		37.5		
12.3	САН СҮРВЭЙ ХХК	Геодезийн багаж, хэрэгсэл	2019.09.20		68.0		
12.4	САН СҮРВЭЙ ХХК	Геодезийн багаж, хэрэгсэл	2019.11.07		31.4		
13.1	АЗИЙН МӨНГӨН БУЛАГ ХХК	Барилга, авто замын шинжилгээний тоног төхөөрөмж	2019.06.24		125.7		
13.2	АЗИЙН МӨНГӨН БУЛАГ ХХК	Барилга, авто замын шинжилгээний тоног төхөөрөмж	2019.09.24		125.6		
14	ГАВШГАЙ БАЯН ӨНДӨР ХХК	Дизель цахилгаан үүсгүүр	2019.09.24		32.0		
15.1	КОНТЕЙНЕР ХАУС ХХК	Зөөврийн угсардаг сууц	2019.06.27		45.0		
15.2	КОНТЕЙНЕР ХАУС ХХК	Контейнер	2019.09.30		172.4		
15.3	КОНТЕЙНЕР ХАУС ХХК	Контейнер	2019.09.30		14.5		
16	ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 017 АНГИ	Зөөврийн угсардаг сууц	2019.06.27		75.9		
17	ГРИН ЭКО ТРЭЙД ХХК	Контейнер	2019.10.09		115.4		
18	МАДЕРЛАНД ХХК	Гэр, түүний дагалдах хэрэгсэл	2019.10.18		78.1		
Үйлдвэр							
19	БИАНКОНЭРО КОНСТРАКШН ХХК	Бутлуурын үйлдвэр	2019.10.18		870.0		
20	БОСОО ХЭЭР ГРУПП ХХК	Бетон зуурмагийн үйлдвэр	2020.02.04		1,700.0		
НИЙТ ДҮН					66,962.1	33,127.8	30,274.5

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хавсралт 9. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн ТЭЗҮ, гэрээний үнэ

№	Зардлын зүйлс	Мөрийн дугаар	Гэрээ байгуулсан		Санхүүжилт тооцох хувийн жин, төгрөг
			Мөнгөн дүн, сая төгрөг	Мөнгөн дүн, мянган ам.доллар	
1	Тоног төхөөрөмж	1=2+...+9	159,865.5	56,093.2	686,282.0
Үүнээс	Бутлуур	2	36,178.6	12,694.3	155,310.0
	Туузан дамжуурга	3	41,999.4	14,736.6	180,298.0
	Дагалдах тоног төхөөрөмж	4	7,686.0	2,696.8	32,995.0
	Овоологч/тэжээгч	5	57,712.5	20,250.0	247,752.0
	Вагонд ачигч	6	6,290.6	2,207.2	27,005.0
	Нүүрс барьцалдуулагч систем	7	2,211.4	775.9	9,493.0
	Бусад (металл хийц-урсгуур)	8	818.4	287.1	3,513.0
	Тоног төхөөрөмжийн суурийн ажил	9	6,968.7	2,445.2	29,916.0
2	Угсралт, суурилуулалт	10	30,579.4	10,729.6	131,273.0
3	Барилга байгууламж	11	20,101.6	7,053.2	86,294.0
4	Эрчим хүч, автоматжуулалт	12	18,151.3	6,368.9	77,921.0
5	Зураг төсөл	13	4,246.6	1,490.0	18,230.0
6	ШУУД ЗАРДЛЫН ДҮН	14=1+10+11+12+13	232,944.3	81,734.9	1,000,000.0
7	Магадалшгүй ажлын зардал	15	18,797.1	6,595.5	80,694.0
8	Захиалагчийн хяналтын зардал 2 хувь	16			
9	ЕРС гэрээний менежментийн зардал 10 хувь	17	25,376.1	8,903.9	108,936.0
10	ДҮН	18=14+15+17	277,117.6	97,234.2	1,189,630.0
11	НӨАТ	19	27,711.8	9,723.4	118,963.0
	НИЙТ ДҮН	20=18+19	304,829.3	106,957.7	1,308,593.0

*1 ам.доллар = 2,850.0 төгрөг

№	Зардлын зүйлс	ТЭЗҮ-ийн үнийн дүн	Гэрээний үнийн дүн	ЗӨРҮҮ
1	Тоног төхөөрөмж	160,006.1	159,865.5	(140.6)
2	Угсралт, суурилуулалт	30,606.3	30,579.4	(26.9)
3	Барилга байгууламж	20,119.3	20,101.6	(17.7)
4	Эрчим хүч, автоматжуулалт	18,167.3	18,151.3	(16.0)
5	Зураг төсөл	6,270.0	4,246.6	(2,023.4)
6	Магадалшгүй ажлын зардал	18,813.5	18,797.1	(16.4)
7	Захиалагчийн хяналтын зардал 2 хувь	5,587.6	-	(5,587.6)
8	ЕРС гэрээний менежмент 10 хувь	25,398.6	25,376.1	(22.5)
9	НӨАТ	28,496.8	27,711.8	(785.1)
	НИЙТ ДҮН	313,465.5	304,829.3	(8,636.1)

Эх сурвалж: Соёолон инженеринг ХХК-ийн боловсруулсан ТЭЗҮ, Бодь интернэшнл ХХК-тай байгуулсан гэрээ

Хавсралт 10. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын шилжүүлэн ачих терминалын ажилд шаардагдах хөрөнгө оруулалт, сая нэгж

№	Хөрөнгө оруулалтын бүтэц	Мөнгөн дүн	
		сая ам.доллар	сая төгрөг
Нэгдүгээр шатны хөрөнгө оруулалт		31.1	88,338.8
1	Төмөр замын доод, дээд бүтцийн барилга угсралтын ажил	5.4	15,182.8
1.1	Төмөр замын доод бүтцийн барилга угсралтын ажил	2.1	5,781.3
1.1.1	Газар шорооны ажил	2.0	5,601.7
1.1.2	Хоолойн ажил	0.1	179.6
1.2	Төмөр замын дээд бүтцийн барилга угсралтын ажил	3.3	9,401.5
2	Авто зам	4.6	13,011.7
2.1	Газар шорооны ажил	2.8	7,936.5
2.2	Гүүр	1.3	3,591.0
2.3	Хоолой	0.5	1,484.2
3	Дохиолол холбоо	1.8	5,066.2
4	Чингэлэг болон зам талбай	5.7	16,317.8
5	Барилга байгууламж	4.7	13,471.7
6	Цахилгаан хангамж, гэрэлтүүлэг, дэд өртөөний тоног төхөөрөмж	1.0	2,765.7
7	Гадна дулаан, цэвэр бохир ус	2.5	7,211.4
8	Уурын зуух	0.1	170.6
9	Машин механизм, тоног төхөөрөмж	4.9	13,970.4
10	Бусад (геологи хайгуул, БОННУ, зураг төсөл)	0.4	1,170.5
Хоёрдугаар шатны хөрөнгө оруулалт		11.6	33,144.3
1	Төмөр замын доод бүтцийн барилга угсралтын ажил	1.9	5,370.3
1.1	Газар шорооны ажил	1.8	5,190.7
1.2	Хоолойн ажил	0.1	179.6
2	Төмөр замын дээд бүтцийн барилга угсралтын ажил	1.5	4,271.2
3	Дохиолол холбоо	0.8	2,308.0
4	Чингэлэг болон зам талбай	3.5	9,990.7
5	Гараашийн барилга	1.5	4,381.2
6	Машин механизм, тоног төхөөрөмж	2.4	6,822.9
НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		42.7	121,483.1
НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (НӨАТ-тай дүн)		46.9	133,631.5

Хавсралт 11. Тавантолгой - Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, сая ам.доллар, хувь

Багцын дугаар	Ажлын нэр төрөл	Үндсэн гэрээ	Гэрээний нэмэлт	Гэрээний нийт дүн	Баталгаажсан гүйцэтгэл өссөн дүнгээр /IPC-001-IPC023/*	Захиалагчийн баталгаажуулах гүйцэтгэлийг нэмсэн дүн /IPC024-IPC028/**	НИЙТ ГҮЙЦЭТГЭЛ /IPC 029/**	Хийгдээгүй болон дутуу ажил	Ажлын гүйцэтгэлийн хувь		
									Баталгаажсан гүйцэтгэлийн дүнд эзлэх /IPC001-IPC023/*	Захиалагчийн баталгаажуулах гүйцэтгэлийг /IPC024-IPC028/, нэмсэн дүнд эзлэх**	Нийт гүйцэтгэлд /IPC 029/ эзлэх***
БАГЦ 1	Дээд доод бүтцийн ажил: Зураг төсөл	4.8	-	4.8	4.8	4.8	4.8	-	100.0	100.0	100.0
	Дээд, доод бүтцийн ажил /0+000-207+550/	295.9	-	295.9	271.6	288.7	291.9	7.1	91.8	97.6	98.7
	Дээд, доод бүтцийн ажил /Тавантолгой өртөөний нэмэлт зам/	-	3.9	3.9	2.5	3.6	3.7	0.3	64.6	93.4	95.8
	Дээд, доод бүтцийн ажил /Зөрлөг I-ийн нэмэлт зам/	-	2.0	2.0	-	-	-	2.0	-	-	-
	Дээд, доод бүтцийн ажил /Ачилтын тойргийн төмөр зам/	-	21.6	21.6	16.4	17.1	20.6	4.4	76.0	79.4	95.7
	Дээд, доод бүтцийн ажил /Хил холболтын төмөр зам/	-	97.6	91.6	75.9	75.0	78.7	16.6	82.9	81.9	86.0
	Гүүрийн ажил /0+000-207+550/	18.5	-	18.5	13.1	15.6	18.3	2.9	70.9	84.2	99.0
	Хүннү Коалын авто замтай огтолцох хэсэг	2.9	-	2.9	2.6	2.6	2.6	0.4	87.0	87.0	87.0
	Суурь бүтцийн эвдрэл гэмтлийн засвар	27.0	-	27.0	26.2	26.9	26.9	0.1	97.2	99.8	99.8
БАГЦ 2	Дохиолол холбоо	72.5	4.4	76.9	52.6	73.5	79.2	3.5	68.4	95.5	103.0
БАГЦ 3	Өртөө, зөрлөгийн барилга байгууламж	48.9	7.9	56.8	12.5	39.8	48.9	16.9	22.0	70.2	86.2
БАГЦ 4	Эрчим хүч хангамж	20.0	-	20.0	10.6	19.4	19.4	0.6	53.2	97.2	97.2
БАГЦ 5	Хөдлөх бүрэлдэхүүн	203.7	-	203.7	28.8	102.8	154.5	101.0	14.1	50.4	75.8
БАГЦ 6	Хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмж	13.0	1.0	14.0	3.5	9.4	11.2	4.6	25.2	67.3	79.6
	Зам засварын машин механизм	-	5.0	5.0	4.0	4.9	5.0	0.1	79.5	98.0	100.0
БУСАД	Суурьшлын бүсийн барилга байгууламж	-	45.0	0.2	-	0.0	0.0	0.2	-	17.5	17.5
	Гашуунсухайт шилжүүлэн ачих терминал	-	-	20.6	-	6.4	7.9	14.3	-	30.8	38.2
	Гашуунсухайт шилжүүлэн ачих терминалын чингэлгийн талбай	-	-	9.6	-	-	-	9.6	-	-	-
	Ухаа худаг(ER)-ийн ачилтын тойрог	-	-	10.2	-	6.5	6.7	3.7	-	63.6	65.5
	Зүтгүүр эргэх тойргийн газар шороо, хоолой	-	-	3.4	-	1.6	1.6	1.8	-	46.9	46.9
	Гашуунсухайт өртөөний өргөсөлт дээд бүтцийн ажил	-	-	0.5	-	0.2	0.2	0.3	-	35.0	39.3

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Гашуунсухайт өртөөний өргөсөлтийн ДХ ажил	-	-	1.8	-	1.8	1.8	0.0	-	100.0	100.0
Тавантолгой өртөөний 7,8 дугаар замын өргөсөлтийн ДХ ажил	-	-	2.1	-	2.1	2.1	0.0	-	100.0	100.0
Тавантолгой өртөөний асфальтан зам	-	-	0.6	-	-	0.6	0.6	-	-	100.0
Үндсэн хөрөнгө	-	-	2.1	-	-	0.7	2.1	-	-	32.4
Хил дагуу камер суурилуулах ажил	-	0.4	0.4	-	-	-	0.4	-	-	-
ДҮН	707.3	188.7	896.1	525.1	702.8	787.4	193.3	58.6	78.4	87.9
Захиалагчийн хяналтын зардал	12.9	5.3	18.2	10.6	14.2	16.0	3.9			
НӨАТ /10%/	72.0	19.4	91.4	53.6	71.7	80.3	19.7			
НИЙТ ДҮН	792.2	213.4	1,005.6	589.3	788.7	883.7	216.9	58.6	78.4	87.9

Тайлбар:

- * Явц дундын төлбөрийн хүсэлтийг захиалагч болон ерөнхий гүйцэтгэгч талууд харилцан тохиролцож албан ёсоор баталгаажуулсан буюу IPC-001-IPC023-ын гүйцэтгэлийн мөнгөн дүн, түүний гэрээний нийт дүнд эзлэх хувь;
- ** Ерөнхий гүйцэтгэгчээс тухайн ажлуудын гүйцэтгэлийг хувийн жингээр тооцож, баталгаажуулахаар ирүүлсэн гүйцэтгэл буюу IPC-024, IPC-025, IPC-026, IPC- 027, IPC-028-өөрх ажлын гүйцэтгэлийн дүн, түүний гэрээний нийт дүнд эзлэх хувь;
- *** Ерөнхий гүйцэтгэгчээс ирүүлсэн өдөр тутмын ажлын гүйцэтгэл буюу "Daily report" IPC-029 дээр үндэслэн тооцсон ажлын нийт гүйцэтгэлийн дүн, түүний гэрээний нийт дүнд эзлэх хувийг харуулав.

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хавсралт 12. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын нүүрс ачих логиستيкийн төвийн ажлын гүйцэтгэл, сая төгрөг, хувь

№	Багцын дугаар	Ажлын нэр төрөл	Үндсэн (ЕРС) гэрээний дүн	Нийт баталгаажсан гүйцэтгэл (IPC 001- PC 004)*	Баталгаажуулах гүйцэтгэл (IPC 005- PC 006)**	Нийт гүйцэтгэл өссөн дүнгээр	Хийгдээгүй болон дутуу ажил	Гүйцэтгэлийн хувь
1	Багц 1	Вагонд ачигч	13,264.0	8,961.5	-	8,961.5	4,302.5	67.6
2	Багц 2	Бутлуур	45,611.4	23,666.8	8,260.7	31,927.6	13,683.9	70.0
3	Багц 3	Туузан дамжуурга, дагалдах тоног төхөөрөмж	64,941.5	37,041.1	1,435.2	38,476.3	26,465.3	59.2
4	Багц 4	Овоологч, тэжээгч	81,700.3	47,239.3	9,046.5	56,285.8	25,414.5	68.9
5	Багц 5	Барилга байгууламж, зам талбай	9,275.7	4,458.4	296.9	4,755.3	4,520.5	51.3
6	Багц 6	Эрчим хүч, автоматжуулалт	18,151.3	6,795.1	6,759.2	13,554.3	4,597.0	74.7
ХЭСГИЙН ДҮН			232,944.2	128,162.2	25,798.5	153,960.8	78,983.7	66.1
7	Магадалшгүй ажлын зардал		18,797.1	-	5,407.9	5,407.9	13,389.3	28.8
8	Менежментийн зардал		25,376.1	13,961.5	2,810.4	16,771.9	8,604.2	66.1
ДҮН			277,117.4	142,123.7	34,016.8	176,140.6	100,977.2	63.6
НӨАТ (10%)			27,711.8	14,212.4	3,401.7	17,614.1	10,097.7	
НИЙТ ДҮН			304,829.2	156,336.1	37,418.5	193,754.7	111,074.9	63.6

Тайлбар:

* Явц дундын төлбөрийн хүсэлтийг захиалагч болон ерөнхий гүйцэтгэгч талууд харилцан тохиролцож баталгаажуулсан буюу IPC-001-IPC004-ээрх ажлын гүйцэтгэлийн дүн;

** Ерөнхий гүйцэтгэгчээс тухайн ажлуудын гүйцэтгэлийн хувийн жингийн мөнгөн дүнгээр тооцож, баталгаажуулахаар ирүүлсэн буюу IPC-005, IPC-006-аарх баталгаажуулахаар хүлээгдэж байгаа ажлын гүйцэтгэлийн дүнг харуулав.

Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Хавсралт 13. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын холболтын төслийн ажлын гүйцэтгэл, сая төгрөг, хувь

№	Ажлын нэр төрөл	Үндсэн ЕРС гэрээний дүн	Баталгаажсан ажлын гүйцэтгэл, (IPC 001- PC 008)*	Баталгаажуулах гүйцэтгэл (IPC 009- PC 012)**	Нийт гүйцэтгэл буюу гүйцэтгэгчээс баталгаажуулах хүсэлт ирүүлсэн дүнг нэмсэн (IPC 013)***	Хийгдээгүй болон дутуу ажил	Ажлын гүйцэтгэлийн хувь		
							Баталгаажсан гүйцэтгэлийн дүнд эзлэх	Баталгаажуулах гүйцэтгэлийг нэмсэн дүнд эзлэх	Нийт гүйцэтгэлд эзлэх
1	Төмөр замын нарийвчилсан зураг төсөл	2,667.6	2,667.6	2,667.6	2,667.6	-	100.0	100.0	100.0
2	Доод бүтцийн ажил	29,443.7	23,926.0	25,047.9	25,047.9	4,395.8	81.3	85.1	85.1
3	Гүүр, төмөр зам, авто замын огтлолцлын ажил	14,930.0	11,313.3	12,677.3	12,677.3	2,252.7	75.8	84.9	84.9
4	Дээд бүтцийн ажил	66,551.9	47,677.4	64,536.2	65,178.0	1,373.8	71.6	97.0	97.9
5	Дохиолол холбоо, шилэн кабелийн ажил	19,621.2	5,318.2	13,538.7	13,538.7	6,082.5	27.1	69.0	69.0
6	Эрчим хүчний ажил	5,284.8	447.3	789.4	789.4	4,495.5	8.5	14.9	14.9
7	Хөдлөх бүрэлдэхүүн	48,235.0	17,205.4	17,700.4	40,899.4	7,335.6	35.7	36.7	84.8
ХЭСГИЙН ДҮН		186,734.2	108,555.2	136,957.5	160,798.3	25,935.9	58.1	73.3	86.1
8	ЕРС гэрээний удирдлага, менежментийн зардал	1,952.7	1,135.2	1,432.2	1,681.5	271.2	58.1	73.3	86.1
9	Эрсдэл, магадалшгүй ажил 3 хувь	5,092.8	-	1,346.8	1,346.8	3,745.9	-	26.4	26.4
10	НӨАТ (10 хувь)	19,378.0	10,969.1	13,973.7	16,382.7	2,995.3	56.6	72.1	84.5
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН		213,157.7	120,659.5	153,710.2	180,209.3	32,948.3	56.6	72.1	84.5
1	Захиалагчийн хяналтын зардал 2 хувь	4,108.2	2,388.2	3,043.7	3,568.2	540.0			
2	ТЭЗҮ, БОННУ, Геодези, гидрогеологи, геологи	814.1	814.1	814.1	814.1	-			
НИЙТ ДҮН		218,080.0	123,861.8	157,568.0	184,591.6	33,488.3	56.8	72.3	84.6

Тайлбар:

* Явц дундын төлбөрийн хүсэлтийг захиалагч болон ерөнхий гүйцэтгэгч талууд харилцан тохиролцож баталгаажуулсан буюу IPC-001-IPC008-ын ажлын гүйцэтгэлийн дүн;

** Ерөнхий гүйцэтгэгчээс тухайн ажлуудын гүйцэтгэлийг хувийн жингээр тооцож, баталгаажуулахаар ирүүлсэн буюу IPC-009, IPC-010, IPC-011, IPC-012-оорх ажлын гүйцэтгэлийн өссөн дүн;

*** Ерөнхий гүйцэтгэгчээс ирүүлсэн өдөр тутмын ажлын гүйцэтгэл буюу "Daily report дээр үндэслэсэн IPC-013-аарх гүйцэтгэлийг нэмж тооцсон нийт ажлын гүйцэтгэлийн дүнг харуулав.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.